

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д "Хүүхэд хамгааллын тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах, уг хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх зүйн үндсийг бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг, эх, олон нийт, байгууллага, хуулийн этгээдийн үүргийг нарийвчлан тусгах, түүнчлэн хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээний төрлийг тодорхой болгох, үйлчилгээг хүргэх үйл явц, хяналт, хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг давтан сургах, лицензжүүлэх, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах"-аар тусгасан нь тухайн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үндэслэл болов.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг боловсруулах хүрээнд 2021 оны 7 дугаар сараас 5-7-ны өдрүүдэд /Ковид-19/ цар тахлын үе байсан тул хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийг ярилцлага болон асуумжийн аргаар зохион байгуулж, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр ажилладаг төрийн байгууллагуудын албан хаагчид, сум, хорооны нийгмийн ажилтнууд, хүүхэд, гэр бүлийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын ажилтнууд, хүүхдийн эрхийн талаар мэргэшсэн өмгөөлөгчдийг оролцуулсан цахим хэлэлцүүлэг 6 удаа, мөн Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсгийн гишүүдэд хэлэлцүүлж, 2021 оны 9 дүгээр сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран үзэл баримтлалыг баталсан.

Баталсан үзэл баримтлалын дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 02 дугаар сарын хугацаанд ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлага, мэргэжилтэн 409 хүнд, мөн Хүүхдийн эрхийн улсын байцаагч 51 хүнд 2021 оны 12 дугаар сарын 14-нд, 2023 оны 6 дугаар сарын 15-нд 43 хүнд тус тус хэлэлцүүлж "Хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай судалгааны дүн", "Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал"-ыг гаргасан.

2022 оны 3 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг ивээх сан, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Норвегийн тусламжийн байгууллага, Дэлхийн зөн Монгол ОУБ, Холт олон улсын байгууллага, Гүүд Нейборс Монгол олон улсын байгууллагын төлөөллүүдэд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлж санал авч тусгасан.

2022 оны 5 дугаар сард Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хүний эрхийн үндэсний комисс, "Хүний эрх-дэвшилтэт бодлогын хүрээлэн"-тэй хамтран хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авсан.

2023 оны 5 дугаар сард Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсгийн гишүүд хуулийн төслийг дахин хэлэлцэж сайжруулав.

Японы Хүүхдийг ивээх сангаас биечлэн оролцоогүй тул саналыг цаасаар ирүүлсэн.

2022 оны 6 сар, 9 дүгээр сард Засгийн газрын гишүүдээс санал авч төсөл тусган сайжруулсан.

Хуулийн төслийг салбартаа 8 удаа, Салбар дундын ажлын хэсгээр 2021 оны 12 сар, 2022 оны 3, 5, 10, 2023 оны 4, 7 дугаар саруудад хэлэлцүүлж, саналыг тусган боловсруулсан.

2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хуулийн төслийг танилцуулсан.

2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 2 дэд бүлэг, 58 зүйлтэйгээр боловсрууллаа.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдан дараах хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа.

1. Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
4. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
5. Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
7. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
8. Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
9. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
10. Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
11. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
12. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай;
14. Хууль хүчингүй болсонд тооцох тухай;

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны www.mlsp.gov.mn сайтад 2021 оны 12 дугаар сараас 2023 оны 10 дугаар сарын 11-нийг дуустал байршуул, 3 удаа өөрчлөлтүүдийг оруулсан.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛУУДЫГ ТУСГАСАН БАЙДАЛ

д/д	Санал ирүүлсэн байгууллага, хүний нэр	Ирүүлсэн санал	Саналыг төсөлд тусгасан байдал
1.	Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо Албан бичгийн дугаар 2022.06.30 №2/3228	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж байна.	Тэмдэглэв.
2.	Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн Албан бичгийн дугаар 2023.01.19 №1/227	1.Төслийн 4.5 дугаар зүйлийн 1.2-т "Хүүхдийг суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх зорилгоор хүүхдийн нас хүйсийн онцлог, хөгжлийн түвшинд тохируулан амьдрах ухааны сургалт, үйлчилгээнд хамруулах, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөхөд тохиромжтой үйл ажиллагаанд холбон зуучлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх" гэж заасныг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т "...товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих" гэж заасан шаардлагад нийцүүлж, өөрчлөн найруулах саналтай байна.	1. Саналыг хүлээн авч найруулгыг тусгав.
3.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ Албан бичгийн дугаар 2022.06.28 №01/3672	1.Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт "мэргэжлийн удирдлага" гэснийг тайлбарласан байх бөгөөд заавал тайлбарлах шаардлагатай эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг анхаарах; 2.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 2-т "Энэ зүйлд зааснаас бусад хуульд заасан нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, захиргааны хэм хэмжээний акт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг баримтална" гэж тусгажээ. Захиргааны хэм хэмжээний актаар нэр томьёог тайлбарладаггүй бөгөөд уг хэсгийн найруулгыг засах;	1. Хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.12 дахь хэсэгт "хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага" гэж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй нийгмийн ажлын мэргэжилтнийг онол, арга зүйн хувьд удирдан чиглүүлэх, дэмжих, зөвлөн туслах, хөгжүүлэх үйл ажиллагааг" ойлгоно гэж тодорхойлов. 2.Саналыг хүлээн авч Захиргааны хэм хэмжээний акт гэснийг хасаж найруулав. Уг заалтыг Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална" гэж заасныг жишиг болгож Хүүхдийн эрхийн чиглэлээр олон улсын цөөнгүй гэрээ, конвенц байдаг тул нэр томьёог тайлбарлахдаа

		олон улсын гэрээ, конвенцыг баримтлах нь зүйтэй гэж үзсэний үзсэний үндсэн дээр оруулсан. 3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг хэлж байгаа болно.	олон улсын гэрээ, конвенцыг баримтлах нь зүйтэй гэж үзсэний үзсэний үндсэн дээр оруулсан. 3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг хэлж байгаа болно.
		3.Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 10-д “Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тандалт, судалгаа хийхийг хориглоно” гэж заажээ. Уг хэсэгт заасан төрийн захиргааны байгууллага гэдэг нь ямар асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байх нь тодорхойгүй байх тул төрийн захиргааны байгууллага гэсэн хэсгийг тодорхой болгох саналтай байна.	Саналыг хүлээн авч дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын хуульд буй “Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18-аас 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно” гэсэн заалтаар өөрчлөн найруулав.
4.	Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Албан бичгийн дугаар 2022.06.28 №1а/2452	1.Хуулийн төслийн 1.3 дугаар зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар 18 насанд хүрсэн хүний зөвшөөрснөөр энэ хуульд заасан зарим хүүхэд хамгааллын үйлчилгээг түүнийг 21 нас хүртэл үзүүлж болно.” гэснийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3.3-т заасантай нийцүүлэн “Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд түүний зөвшөөрснөөр энэ хуульд заасан зарим хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээг үзүүлж болно.” гэж; 2.Хуулийн төслийн 2.18 дугаар зүйлийн 10-д “...тандалт, судалгаа хийхийг хориглоно.” гэснийг “...тандалт, судалгаа хийх, Монгол Улсын үндэсний язгуур эрх ашиг, түүх, соёл, уламжлалт ахуй, зан заншлын эсрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэж; 3.Хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлийн 1.3-т “...үндэсний олон улсын төсөл, хөтөлбөр,” гэснийг “...үндэсний болон олон улсын төсөл хөтөлбөр,” гэж тус тус өөрчлөн найруулав.	2.Хуулийн зохицуулах харилцаа, зорилгод хамааралгүй байх асуудал гэж үзэж хуулийн төслийн заалтыг хэвээр үлдээв. 2.18 дугаар зүйлийн 10 дахь хэсэг “Олон улсын болон гадаад улсын байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт судалгаа хийхийг хориглоно” 3. Саналыг хүлээн авч найруулгыг засав.

	4.Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 1-д “Аймаг, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.” гэсэн нь хүн ам ихтэй сум (Тосонцэнгэл, Мандал, Замын-Үүд гэх мэт)-ын дээрх үйл ажиллагаанд оролцогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажил орхигдох, цаг хугацаа алдах, үйлчилгээг шууд авах боломжгүй байдлаар тусгасан байгааг анхаарах.	4. Саналыг хүлээн авч төслийн 2.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг “Хууль зүйн хороог шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нэгж, сум буюу сум дундын прокурорын газар болон шүүх ажиллаж байгаа сумдад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрснөөр сумын Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулж болно” гэж тусгав.
	5.Хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлийн 6-д “Байгууллага, аж ахуйн нэгж нь жилийн үйл ажиллагааны төсвийнхөө нэг хувийг хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэхэд зарцуулна.” гэснийг тухайн жилийн төсвийн ямар сангаас нэг хувийг зарцуулах талаар хуульд нарийвчлан тусгах зэрэг болно.	5. Цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх тодотгов.
Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр	1.Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлийн 4-т “терийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь тухайн байгууллагынхаа хүрээнд хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын бодлогыг батлан мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.” гэжээ. Төрийн байгууллага нь “Хүүхэд хамгааллын бодлогыг дангаар баталж, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтгүй. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр салбарын бодлого гэснийг хассан тул уг нэр томьёог “Хүүхэд хамгааллын талаар баримтлах тэргүүлэх чиглэл” болгон өөрчлөн найруулах;	1.Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж нь байгууллагынхаа хүрээнд хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын бодлогыг батлахаар байгаа тул хуулийн төслийн заалтын хэвээр үлдээв.
5.	2.Төслийн 2.4 дүгээр зүйлийн 2.3-т заасан “...өдөр өнжүүлэх төв, ... үзүүлж байгаа хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах” гэж заасан байх тул энэ төвийн үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг батлах эрхийг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт нэмж тусгах;	2. Боловсролын тухай хууль тогтоомжид тусгах боломжтой гэж үзэж төслийн заалтыг хэвээр үлдээв.
	3.Төслийн 3.2 дугаар зүйлийн 3-т заасан “...багш...” гэсний дараа “ажилтан, ... гэж нэмэх; мөн хэсэгт хэрэглэсэн “...сургуулийн хүүхэд хамгааллын баг...” гэсэн нэр томьёог хэрхэн ойлгохыг тайлбарлах.	3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ын Долоо дахь хэсэгт Сургуульд “анги удирдсан багш, сургуулийн нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйч”

		нараас бүрдсэн хүүхэд хамгааллын баг байхаар заасан ба хуулийн төсөлд хүүхэд хамгааллын баг гэж тусгасныг хасав. 4.Саналыг хүлээн авч тусгав. 5. Хэлэлцүүлгийн явцад дугаарлалтыг засах боломжтой. Тэмдэглэв.	нараас бүрдсэн хүүхэд хамгааллын баг байхаар заасан ба хуулийн төсөлд хүүхэд хамгааллын баг гэж тусгасныг хасав. 4.Саналыг хүлээн авч тусгав. 5. Хэлэлцүүлгийн явцад дугаарлалтыг засах боломжтой. Тэмдэглэв.
	4.Төслийн 3.2 дугаар зүйлийн 5-д заасан "...хөндлөнгийн хяналтыг тавина" гэснийг "хамгарч ажиллах, зөвлөн туслах" гэж өөрчлөх; 5. Төслийн зүйлийг давхар дугаараар томъёолсон байгааг анхаарч, төслийн 1.1 дүгээр "зүйл" гэснийг 1 дүгээр зүйл" гэж мэтээр дугаарлах.	1."Боловсролын орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дагаж мөрдөх стандартын шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, боловсруулах, хяналт тавих тогтолцоог тухайн салбарын хяналт тавих зохицуулалтыг тусгана"	Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 5.6-д "боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөх стандартын ерөнхий шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах. гэж нэмж орууллаа.
Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Албан бичгийн дугаар 2023.07.28 №1а/3510	6.	1.Хуулийн төслийн зургадугаар бүлгийн 6.1 дүгээр зүйлийн 7-д "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар батална." гэж өөрчлөн найруулав. 2.Мөн хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 5.3-т "боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээг авах" тухай зохицуулалт туссан болно. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний талаар дараах зохицуулалт туссан. -Эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг болон нийгмийн бусад үйлчилгээ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна. -Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана. -Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлын санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн,	нараас бүрдсэн хүүхэд хамгааллын баг байхаар заасан ба хуулийн төсөлд хүүхэд хамгааллын баг гэж тусгасныг хасав. 4.Саналыг хүлээн авч тусгав. 5. Хэлэлцүүлгийн явцад дугаарлалтыг засах боломжтой. Тэмдэглэв. Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 5.6-д "боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мөрдөх стандартын ерөнхий шаардлагыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах. гэж нэмж орууллаа. 1.Хуулийн төслийн зургадугаар бүлгийн 6.1 дүгээр зүйлийн 7-д "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг Засгийн газар батална." гэж өөрчлөн найруулав. 2.Мөн хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 5.3-т "боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээг авах" тухай зохицуулалт туссан болно. Мөн Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөлд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний талаар дараах зохицуулалт туссан. -Эрүүл мэнд, спорт, боловсрол, соёл урлаг болон нийгмийн бусад үйлчилгээ нь хүүхдийн хөгжлийг дэмжсэн байна. -Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үйлчилгээний бодлого, хөтөлбөртэй байх бөгөөд эрх бүхий этгээдээс баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллана. -Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлын санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн,

		боловсролын, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус хамтран батална.” гэсэн байгаа. 1.Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 2-т “Боловсролын сургалтын байгууллагын хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 2.Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлийн 4-т “Боловсролын сургалтын байгууллагын удирдлага, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгж нь энэ зүйлийн 3-т заасан мэдээллийн мөрөөр нэн даруй хяналт шалгалт явуулж дараах арга хэмжээг авна.” гэж тус тус өөрчлөн найруулав.
7.	Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжин Албан бичгийн дугаар 2022.07.19 №09/3678	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах, энэ хүрээнд онцлог, хэрэгцээнд нь нийцсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх асуудлыг уялдуулан тусгах саналтай байна.
8.	Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Албан бичгийн дугаар 2023.01.13 №09/218	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 09/3678 тоот албан бичгээр хүргүүлсэн саналаа дахин хүргүүлэв.
9.	Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Албан бичгийн дугаар 2022.06.28 №01/3027	1. Саналыг хүлээн авч хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны эрхийг заав. 2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ын Долоо дахь хэсэгт Сургуульд “анги удирдсан багш,

		байгааг анхаарч хуулийн төсөлд хүүхэд хамгааллын багийн талаар тодорхой тусгах; /Сургуулийн хүүхэд хамгааллын багийг тайлбарлав./	сургуулийн нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйч" нараас бүрдсэн хүүхэд хамгааллын баг байхаар заасан ба хуулийн төсөлд хүүхэд хамгааллын баг гэж тусгасныг хасав.
10.	Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Албан бичгийн дугаар 2023.01.10 №01/105	3.Хуулийн төслийн "3.3 дугаар зүйл.Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал" зүйлд эрсдэлт бүлгийн хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж үзүүлэх талаар тусгах зэрэг болно.	3. Саналыг хүлээн авч хуулийн төсөл болон дагалдуулан Эрүүл мэндийн тухай хуульд хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байхаар хуулийн төслийг боловсруулав. Саналыг хүлээн авав.
11.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Албан бичгийн дугаар 2022.06.28 №01/1832	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2.6 дахь зүйлийн 3-д "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах асуудлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан хэдий ч зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10-д "Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа", 8.2 дугаар зүйлийн 9-д "Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны чиглэлээр энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа"-ны жагсаалтад тусгаагүй байгааг анхаарахыг хүсье.	Тэмдэглэв.
12.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд О.Цэндсүрэн Албан бичгийн дугаар 2023.01.09 №02/33	Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл, танилцуулгатай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тэмдэглэв.
13.	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Албан бичгийн дугаар 2022.07.29 №1/4071	1.Хуулийн төслийн зарим зүйл, заалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулах шаардлагад нийцээгүй байна.Тухайлбал, хуулийн төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д "...хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг	1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.4 дүгээр зүйлд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт дараах асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан: - хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр, журмыг батлах;

	давтан сургах, лицензжүүлэх, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах"-аар заасан боловч дээрх агуулга нь хуулийн төсөлд тусгагдаагүй байх бөгөөд холбогдох зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төслийг дагалдан Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар заасан байх боловч тус хуулийн төслийг боловсруулж ирүүлээгүй байгааг анхаарах.	- хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчид зориулсан сургалтын хөтөлбөр, журмыг батлах; Мөн 2.5 дугаар зүйлд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт дараах зохицуулалтыг тусгасан: - хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллага, их, дээд сургуультай хамтран зохион байгуулах; - аж ахуйн нэгж, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагч, ажилтнуудыг хүүхэд хамгааллын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх талаар тухайн байгууллагатай хамтран ажиллах; Хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 5-д "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх, мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан.
	2.Хуулийн төслийн 3.6 дугаар зүйлийн 4.3 дахь заалтад уралдаанч хүүхдийг гэнэтийн ослын даатгалд даатгуулахаар тусгасныг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "... уралдаанч хүүхэд нь үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байна." гэж заасантай нийцүүлэх. Мөн хуулийн төслийн зүйлийн 3.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, стандартын хэрэгжилтэд тухайн орон нутгийн Засаг дарга, хуулиар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага хяналт тавьж ажиллана" гэж тусгасныг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Үндэсний хурдан морины уралдааны явцад хүүхдийг ослын даатгалд даатгуулсан эсэх болон стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэж байгаа эсэхэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн	2. Саналыг хүлээн авч хурдан морины уралдаанч хүүхдийн талаарх төслийн зохицуулалтыг төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгээр хуулийн үйлчлэх хүрээг тодорхой зааж, мөн төслийн 3.6 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсгийн зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зохицуулалттай нийцүүлж тусгав.

	захиргааны төв байгууллага хяналт тавина.” гэж заасантай нийцүүлэх.	
	3.Хуулийн төслийн 2.13 дугаар зүйлд хамтарсан багийн хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан хамтарсан багийн чиг үүрэгтэй давхардаж байна. Тухайлбал, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, таслан зогсоох, мэдээлэх үйл ажиллагааг төлөвлөх хэрэгжүүлэх чиг үүрэг болон сум, хорооны нийгмийн ажилтан хамтарсан багийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэхээр тусгасан байна. Түүнчлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хамтарсан баг хуулийн төсөлд тусгасан хамтарсан багийн чиг үүргийг хэрэгжүүлэх эсэх, эсхүл өөр бүтэц, бүрэлдэхүүнтэй хамтарсан багийг дахин байгуулж ажиллуулах эсэх нь тодорхой бус байгааг анхаарч чиг үүргийн давхардал үүсгэхгүй байх.	3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зохицуулалттай харьцуулж, давхардлыг арилгав.
	4.Хуулийн төслийн найруулга зүйн болон хууль зүйн техникийг дахин нягтлах шаардлагатай буюу хуулийн төслийн зарим нэр томъёо болон зохицуулалт тодорхойгүй байгааг анхаарах. Тухайлбал, хуулийн төслийн 1.5 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад “дээд ашиг сонирхол” гэж тусгасан нь ойлгомжгүй байх тул бусад хуулийн нэр томъёотой нийцүүлэх, мөн төслийн 2.10 дугаар зүйлд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны даргын үүргийг гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох, түүнчлэн даргын эзгүйд хороог болон хуралдааныг даргалах албан тушаалтныг тодорхой болгох нь зүйтэй. Мөн хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл болон орон нутгийн зөвлөлийн гаргах хүүхэд хамгааллын тайлангийн тайлант хугацааг тодорхой болгох.	4. Хүүхдийн эрхийн тухай конвенцыг Монгол хэл рүү хөрвүүлэхдээ “хүүхдийн дээд ашиг сонирхол” гэсэн нэр томъёог хэрэглэсэн байдаг тул төслийн Саналыг хүлээн авч төслийн 2.8 дугаар зүйлийн 2-т “Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна” гэж тусгасан.
	5.Хуулийн төслийн 2.11 дүгээр зүйлд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, эсхүл гэрч, хохирогчоор оролцох тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо оролцохоор тусгасан байна. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.3-т “бусад оролцогч” гэж гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн	5. Саналыг хүлээн авч төслөөс хассан.

	даргыг” гэж, мөн зүйлийн 1.13-т ““оролцогч” гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг” гэж тус тус заасан тул Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хэргийн оролцогчоор оролцох боломжгүй байна. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад мөрдөгч, прокурор өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор хуульчилсан ба 2 дахь хэсэгт “... арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.” гэж заасан хуулийн зохицуулалттай нийцүүлэх.	6. Саналыг хүлээн авч 2.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн мэдээллийг ялын хугацаа дуусахаас хамгийн багадаа 30 хоногийн өмнө, бусад үндэслэлээр суллагдсан тохиолдолд ийнхүү суллагдсанаас хойш 3 хоногийн дотор” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын албанд ирүүлдэг байхаар өөрчлөн найруулав.
	7.Хуулийн төслийн 2.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй гомдол, нэхэмжлэлийг хүлээн авагч иргэний хэрэг үүсгэнээс хойш 7 хоногийн дотор тухайн шүүхийн тамгын газраараа дамжуулан харьяа Хууль зүйн хороонд мэдэгдэнэ” гэж тусгажээ. Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулийг хэрэглэх бөгөөд шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан байх тул хуулийн төслийн дээрх зохицуулалтыг тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар боловсруулах нь зүйтэй.	7. Саналыг хүлээн авч 2.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т “Шүүх нь шүүхэд шилжүүлсэн өсвөр насны яллагдагч, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, ял шийтгэгдсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийн мэдээллийг тухай бүр” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын албанд ирүүлдэг байхаар өөрчлөн найруулав.

14. Хуул зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2023.02.10 № 1/800	Нэг.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар 1.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.1, 1.5-д “хүүхэд хамгаалал” гэж зөвхөн урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаа, үйлчилгээг ойлгохоор тусгасан буюу гэмт хэргийн хохирогч эсхүл эрх нь зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээг тусгаагүй байх тул “хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх” гэсэн агуулга нэмэх. 2.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-т тусгасан дээрлэлт үйлдэх субъект нь зөвхөн хүүхэд буюу насанд хүрээгүй хүн байхаар тодорхойлсныг дахин нягтлах. Өөрөөр хэлбэл, дээрлэлтийг зөвхөн хүүхэд үйлддэг эсэх нь тодорхойгүй байна. Хэрэв тус хуульд зөвхөн дээрлэлтийг хүүхэд үйлдэхээр тодорхойлох шаардлагатай бол “үе тэнгийн дээрлэлт” гэж тодотгох. 3.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д “эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхэд” гэж гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамааруулахаар тодорхойлсон нь ойлгомжгүй байгааг дахин нягтлах. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн хохирогч болох эрсдэлтэй байгаа хүүхдийг “эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхэд” гэж, харин гэмт хэргийн хохирогч хүүхдийг “хохирогч хүүхэд” гэж ялгаж томьёолох. Учир нь эдгээр хүүхдүүдийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь харилцан адилгүй байх шаардлагатай. 4.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.11-д тусгасан “кейс менежмент” гэснийг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын 4.1.2-т заасантай нийцүүлж Монгол хэлний нэр томьёогоор тусгах. Түүнчлэн мөн зүйлийн 2-т тусгасан “Энэ хуульд заасан нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална.” гэж заасныг хасаж, шаардлагатай тохиолдолд нэг бүрчлэн нэр томьёоны тайлбар нэмэх.	1.Саналыг хүлээн авч 1.4 дүгээр зүйлийн 1.1-д “зөрчигдсөн эрхийг сэргээх” агуулгыг тусгав. Харин 1.4 дүгээр зүйлийн 1.5-д “хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ” гэж орсон байгаа тул уг заалтад тусгах шаардлагагүй гэж үзэв. 2.Саналыг хүлээн авч нэр томьёог “үе тэнгийн дээрлэлт” гэж өөрчлөв. 3. 1.4 дүгээр зүйлийн 1.6 дахь заалтаас “бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг” гэснийг хасав. Учир нь уг агуулга нь “эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан; хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөл байдалд байгаа,” гэсэн ойлголтод багтаж байна. “Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч” хүүхэд гэснийг томьёолов. 4.Саналыг хүлээн авах боломжгүй. Кейс менежмент гэсэн нэр томьёо нь олон улсад тогтсон, мэргэжлийн нэр томьёо тул уг нэр томьёог Монгол хэл рүү буулгахад оновчтой нэр томьёо олдсонгүй. Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэснийг жишиг болгож оруулсан. Хүүхдийн эрхийн чиглэлээр олон улсын цөөнгүй гэрээ, конвенц байдаг тул нэр томьёог тайлбарлахдаа олон улсын гэрээ, конвенцыг баримтлах нь зүйтэй гэж үзсэн. Мөн MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагад “кейс
---	--	--

		менеджмент” гэх мэргэжлийн нэршлээр батлагдсаныг ашиглав. 5.Саналыг хүлээн авч “хүүхдийн үзэл бодол, нөхцөл байдал, онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх” гэж тусгав. 6.Саналыг хүлээн авч 4.12 дугаар зүйлийн 6-д “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна” гэж тусгав. 7.Саналыг хүлээн авч холбогдох хэсгийг хасав. 8.Саналыг хүлээн авч “Хууль зүйн хорооны гишүүн хууль зүйн хороонд хандсан, үйлчилгээ авсан хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчийн талаарх хүний хувийн болон эмзэг мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй” гэж найрууллыг засав. 9.Саналыг хүлээн авч уг заалтыг хасав.
	5.Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлийн 1.4-т “хүүхдийн” гэсний дараа “үзэл бодол,” гэж нэмэх. 6.Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлийн 3-т “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна” гэж заасан нь хуулийн зарчимд хамаарахгүй буюу зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа байх тул тус хэсгийг хасаж, холбогдох зүйлд нэмэх. 7.Хуулийн төслийн 2.6 дугаар зүйлийн 5-д хүүхэд, гэр бүл хамгааллын нийгмийн ажилтны эрхийг тодорхойлсон. Гэтэл тус зүйлийн 5.5-д цагдаагийн байгууллагын үүргийг тусгасан байх тул “Цагдаагийн байгууллага хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны хүсэлтийн дагуу түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг нэн даруй авна” гэснийг тус хэсгээс хасах. 8.Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 8-д заасан мэдээллийн нууцлах зохицуулалт нь хувь хүний нууцад хамаарах тул төрийн эрх бүхий албан хаагчийн нууц хадгалах зохицуулалтыг Хүний хувийн мэдээллийн тухай хуультай нийцүүлэх. 9.Хуулийн төслийн 2.11 дүгээр зүйлийн 2-т хууль зүйн хорооны ажлын алба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн хүсэл зориг, байр суурийг илэрхийлэх төлөөлөгчийг томилон оролцуулах эрх олгосон нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1.1-д мөрдөгч, прокурор, өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох, мөн зүйлийн 2-т “... арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны	

	төлөөлөгчөөр тогтоож болно.” гэж заасантай нийцэхгүй байгааг анхаарах.	
10.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 10-т “Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээг дэмжих, цахим орчинд хүүхдэд учрах нийтлэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах журмыг батлах асуудал нь хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй байх тул тус хэсгийн “хууль зүйн асуудал эрхэлсэн” гэснийг хасах.	10.Саналыг хүлээн авч “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн” гэж өөрчлөв.	
11.Хуулийн төслийн 3.5 дугаар зүйлийн 2-т “хуульд заасан хариуцлага хүлээнэ” гэж заасан нь ойлгомжгүй байх тул эшлэх хэлбэрээр холбогдох хуулийг тодорхой тусгах.	11.Саналыг хүлээн авах боломжгүй. Дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2 дахь хэсгийн зохицуулалтыг хэвээр хадгалсан болно.	
12.Хуулийн төслийн 3.5 дугаар зүйлийн 2-т “Жагсаал, цуглаанд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасныг хасах. Учир нь жагсаал, цуглаанд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах асуудлыг Жагсаал, цуглааны тухай хуулиар зохицуулах шаардлагатай.	12.Саналыг хүлээн авч хасав.	
13.Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлд тусгасан гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын зохицуулалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зохицуулалт, мөн Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээний үед авах арга хэмжээтэй нийцэхгүй байгааг анхаарах.	13.Саналыг хүлээн авах боломжгүй. Монгол Улсын одоогийн мөрдөж байгаа хуулиудад гамшгийн үе дэх хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулж өгөөгүй байдаг. Тухайлбал, 2020-2021 онд коронавируст /Ковид-19/ цар тахлын үед авсан хөл хорионы үед хүчирхийлэлд өртсөн хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж, эрхийг нь хамгаалах боломж хязгаарлагдмал, хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт өмнөх онуудтай харьцуулахад 50 хувиар буурсан байдаг. НҮБ-ын гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын удирдамжийг үндэслэн MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага батлагдсан.	
14.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 2-т “шаардлагатай тохиолдолд бусад мэргэжилтнийг байлцуулна” гэж тусгасан нь ямар мэргэжилтэн нь тодорхойгүй байх тул тодорхой тусгах.	14.Саналыг хүлээн авч сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч гэж тодорхой болгов.	

	15.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 3-т “Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдөхөөс бусад тохиолдолд хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авахдаа түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эсхүл хүүхэдтэй ойр дотно харилцаатай хүнийг байлцуулна” гэж заасан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1.1-д мөрдөгч, прокурор өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох, мөн зүйлийн 2-т “... арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.” гэж, мөн хуулийн 18.5 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагааны явцад ямар эрхтэй оролцохыг тус тус заасантай нийцэхгүй байгааг анхаарах.	15.Саналыг хүлээн авч холбогдох хэсгийг хасав.
	16.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 6-д “Хүүхэд өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хууль зүйн туслалцаа авах, гомдол гаргах эрхтэй” гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжийн зарчимтай агуулгын хувьд давхардаж байгаа тул давхардуулан заах шаардлагатай эсэхийг дахин нягтлах.	16.Саналыг хүлээн авч холбогдох хэсгийг хасав.
	17.Хуулийн төслийн 4.11 дүгээр зүйлийн 3-т “мэргэжлийн нууц” гэж тусгасан нь ойлгомжгүй байх тул холбогдох нууцын хууль тогтоомжтой нийцүүлэх.	17.Саналыг хүлээн авч “мэргэжлийн нууц” гэснийг хасав.
	18.Хуулийн төслийн 4.2 дугаар зүйлийн 1-д “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээд нь өөрийнхөө тухай мэдээллийг бусад этгээдэд задруулахгүй байх хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн нууцлалыг чандлан хадгална” гэж заасан нь мэдээлэл гаргагчийн мэдээллийг задруулах эрсдэл үүсэх тул тухайн этгээдийн мэдээллийг шууд нууцлах бөгөөд тухайн этгээд өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг ил болгох байдлаар тусгах.	18.Саналыг хүлээн авч найруулгыг засав.

	19.Хуулийн төсөлд асралт гэр бүлийн асуудлыг тусгасан бөгөөд энэ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хувилбарт хэлбэр байхаар тодорхойлсон буюу Гэр бүлийн тухай хуульд тусгасан гэр бүлийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээхгүй юм. Иймд асралт гэр бүлийг сонгон шалгаруулах, ажиллах, хяналт тавих зэрэг нарийвчилсан зохицуулалтыг Хүүхэд хамгааллын тухай хуулиар нэмж зохицуулах, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасныг хасах. Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “2.Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнаар дамжуулан энэ хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3.8 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.” гэж нэмэхээр заасан нь Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан ба Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.9 дүгээр зүйлийн 5-д “Эрх бүхий албан тушаалтан 6.20 дугаар зүйлд заасан зөрчлийн хохирогч, гэрч, тэдгээрт тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор зөрчлийн хэргийг холбогдогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид танилцуулахдаа хохирогч, гэрчийн мэдүүлэг болон биеийн байцаалтыг нууцлах арга хэмжээг авна” гэж заасантай нийцэхгүй байна. Түүнчлэн мэдүүлэг авах ажиллагааг эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэдэг зохицуулалттай зарчмын хувьд зөрчилдөж байх тул тус зүйлийг хасах.	19.Саналыг хүлээн авч 4.8 дугаар зүйлд нарийвчилсан зохицуулалтыг тусгав.
Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Албан бичгийн дугаар 2023.03.24 №1/1473	1. 1.4 дүгээр зүйлийн 1.6 дахь заалтаас “бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг” гэснийг хасав. Учир нь угаулга нь “эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан; хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөл байдалд байгаа,” гэсэн ойлголтод багтаж байна. “Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч” хүүхэд гэснийг томъёолов. 2.Саналыг хүлээн авах боломжгүй. Дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2 дахь хэсгийн зохицуулалтыг хэвээр хадгалсан болно.	Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1.Саналыг хүлээн авав.

		3. Хуулийн төслийн 3.7 дугаар зүйлд тусгасан гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын зохицуулалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зохицуулалт, мөн Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой араг хэмжээний үед авах араг хэмжээтэй нийцэхгүй байгааг анхаарах. Монгол Улсад өнөөгийн байдлаар мөрдөгдөж буй хуулиудаар гамшгийн үе дэх хүүхэд хамгааллын асуудлыг зохицуулж өгөөгүй байдаг тул тус асуудлыг салбарын хуулиудад тусгахаар хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд: 1. Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд “Энэхүү Конвенцын зорилгод тухайн хүүхдэд хэрэглэх хуулийн дагуу тэрээр 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ” гэж тус тус заасныг үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу 18-аас дээш 21 хүртэл насны хүнд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж болно” гэж заасныг хасах. Цаашид хуулийн төсөлд тус агуулга бүхий хэд хэдэн заалт байгааг хасах нь зүйтэй; 2. Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.4-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчилд холбогдсон; эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэл хүлээсэн; гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон; иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийг,” гэж тусгасныг “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчилд холбогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрч; иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийг” гэж найруулах;
16.	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар 2023.05.22 №1/2835	3. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав. 1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн /2016 он/ 3 дугаар зүйлийн 3.3-т “Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.” гэснийг хэвээр үлдээж саналыг хүлээн авав. Саналыг хүлээн авав.

	3. Хуулийн төсөлд тусгагдсан "хохилогч хүүхэд", "хохилогч болсон хүүхэд" гэх ойлголтуудыг жигдлэн томъёолох;	Саналыг хүлээн авч нэр томъёог жигдлэв. "Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд" гэж жигдрүүлж, нэр томъёоны хэсэгт "гэмт хэрэг, зөрчлийн хохирогч хүүхэд" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийг; ойлгоно тодорхойлолтыг оруулав.
	4.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 4-т хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах аргачлал, зааврыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар, мөн зүйлийн 7-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батлахаар тус тус тусгасан нь давхардаж байна. Иймд хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 4-т "Хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах аргачлал, зааврыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална" гэж тусгасныг хасах;	4.Саналыг хүлээн авч 3.8 дугаар зүйлийн 4-ийг хасав.
	5.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн "журмыг" гэсний дараа "хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон" гэж нэмэх, мөн хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсгийн "хамтарсан баг" гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг гэснийг "хамтарсан баг" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасныг" гэж, 2.10 дугаар зүйлийн 2.5, 3.3 дахь хэсэгт "энэ хуульд заасны дагуу хамтарсан багийг тэргүүлэх" гэснийг "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаар ахлах" гэж тус тус өөрчлөх;	5. ""Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална." гэж оруулав -Саналыг хүлээн авч хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.10-ыг "хамтарсан баг" гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасныг" гэж өөрчлөв. -Саналыг хүлээн авч Хуулийн төслийн 2.10 дугаар зүйлийн 2.5, 3.3 дэх дахь хэсгийг өөрчлөв.
	6.Хуулийн төслийн 6.4 дүгээр зүйлд Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн бүрэн эрхийг тусгасныг төслийн Хоёрдугаар бүлэг буюу Хүүхэд хамгааллын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт бүлэгт оруулах;	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн бүрэн эрхийг заасан хэсгийг Хүүхдийн эрхийн тухай хуулийн төслийн "Хүүхэд хамгааллын санхүүжилт ба хяналт" гэсэн 6 дугаар бүлэгт оруулах нь зүйтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, энэ нь хүүхэд хамгааллын хууль тогтоомжид тавих захиргааны

		хяналтын хүрээнд хүүхдийн эрхийн улсын байцаагч ямар бүрэн эрхийг эдлэх тухай асуудал юм. Бусад хуулиудыг харахад ийм байдлаар тусгасан байна. Тухайлбал, Автотээврийн тухай хуулийн "Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих" гэсэн Тавдугаар бүлгийн 22 дугаар зүйлд "Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн эрхийг заасан байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт" гэсэн Долдугаар бүлгийн 33 дугаар зүйлд Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг заасан байна. Товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэсэн болно.	хяналтын хүрээнд хүүхдийн эрхийн улсын байцаагч ямар бүрэн эрхийг эдлэх тухай асуудал юм. Бусад хуулиудыг харахад ийм байдлаар тусгасан байна. Тухайлбал, Автотээврийн тухай хуулийн "Автотээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих" гэсэн Тавдугаар бүлгийн 22 дугаар зүйлд "Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн эрхийг заасан байна. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт" гэсэн Долдугаар бүлгийн 33 дугаар зүйлд Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн бүрэн эрхийг заасан байна. Товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэсэн болно.
	7.Хууль тогтоомжийн тухай хуульд 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар холбогдох нэмэлт, өөрчлөлт орсон. Тус нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д хууль санаачлагч хуулийн төслийн талаар товч болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэхээр, мөн зүйлийн 33.3-т хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад хуулийн төсөл болон дагаж гарах хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрд хуульд заасан холбогдох тайлбарыг тусгахаар тус тус заасныг анхаарах.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд ""хамтарсан баг" гэж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.8-д заасныг," гэж тусгасныг ""хамтарсан баг" гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дүгээр зүйл болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хамгааллын үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг," гэж найруулах;	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.2 дахь заалт буюу "гэр бүлийн хүчирхийллийн хохирогч" /цаашид "хохирогч" гэх/ гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг" гэсэн заалтын "гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" болон "цаашид "хамтарсан баг" гэх" гэснийг тус тус хасахаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туслав.

	Саналыг хүлээн авах боломжгүй. -Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл батлагдсанаар сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо шинээр бий болох уг мэргэжилтнийг Хамтарсан багийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай. Дагаж мөрдөж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 201.1 дэх хэсэг буюу Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг заасан хэсгийг бичилт, нэршлийн хувьд ойлгомжтой байлгах үүднээс уг хэсгийг өөрчлөн найруулахаар төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан болно. Саналыг хүлээн авах боломжгүй. -Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд "Хамтарсан баг"-ийн тодорхойлолтыг заахдаа "эр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас эш татаж заасан болно. Саналыг хүлээн авч тусгав.	Саналыг хүлээн авах боломжгүй. -Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл батлагдсанаар сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоо шинээр бий болох уг мэргэжилтнийг Хамтарсан багийн бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай. Дагаж мөрдөж буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 201.1 дэх хэсэг буюу Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг заасан хэсгийг бичилт, нэршлийн хувьд ойлгомжтой байлгах үүднээс уг хэсгийг өөрчлөн найруулахаар төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тусгасан болно. Саналыг хүлээн авах боломжгүй. -Тайлбар: Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд "Хамтарсан баг"-ийн тодорхойлолтыг заахдаа "эр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас эш татаж заасан болно. Саналыг хүлээн авч тусгав.
2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийг тус тус хасах.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1.Хуулийн төсөлд ашигласан "бэлгийн мөлжлөг" гэсэн нэр томъёоллыг, мөн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "5.2.5.бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах" гэж тус тус тусгасныг хасах; 2.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа агуулгыг хэвээр үлдээх нь зүйтэй.	Саналыг хүлээн авч, 3.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ зүйлийн 1.1 дэх заалтад заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон хүн хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй болсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр өөрчлөн тогтооно." Гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэхээр хуулийн төсөлд тусгав.
	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: 1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан асуудлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсэгт тодорхой заасан байх тул хасах;	- Тайлбар. Хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад хүүхдийнхээ хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь

		хүүхэдтэйгээ ашиг сонирхлын зөрчилтэй болсон нь тогтоогдсон буюу хувийн ашиг сонирхлын үүднээс, тухайлбал, эсрэг талтайгаа тохиролцох, гомдол, саналаасаа татгалзах зэргээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахгүй, ашиг сонирхлын зөрчилтэй болох тохиолдол гардаг. Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан урьд томилсон хууль ёсны төлөөлөгчийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнаар өөрчилж томилох зохицуулалт байхгүй байгаа нь учир дутагдалтай байгаа тул уг асуудлыг зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан болно. Саналыг хүлээн авах.	хүүхэдтэйгээ ашиг сонирхлын зөрчилтэй болсон нь тогтоогдсон буюу хувийн ашиг сонирхлын үүднээс, тухайлбал, эсрэг талтайгаа тохиролцох, гомдол, саналаасаа татгалзах зэргээр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахгүй, ашиг сонирхлын зөрчилтэй болох тохиолдол гардаг. Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан урьд томилсон хууль ёсны төлөөлөгчийг хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнаар өөрчилж томилох зохицуулалт байхгүй байгаа нь учир дутагдалтай байгаа тул уг асуудлыг зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан болно. Саналыг хүлээн авах.
	2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 2-т арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болохоор заасан байна. Иймд тус хуулийн зохицуулалттай уялдуулах үүднээс хуулийн төслийн 2 дугаар зүйлд "хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг байлцуулна" гэж тусгасныг "хууль ёсны төлөөлөгчийг байлцуулна" гэж өөрчлөх; 3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дугаар зүйлийг өөрчлөх шаардлагагүй байх тул хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах. 4.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хасах нь зүйтэй.	2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 2-т арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болохоор заасан байна. Иймд тус хуулийн зохицуулалттай уялдуулах үүднээс хуулийн төслийн 2 дугаар зүйлд "хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтныг байлцуулна" гэж тусгасныг "хууль ёсны төлөөлөгчийг байлцуулна" гэж өөрчлөх; 3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.5 дугаар зүйлийг өөрчлөх шаардлагагүй байх тул хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах. 4.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хасах нь зүйтэй.	Саналыг хүлээн авч хасав.
17.	Сангийн сайд Б.Жавхлан Албан бичгийн дугаар 2022.08.23 №01/5738	1.Хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор өөрчлөх; 2.Хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоохдоо нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо	1. Саналыг хүлээн авч төслийн 2.7 дугаар зүйлийн 7-д "Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална" гэж тусгав. 2. Саналыг хүлээн авч 2.7 дугаар зүйлийн 6-д "6.Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн

	зэргийг шалгуур үзүүлэлт болгосон байна. Үүнтэй холбогдуулан хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд оногдох хүүхдийн тоо, хүртээмжийг хангалттай хэмжээнд байлгах шалгуур үзүүлэлтийн талаар тодорхой зохицуулалт тусгах; /ЗГ тогтоохоор найруулав./ 3.Хуулийн төслийн 2.5 дугаар зүйлийн 1.3 дахь заалтад бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын батлах аргачлал нь тодорхойгүй байх тул заалтыг нягтлах; 4.Хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалаа үзүүлэхээр заасан байх ба холбогдох дэмжлэг, тусалцааг хэрхэн, ямар хэлбэрээр үзүүлэх талаар тодорхой зохицуулалт тусгах; 5. Хуулийн төслийн 2.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт Хууль зүйн хорооны тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлээгүй эсхүл хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн албан хаагчид ёс зүйн болон сахилгын хариуцлага тооцуулахаар томилсон этгээд, албан тушаалтанд санал хүргүүлэхээр тусгасан байна. Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн дагуу нийтлэг үүргээ зөрчсөн, тус хуулийн дагуу хориглосон үйл ажиллагааг явуулсан, мөн албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулахаар заасан байна. Үүний дагуу Хууль зүйн хорооны тогтоол, шийдвэр нь холбогдох төрийн албан хаагчийн хуульд заасан албан үүрэгтэй нь шууд хамааралтай тохиолдолд сахилгын хариуцлага тооцуулахаар санал хүргүүлэх боломжтой байгааг анхаарах; 6.Хуулийн төслийн 2.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн найруулгын алдааг засаж, өөрчлөн найруулах; 7. Хуулийн төсөлд заасан "орон нутгийн байгууллага", аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан/эрхэлсэн байгууллага", мөн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд
	эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална" гэж тусгасан. 3. Саналыг хүлээн авч, төслөөс хасав. 4. Хуулийн төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээний шуурхайн тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийн гурван хэлбэрийг заасан. Сургалт хүмүүжлийн байгууллагаас суллагдсан хүүхдийг "эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж үзэх ба энэ хүрээнд тухайн хүүхэд дээр кейс нээж, хуулийн төслийн 4.10 дугаар зүйлд заасан кейс менежментийн хүрээнд үйлчилгээ үзүүлнэ. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хүрээнд үзүүлэх тусламж, дэмжлэгийг хуулийн төслийн 4.3 дугаар зүйлд тусгасан болно. 5. Зөвхөн санал хүргүүлэх буюу хариуцлага тооцох асуудлыг эрх бүхийн этгээдэд үүрэг болгосон шинжгүй тул Төрийн албаны тухай хуультай зөрчилдөхгүй гэж үзэв. 6. Саналыг хүлээн авч, уг хэсгийг төслөөс хассан. 7. Саналыг авч нэр томьёог жигдлэв.

	хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гэх нэршлийг нэг томъёололд оруулах;	8. Саналыг хүлээн авч хуулийн төслийн 2.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д "хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэл буюу нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх, бага насны болон хохирогч хүүхэдтэй ажиллах зэрэг мэргэшсэн дэмжих багийг байгуулах" чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээхээр тусгав.
	8.Хуулийн төслийн 2.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "мэргэшсэн дэмжих баг" байгуулахаар тусгасан нь "хамтарсан баг"-аас ялгаатай эсэх, хэрэв ялгаагүй бол зөрүүтэй томъёоллыг нэг мөр болгох;	Тодорхой хугацааг шууд заах боломжгүй. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам болон Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмаар зохицуулах боломжтой гэж үзэв.
	9.Хуулийн төслийн 6.2 дугаар зүйлд заасан хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор хийгдэх хяналт, шинжилгээ, үнэлгээ, үр дүнг шалгах ажлуудын хугацааг тодорхой тусгах;	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам болон Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмаар зохицуулах боломжтой гэж үзэв.
	10.Хуулийн төслийн 6.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалтад "хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх" гэж тусгасан байна. Тус үнэлгээг ямар журмын дагуу хийхийг тодорхой болгох, шинэ журам батлах шаардлагатай эсэхийг хянан үзэх;	Хуулийн төслийн 2.5 дугаар зүйлд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь "хүүхэд хамгааллын талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө жил бүр хариуцан тайлагнах;" чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.
	11.Хуулийн төслийн 6.2 дугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ, гарсан үр дүнг хаана, хэзээ тайлагнах, хүүхэд хамгааллын үйлчилгээний үр нөлөөг сайжруулахад чиглэсэн эргэх холбоо, үүрэг хариуцлагын талаар зохицуулалт тодорхойгүй байх тул энэ талаар хуулийн төсөлд тусгах;	Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлд "Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбогдох гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна." гэсэн зохицуулалтыг тусгасан.
		Хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллага нь "жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан тухайн шатны хүүхдийн төлөө

		зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх" зохицуулалтыг тусгасан. 12.Хуулийн төсөл дэх "хүүхэд хамгааллын кейс" гэснийг шаардлагатай бол Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ын 4.1.2-т заасны дагуу тохирох Монгол хэлний нэр томъёогоор оруулах; 13. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт тусгасан хамтарсан баг нь Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 2.12 дугаар зүйлд тусгасан хамтарсан багийн чиг үүрэгтэй адил эсэх; хэрэв ижил бол эдгээр хуулиудын хоорондын уялдааг хангах; шаардлагатай бол Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хамтарсан багийн бүрэлдэхүүн, төлөөллийг тогтоосон заалт нэмэх;	зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх" зохицуулалтыг тусгасан. 12.Монгол хэл рүү хөрвүүлэхэд тохиромжтой нэр томъёо олдохгүй байгаа тул төслийн заалтын хэвээр үлдээв. Түүнчлэн уг нэр нэр томъёог дотооддоо баталсан журам, заавар, стандартад тусган хэрэглэж байна. 13.Саналыг хүлээн авч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай уялдуулсан. Хамтарсан багийн бүрэлдэхүүний зохицуулалт нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгагдсан байдаг ба тус хуулийн 20.1 дэх хэсгийг "Хамтарсан баг нь өрхийн эмч, сум болон хорооны хөгжлийн нийгмийн ажилтан, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөлөөс бүрдэх бөгөөд хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахална." гэж өөрчлөн найруулахаар дагалдах хуулийн төсөлд тусгасан.
		14.Хүүхэд хамгааллын үйлчилгээнд чиглэсэн улсын болон орон нутгийн төсвийн хуваарилалтыг хуульд заасан төрөл, хэлбэр тус бүрээр зохистой зарцуулах, зарцуулалтад хяналт тавих, төсвийн үр дүн, үр ашгийг сайжруулах талаар тодорхой заалт тусгах.	Хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлийн 4-т "Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтооно." гэж тусгасан.
18.	Соёлын дэд сайд М.Батбаяр Албан бичгийн дугаар 2022.07.25 №2/1925	1.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 8-д "хууль зөрчсөн контентыг" гэсний дараа "түгээхгүй байх болон" гэж нэмэх; /тусгасан/	1. Саналыг хүлээн авч тусгав.
		2.Төслийн 3.5 дугаар зүйлийн 3-т "нийгмийн ажилтан" гэсний дараа "цагдаагийн байгууллага" гэж нэмэх;	2. Саналыг хүлээн авч тусгав.
		3.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 5-д "зохион байгуулагч, асран хамгаалагч багш, дасгалжуулагч нь уралдаан, тэмцээн бэлтгэлийн үед хүүхдийн аюулгүй байдал, эрсдэлт нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц эд зүйл, бодис хэрэглүүлэхгүй байна" гэж шинээр нэмэх, үүнтэй холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх;	3. Саналыг хүлээн авч тусгав.
		4.Төслийн 3.6 дугаар зүйлийн 4 дэх заалтын 4.3, 5 дахь заалт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.2, 10.3 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардаж байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу эш татах байдлаар заах;	4. Үндэсний их баяр наадмын тухай хуультай нийцүүлэв.

	5.Төслийн 3.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Үндэсний их баяр наадам болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулсан үндэсний хурдан морины уралдаанаас бусад уралдаан тэмцээнд оролцож байгаа уралдаанч хүүхдийн хамгааллын асуудлыг энэ хуульд нэмж тусгах, шаардлагатай тохиолдолд уг хуулийг дагалдуулж Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;Тухайлбал:уул, овооны тахилга тахих уламжлалт зан үйлийн ёслол үйлдэх болон аймаг, сумын даншгийн хэмжээнд Үндэсний их баяр наадмын тухай хуульд хамаарахгүй наадам зохион байгуулахад хурдан морины уралдаан уралдуулдаг.	5. Үндэсний их баяр наадмын тухай хуультай нийцүүлж бусад хэлбэрийн хурдан морины морины уралдааны үед хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хэрхэн хангах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
	6.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 6-д заасныг “үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэл болон соёл, спортын уралдаан тэмцээнд оролцож буй хүүхдийн хувцас, хэрэгсэл, орчинд тавих шаардлагыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуульд заасны дагуу боловсруулан мөрдүүлнэ” гэж өөрчлөн найруулах.	6. Хуулийн төслийн 3.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.3-т “уралдаанч хүүхдийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасны дагуу батлагдсан стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах” гэж гэж тусгасан.
	7.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 8-д “Хүүхдийн амралт, чөлөөт цагийг бүтээлч хэлбэрээр зохион байгуулах, авьяас чадвар, бие бялдрыг хөгжүүлэх, хүүхдийн соёл, хүмүүжилд зориулан соёл, спортын үйл ажиллагаа, үзвэр, үйлчилгээний хөнгөлөлт, тэтгэмжийг жил бүр олгоно” гэж шинээр нэмэх.Тухайлбал:Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайланд Улсуудад “cultural pass, sport pass” буюу соёл, урлагийн үйл ажиллагаа, үзвэр үйлчилгээг зорилтот бүлэг (Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, үндэсний цөөнх) болон хүүхдэд түүх, соёлын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэдний нас, сэтгэхүйн онцлог, хүсэл сонирхолд тохирсон үзвэр, үйлчилгээ, дугуйланд хамруулан чөлөөт цагийг өнгөрүүлэх зэргээр хүүхдийн нийгмийн амьдралд байр сууриа олох нөхцөлийг бүрдүүлдэг байна. /Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд/	7-8. Энэ хуулиар зохицуулах боломжгүй Нийгмийн халамжийн тухай хууль эсхүл Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тэгэхдээ бие даасан үзэл баримтлалтайгаар боловсруулагдаж батлагдах хэмжээний асуудал байна гэж үзэж төслийн заалтыг хэвээр үлдээв.
	8.Төслийн 3.4 дүгээр зүйлийн 9-д “Төслийн 3.4 дүгээр зүйлийн 8-д заасан тэтгэмж олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын, соёлын, боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж шинээр нэмэх;	
	9.Төслийн 4.6 дугаар зүйлийн 2-ын 1.2-т заасан “хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ” үзүүлэх байрны аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах талаарх зохицуулалтыг нэмж тусгах.	9. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нийтлэг стандарт батлагдсан. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/209 дүгээр

		тушаалаар "Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам"-ыг тус тус батлан мөрдүүлж байна.
19.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Албан бичгийн дугаар 2022.06.30 №01/2131	1.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.10 дахь хэсэгт заасан "...кейс менежмент" гэснийг оновчтой монгол үгээр тайлбарлах, уг нэр томъёог ашигласан хуулийн төслийн холбогдох заалтуудыг өөрчлөх, 2.Хуулийн төслийн 2.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "хууль зүйн хорооны гишүүн хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хууль зүйн хорооны даргад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно" гэсэн байна. Энэ тохиолдолд төлөөлөн оролцогч этгээд хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нууцын баталгааг гаргах талаар нэмж тусгах.
20.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Албан бичгийн дугаар 2023.01.05 №01/39	Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах хуулийн төсөлтэй танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно Тэмдэглэв.
21.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Албан бичгийн дугаар 2022.07.08 №01/1195	1.Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газрын даргын 2020 оны А/68 дугаар тушаалаар батлагдсан "Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-д хэрэглэсэн томъёо болох "хориотой, хортой контент гэсэн нэр томъёог хэрэглэж жигдлэв. 2. Саналыг хүлээн авч төслөөс хасав. 3. Саналыг хүлээн авч засав. 4. Саналыг хүлээн авч засав.

5.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "сөрөг нөлөө үзүүлэхүйц" гэдэгт юуг хамааруулж байгааг, мөн хэн тогтоохыг тодорхой болгох; /	5. Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газрын даргын 2020 оны А/68 дугаар тушаалаар батлагдсан "Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл"-д хэрэглэсэн томъёо болох "хориотой, хортой контент гэсэн нэр томъёог хэрэглэж жигдлэв.	
6.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...зөвлөмж, зааварчилгааг" гэснийг "...зөвлөмжийг" гэж өөрчлөх;	6.Саналыг хүлээн авч засав.	
7.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хүүхдэд зориулсан контент, бүтээл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзвэл иргэн, хуулийн этгээд энэ талаарх гомдол, мэдээллийг хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах газарт гаргаж шийдвэрлүүлнэ." Гэж өөрчлөх;	7.Саналыг хүлээн авч тусгав.	
8.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, цахим орчин ашиглаж" гэснийг "хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин ашиглаж" гэж өөрчлөх;	8. Саналыг хүлээн авч засав	
9. Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан "Үүрэн холбооны, интернэтийн болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх" гэснийг "Интернэт болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь айл өрх, албан байгууллагад үзүүлэх үйлчилгээг хүүхдийг зохисгүй агуулга, сөрөг нөлөөллөөс хамгаалахаар тохируулсан байх ба үйлчлүүлэгчийн хүсэлтэд үндэслэн насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна" гэж өөрчлөх;	9. Саналыг хүлээн авч тусгав.	
10.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан "Цахим орчин болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд" гэснийг хасах;	10. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд 4.1.2-т "Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ" гэж энэ хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5-д заасан үйлчилгээг" ойлгоно гэж заасан. 4.1.3."радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ" гэж радио давтамж ашиглан сүлжээ байгуулж, хэрэглэгч хүлээн авах төхөөрөмж ашиглан радио, телевизийн үйлчилгээг тодорхой хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг;	

		4.1.4."олон суваг дамжуулах үйлчилгээ" гэж утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр, интернэт протоколд суурилж радио, телевизийн олон сувгийг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан хүргэхийг; 4.1.5."радио, телевизийн үйлчилгээ" гэж өөрийн редакцияд хөтөлбөр бэлтгэн харилцаа холбооны сүлжээнд холбогдож, олон нийтэд түгээх үйлчилгээг; Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хүүхэд хамгааллын асуудал орхигдохоор байгаа тул төслийн заалтыг хэвээр үлдээв.
		11. Саналыг хүлээн авч тусгав.
		12. Саналыг хүлээн авч засав.
		13. Саналыг хүлээн авч тусгав.
		14. Саналыг хүлээн авч тусгав.
		15. Саналыг хүлээн авч тусгав
22.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Албан бичгийн дугаар 2023.01.02 №01/04	1. 18-аас 21 насны хүн" гэдэг ойлголт нь дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3.3 дахь хэсэгт тусгагдсан. Мөн иргэн гэх ойлголт нь зөвхөн Монгол Улсын иргэн гэх ойлголтыг илэрхийлэх тул хуулийн үйлчлэх хүрээг явцуу болгохоор байна.

		Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгийг Гэр бүлийн тухай хуульд хэрэглэсэн нэр томьёонд нийцүүлэн өөрчлөн найруулах;	Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгийг Гэр бүлийн тухай хуульд хэрэглэсэн нэр томьёонд нийцүүлэн өөрчлөн найруулах;
		Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “иргэн, аж ахуй нэгж” гэснийг “хүн, хуулийн этгээд” гэж өөрчлөх;	2. Төрлийн хүн, садны хүн гэх ойлголт нь Гэр бүлийн тухай хуульд хэрэглэгдсэн нэр томьёо. тул хэвээр үлдээв.
		4. Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн нэрийг “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” гэж өөрчлөх;	3. Аж ахуйн нэгж, байгууллага гэсэн хэллэгийг ашигласан хуулиуд цөөнгүй байдаг. Жишээ нь: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль.
		5. Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болгож, “Хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц цахим тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд түгээх, хяналт тавих чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлнэ” гэж шинээр нэмэх;	4. “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдэг нь хэвлэл мэдээллийг эрхлэн гаргаж байгаа субъектийг илэрхийлдэг ойлголт байдаг. Агуулгыг жигдлэв.
		6. Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг “Өргөн нэвтрүүлгийн болон контентын үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хориотой, хортой контентыг хягаарлах, контентын ангиллын тэмдэглэгээг олон нийтэд түгээхийн өмнө байршуулах, насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх боломжоор хэрэглэгчийг хангасан байна” гэж өөрчлөн найруулах;	5.Саналыг хүлээн авч тусгав.
		7. Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийг “Өргөн нэвтрүүлгийн болон контентын үйлчилгээ эрхлэгч нь хүүхдийн эсрэг, түүний эр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, гүтгэсэн, заналхийлсэн утгатай, эсхүл хүүхдийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн хувийн мэдээлэл, зураг, дүрс, дуу авиа, хэн болохыг тогтоох боломжтой бусад мэдээллийг агуулсан контентыг бүтээх, түгээхийг хориглоно.” гэж өөрчлөн найруулах;	6.Саналыг хүлээн авч тусгав.
		8.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг “Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь цахим орчин дахь хүүхдийг хамгаалахад баримтлах	7.Саналыг хүлээн авч тусгав.
			8.Саналыг хүлээн авах боломжгүй. Хуулийн төслийн 3.5 дугаар зүйлийн 8-д туссан заалттай агуулгын хувьд давхардаж байна. Улсын

	бодлогын чиглэлийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, цахим орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж хүргүүлнэ” гэж өөрчлөн найруулах; 9.Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болгож шинээр нэмсэн зохицуулалттай давхардаж байх тул хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн 5,10 дахь хэсгийг хасах; 10. Хуулийн төслийн 3.6 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийг “уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчтай хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, урамшуулал, шагналын асуудлыг тусгасан гэрээг цаасан, эсхүл цахим хэлбэрээр байгуулах, гэрээг цахим хэлбэрээр байгуулах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэх” гэж өөрчлөх; 11.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх нь хүүхдийн хууль ёсны ашиг сонирхолтой зөрчилдөхөөс бусад тохиолдолд хүүхдээс тайлбар, мэдүүлэг авахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлийг баримтална” гэж найруулах; 12.Хуулийн төслийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т заасан улсын төсөв, 1.4-т заасан “дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж”-д мөн хэсгийн 1.3-т заасан “үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр” нь хамаарахаар байх тул 1.3-ийг хасах. 13.Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх бөгөөд” гэснийг хасах саналтай байна.	байцаагчийн эрхгүй этгээд “шаардлага” хүргүүлэх боломжгүй.
		9. Саналыг хүлээн авч тусгав.
		10.Саналыг хүлээн авч тусгав.
		11.Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн саналын дагуу төслөөс уг хэсгийг хассан.
		12.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хандив, тусламж өгөх харилцааг шууд нэг ойлголт гэж үзэх боломжгүй тул хэвээр үлдээв.
		13. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүүхдийн эрхийн улсын ерөнхий байцаагчийн эрх эдлэх” зохицуулалт нь Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20.2 дахь хэсэгт тусгагдсан байдаг.
23.	Эрүүл мэндийн сайд С.Энхболд	Саналыг хүлээн авч “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал” гэж өөрчлөв.

	Албан бичгийн дугаар 2022.07.01 №1а/3158	2. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 5 дахь заалтад тусгагдсан "Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэсэн заалтыг Эрүүл мэндийн салбарын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг батлах тухай" тушаалын төсөлтэй давхцаж байгаа тул хасах саналтай байна.	2.Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам нь процессын асуудлыг зохицуулсан, захиргааны хэм хэмжээний акт байх тул төслийн заалтыг хэвээр үлдээв.
24.	Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Албан бичгийн дугаар 2023.01.17 №1а/227	1.Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 3.3.2-т "...хүүхдийн тусламжийн утас" гэсэн нь хуулийн төслийн 3.3.4-т заасан "эрх бүхий байгууллага" гэсэнд хамаарахгүй тул 3.3.2 дахь заалтын "эрсдэлт нөхцөлд байгаа" гэснийг хасах; 2. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтын "эрсдэлт нөхцөлд байгаа" гэснийг хасах; 3. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 3.3.4-д заасан "...бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна." гэснийг хасах; 4. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 3.3.5.5 дахь заалтад "...тусламж, үйлчилгээ үзүүлэх" гэсний дараа "эрүүл мэндийн ажилтан" гэж нэмэх; 5. Хуулийн төслийн 2.3 дугаар зүйлийн 2.3.1.5-д "...дундын" гэснийг "нэгдсэн" гэж өөрчлөх, үүнтэй холбогдуулан хуулийн төслийн 3.3.5.4 дэх заалтыг хасах; 6. Гэр бүлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт "холбогдох эрх бүхий этгээдтэй хамтран ажиллана." гэсний холбогдох эрх бүхий этгээдийг тодорхой тусгах.	1.Хүүхдийн тусламжийн 108 утас нь төрийн үйлчилгээний байгууллага тул хэвээр үлдээв. 2.Дагаж мөрдөж буй Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1 дэх хэсгийг агуулгаар нь өргөжүүлж нарийвчлан тодорхойлж, нэр томьёог тодорхой заасан . 3.Саналыг хүлээн авч тусгав. 4.Саналыг хүлээн авч тусгав. 5.Саналыг авч агуулгыг жигдлэв. 6.Саналыг хүлээн авч "холбогдох эрх бүхий этгээд" гэснийг "хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага" гэж тодруулав.
25.	Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан Албан бичгийн дугаар 2022.07.05 №01/732	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, материалтай танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тэмдэглэв.

26.	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Албан бичгийн дугаар 2023.01.06 №01/44	1.Хуулийн төслийн 1.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.5-д нийцүүлэх;	1. Хөдөлмөрийн тухай хуулийн 2.5 дахь хэсэг “Энэ хуулийн 2.3-т заасан хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд хоорондоо зөрчилдвөл ажилтанд илүү таатай нөхцөлийг олгосон зохицуулалтыг хэрэглэнэ” гэсний жишиг болгож оруулсан.
		2.Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээс “ухагдахуун” гэсэн үгийг хасаж, нэр томъёоны тайлбар хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1-д заасан шаардлагад нийцүүлэх;	2.Эрүүгийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэсний жишиг болгож оруулсан. Саналыг хүлээн авах боломжгүй. Хүүхдийн эрхийн чиглэлээр цөөнгүй гэрээ, конвенц байдаг тул нэр томъёог тайлбарлахдаа олон улсын гэрээ, конвенцыг баримтлах нь зүйтэй гэж үзсэн.
		3. Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг болон 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-д заасан “хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх” гэсэн шаардлагад нийцэхгүй байх тул хасах;	3.Саналыг хүлээн авч, агуулгыг жигдлэв.
		4. Хуулийн төсөлд “аж ахуйн нэгж”, “байгууллага” гэсэн нэр томъёог Иргэний хуулийн нэр томъёонд нийцүүлж “хуулийн этгээд” болгох;	4.”Хуулийн этгээд” гэж нэр томъёог жигдлэв.
		5.Хуулийн төслийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг ойлгомжгүй байх тул найруулгыг засах;	5.Саналыг хүлээн авч, агуулгыг жигдлэв.
		6. Хуулийн төслийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих”, “хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардагдах төсөв, санхүүжилтийн талаар санал боловсруулж Засгийн газарт өргөх барих”-аар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт тусгасан байгаа нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тухай хуулиудтай давхардаж байгаа тул хасах;	6.Саналыг хүлээн авч уг заалтыг хасаа.

	7. Хуулийн төслийн 2.3 дугаар зүйлийн 1.6-д “хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах журмыг батлах”-аар заасан байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “зөвшөөрөл” гэсэн нэр томъёотой ижил байх тул өөр нэр томъёогоор илэрхийлэх; 8. Хуулийн төслийн 2.5 дугаар зүйлийн 2 болон 3 дахь хэсгийг дахин найруулах, томилох субъектийг тодорхой болгох; 9. Хуулийн төсөлд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгохоос гадна ямар байгууллага уг үйлчилгээг эрхлэхийг хориглох зэрэг зохицуулалтыг тодорхой болгож, холбогдох шалгуурыг тогтоох; 10. Үе тэнгийнхэн, хүүхэд хүүхдийнхээ эрхийг зөрчих, бие махбод болон сэтгэл санааны хувьд хүчирхийлэл үйлдэх харилцааг хэрхэн зохицуулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хуулийн төсөлд тодорхой тусгаагүйг анхаарах; 11. Хүүхдийн эрх, аюулгүй байдал, бусдын өмнө хүлээх үүргийн талаар сургалтын хөтөлбөрт оруулж, боловсролын байгууллагаар дамжуулан хүүхэд өөрийн эрх, үүргээ танин мэдэх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгодог байх зохицуулалтыг тусгах; 12. Хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж, сургалтын төлбөр зэрэг эцэг, эхийн санхүүгийн үүрэгтэй холбогдох зохицуулалтыг чангатгах, тэдгээрийн хэмжээ эдийн засгийн өнөөгийн үнэ цэнийг хадгалах үүднээс тодорхой хугацааны давтамжтай шинэчлэн тогтоогддог байх эрх зүйн зохицуулалтыг тусгах; 13. Хуулийн төслийн нийт найруулгыг засах, бусдаар үйлдүүлэх хэв хэрэглэхгүй байх, нэг зүйлд нэг утга санааг тусгах зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах шаардлагыг дагаж мөрдөх.	7. Саналыг хүлээн авав. 8. Найруулгыг засав. 9. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг яам батлахаар хуулийн төсөлд тусгасан болно. 10. Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлд “Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” хэсэгт үе тэнгийнхний дээрэлхэлтийн талаар нарийвчлан тусгасан болно. 11. Саналыг хүлээн авах боломжгүй. Боловсролын хууль тогтоомжоор зохицуулагдах асуудал гэж үзэв. 12. Саналыг хүлээн авах боломжгүй. Хүүхдийн мөнгөний асуудлыг тусгай хуулиар, мөн гэрлэлт цуцалсны дараах хүүхдэд олгох тэтгэлгийн асуудлыг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулдаг. 13. Саналыг хүлээн авав.
27.	Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Албан бичгийн дугаар 2022.06.30 Nea/2617	1. Төслийн 4.10 дугаар зүйлийн 3-т “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг

	биелэгдээгүй тохиолдолд хариуцлага тооцох үндэслэл бүхий заалт байх тул хүүхэд хамгааллын зарчмаас хасах;	сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна” гэж тусгав.
	2. Мөн хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлийн 6-д “...ажил хайгч, ажилтан...” гэснийг “...ажил горилогч, иргэн...” гэж өөрчлөх; Учир нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “ажилтан” гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.	2. Саналыг хүлээн авч найруулгыг засав.
	3. Хуулийн төслийн 2.6 дугаар зүйлийн 1.3-т “Нийгмийн ажилтны дагаж мөрдөх Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах” гэж нэмэх;	3. 2.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.9-д “нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх” гэж тусгав.
	4. Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 2-т “Хууль зүйн хороо нь ...удирдах албан тушаалтнуудаас бүрдэнэ.” гэснийг “Хууль зүйн хороо нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас, нутгийн захиргааны байгууллагаас, боловсролоос, эрүүл мэндээс, цагдаагаас, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас, прокурорын нэгжээс, шүүхийн тамгын газраас тус тус нэр дэвшүүлж ирүүлсэн саналыг үндэслэн тодорхой тооны гишүүдээс бүрдэнэ” гэж өөрчлөх;	4. Удирдах албан тушаалтнуудаас Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог бүрдүүлж байж тус хорооны хүлээн зөвшөөрөгдөх шинж, шийдвэрийн биелэлт хангагдах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа тул төслийн заалтыг хэвээр хадгалав.
	5. Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 3-т “хууль зүйн хорооны гишүүд болон Ажлын алба нь тухайн хороонд хандсан, шийдвэр гаргуулсан хүүхдийн талаар мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд Хууль зүйн хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан, ажилтнаас энэ талаар баталгааг бичгээр гаргуулна.” гэснийг агуулгын хувьд бүхэлд нь өөрчлөх саналтай байна. Хууль зүйн хороо болон ажлын албанд эрхээ хамгаалуулахаар хандсан хүүхэдтэй холбоотой бүхий л харилцааг эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд байгууллагын нууцад хамааруулах үүрэгтэй бөгөөд Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын дагуу “Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгаа”-г Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон Ажлын албаны гишүүдээс аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын “нууцын ажилтан” гаргуулах нь хуульд нийцнэ.	5. Саналыг хүлээн авав. Нууцын баталгаа гаргуулах асуудал нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул уг хэсгийг төслөөс хассан болно.
	6. Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 4-т “Хууль зүйн хорооны ажлын албаны үүргийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн	6. Саналыг хүлээн авч тусгав.

	хөгжлийн асуудал хариуцсан байгууллага гүйцэтгэнэ” гэснийг “Хууль зүйн хороо нь ажлын албатай байна. Ажлын албыг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага гүйцэтгэнэ.” гэж өөрчлөх;	
	7. Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 5-т “ажлын албаны эрх, үүргийг ямар субъект батлах талаар нэмэлтээр тусгаж зохицуулах;	7. Ажлын албан чиг үүрэг буюу хүүхэд, гэр бүлийн орон нутгийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүргийг хуулийн төслийн 2.6 дугаар зүйлд тусгасан.
	8.Хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлийн 1.3-т “...мөрдөн байцаах байгууллагатай хамтран” гэснийг Цагдаагийн албаны тухай хуульд заасан нэр томъёог үндэслэн “...цагдаагийн байгууллагатай хамтран...” гэж өөрчлөх;	8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “мөрдөн шалгах байгууллага” гэсэн нэр томъёогоор жигдлэв.
	9.Хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлийн 1.7-д “хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах” гэх заалтын “хорт зуршил” гэсэн нэр томъёог хэрхэн, яаж ойлгох талаар хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлд нэмэлтээр тусгаж нэр томъёог тайлбарлах;	9. Хорт зуршил гэсэн нэр томъёо нь дагаж мөрдөж Хүүхэд хамгааллын тухай хууль болон Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд байдаг нэр томъёо байна.
	10. Хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор санхүүжилтийн асуудлыг тус заалтад нэмж зохицуулах нь зүйтэй байх тул “...сургалтад хамруулах” гэснийг “...сургалтад улсын төсвийн санхүүжилтээр хамруулах” гэж өөрчлөх;	10. Хуулийн төслийн 2.12 дугаар зүйлийн 2-т “Хууль зүйн хороо нь үйл ажиллагааныхаа жилийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийг боловсруулж тухайн шатны Хүүхдийн төлөө зөвлөлөөр батлуулна” гэж тусгасан.
	11. хуулийн төслийн 2.12 дугаар зүйлд хамтарсан багийн гишүүдээс нууцын баталгаа гаргуулах асуудлыг зохицуулаагүй орхисон байх тул энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлж нэмэлтээр зохицуулах;	Нууцын баталгаа гаргуулах асуудал нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул уг хэсгийг төслөөс хассан болно..
	12.Иргэний хуульд гэрээг нэг талын санаачилгаар бус талуудын хүсэл зоригт тулгуурлан харилцан хүлээн зөвшөөрсөн хоёр талын санаачилгаар байгуулахаар зохицуулсан байгааг анхаарч хуулийн төслийн 2.12 дугаар зүйлийн 5-д “...хамтран ажиллаж буй хувь хүн, байгууллагатай нууцын гэрээг байгуулна.” гэснийг дахин нягтлах;	Нууцын баталгаа гаргуулах асуудал нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул уг хэсгийг төслөөс хассан болно.
	13. Хуулийн төслийн 7.3 дугаар зүйлийн 2-т “...хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл зөрчлийн шинжтэй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж өөрчлөх тус тус саналтай байна.	13. Хуулиудад байдаг нийтлэг техникийг ашигласан болно.
28.	Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн	1. Саналыг хүлээн авч 4.12 дугаар зүйлд оруулав.

Албан бичгийн дугаар 2023.01.16 №а/102	хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хэлмэрч заавал оролцуулна гэсэн нь ямар харилцаанд оролцуулах, мөн зардлын талаар тодорхой заах саналтай байна.	хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хэлмэрч заавал оролцуулна гэсэн нь ямар харилцаанд оролцуулах, мөн зардлын талаар тодорхой заах саналтай байна.
Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат Албан бичгийн дугаар 2022.06.30 №т/4279	2.Хуулийн төслийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлтээр эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ гэж нэмэх; 3.Хуулийн төслийн 4.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.7-д эцэг, эх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асран хамгаалах үүргээ удаа дараа биелүүлээгүй гэснийг тодорхой болгох; 4.Хуулийн төслийн 1.11 дүгээр зүйлд кейс менежментийг тодорхойлсон заалтыг илүү нарийвчлан тусгах, дээрх кейс менежментийг хэн хэрхэн үзүүлэх талаар хуулийн төсөлд тусгах; 5.Хүүхэд хамгааллын тухай хууль нь хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байгаа тул хуулийн төслийн 3.6 дугаар зүйлийн 5 дахь заалтыг хасах саналтай байна. 1.Монгол Улсын Үндсэн хуулийн наймдугаар зүйлийн 1-д "Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн" гэж, Монгол хэлний тухай хуульд ...Монгол Улсын нутаг дэвсгэрт албан хэргийг монгол хэлээр хөтлөн явуулна... гэж заасан. Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.10 дахь хэсгийн "хүүхэд хамгааллын кейс менежмент гэснийг" "хүүхэд хамгааллын зохицуулалтын цогц арга хэмжээ" гэж өөрчлөх. 2.Гэр бүл, нийгмийн бүх орчинд хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж буй эсэхэд харьяа нэгж, газруудаар дамжуулан хяналт тавих нь хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулахаас урьдчилан сэргийлэх ажилд чухал үр дүнтэй тул төслийн 2.4 дүгээр зүйлийг "...хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих" гэж өөрчлөх.	2.Хүүхдийн эрхийн тухай хуульд тусгагдсан агуулга байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй. 3."Асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ" гэж тодотгов. Уг ойлголт нь Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан ойлголт байдаг. Удаа дараа гэсэн нь 2 буюу түүнээс дээш удаа гэсэн утгыг илэрхийлдэг 4.Кейс менежмент гэсэн тодорхойлолтыг олон улсад хэрэглэгддэг байдлаар нь оруулсан тул нарийвчлах боломжгүй. Хүүхэд хамгааллын үйлчилгээг Кейс менежментэд тулгуурлан нийгмийн ажилтан үзүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. 5.Саналыг хүлээн авах боломжгүй. Хүүхэд хамгааллын тухай хууль нь хүүхдийг гэр бүл, нийгмийн орчинд хамгаалах асуудлыг хамарч байгаа. 1. Монгол хэл рүү хөрвүүлэхэд тохиромжтой нэр томъёо олдохгүй байгаа тул төслийн заалтын хэвээр үлдээв. Түүнчлэн уг нэр нэр томъёог дотооддоо баталсан журам, заавар, стандартад тусган хэрэглэж байна. Тухайлбал, MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлагад "кейс менежмент" гэх мэргэжлийн нэршлээр батлагдсаныг ашиглав.. 2. Саналыг хүлээн авч тусгав. 3. Саналыг хүлээн авч тусгав.

	байгууллагатай, бусад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх ажлыг хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хамтран зохион байгуулах нь үр дүнтэй тул төслийн 2.5 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг "...ерсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх, судалгаа авах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллага болон хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хамтран зохион байгуулах" гэж өөрчлөх.	
	4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.12 дахь заалтад "Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага" гэж нэр томьёог тодорхойлсон тул төслийн 3.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 2.9 дүгээр зүйлийн 1.3, 2.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 2.9 дүгээр зүйлийн 1.3, 2.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "мөрдөн байцаах байгууллага" гэсэн нэр томьёог хуульд нийцүүлэн өөрчлөх.	4. Саналыг хүлээн авч нэр томьёог жигдлэв.
	5. Эрүүгийн хуулийн 8.1, 8.2, 8.6 дугаар зүйлүүдэд, шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан, ял, албадлагын арга хэмжээг сонгож оногдуулахаар заасан. Төслийн 2.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "гэмт хэрэг үйлдэж ял оногдуулсан, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан" гэж өөрчлөх.	5. Саналыг хүлээн авч тусгав.
	6. Хуулийн төслийн 1.5 дугаар зүйлд "хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүүхдийн сурч боловсрох орчин, нөхцөл бололцоогоор ханта" гэсэн нэмэлт оруулах.	6. Саналыг хүлээн авч тусгав.
	7. Хуулийн төслийн 2.4 дүгээр зүйлд "хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүүхдийн сурч боловсрох орчин, нөхцөлийг хангахад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран ажиллах", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорих ял, баривчлах шийтгэл эдэлж буй болон цагдан хоригдсон өсвөр насны хүүхдийг хорих анги, баривчлах, цагдан хорих байрнаас суллахдаа, заавал гэр бүлийн насанд хүрсэн хүнд хүлээлгэн өгнө. Эцэг эх, асран хамгаалагчгүй хүүхдийг харьяа Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд шилжүүлэх, эсвэл хуульд заасан журмаар асран хамгаалалт тогтоолгоно" гэсэн нэмэлт оруулах.	7. Саналыг хүлээн авч тусгав.
	Хоёр: Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлтэй холбогдуулж анхаарах бусад асуудлын талаар:	
	1. Төслийн 2.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "...Мөрдөн байцаах байгууллага, шүүх хүүхдийн эрх зөрчигдсэн эсэх, хүүхдийн амьдарч, сурч байгаа орчны нөхцөл байдлыг тогтоолгох	Саналыг хүлээн авч төслөөс хасав.

	зорилгоор харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, нийгмийн ажилтныг шинжээчээр томилж дүгнэлт гаргуулж болно. Энэ тохиолдолд шинжээчийн зардлыг тухайн томилсон байгууллага хариуцан төлнө" гэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд шинжээчийн зардал хамаардаг тул хуулийн төслийн 6.3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална" гэж заасантай уялдуулах. Учир нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам"-ыг баталсан байна.	
	2.Цагдаагийн байгууллага гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан даруйд хүүхэд гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон байж болзошгүй нөхцөл байдлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоох тул төслийн 2.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүх тохиолдлыг Хууль зүйн хороонд 24 цагийн дотор мэдэгдэх боломжгүй. Иймд заалтыг эргэн харж, бодит байдалд нийцүүлэн өөрчлөх, мэдэгдэх хугацааг боломжит байдлаар тусгах шаардлагатай байна.	Саналыг хүлээн авч төслөөс хасав.
	3.Төслийн 2.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг "...Хууль зүйн хорооноос томилогдсон төлөөлөгч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн болон хохирогч болсон хүүхэдтэй холбогдох мөрдөн шалгах ажиллагаанд оролцох боломжоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хангагдана. Энэ заалт нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч хүүхдээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд нэгэн адил үйлчилнэ" гэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад мөрдөгч, прокурор нь өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах талаар заасан. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт "арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн	Саналыг хүлээн авч төслөөс хасав.

	төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно” гэсэн бөгөөд бусад тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос томилогдсон төлөөлөгчийг оролцуулах зохицуулалт хуульд тусгаагүй байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах ажиллагаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж оролцох талаар тусгасан боловч эдгээр нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудтай хэрхэн уялдах нь тодорхойгүй байгааг анхаарах.	
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэлхам Албан бичгийн дугаар 2022.07.01 №01/844	1.Хуулийн төслийн 1.5. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах үе шатанд татагдан оролцож байгаа, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, эрүүгийн хариуцлага болон зөрчлийн шийтгэл хүлээсэн, гэмт хэрэг зөрчлийн гэрч, хохирогч болсон, гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан хүүхдийн саналыг авч байгаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийг” гэж тодруулсан хэсгийг нэмэх; Энэ санал нь Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д “Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ” гэж заасны дагуу хүүхдээс санал авахаас өмнө эцэг, эх хүүхдийн санаа бодолд нөлөөлөх, ээж /аав/-тэйгээ үлдэнэ гэж хэл гэж тулгах, ятгах, ухуулах, дарамтлах болон шүүхээс санал авах хүртэл хугацаанд ээж, /аав/-тэй нь уулзуулахгүй байх зэргээр хүүхдэд нөлөөлж, өөрөө бие даан саналаа илэрхийлэх боломжийг нь хаах нөхцөл байдал үүсэж болзошгүй тул зөвхөн эрүү, зөрчлийн хэргээр хязгаарлахгүйгээр гэр бүл түүн дотроо гэр бүл цуцлалт, хүүхдийн асрамжийн асуудлыг нэмсэн. 2. Хуулийн төслийн 2.1.1. “Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, төсөв, санхүү, хүүхэд хамгааллын үйлчилгээ, сургалт, судалгаа, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.” гэж тодруулсан хэсгийг нэмэх; Өнөөгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, хэрэгжилт, олон улсын сайн	1. Саналыг хүлээн авч “иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхэд” гэж оруулав. 2. Мэргэшсэн хүний нөөц, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээнд гэдэгт багтаж байгаа тул төслийн заалтын хэвээр үлдээв. 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “1Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, мэдээллийн сан,

	туршлага, эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаанд тулгуурлан сурталт зохион байгуулах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх нь чухал гэж үзсэн тул энэ саналыг нэмсэн болно. 3. 2.2.3 “Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоохдоо нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг шалгуур үзүүлэлт болгоно.” Гэж тодруулсан хэсгийг нэмэх; -Амьжиргааны түвшин доогуур, хөдөлмөр эрхэлдэггүй, ядуу, нэн ядуу өрх, гэрийн хувьд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдал, зүй бус хандлага, дарамт, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэх нь өндөр тул гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо, амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлтийг ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлтэд нэмсэн болно. 4. 2.5.1.1.2. “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан, <u>судалгаанд</u> үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх” гэж тодруулсан хэсгийг нэмэх; Мэдээллийн сангаас гадна хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, үр дүнг судалж, түүнд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй гэсэн санаагаар нэмсэн болно. 5. 2.9.1.1.9. “Шүүхийн журмаар гэрлэлт цуцлах үед хэний асрамжид үлдэх талаар хүүхдийн саналыг авч байгаа тохиолдолд хүүхдэд эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн зүгээс ятгалаг, дарамт үзүүлж байгаа эсэх талаар тандаж, сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүүхэд өөрөө бие даан шийдвэр гаргахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх” гэж шинээр нэмэх; 6. 2.11.3. “Шүүх хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй гомдол, нэхэмжлэлийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэсэн болон эцэг, эхийн хэний асрамжид үлдэх талаар хүүхдийн саналыг авахаар шийдвэрлэснээс хойш 7 хоногийн дотор тухайн шүүхийн тамгын газраараа дамжуулан харьяа хууль зүйн хороонд мэдэгдэнэ.” гэж тодруулсан хэсгийг нэмэх;	хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.” 3. Саналыг хүлээн авч 2.7 дугаар зүйлийн 7-д “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална.” гэж тусгав. 4. Саналыг хүлээн авч тусгав. 5. Саналыг хүлээн авч тусгав. 6. 2.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т “Шүүх нь шүүхэд шилжүүлсэн өсвөр насны яллагдагч, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, ял шийтгэгдсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан болон иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийн
--	---	--

		мэдээллийг тухай бүр" хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын албанд ирүүлдэг байхаар өөрчлөн найруулав.	мэдээллийг тухай бүр" хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн мэдээллийг Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны Ажлын албанд ирүүлдэг байхаар өөрчлөн найруулав.
		7. 3.2.2. "Сургалтын байгууллага хүүхдийг тухайн орчинд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршил, дээрэлхэх үйлдэл, ялгаварлан гадуурхах, үл ойшоох, сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ." гэж тодруулсан хэсгийг нэмэх;	7. "хүүхдийн эсрэг хүчирхийлэл" гэсэн нэр томьёонд багтаж байгаа тул оруулах шаардлагагүй гэж үзэв.
		1. 1.5 дугаар зүйл.Хүүхэд хамгааллын зарчим 1.1.хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээнд хүүхдийн эрх, ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих, хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах; Тайлбар:-"Дээд ашиг сонирхол" нь нэр томьёоны хувьд ойлгомжгүй, хүүхдийн хууль ёсны ашиг сонирхлыг хувааж, дээдийг нь хамгаална гэсэн ойлголтыг бий болгож байгаа тул "дээд" гэснийг хасах.	1.Хүүхдийн эрхийн тухай конвенцыг Монгол хэл рүү хөрвүүлэхдээ "хүүхдийн дээд ашиг сонирхол" гэсэн нэр томьёог хэрэглэсэн байдаг тул төслийг заалтыг хэвээр үлдээв.
		2. 1.7, 2.12, 2.13 дугаар зүйл. Хамтарсан багтай холбоотой 1.7, 2.12, 2.13 дугаар зүйлийг эргэн харж, найруулах Тайлбар:Хамтарсан багийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж, багийн гишүүдийн үүрэг тус бүрийг тодруулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хамтарсан багийн зохицуулалттай уялдуулан тодорхой болгох.	2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зохицуулалттай уялдуулсан, давхардлыг арилгав.
31.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар Албан бичгийн дугаар 2022.06.30 №01/3458	3. 2.5 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүрэг. 2.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.	3. Зөвшилцөн томилох нь Төрийн албаны тухай хуульд заасан мерит сонгон шалгаруулалтын зарчимд нийцэхгүй тул төслийн заалтыг хэвээр үлдээв.
		4 .3.Дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргатай зөвшилцөн Засаг дарга, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга томилж, чөлөөлнө. Тайлбар: хуулийн төслийн 2.8 дугаар зүйлийн 1, 2.12 дугаар зүйлийн 2, 4.6 дугаар зүйл, 4.7 дугаар зүйл зэрэгт тухайн шатны Засаг даргад чиг үүргийг хариуцуулсан боловч, томилгооны асуудал дээр оролцуулахгүй байгаа нь тухайн ажлыг	4. Зөвшилцөн томилох нь Төрийн албаны тухай хуульд заасан мерит сонгон шалгаруулалтын зарчимд нийцэхгүй тул төслийн заалтыг хэвээр үлдээв.

	гүйцэтгэхэд хүндрэл учрахаар байна. Мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан зарчмын дагуу тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Засаг даргад олгох шаардлагатай.
	5. 3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал. 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмэх: 2.4. сургалтын байгууллагын орчинд хяналтын камер байршуулж, авто замд хурд сааруулагч, аюулгүй тэмдэг, тэмдэглэгээ хийлгэн хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах; 2.5. сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; 2.6. хүүхэд хоорондын болон эцэг эх, багш, ажилчдын харилцааны зөрчил, хүүхдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх; 2.7. хүүхдийг хорт зуршил, сэтгэл санааны шийтгэл, дээрэлхэх үйлдэл, сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, үр дүнг нь тооцох. Тайлбар: -Сургалтын байгууллагын орчинд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг тодорхой болгох, сургалтын байгууллагын хариуцах ажил, үүргийг нэмэх шаардлагатай.
	5. Саналыг хүлээн авч тусгав.
	Саналыг хүлээн авч хуулийн төслийн 2.9 дүгээр зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллага нь "жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, чиглэл өгөх" зохицуулалтыг тусгав.
	Хүүхэд хамгааллыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа тул төслийн заалтыг хэвээр үлдээв.
	Харин Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар хүүхэд хамгаалал нь нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгэх төрийн чиг үүрэгт хамаарахаар заасан байгаа тул хуулийн төслийн 6.1 дүгээр зүйлийн 3-т "Төр хүүхэд
	6. 6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт 2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэнэ.
	7. 6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт 1.2. орон нутгийн төсөв Хасах
	8. 2. "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг энэ хуульд заасан төрөл, хэлбэр тус бүрээр улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ."
	9. "4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хамтарсан баг, Хууль зүйн хороо ажил, үйлчилгээний зардал, нийгмийн

		ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.” гэснийг хасах Тайлбар:-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.5-д заасны дагуу “хүн амын хөгжил, хамгааллын үйлчилгээ” нь нэгжийн удирдлагаар гүйцэтгүүлж болох төрийн чиг үүрэгт хамаарч байгаа тул мөн зүйлийн 27.2-д заасны дагуу тухайн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлэхдээ тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад нь шийдвэрлэнэ гэж заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс гаргах ёстой.	хамгааллын асуудлаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлж чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.” гэж тусгасан.
32.	Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Албан бичгийн дугаар №3Г-2/410	Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.	Тэмдэглэв.
33.	Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцлаа. Хуулийн төсөлд тусгайлан саналгүй болно.	Тэмдэглэв.
34.	Албан бичгийн дугаар 2023.01.10 №01/08 Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ танаа	Санал ирээгүй.	Санал ирээгүй .
35.	Монгол Улсын сайд, Боомтын сэргээлтийн үндэсний хорооны дарга Х.Булгантуяа Албан бичгийн дугаар 2023.02.09 №23/81	1.Төслийн 2.6 дугаар зүйлийн 2.6.1 дэх заалтад Хүүхэд, гэр үлийн нийгмийн ажилтнаар ажиллах ажилтанд Нийгмийн ажилтын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой байх шалгуур тавьсан байгаа нь тухайн чиглэлээр одоо ажиллаж байгаа ажилтнуудын мэргэжил эзэмшсэн байдал болон тухайн мэргэжлээр шинээр төгсөж байгаа төгсөгчдийн тоотой уялдсан эсэхийг анхаарах;	1.Судалгааг хийсэн байгаа тул саналыг тэмдэглэв.

	2.Төслийн 4.6 дугаар зүйлийн 4.6.2 дахь заалтад хүүхдийг асралт гэр бүлд асруулах тухай зохицуулсан байх бөгөөд хүүхдийг асралт гэр бүлд асруулсан тохиолдолд төрөөс хувьсах зардал олгох асуудлыг тусгах;	2.Хүүхдийн асралт гэр бүлд асруулах нь "хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ"-ний нэг төрөл бөгөөд хүүхдийг уг үйлчилгээнд хамруулж байгаа тохиолдолд санхүүжилт өгөх талаар Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан болно.
	3.Төслийн 4.7 дугаар зүйлийн 1.6, 1.7 дахь заалтуудад тусгагдсан хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах үндэслэлийг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг анхаарах;	3."асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ" гэж тодотгов. Уг ойлголт нь Гэр бүлийн тухай хуульд тусгагдсан ойлголт байдаг. Удаа дараа гэсэн нь 2 буюу түүнээс дээш удаа гэсэн утгыг илэрхийлдэг. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдгийг нэр томъёоны хэсэгт тодорхойлсон байгаа.

REF:

2023 оны 5 дугаар сарын 29

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад санал өгөх тухай

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайд Х. Булгантуяа танаа,

НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх Засгийн газрын үүрэг амлалтад маш их талархдаг. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал, зөвлөмжийн дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулж, холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтыг өндрөөр үнэлж байгаа илэрхийлэхэд таатай байна.

Тус хуулийг үлэмж хэмжээгээр өргөжүүлж утга, үйл ажиллагааг ойлгоход хангалттай дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг байсан нэмэлт зүйл, заалтуудыг оруулан, зөрүүтэй дутуу асуудлыг тусгасан явдалд бид туйлын баяртай байна.

Хуулийн шинэчилсэн найруулгад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан баг болон хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны хамтын ажиллагаа, чиг үүргийг тодорхой болгох, кейс менежментийг хэрэгжүүлэх, гэр бүлд суурилсан хамгаалал, эцэг эхийн халамж асрамжгүй болсон хүүхдийг асран хамгаалах, хууль зүйн тогтолцоо, гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлыг дэмжсэн шинэ зүйл заалтыг оруулж байгаад бид сайшааж байгаагаа илэрхийлэхийг хүсэж байна.

Хууль нь хүүхдийн дээд эрх ашгийг дээдэлсэн зарчмыг бүрэн хэрэгжүүлэх, хуулийг Хүүхдийн эрхийн тухай конвенцод нийцүүлэхийн тулд дараах зүйлийг анхаарч үзэхийг санал болгож байна.

- Хуулийн төсөлд хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг хангалттай тусгах шаардлагатай байна. Хүчирхийллийн төрөл бүрийн тодорхойлолтыг хуульд тодорхой тусгах, ингэхдээ эрсдэлд байгаа бүх эмзэг бүлгийн хүүхдүүдийг орхигдуулахгүйн тулд "эрсдэлтэй хүүхэд" болон "хүүхдийн эсрэг хүчирхийлэл" зэрэг тодорхойлолтыг Ерөнхий зөвлөмж 13, 18-д нийцүүлэн өргөжүүлэх;
- Хуулийн төслийг цаашид хүүхэд өөртэй нь холбоотой аливаа шийдвэрт үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангасан зохицуулалтаар сайжруулах, хуульд хүүхдийн эрхэд суурилсан хандлагыг баримталж, харилцан тохиролцох боломжгүй хамгаалагдах эрхтэй эрх эдлэгч гэхээсээ илүү тусламж шаардлагатай "тал" гэсэн үг хэллэгээс зайлсхийхийг санал болгож байна.
- Хууль хүүхдийн хувийн нууцад хөндлөнгөөс оролцохоос хамгаалагдах эрхийг хангаж чадахгүй байна. Энэ нь ялангуяа хүүхдийн талаарх мэдээлэл цуглуулах, тэдгээр мэдээллийг агентлагууд, байгууллагуудын хооронд солилцоход онцгой чухал ач холбогдолтой юм.
- Мөн хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх заалтуудыг нэмж оруулахыг зөвлөж байна.

Бид Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог үндэсний болон олон нийтийн түвшинд бэхжүүлэх талаар гаргасан таны санаачилгыг цаашид дэмжин ажиллахад үргэлж бэлэн байгаа бөгөөд Эрхэмсэг хатагтай та бидний өндөр ач холбогдол өгч байгааг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

Эваристе Коуасси-Компан
Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн
Суурин төлөөлөгч

**Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад
Хүүхдийг Ивээх Сангаас оруулах санал**

Монгол Улс, Улаанбаатар хот

2023 оны 5-р сарын 04

Шинэчилсэн найруулга дахь заалт	ХИС-гийн Монгол Улс дахь Хөтөлбөрийн газрын санал
2.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо 3.Төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих үүрэгтэй.	Төрийн байгууллага нь өөрийн чиг үүргийн дагуу хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй.
2.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт 1.Хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалт нь Засгийн газар, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багаас бүрдэнэ.	Бүх салбарын нийгмийн ажилтнууд гэж оруулах. Гэхдээ нийгмийн ажлын тухай хууль батлагдахад энэ хэсэгт мөн өөрчлөлт орох болов уу.
2.4 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг 1.5 Хүүхэд хамгааллын ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагчийг давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөр, журмыг батлах 1.6 Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчид зориулсан сургалтын хөтөлбөр, журмыг батлах	Тус заалтууд 2.5-ын 1.9-1.13 заалтуудтай давхцаж байна.
2.5 дугаар зүйл Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг 1.11.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын талаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын албан хаагчийг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ХНХЯ тул өөрөө өөртэйгөө хамтран зохион байгуулах утгатай болоод байгааг анхаарах

2.7 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан Дээд боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийгмийн ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан иргэнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна. 2.4 Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд оролцогч талуудыг удирдан чиглүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх, үйл явц, үр дүнг үнэлэх, кейс менежмент хийх;	Ямар байгууллагын чиг үүрэг дор мэргэшүүлэх сургалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох талаар зааж өгөх 2.1-2.5 нь кейс менежментийн алхмуудад орох тул энд давтахгүйгээр дээр үүрэгт нь тодруулж бичих Нийгмийн ажилтанд нийгмийн хамгааллын орчны өөрчлөлтөөс үүдэн ажлын байранд дасан зохицохын тулд мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зөвлөгөө өгөх ажлыг үе шаттай зохион байгуулах
2.8 дугаар зүйл. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөлийн чиг үүрэг 1. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хүүхэд хамгааллын чиглэлээр Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-г заасан чиг үүргийг хэрэгжүүлэх Ажлын албатай байж болно.	Үндэсний зөвлөл нь Хүүхэд хамгааллын үйлчилгээ, механизм, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн болон олон улсын байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах талаар нарийвчлан оруулах Орон нутгийн зөвлөл нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, механизм, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн болон олон улсын байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллах талаар нарийвчлан оруулах
2.15 дугаар зүйл. Хамтарсан багийн чиг үүрэг 1.6 тухайн жилд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийн саналаа харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлэх.	Мөн урьдчилан сэргийлэх үйлчилгээний төсөв хэрэгтэй. Энд хүүхэд хамгааллын кейс гараад түүнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх төсвийн санал гаргах юм шиг ойлгогдоод байна. Мөн хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах чиглэлийн сургалтын төсвийг төлөвлөдөг байх ба харьяа байгууллагадаа төлөвлөснийхөө төсвийн санал оруулдаг байх шаардлагатай

2.16 дугаар зүйл. Хамтарсан багийн зохион байгуулалт	
1.Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд хамтарсан багийн гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцож, асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. 2.Хамтарсан багийн хуралдаанаас гарах шийдвэр нь дүгнэлт, тэмдэглэл хэлбэртэй байна. 2.3.хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэйн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах хайрцаг байрлуулах; 2.10.хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийн хүний хувийн болон эмзэг мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа этгээдэд мэдээлэх, задруулахгүй байх;	Эрсдэлийн үнэлгээг тогтмол давтамжтайгаар хийж хүүхдүүдээс санал авах Хуулиар зөвшөөрөгдсөн тодорхой нөхцөл байдал, тухайн хүн хүүхэд болон бусдад аюул учирч болзошгүйг мэдсэн нөхцөл байдлаас бусад тохиолдолд хүүхэд болон түүний гэр бүлийн гишүүдийн хувийн болон нууц мэдээллийг хэн нэгэнд мэдэгдэх, задруулахгүй байх.
2.17 дугаар зүйл. Хүүхэд хамгаалал иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын оролцоо 8.Олон улсын болон гадаад улсын байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт, судалгаа хийхийг хориглоно.	Хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг хараат бусаар мэдээлэх үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах тухай заалт оруулах. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдсэн байна гэж оруулах. Судалгааны ёс зүйн хороог харьяа яамдын дэргэд байгуулах, чиг үүргийг нь тодорхойлох.
4 дүгээр зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал	Цахим хуудсууд эрхлэгчдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлон оруулах Хүүхдийг өөрийг нь хүчирхийллийн шинж, агуулгатай контентод оролцуулах, тоглуулах, зураг авах зэрэгт оролцуулахад шаардлагатай зохицуулалтыг энд оруулах. Таниулсан зөвшөөрөл хүүхэд, гэр бүлээс авах, Зураг авалтын дараагаар сэтгэл зүйн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах.

3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал 5.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 5.1.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг батлах; 5.2.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах; 5.3.Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авах; 2. Боловсролын сургалтын байгууллага нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 2.2. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах; 5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/453 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан. 2022 оны 1 сард бодлого журам болж,шинэчлэгдсэн тул 5.1, 5.2 –ийг хасах эсвэл 3 жил тутам шинэчлэх гэж оруулах Сургалтын байгууллага буюу сургууль, цэцэрлэг нь тухайн жилийн хувьсах зардлын 1 хүртэлх хувийг байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд зарцуулна гэж оруулах Хамтарсан багтай тогтмол хамтран ажиллах сургуулиудын үүрэг хариуцлагыг тодорхойлох. 2 эсвэл 4 дэх заалтын дагуу санал гомдолд хариу өгөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаар томилогдсон сургуулийн баг/хорооны үүргийг зааж тодорхойлж өгөх. Бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, үе үе хянан/шинэчлэх үүрэг хариуцлагыг тусгах. Сургуулиудад хэрэгжүүлж буй бодлого, журам, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, тогтмол хяналтын үүргийг тусгах. Боловсролын тухай хуульд тусгагдсан хэсэг орсон байна.
4.5 дугаар зүйл. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ 1.10. сургууль завсардсан хүүхдийн чадвар, бэрхшээлийн онцлог, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад холбон зуучлах;	Сургууль завсардсан хүүхдийн чадвар, бэрхшээлийн онцлог, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад орон нутгийн мэргэжлийн байгууллагагай хамтран холбон зуучлах гэж оруулах Аймаг дүүргийн “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”, болон орон нутгийн Боловсролын газарт ийм чиг үүрэг байгаа тул дэмжлэг үзүүлэх зорилгоор уг заалтыг өргөжүүлэх шаардлагагай гэж үзлээ.

4.8 дугаар зүйл. Хүүхдийг төрөл, садан, ойр дотнын болон асралт гэр бүлд асруулах	Хүүхдийг асралт гэр бүл, төрөл садан, ойр дотнын гэр бүлд нь өгөхөд тухайн гэр бүлд төрөөс үзүүлэх дэмжлэг, зохицуулалтын талаар заалт нэмэх. Нэг хүүхдийн асаргааны сар, жилийн тариф нь тодорхой байх гэх мэт.
4.11 дүгээр зүйл. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ	Сайн дурын ажилтан: Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах сайн дурын ажилтнуудыг сонгох шалгуур болон тавигдах шаардлагын талаар зохицуулалтыг нэмэлт журмаар батлах. Эсвэл хуульд дурдах. Дурын хүнийг хүүхэд хамгаалалд сайн дурын ажилтнаар ажиллуулж болохгүй. Өмнө нь хүчирхийлэл үйлдэж, ийм төрлийн хэрэгт холбогдож байсан хүн сайн дурын ажилтны дүрээр ирэх эрсдэлтэй.
4.12 дугаар зүйл. Кейс менежмент	Гаргах болон хэрэгжүүлэх
1.3 хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргах;	
4.12 дугаар зүйл. Кейс менежмент	Холбон зуучлах мэргэжилтэн, байгууллагын жагсаалтыг гаргах, шинэчлэх
1.4. Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэх бусад байгууллага, мэргэжилтэнтэй холбох;	
4.12 дугаар зүйл. Кейс менежмент	Мэргэжлийн удирдлагаар хангах арга зүй нь өөрөө тодорхой систем, бүтэц, арга зүй шаардана. Кейс менежер, кейс ажилтан, нийгмийн ажилтан, ахлах нийгмийн ажилтан гэж хэнийг хэлэхийг нэр томъёоны тайлбарт оруулах.
4. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнгийн талаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтарсан багийн гишүүд, оролцогч бусад талуудын санал, дүгнэлтийг авах, гэдэнтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, зөвлөгөөн хийх, холбогдох талуудаас мэдээлэл авч	
1.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас доод шатны албан хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг шалгаж, биелэлтийг дүгнэх;	Ажлын явцтай танилцаж, мэргэжлийн дэмжлэг үзүүлж, дараагийн үйл ажиллагааг хамтран төлөвлөж хэрэгжилтийг хянаж ажиллана.

6.4 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт 3.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейст тулгуурлаж, дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтооно 6.4 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт 4.Хүүхэд хамгаалалд хуваарилагдсан төсвийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан багаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэмжлэг, урьдчилан сэргийлэх, тусалцаа үзүүлэхтэй холбогдох үйл ажиллагаанд зарцуулна.	Кейст тулгуурласан зарчмаар зардлыг төсөвлөхийн оронд хүүхдийн тоонд үндэслэн тогтмол коэффициент баримтлах зарчмаар мөнгөн дүнг тогтоох Бүхий л шаардлагатай зардлын нэр төрлөөр ангилан төсөвлөдөг байх. Мөн Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа хүний нөөцийг чадавхжуулах, сургах, мэргэшүүлэх чиглэлээр төсөв хуваарилах хуулийн заалтыг нэмэх Хүүхэд хамгааллын үйлчилгээнд зориулсан төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно гэж нэмэх.
Хүүхэд хамгааллын тухай хуулийн үндсэн бүтцийг дараах агуулгаар санал болгож байна. Огт дурдагдаагүй хамгааллын асуудлууд байгаа тул илүү нарийвчлан боловсруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд: А. Зарчим ба тодорхойлолт хэсэгт: • Хуулийн зорилт • Тодорхойлолт • Хамгааллын хамрах хүрээ • Зарчмууд • Олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүрэг • Олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, олон улсын эрх зүйг хэрэглэх Б. Хүүхэд хамгааллын үндэсний бодлого, үндэсний болон орон нутгийн тогтолцоо • Хүүхэд хамгааллын дээд байгууллага, түүний бие даасан байгууллага байдал, санхүүгийн хариудлага • Судалгаа, урьдчилан сэргийлэх, сургалтын үйл ажиллагаа, техникийн тусалцаа • Хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэгч нэгжүүд • Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгчид • Хүүхэд хамгааллын үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан тусгай зөвшөөрөл, сургалт • Олон улсын хамтын ажиллагаа	

- Хүүхэд хамгааллын арга хэмжээ, систем ба Хүүхдийн тусламжийн утас
- Мэдээлэх үүрэг

- Хүүхэд хамгааллын хяналт шалгалт
- Аюулгүй байдал ба хяналт

- Аюулгүй орон байраар хангагдах эрх асрамж халамжийн хувилбарт үйлчилгээ авах эрх

В. Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний удирдлага ба хяналт

- Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний зарчмууд
- Үрчлэл

Г. Хүүхдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эллүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

- Эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, сэтгэл заслын нөхөн сэргээх, нийгэмшүүлэх арга хэмжээ
- Хууль зүйн тусалцаа авах эрх, шударга ёсны хүртээмж
- Хүүхдийн эсрэг гэмт хэргийн шийтгэл
- Бүрэн нөхөн төлбөр авах эрх
- Хохирогчийн нөхөн төлбөрийн сан

Д. Гэр бүл, нийгэм дэх хүүхэд хамгаалал (Зарим тусгайлан хуульд заасан ч энэ процессын хуульд заавал суурь ойлголтыг оруулах шаардлагатай)

- Гэр бүлийн үүрэг хариуцлага
- Төрийн үүрэг хариуцлага
- Гэр бүлийн хамгаалалд байхгүй байгаа хүүхэд
- Сургууль, мэргэжлийн сургалт
- Бие махбодын шийтгэлийг хориглох
- Хувийн орон зай, нууцтай байх эрхийг хамгаалах
- Цөлөөт цаг, тоглоом ба хүүхэд хамгаалал
- Эрүүл мэнд ба хүүхэд хамгаалал
- Мансууруулах бодис болон бусад хортой бодисуудаас хамгаалах
- Олон нийтийн газар, зугаа цэнгэлийн арга хэмжээний үеийн хүүхэд хамгаалал
- Бизнес ба хүүхэд хамгаалал ба хүүхэд хамгаалал
- Хэвлэл мэдээлэл ба хүүхэд хамгаалал
- Цөөнхийн бүлэгт хамаарах хүүхдүүдийг хамгаалах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамгаалах
- Хүүхэд хулгайлах, худалдаалахаас хамгаалах
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах
- Хүүхдийг биеийг нь үнэлүүлэхэд ашиглагдахаас хамгаалах
- Хүүхдийг бэлгийн аялал жуулчлалаас хамгаалах

- Хүүхдийг порнографаас хамгаалах
- Хүүхдийн порнографын агуулга, материалтай харьцахаас хамгаалах
- Хохирогч хүүхдийг шийтгэхгүй байх зарчим
- Шүүхийн харьяалал, шилжүүлэн өгөх, хариуцлага, хамтын ажиллагаа
- Хүүхдийг эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалах
- Хүүхдийн хөдөлмөрт хандах, зарчим
- Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн доод нас
- Хортой, аюултай, зохисгүй хөдөлмөр эрхлэхийг хориглох
- Ажил олгогчийн үүрэг
- Ажлын цаг, амрах цагийн зохицуулалт
- Онцгой байдлын үед хүүхдийг хамгаалах
- Дотоодод нүүлгэн шилжүүлсэн хүүхдүүд
- Хууль зүйн тогтолцоонд хүүхдийг хамгаалах
- Хүүхэдтэй холбоотой шүүх хуралдааны зарчим
- Хохирогч хүүхэд, гэрч хүүхдүүдийг хамгаалах
- Гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд
- Эрхээ хязгаарлуулсан хүүхдүүдийг хамгаалах, нөхөн сэргээх

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД
ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН
ӨГСӨН САНАЛЫН ТОВЬЁГ**

Хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр
Оролцогчид: Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын байнгын ажлын хэсгийн гишүүд /48 хүн/
Зохион байгуулсан газар: ХНХЯ-ны 10 давхрын хурлын заал

д/д	Байгууллага, хүний нэр	Өгсөн санал	Саналыг төсөлд тусгасан байдал
1.	Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн ТББ-ын Захирал Б.Жавзанхүү	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, холбогдох хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй танилцаад зарчмын хувьд дэмжиж байна. 1.Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцтой нийцүүлж оновчтой тодорхойлсон байна. 2.Хуулийн Гуравдугаар бүлэгт Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгасан нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын зөвлөмжтэй уялдаж байна гэж үзэж байна. 3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журам шинэчлэгдэн батлагдаад хэрэгжиж байна. Гэхдээ хэрэгжилт хангалтгүй байна. Улсын хэмжээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа хүүхэд нэг бүртээ Хууль зүйн хороо үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Хууль зүйн хороогоор үйлчлүүлж байгаа хүүхдийн мэдээллийн сан бүрдүүлж, ашиглахгүй байна. Гэмт хэрэгт холбогдсон, гэрч, сэжигтэн хүүхдийн эрх ашгийг хамгаалж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Хүүхдийг буруутгах хандлага хууль хяналтын байгууллагынхан дунд байсаар байна. Хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх механизмыг тодорхой болгож, хуулийн	1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын талаарх зохицуулалтыг сайжруулан найруулав. 2. Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.3.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан; хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөлд байгаа; эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй; гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг; гэж өөрчлөн найруулав.

	төсөлд дэд бүлэг болгон оруулж төслөө боловсруулсан нь зүйтэй. Өмнөх хэлэлцүүлгүүд дээр өгсөн саналыг тусгасан байна. Баярлалаа. Гэрч хүүхэд явсаар байгаад сэжигтэн, улмаар хэргийн холбогдогч болох эрсдэл, тодорхой тохиолдлууд байна. Мөн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийн мэдээллийг хуулийн байгууллага Хүүхэд хамгааллын хууль, дүрэм, журмаар үүрэг хүлээсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хууль зүйн хороондоо шуурхай мэдээлж хамтран ажиллахгүйгээс хүүхдийн бусад эрх ашиг зөрчигдсөөр байна. Тухайлбал, сэтгэл зүйн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, хөгжлийн үйлчилгээ авч чадахгүй байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед шантрах, мэдээллийн нууцлал алдагдах, хүүхэд хамгааллын үйлчилгээ авч чадахгүй байна. Ийм учраас эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэх нэр томьёоны тайлбар хэсэгт бэлгийн мөлжлөг, хүн худалдаалахын хохирогч, тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд гэж нэмж тусгах нь зүйтэй гэж үзэж байна. 4. Орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтсийн чиг үүргийг хуулийн төсөлд тодорхой, оновчтой тусгаж, бусад байгууллагатай хэрхэн уялдаж хамтарч ажиллахыг энэ хуульд тусгаж өгөх нь зүйтэй.	3. 3.4 дүгээр саналыг тэмдэглэв.
2.	Монголын Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн П.Цэвээн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өмнөхөөсөө илүү сайжирсан байна. 1.Хуулийн төслийн 2.8 дугаар зүйлд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дэд бүлэг болгон тусгаж, хууль зүйн хорооны чиг үүрэг, зохицуулалтыг журмаар биш хуулиар зохицуулах хуулийн төсөл явж байгаад таатай хүлээн авч байна. 2.Хууль зүйн хороог илүү бэхжүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бүх л хүүхдийн эрх ашгийг хамгаалах, бусад эрхийг зөрчихгүй байх хуулийн маш сайн	1.1, 2 дахь саналыг тэмдэглэв.

	зохицуулалттай болохгүй бол хүүхдүүд хохирсоор байх эрсдэлтэй.	
	3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүрэг дотор “хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан баг байгуулна гэж тусгасныг хасах саналтай байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хамтарсан баг гэж мөн байгаа. 4.Харин Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд салбар дундын хамтарсан багаар ажиллах заалтаа тусгах нь зүйтэй болов уу.	2. 3 болон 4 дүгээр саналыг авч, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд салбар дундын хамтарсан баг байгуулах, салбар дундын хамтарсан багийн ажиллах журмыг батлуулах заалтыг тусгаж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс хасав. 3. Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 6-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.” гэж оруулав. 4.Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлийн 5-д “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн хэрэг, маргаанд шинжээчийн дүгнэлт гаргах.
	5. Хуулийн төслийн 3.8 дугаар зүйлд “хүүхдээс мэдүүлэг, тайлбар, санал авах аргачлал, зааврыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тусгасныг дэмжиж байна.	
	6. Шинжээчийг бэлтгэх, зөвшөөрөл олгох асуудлыг маш сайн судалж, хуулийн төсөлд тусгах саналтай байна.	

		мэргэжилтнийг бэлтгэх, сургах, гэрчилгээжүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.
		1. Саналыг тэмдэглэв.
3.	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний сүлжээний зохицуулагч Ц.Баттуяа	Юуны өмнө Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулж, санал авч байгаад баяртай байгаа илэрхийлье. 1. Хуулийн үйлчлэх хүрээ маш тодорхой болсон байна. 2.Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ суурь зарчимд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг бүрэн хориглосон заалт оруулж баталсан нь манай улсын хувьд Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын суурь конвенциудад нэгдсэн өөрөөр хэлбэл 182, 138 дугаар конвенцын үзэл санаа, зарчмыг анх удаа хуульдаа тусгасан. Гэхдээ хөдөлмөр эрхэлж байгаад эрх ашиг нь зөрчигдсөн, эсвэл амь насаа алдсан хүүхдийн асуудлыг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэж, хуулийн байгууллага шалгаж хариуцлага тооцсон тохиолдол бараг байхгүй. Мөн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох журмаар хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалт байхгүй байдаг. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэх нэр томьёоны тайлбарт байхгүй, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд эцэг эх хүүхдээрээ тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэхгүй гэсэн агуулгатай ганц заалт бий. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэлэлцүүлэгт өмнө оролцохдоо ч энэ байр сууриа илэрхийлж байсан. Хуулийн төслийн нэр томьёонд тусгах, мөн Гэр бүл дэх хүүхэд хамгааллын хэсэгт “эцэг эх хүүхдээрээ хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон заалт нэмж тусгах саналтай байна. 2.Саналыг хуулийн төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.6 болон Гуравдугаар бүлгийн 3.1 дүгээр зүйлийн 5-д “Эцэг, эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрөх, хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээндээ ажиллуулахаыг хориглоно” гэж тусгасан.

		3.Хуулийн төсөлд салбар бүр хүүхэд хамгааллын бодлоготой байх, холбогдох төсөв, санхүүжилтийг шийдвэрлэх гэх зэрэг шинэлэг заалтууд туссаныг дэмжиж байна.	Хуулийн төслийн 2 болон 6 дугаар бүлэгт туссан.
4.	ХЗДХЯ Мэргэжилтэн н.Дуламжав.	1.Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журам хэрэгжиж байгаа хэдий ч цаашид холбогдох хуулиудад өөрчлөлт орж, журмыг хүчингүй болгохыг хэлж мэдэхгүй. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүтэц, чиг үүргийг хуулийн төсөлд тусгаж оруулж ирснийг дэмжиж байна.	Хуулийн төслийн хоёрдугаар бүлгийн дэд бүлэг болгон тусгасан.
		1.Хуулийн төсөлд гуравдугаар бүлгийн 3.3 дугаар зүйлд туссан саналыг дэмжиж байна. 2. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 5.3-т “эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээг авах” гэж тусгасныг дэмжиж байна. Манай яам энэ онд салбарынхаа хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж, салбартаа хэлэлцүүлэхэд байхад хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зардлыг хаанаас шийдвэрлэх вэ гэдэг асуудал их тавигдсан. Хуульд тодорхой тусгаад өгчихвөл цаашид хэрэгжих боломжтой гэж харж байна.	1/ 1, 2,3 дахь саналыг тэмдэглэв. 2/ 2 дахь саналыг тусгаж найруулгыг засав. 3/ 5 дахь саналыг тусад нь авч үзэж, бодлогын шинжилгээ хийхээр ажиллаж байна.
5.	ЭМЯ Ахлах шинжээч Н.Энхмаа	3. Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 5.2-д тусгасан “эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах” гэснийг дэмжиж байна.	Саналыг тусгав.
		4.Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн 1-т “Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.” гэж найруулах 5. Хорт хавдартай хүүхдийн хамгааллын асуудал, гэр бүлд үүсэх бусад хүндрэл бэрхшээл, хүүхдийн боловсрол эзэмших, хөгжих эрхийн асуудал үнэхээр хөндөгддөг. Энэ асуудлыг мөн холбогдох хуулиудаар зохицуулах хэрэгтэй байна.	Хуульд агуулга тусгагдсан.

6.	Эцэг эхийн төлөөлөл Маралын ээж	1. Өнөөдөр энэ уулзалтад оролцож, олон мэдээлэл сонсож, хуулийн төсөлд санал өгч байгаадаа талархаж байна. Би хүүхдийнхээ хорт хавдрыг эмчлүүлж эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа. Үнэхээр эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүүхдийн эцэг, эхийн хариуцлага харилцан янз бүр байна. Хүүхэд нь хүндээр өвдсөн, удаан хугацааны асаргаа шаардлагатай хүүхэдтэй гэр бүлийг дэмжих орчин, эрх зүйн зохицуулалт маш чухал байна. 2. Боловсролын орчин дахь хүүхэд хүүхдээ дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, багшийн зүгээс хүүхэдтэй зүй бус харилцах байдал маш их байна. Энэ нь хүүхдэд олон сөрөг үр дагаврыг бий болгож байна. Бодитой арга хэмжээ авч, хариуцлагажуулах тогтолцоо сул байна. Хуульд хүүхдийн эрх ашгийг хамгаалсан, эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчийг үүрэгжүүлсэн, хэн буруутайд нь тооцох хариуцлагын асуудлыг маш тодорхой тусгах саналтай байна. 3. Олон хүүхэд эцэг, эхдээ хүчирхийлүүлж, түүнийгээ нууж байгаа. Үүнийг илрүүлэх, хамгаалах, эрхийг нь хамгаалах зохицуулалт маш тодорхой байх ёстой байна.	Саналыг тэмдэглэж, агуулгаар нь авч үзэж, хуулийн төслийн 3.1, 3.2 дугаар зүйлд тусгасан.
7.	Харилцаа холбооны зохицуулах хорооны хэлтсийн дарга С.Батболд	1. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл өмнөхөөсөө илүү сайжирсан, олон асуудлыг тусган боловсруулжээ. 2. Хуулийн төслийн 3.5 дугаар зүйлтэй холбоотой санал хэлье. 3.5-ын 1-т “Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, боловсролын сургалтын байгууллага сургалтын болон дотуур байрны орчинд, аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан эрх эдэлж, үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийг эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд нь сөргөөр нөлөөлөх бүх төрлийн хориотой, хортой контент, бүтээлээс хамгаална,” гэж найруулах;	1. 1, 3, 5 дахь саналыг тэмдэглэв. 2. 2 болон 4 дэх саналыг тусгаж, найруулгыг засав.

		3. Хуулийн төслийн “Хүүхэд өрөө болон хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан, иргэн, байгууллага, аж ахуйн нэгж өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хүүхдэд зориулсан контент, бүтээл нь хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн, хэвлэл, мэдээлэл, цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй, хүүхдийг цахимаар дарамталсан, дээрэлхсэн байж болзошгүй тохиолдлыг хүүхдийн тусламжийн утас, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, цагдаагийн байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах газарт гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй” гэснийг дэмжиж байна. 4. “Өргөн нэвтрүүлгийн болон контентын үйлчилгээ эрхлэгч нь өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, оюун санаа, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх хориотой, хортой контент, бүтээлийг таних, хязгаарлах, хаах арга хэмжээг авах үүрэгтэй.” гэж засах найруулах нь зүйтэй. 5. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад хуультай нийцсэн эсэхийг дахин харах хэрэгтэй. 6. Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна.
--	--	--

Тэмдэглэл: Хуулийн төслийг зөвлөх Б.Баттулга танилцуулж, санал авч хэлэлцүүлээ. Оролцогчдын хувьд хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Хэлэлцүүлэгт 26 санал өгснийг тэмдэглэж, хуулийн төсөлд тусган найруулав.

---oOo---

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНД ХУУЛЬЧИД БОЛОН
ХҮНИЙ ЭРХИЙН БАЙГУУЛЛАГЫН ДУНД ХИЙГДСЭН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

2022.05.12

1. Судлаач Баттулга: Шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд тусгагдсан агуулга.

- Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлсэн.
- 18 нас хүрсний дараах үйлчилгээ.
- Төрийн бүх байгууллага ААНБ баримтлах зарчмыг ерөнхийлөн оруулсан
- Мэдээллийн хангалтгүй байдал. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлэх
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд Цагдаагийн байгууллагаас 24 цагийн дотор мэдэгдэнэ.
- Ослын даатгал, эцэг эхтэй байгуулж буй гэрээнд шагнал, урамшууллыг тодорхой тусгах, осол, гэмтэл гарсан тохиолдолд зардлыг өөрсдөөсөө гарган хариуцах /Унаач хүүхэд/
- Үндэсний их баяр наадмаар хязгаарлахгүйгээр бусад тохиолдолд мөн хэрхэх талаарх зохицуулалт.
- Хүүхэд хамгаалал: Гэр бүлд суурилсан мөн гэр бүлээс гадна тусгаарлах /үүнд асралт гэр бүлийн тухай мөн/ зохицуулалт
- Хүүхэдтэй харьцдаг хүмүүс заавал эрх зөрчигдсөн, хүүхдийн эрхийн талаар мэдээлэл хүргэх үүрэг. Мөн эрх зүйн чадамжтай хүн бүр мэдээлэл хүргэх үүрэг.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхдийн асуудал.

2. Хуульч, судлаачдын асуулт, хариулт:

1. Хөөрхөн зүрх ТББ /Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг./

- Хууль ёсны төлөөлөгчөөр оролцох
- Нөхөн сэргээх үйлчилгээ /урт хугацаанд, хохирогчид ээлтэй байдлаар зохицуулах/
- Хэрэгжилтийг сайн хангах тал дээр анхаарах
- Хамгаалах байрнуудын хугацаанаас хамаараад хүүхэд тусгаарлах асуудал асуудалтай болж эхэлдэг.
- Гэр бүлээс гадуур тусгаарлах талаар.

Хариулт: Оюунболд

-Гэр бүлийн хүрээнд нэн даруй хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг авах талаар хуулийн төсөл бичигдэж байгаа. Энэхүү арга нь үр дүнгүй байгаа тохиолдолд гэр бүлээс гадуурх үйлчилгээг авч болно. Төрөл садан, асралт, асрамжийн байгууллагад байлгах талаар 3 түвшний зохицуулалт орж байгаа. Тодорхой үндэслэлүүдээр орсон.

- Хөөрхөн зүрх ТББ: Одоогийн хуулиудаар хамтарсан баг ТББ хамтрах дутагдалтай байдаг. Энэ талаар зохицуулалт төсөлд тусгагдсан уу?

-Хүүхэд хамгааллын төсөл дээр тусгагдаж байгаа. Тодорхойлолтыг мөн тусгаж байгаа нэр томъёоллын хувьд. Одоогоор харьяа нь тодорхойгүй байгаа. Төрийн албан хаагчдын санхүүг шийдэх шаардлага. Хамтарсан багийн мэргэжлийн удирдлагыг оруулж ирж байгаа. Нийгэм хамгааллын яам зохицуулах нь зөв гэдэг агуулгаар тусгагдаж байгаа.

- Хөөрхөн зүрх ТББ: Кейс хаах асуудлын талаар Фоллов апп гээд ОУ-ын жишгийг оруулах саналтай байна.

-Мэргэжлийн түвшинд хуульд бүгдийг оруулах боломжгүй. Мэргэжилтнүүдэд зориулсан ерөнхий менежментийг илүү тодорхой болгож байгаа. Журмыг баримтлан зохицуулна.

2. Хуульч Х.Баасанжаргал

-Тухайн үеийн эдийн засгийн зардлуудыг танаж байгааг зохицуулах бололцоо хэр вэ? Төсвийн тухай хуульд тусгах боломж.

-Тэр талаар зохицуулалт ороогүй.

- Орон нутгийн хүүхдүүдийн талаар ямар зүйл тусгагдаж байгаа вэ? Монгол Улсын онцлогийг хэр тусгасан бэ? Дотуур байрны асуудал. Үүнээс үүдсэн асуудлын хариуцлага эцэг, эхэд шилжих үү эсвэл боловсролын байгууллага хариуцах уу.

-Ялгасан байдлаар тусгагдаагүй. Сургуулийн орчин гэдэг байдлаар дотуур байрны асуудлыг тусгаж байгаа гэж бодож байгаа.

-Гуравласан гэрээгээр зохицуулагдаж байгаа дотуур байрны асуудал. Тиймээс үүргийг бүтэн шилжүүлэхгүй. Дотуур байранд болсон асуудалд боловсролын байгууллага. Түүнээс гадуурх эрх, асуудлын талаар эцэг, эх хариуцах. Эрсдэлд бүлгийн хүүхэд гэж дотуур байрны хүүхэд гэж тусгаж болохгүй.

3. Доктор Сүхбаатар:

-Хүүхдийн эрхийн тухай хуультай хэрхэн холбогдож байгаа вэ?
-Барууны загвараар төрийн хамгаалалтад ийнхүү авч байгаа нь эцэг, эх нарыг хариуцлагагүй болгож, төрд даатгах байдлыг бий болгож байна. Хуульд уламжлалт эцэг, эхийн хяналтын талаархыг яаж зохицуулсан бэ? Тооцож үзсэн эсэх? Сегмент бүрийг нь тооцож байгаа эсэх, хэн яаж хүрч ажиллах вэ?

Хариулт: Г.Оюунболд

- Гэр бүлд хүүхэд хамгааллын асуудлыг тусгасан. Эцэг, эх ямар үүрэгтэйг тодорхойлсон. Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдүүд рүү илүү чиглэж, асуудал яригдаж байгаа. Энэ хүүхдүүдэд ямар арга хэмжээг авах вэ, хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдийг тусгаарлахаас өөр аргагүй учир энэ талаар зохицуулагдаж байгаа. Урьдчилан сэргийлэх талаар мөн зохицуулдаг. Боловсролын асуудалд ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлт их байгаа тул эцэг, эх, нийгмийн ажилтан, багш ямар арга хэмжээг авах вэ гэдэг талаар тусгаж байгаа. Сургалтын байгууллагыг зөвхөн сургуулийг хамруулахгүйгээр зохицуулж байгаа.

П.Баттулга:

-Хүүхэд эрсдэлд орсон гэж үзвэл хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хамгаалах, дахин эрх нь зөрчигдөхөөс хамгаална. Энэ чиглэл рүү боловсруулагдаж байгаа.



ХҮНИЙ ЭРХ ДЭВШИЛТЭТ
БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН

“ХҮНИЙ ЭРХ – ДЭВШИЛТЭТ БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН”

**ХҮҮХЭД ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ӨГӨХ САНАЛ**

2022 он

**ХӨДӨЛМӨР
НИЙГЭМ ХАМГААЛЛЫН
ЯАМАНД**

2022 он

**ХҮҮХЭД ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
ӨГӨХ САНАЛ**

Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн нь Ардчилсан Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг сахин хамгаалж, хүний эрхийг дээдэлсэн, хүндэтгэсэн төрийн албыг бий болгох санал, санаачлагыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, таниулах, энэхүү үйл ажиллагаагаар дамжуулан “Хүний эрхийг хамгаалах, хууль эрх зүйн орчныг сайжруулах дэвшилтэт бодлого”-ыг хэрэгжүүлэх эрхэм зорилгыг удиртгал болгон үйл ажиллагаагаа явуулдаг.

Бид эрхэм зорилгоо хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд “Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, Тулгамдсан асуудал, шийдэл”, “Хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа”, “Хүчин төгөлдөр үйлчилж буй 318 хуульд хийсэн Хүний эрхийн мониторинг” зэрэг 3 үндсэн томоохон судалгааг хийж гүйцэтгээд байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1 дэх хэсэгт “Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:”, 8.1.6 дахь хэсэгт “хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах” гэж заасан.

Дээр дурдсаныг үндэслэн Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн зүгээс (1) дээр дурдсан судалгааг гүйцэтгэсэн судлаачдын санал болон (2) хуулийн төсөлд судлаачдын санал туссан эсэх, хүний эрхийн зөрчилтэй бусад заалтын талаарх саналыг хүргүүлж байна.

Хуулийн төсөлд бидний саналыг тусган ажиллана гэж найдаж байна.
Хавсралт 24 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Х.БААСАНЖАРГАЛ

ХҮҮХДИЙН ЭРХ

Хүүхэд эрх эрх зүйн чадамжийн хувьд онцгой халамж, туслалцаа шаардлагатай нийгмийн онцлог бүлэг бөгөөд хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай болохыг 1924 онд Хүүхдийн эрхийн тунхаглалд баталгаажуулснаас хойш хүүхдийн эрхийг хангах чиглэлээр олон улс, бүс нутаг болон үндэсний эрх зүйн механизм ихээхэн анхаарсаар ирсэн.

1989 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хурлаас Хүүхдийн эрхийн тухай конвенцыг баталсан бөгөөд хүүхдийн амьд явах; эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх, иргэний харьяалалтай байх, гэр бүл, эцэг эхтэйгээ хамт амьдрах, үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цуглах, мэдээлэл хайх, олж авах, аливаа хүчирхийлэл, дарамт, шахалтаас анги байх, нийгмийн хамгаалал хүртэх, сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, эдийн засгийн болон хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөгөөс ангид байх гэх зэрэг эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх талаарх оролцогч улс орнуудын үүрэг, хариуцлагыг тусгайлан заасан.

Уг конвенцын дагуу нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулах¹ бөгөөд конвенцод хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоох, захиргааны болон бусад шаардлагатай бүх арга хэмжээг дотоодын нөөц бололцоондоо тулгуурлан дээд зэргээр ашиглах үүрэгтэй.²

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин

Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын суурь стандарт Монгол Улсад үйлчилдэг. Монгол Улс 1990 оны 7 дугаар сард НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцыг соёрхон баталсан бөгөөд Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцын нэмэлт протоколыг 2003 онд, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 2 дугаар протоколыг 2004 онд, Мэдээлэл хүргүүлэх журмын тухай хүүхдийн эрхийн тухай Конвенцын 3 дугаар нэмэлт протоколыг 2015 онд тус тус соёрхон баталсан. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцыг 2002 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182-р конвенцыг 2001 онд соёрхон баталсан.

Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үндэсний хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 онд баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангахтай холбоотой харилцааг 2016 онд баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар нарийвчлан зохицуулж байна. Цаашлаад Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Нийгмийн

¹ Хүүхдийн эрхийн тухай конвенц, 3 дугаар зүйлийн 1.

² Хүүхдийн эрхийн тухай конвенц, 4 дүгээр зүйл.

халамжийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэх зэрэг салбар болон салбар дундын зохицуулалттай олон хуулиар хүүхдийн эрхийг хангахтай холбоотой харилцааг зохицуулж байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Засгийн газар болон асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас 30 гаруй дүрэм, журам, стандартыг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлд үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг батлах, хэрэгжүүлэх чиглэлд тасралтгүй анхаарсаар ирсэн бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2026/, Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр /2016-2025/, Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /2017-2021/, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжин үндэсний хөтөлбөр /2018-2022/, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр /2017-2021/, Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр /2017-2021/, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр /2017-2021/ зэрэг хөтөлбөрүүд үндэсний хэмжээнд хэрэгжиж байна. Хүүхдийн эрх хамгааллын салбарт гарсан ахиц дэвшлийг ерөнхийлөн тодорхойлбол:

- Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр шаардлагатай олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан
- Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн шинэтгэлийн хүрээнд төрөлжсөн болон бусад салбарын хууль тогтоомж хангалттай хэмжээнд батлагдсан.³
- Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний механизмын байгууллага, институт байгуулагдсан.
- Хүүхэд, гэр бүлийг хамгаалах чиглэлээр бодлогын баримт бичиг болон хөтөлбөрүүдийг зохих төвшинд боловсруулж, баталсан.
- Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр төрийн болон олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагаас олон тооны судалгааны тайлан гаргаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Хэдийгээр хүүхдийн эрхийг хамгаалах эрхзүйн шинэтгэлийн хүрээнд хууль зүйн орчинд ахиц дэвшил гарсан хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангалтгүй байдал, төсөв санхүүгийн хуваарилалт, төрийн болон орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, хүүхдийн эрхийг хүндэтгэх талаарх нийгмийн хандлагын дулимаг байдал болон ядуурал гэх зэрэг нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан хүүхдийн эрхийн зөрчил цөөнгүй гарч байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос тодорхой чиглэлд төрөлжүүлэн нэгтгэсэн зөвлөмж өгсөн нь цаашид хүүхдийн эрхийн хамгаалалд анхаарах шаардлагатай үндсэн асуудал болно. Тухайлбал, Хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад шаардлагатай мэдээллийн тогтолцоогоо яаралтай үр дүнтэй сайжруулах, уул уурхай гэх зэрэг бизнесийн үйл ажиллагаанаас хүүхдэд учруулж буй сөрөг нөлөөг багасгаж бизнесийн үйл ажиллагаанд хүүхдийг эрхийг хүндэтгэх дүрэм, журмыг тодорхой болгох, осол, гэмтлээс ангид нийгмийн орчин нөхцөлийг бий болгох, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, гэр бүлийн орчинд хүүхдийг үл хайхрах үйлдлийн эсрэг үр дүнтэй үндэсний

³ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Нийгмийн бодлого, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хамтран 2018.12.12-нд Төрийн ордонд зохион байгуулсан “Хүүхэд хамгааллын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал ба шийдэл” хэлэлцүүлэг, <https://news.mn/r/2058872/>

механизмыг бий болгох, хүүхдийн боловсрол, чөлөөт цаг, соёлын арга хэмжээ, эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эцэг эхийн хараа хяналтгүй гудамжны нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн эрхийн асуудалд онцгойлон анхаарах талаар зөвлөжээ.

Цаашид хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой дараах харилцаанд анхаарч, шийдвэрлэх шаардлагатай байна.

№	Шийдвэрлэх асуудал	Зөвлөмж
1.	Гэр бүлийн хүчирхийлэл ба хүүхдийн эрх. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 онд шинэчлэн баталсан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурахгүй байгааг олон тооны судалгаа харуулж байна.⁴ Зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн тухайд, 2020 оны эхний гурван сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэрэгт бүртгэгджээ. Эдгээр гэмт хэргийн хохирогчийн 87 хувь нь эмэгтэйчүүд, 22 хувь нь хүүхэд байжээ.⁵ Хэдийгээр Эрүүгийн хууль (11.7 Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх), Зөрчлийн тухай хууль (5.4 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих)-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчилж хэдий ч хариуцлагын тогтолцоонд илүүтэй суурилсан өнөөгийн бодлого, зохицуулалт нь үр нөлөөтэй эсэхийг анхаарах шаардлагатай.	- Хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, эрх хамгааллын байгууллагын нөөцийн чадавх, хөрөнгө санхүүг нэмэгдүүлэхээс гадна хүүхдийн хүчирхийллийг нийгмийн бүх төвшинд үл тэвчих үзэл, соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээнд илүүтэй анхаарах шаардлагатай. - Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын сургалтын агуулга, чанарт анхаарч ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал, ХЗДХС, ХНХС, ЭМС-ын хамтарсан тушаалаар “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр”, “зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам”-ыг баталсан хэдий ч уг сургалтыг зохион байгуулах байгууллага, хөрөнгө санхүү, хүний нөөц гэх зэрэг үндсэн асуудлыг шийдвэрлээгүйгээс хэрэгжиж эхлээгүй байна.
2	Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь тулгамдсан асуудал хэвээр байна. 2019 онд хүчиндэх гэмт хэргийн улмаас	- Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болох хүүхдийг илрүүлэх чиг үүрэг бүхий холбогдох талуудын үүрэг, оролцоог

⁴ Монгол дахь хүүхдийг ивээх сан, “Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ” 2018 он; Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Good neighbors олон улсын байгууллага, “Хүүхдийн эрх ба хамгаалал” судалгаа 2017 он.

⁵ Үндэсний Статистикийн Хороо, Цагдаагийн Ерөнхий Газар “Статистикийн тойм: Гэр бүлийн хүчирхийлэл” 2020 он, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GBHuchirhiilel_2020q1.pdf&ln=Mn

492 хүн хохирсны 253 буюу 51.4 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, эдгээрээс 50.6 хувийг 14-17 насны хүүхэд, 37.9 хувийг 8-13 хүртэлх насны хүүхэд, 11.5 хувийг 7 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.⁶ 2015-2017, 2018 оны эхний 10 сарын байдлаар 872 хүүхэд бэлгийн халдлагад өртсөнөөс нийт 676 хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болжээ. Эдгээрээс 7 хүртэлх насны 58 хүүхэд, 8-13 насны 233 хүүхэд, 14-17 насны 384 хүүхэд байжээ.⁷ Зөвхөн 2016-2017 оны 3 дугаар улирлын байдлаар бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хүчиндэх нийт 228 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 89.9 хувь буюу 205 гэмт хэрэгт бага насны 213 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж хохирчээ. Эдгээрээс 26.3 хувь буюу 56 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд давтан өртсөнөөс 30.4 хувь буюу 17 хүүхэд удаан хугацааны турш буюу 3-7 жилийн хугацаанд бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Бэлгийн хүчирхийллийн улмаас хохирогчдын 10.8 хувь буюу 23 хүүхэд бэлгийн замын халдвар өвчин туссан, 5.6 хувь буюу 12 хүүхэд жирэмсэлсэн, 4.2 буюу 9 хүүхэд гэмтлийн дараах дарамтат эмгэг, сэтгэл гутрал, сэтгэл гутрах сунжирсан хариу	нэмэгдүүлэх, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг ярилцлагын гэх мэт үр нөлөөтэй аргаар тогтмол авч хэвших. - Хүүхэд хүчиндсэн гэмт хэрэг нь ихэвчлэн гэр, орон сууцанд, үйлдэгддэг бөгөөд гэмт хэрэг үйлдэгчдийн 20 орчим хувийг ураг төрлийн хамааралтай хүмүүс байдал тул хорооны анхан шатны нэгжид ажиллаж байгаа ажилтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх. - Энэ төрлийн гэмт хэргээс сэргийлэхэд хувь хүний мэдээллийг нийтэд цацах нь үр нөлөө багатайг харгалзан үзэж гэр бүлийн гишүүдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргээ биелүүлэх ёстойг сануулахад мэдээллийн агуулгыг чиглүүлэх - Бүх насны хүүхдүүдийн нас, сэтгэл зүйн онцлогт тохируулан тэдний биеийн нандин, нууц хэсгүүдэд бусдыг чөлөөтэй хүрэхийг хориглож сурахыг сургалтын олон арга хэлбэрээр тогтмол хүргэх - Гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх нэг цэгийн үйлчилгээний тогтолцоо бүрдүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн Шүүх шинжилгээний байгууллагын үйлчилгээний хөлсийг хохирогч төлөх үүргээс чөлөөлөх, хохирогч хүүхдийн аюулгүй байдал болон хувийн нууцыг хамгаалах¹⁰ шаардлагатай. - Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд ногдуулах ялын бодлогыг чангатгах, Бэлгийн дарамт гэсэн үйлдлийг Эрүүгийн хуулиар дахин гэмт хэрэгт тооцох¹¹ - Хохирогч хүүхдэд учирсан эрүүл мэнд, эдийн болон эдийн бус гэм хорыг арилгах иргэний хуулийг зохицуулалтыг боловсронгуй болгох, - Гэр бүлийн гишүүдээс хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд Гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан байгууллага, эсхүл хүүхдийн эрхийн чиглэлээр
--	---

⁶ Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик-2019, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Crime_2019.pdf&ln=Mn

⁷ Тухайлбал, Монголын Эмэгтэйчүүдийн сан, ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Хүйсийн тэгш эрх төв, “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл судалгааны тайлан”, (2019)

¹⁰ Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг. http://www.upr-mongolia.mn/images/xupld/201910/Sexual_abuse_rape_UPR_mng.pdf

¹¹ Монголын Эмэгтэйчүүдийн сан, ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэн, Хүйсийн тэгш эрх төв, “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: Шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйл судалгааны тайлан”, (2019), 47

	урвал бүхий дасан зохицох эмгэгтэй болжээ.⁸ Хүчиндэх гэмт хэрэг үйлдэгчдийн 20 орчим хувь нь ураг төрлийн хамааралтай хүмүүс байх бөгөөд тэдгээрийн 57 орчим хувийг хойд эцэг үйлдсэн байгаа нь гэр бүлийн салалтын золиосонд хүүхэд хохирч байгааг харуулж байна.⁹ 2020 онд Эрүүгийн хуульд хүүхдийн бэлийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт ногдуулах ялын бодлогыг чангатгасан хэдий ч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн тогтолцоот хандлага үгүйлэгдэж байна.	үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг төлөөлөн оролцуулах
3	Хүн худалдаалах гэмт хэрэг. Эрүүгийн хуулиар Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийг гэмт хэрэгт тооцсон хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь хүүхэд байсан хэвээр байна. 2018-2020 онд хүн худалдаалах гэмт хэрэгт нийт 131 хохирогчийг илрүүлж тогтоосноос 47 нь хүүхэд байжээ.¹² 2019 онд улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэрэг 9 бүртгэгдсэний 5 буюу 55.6 хувь нь 14-17 насны хүүхэд байжээ.¹³ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021) батлагдан хэрэгжиж байгаа нь сайшаалтай хэдий ч Монгол Улсын Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийг таслан	- Олон улсын ажиглагчид хүн худалдаалсан хорих ялтныг хугацаанаас нь өмнө суллаж буй төрийн үйлдлийг хэт өршөөнгүй бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг зогсохгүй байхад хүргэж байж болзошгүй хэмээн дүгнэснийг анхаарах.¹⁵ - Энэ төрлийн гэмт хэрэгт ял оногдуулахдаа хөнгөн ялтай ойролцоо төрлийн гэмт хэргээр зүйлчилж байгааг анхаарах,¹⁶ хүүхэд худалдаалах гэмт хэрэгт ногдуулах ялыг хүн худалдаалах гэмт хэрэгт ногдуулах ялтай дүйцэхүйц болгож өөрчлөх - Хохирогч хамгааллын байрны нөхцөл, аюулгүй байдлын баталгааг нэмэгдүүлэх, бүх хүйсийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх.¹⁷ Хүнд худалдаалагдаж, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдүүд хамгаалах байранд байхдаа хараа хяналт сул, тусгайлсан халамж, үйлчилгээ дутмагаас болж дахин бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж талууд мэдээлсэн.

⁸ Б.Өнөрмаа, “Хүүхдийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг буюу бэлгийн хүчирхийллийн талаар” (2018), <https://news.zindaa.mn/2bd5>

⁹ Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа, (2019), 22.

¹² А.Маралмаа, “Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөх эрсдэл нэмэгдсэн”, 2021.08 сар, <http://newspress.mn/v1/p/news/22133>

¹³ Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик-2019, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Crime_2019.pdf&ln=Mn

¹⁷ Мөн тэнд.

	зогсооход тавигдах суурь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгааг АНУ-ын Төрийн департаментын 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайланд¹⁴ дурдсан бөгөөд хэд хэдэн зөвлөмж өгснийг энэхүү судалгаанд тусгасан.	- ЦЕГ-ын мөрдөн байцаагчид хохирогчийг таних 11 асуулт бүхий хүн худалдаалах эрсдэлийн хяналтын хуудас ашигладаг хэдий ч эмзэг бүлгийнхнийг таньж, үнэлэх ажиллагаа энэхүү процесст суугдаагүй байгааг засварлах¹⁸ - Хохирогчдыг олж тогтоох, тэднийг үйлчилгээнд хамруулах журам тодорхой бус, хангалттай хэмжээнд системчилсэн биш, мөн ихэнх тохиолдолд тухайн мөрдөн байцаагчийн мэдлэг, идэвх санаачилгаас ихээхэн хамаарч байгааг анхаарах
4.	Сэтгэцийн эрүүл мэнд ба Хүүхдийн амиа хорлолт: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөр эмчлүүлэгчдийн дийлэнх нь өсвөр насны хүүхдүүд байгаа нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал өсвөр үеийнхний тулгамдсан асуудлын нэг болсныг харуулж байна. Өсвөр насны хүүхэд дундах амиа хорлолт жил бүр өссөн бөгөөд 2012-2016 оны хооронд 10-25 насны 605 хүн амиа хорлосон нь нийт амиа хорлосон тохиолдлын 29.44%-ийг эзэлж байна. Үүнээс 10-14 насны хүүхэд амиа хорлосон нийт 78 тохиолдол бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод хамгийн их 27 буюу 34.6 хувь байна.¹⁹	Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлолтын ерөнхий тоон мэдээлэл байгаа хэдий ч ийнхүү амиа хорлох суурь шалтгааны талаарх хангалттай судалгаа байхгүй байгаа нь шаардлагатай хариу арга хэмжээ авах нөхцөлийг хязгаарлаж байна. Иймээс энэ чиглэлийн судалгааг хийж хариу арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.
5.	Цахим орчин дахь хүүхэд хамгаалал: Цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал тулгамдсан асуудал болж байгааг хэд хэдэн судалгааны тайланд онцолжээ.²⁰ 2021 онд Харилцаа холбооны зохицуулах хорооноос хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан	- Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалахын тулд Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтыг бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын сайн туршлага болон олон улсын байгууллага, тухайлбал Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU)-аас 2020 онд боловсруулсан Цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар бодлого боловсруулагч нарт

¹⁴ АНУ-ын Төрийн департаментын 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан, <https://nn.usembassy.gov/mn/2020-trafficking-persons-report-mn/>

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Монгол дахь Хүүхдийг ивээх сан, “Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ” 2018 он, 129.

²⁰ Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, Цагдаагийн Ерөнхий Газар, Дотоод хэргийн их сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан, “Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгааны тайлан, 2021 он; ГБХЗГ, “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал” 2019 он.

хүүхдүүдийн цахим орчинд өнгөрөөдөг дундаж хугацаа 4 цаг байгаа нь олон улсад зохимжтой гэж үздэг хугацаанаас 2 цагаар илүү байна. Цахим орчинд дарамт шахалтад өртөж байсныг асуухад ердөө 13 хувь нь үгүй гэсэн бол 1-2 удаа тохиолдсон гэж 31 хувь, 3-4 удаа гэж 23 хувь 5-6 удаа гэж 14 хувь, 7-8 удаа гэж 10 хувь, 9-10 гэж 6 хувь тус тус хариулсан нь цахим орчин дахь дарамт, шахалт тулгамдсан асуудал болсныг харуулж байна. дунджаар 43 орчим хувь нь үл таних хүний, үлдэх 57 хувь нь үе тэнгийнхний цахим дарамтад өртсөн хэмээн хариулжээ.²¹ Цахим орчинд хүүхдийн эрхэд халдсан гэмт хэрэг 2012 онд 17 бүртгэгдсэн бол энэ тоо 2018 онд 279 болж өсжээ.²² Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээний төв хүүхдийн цахим дарамттай холбоотой дуудлага 2016 онд 85 байсан бол 2018 онд 229 болж өсжээ.²³ Ийнхүү цахим орчинд хүүхдийг дарамтлах, хуурах, түүнчлэн цахим орчныг ашиглан хүүхдийг садар самуунд уруу татах, биеийг нь үнэлүүлэх, цахим шоглолт зэрэг гарах болсон нь энэ чиглэлийн төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтад онцгойлон анхаарч, холбогдох талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгохыг шаардаж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлд цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах эцэг, эх асран хамгаалагч, багш сургуулийн ажилтны хүлээх	өгөх зөвлөмжид үндэслэн боловсронгуй болгож, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай. - Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах, цахим орчинд хүүхдийг аюулгүй сурч, хөгжих нөхцөлийг хангах, цахим халдлага, гэмт хэргээс хамгаалах зэрэг өргөн хүрээг хамарсан үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх - Уг харилцаан дахь олон талд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үүрэг хариуцлагыг тодорхой болгохын тулд хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах үүргийн хүрээнд цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тусгайлсан хууль батлах нь илүү үр дүнтэй байхыг үгүйсгэхгүй. - Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, хуулиар хүүхэд хамгааллын ерөнхий тогтолцоог бүрдүүлсэн хэдий ч оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй, мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ байхгүй, мэргэшсэн албан хаагчдын хүрэлцээ хангалтгүй байгааг анхаарах - Цахим орчин дахь хүүхдийн хувийн эрхэд хэт хохирол учруулахгүйгээр хүүхдийн цахим орчны хэрэглээнд тавих эцэг, эхийн хяналтыг нэвтрүүлэх, сургуулийн орчинд зарим цахим орчны мэдээллийг хязгаарлах талаарх хууль зүйн болон технологийн шийдлийг боловсруулах. - Түүнчлэн цахим орчинд хүүхдийг эрхийг хүндэтгэх талаарх бизнес эрхлэгчдийн үүргийг Зар сурталчилгааны тухай хууль гэх зэрэг хуульд тодорхой тусгаж хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг тодорхой болгох - Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчлах - Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээний стандарт гаргах, сөрөг нөлөөтэй
---	--

²¹ Харилцаа холбооны зохицуулах хороо, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар судалгааны тайлан, 2021 он,

²² ГБХЗГ, Судалгааны эмхтгэл, (2019) 3 дугаар бүлэгт “Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал”, 63.

²³ Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Статистик мэдээ (2018) <https://crc.gov.mn/w/389>

	үүргийг хэт ерөнхий байдлаар хуульчилсны зэрэгцээ Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага цахим сүлжээнээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих төдий чиг үүрэг гүйцэтгэхээр хуульчилжээ. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн шинжтэй мөлжлөг гэх зэрэг үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр нарийвчлан зохицуулаагүй. Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/68 тоот тушаалаар “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг баталжээ. Дээрх чиглэлд цахим орчин дахь хүүхэд хамгааллын агуулгыг өргөн хүрээнд тодорхойлохыг эрмэлзсэн нь сайшаалтай хэдий ч хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрээр хамаарах этгээдийн хүлээх үүрэг, оролцоог ойлгомжтой, тодорхой байдлаар тусгаагүй нь уг баримт бичгийг агуулгыг хөтөлбөр буюу ажлын төлөвлөгөөний жагсаалт төдий болгожээ. Цаашид уг баримт бичгийн хууль зүйн үр дагавар болон чиглэлд тусгагдсан асуудлын талаар холбогдох талуудын чиг үүрэг, оролцоог ойлгомжтой тодорхой болгох шаардлагатай.	мэдээллийг насны ангилалд тохируулан ялгамжтай, оновчтой тодорхойлох - Зүй бус агуулга бүхий мэдээллийг шүүгч программ, түүний ач холбогдол, хэрэглээний талаарх мэдлэг, мэдээллийг эцэг, эхчүүдэд тайлбарлан таниулах, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын энэ талаарх үүргийг хэрэгжилтийг сайжруулах - Цахим орчинд аюулгүй байдлаа хангах талаарх хүүхдийн мэдлэг, ур чадвар, хандлага, соёлыг бий болгох чиглэлээр сургалтын олон арга, хэлбэр бүхий үйл ажиллагаа явуулах.
6.	Ялгаварлан гадуурхалт. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хуульчилсан хэдий ч нийгмийн эмзэг болон маргинальчлагдсан	- Юуны өмнө боловсролын бүх шатны байгууллагад ялгаварлан гадуурхалт нь зөрчил болохыг сургуулийн дотоод хэм хэмжээнд ойлгомжтой, тодорхой тусгаж, суралцагчдад ялгаварлан гадуурхалт нь хүний эрхийн зөрчил бөгөөд ийм үйлдэл хийхээс татгалзах мэдлэг,

	бүлгийн хүүхдүүд тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх болон өөр хэлтэй хүүхдүүд шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, үл ялгаварлан нийгмийн сэтгэл зүй, хандлага, дадал бий болгоход чиглэсэн системт, үр нөлөөтэй, үндэсний механизм бий болоогүй байна.	хандлага, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үр нөлөөтэй сургалт, хүмүүжлийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх талаарх сургалтын байгууллага, багшийн хүлээх эерэг үүргийг Боловсролын тухай хууль гэх зэрэг холбогдох бусад тусгаж, хэрэгжилтийг хангуулах шаардлагатай. - НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос хүүхдийг ялгаварлан гадуурхалтын талаар мэдээлэх, зөрчил гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэх, энэ талаарх нийгмийн ойлголт, хандлага, боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр яаралтай арга хэмжээ авах зөвлөмж²⁴ өгснийг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай. - Хүүхдийн эрхийн тухай хууль болон хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийг хууль бусаар ялгаварлан гадуурхахгүй байх баталгааг хуульчлахаас гадна төр болон хувийн хэвшлийн салбар дахь шууд болон шууд бус бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх тусгайлсан хуулийг батлах шаардлагатай байна. Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний хоёр болон гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр Чили, Аргентин, Исланд, Ирланд, Англи, Чех, Зүүн Тимор, БНХАУ зэрэг улсаас ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц, иж бүрэн тусгайлсан хуулийг батлах талаар зөвлөмж өгснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.
7.	Хүүхдийн өмчийн эрхийг хамгаалах. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль²⁵ болон Иргэний хуулиар хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах зарим зохицуулалт хуульчлагдсан хэдий ч тэдний эд хөрөнгийн эрхийг хамгаалах, ялангуяа хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтын тогтолцоо байхгүйгээс хүүхдийн ашиг сонирхол хохиролтой байдлаар эд хөрөнгийг захиран зарцуулж	- Хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгө болон зарим тогтоосон хэмжээнээс дээш үнийн дүн бүхий хэлцлийг тэдний хууль ёсны төлөөлөгч хийхдээ хүүхдийн эд хөрөнгийн эрх, ашиг сонирхолд хохиролгүй болохыг нотлон төрийн зохих байгууллага, тухайлбал шүүх болон орон нутгийн захиргааны байгууллагаас зохих зөвшөөрөл авдаг тогтолцоо эрх зүйн өндөр хөгжилтэй улс орнууд олонтоо хэрэглэж байна. Тухайлбал, Канадын Онтарио мужийн Хүүхдийн тухай хуульд хүүхдийн эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан шүүхийн байгууллагын хяналтыг бий болгосон байдаг бол Хорват улсад хүүхдийн үл хөдлөх эд хөрөнгийг эцэг, эх нь захиран зарцуулахдаа хүүхдийн дээд ашиг сонирхол болон эд хөрөнгийн ашиг сонирхолд хохиролгүйг

²⁴ Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж 2017 он (15);

²⁵ Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.4 дэх заалт.

	байгаа нь хүүхдийн өмчийн эрхийг ноцтой зөрчиж байна. Иргэний хуульд эд хөрөнгийн эрхийн харилцаанд хүүхдийг төлөөлөн түүний нэрийн өмнөөс хууль ёсны төлөөлөгч нь хэлцэл хийхээр заасан төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй хэмээн хуульчилсан. Гэвч хүүхдийн эд хөрөнгийг түүний нэрийн өмнөөс захиран зарцуулах хууль ёсны төлөөлөгчийн хийх гэрээ, хэлцэл нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцэж байгаа эсэхийг хэн, хэрхэн тогтоох тодорхой зохицуулалт, практик бүрдээгүй байна.	нотлон Нийгмийн хамгааллын төвөөс зохих зөвшөөрөл авдаг байна.²⁶ - Энэхүү зөвшөөрлийн тогтолцоо нь хүүхдийн өмчийн эрхийг хамгаалахад ямар чухал ач холбогдолтой болохыг Европын Хүний эрхийн шүүхээс 2015 онд гаргасан S.L. and J.L. v. Croatia (no. 13712/11)²⁷ хэргийн шийдвэрээс тодорхой харах боломжтой. Иймээс хүүхдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах тусгайлсан зохицуулалтыг Иргэний хуульд хуульчлахын зэрэгцээ хүүхдийн эд хөрөнгийн эрхийг гэрээ, хэлцлийн харилцаанд хэрхэн хамгаалах талаар нотариат, эд хөрөнгийн эрхийн улсын байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай. - Хүүхэд эцэг, эхийн эд хөрөнгийг, эцэг, эх нь хүүхдийн эд хөрөнгийг хязгаартайгаар буюу узуфруктаар ашиглах талаар Иргэний хуульд тодорхой зохицуулах тусгах замаар хүүхдийн эд хөрөнгийг эрх, ашгийг хамгаалах шаардлагатай.
8.	Хурдан морь унаач хүүхэд. Хурдан морины уралдаан нь Монголын ард түмний төрт ёсны өв соёлын үнэт баяр цэнгээн байх уламжлалт хэв маягаасаа нэлээд хэлбийж улс төрчид, бизнес эрхлэгчдийн хувийн ашиг сонирхолтой холбоотой болжээ.²⁸ Морин уралдаан нь хэдийгээр үндэсний өв соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг хэдий ч ялангуяа, өвөл, хаврын улиралд морин уралдаан зохиож байгаа нь хүүхдийн амь нас, эрүүл мэнд, боловсролд сөргөөр нөлөөлөхүйц хүүхдийн аюултай хүнд хэлбэр болохыг хэд хэдэн судалгаанд дурджээ.²⁹ 2006 онд ХЭҮК-ын хурдан морь унаач	Унаач хүүхдийн эрхийг хамгаалахын тулд цаашид: - Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх. Тухайлбал, хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн, амь насаа алдсан хүүхдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох шаардлагатай. Үндэсний их баяр наадмын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд унаач хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалсан хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчлаагүйг цаашид анхаарах шаардлагатай. - Унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр батлан гарсан хууль, тогтоомжийг бүрэн, үр

²⁶ <https://www.legalline.ca/legal-answers/do-parents-have-the-right-to-make-decisions-about-their-childrens-property/?fbclid=IwAR0UUhAKFcJlvPuwt3NkG1qRDMQmlKsVru9EZ71JR7wR1fKn45R-tyFw014>

²⁷ https://www.echr.coe.int/documents/fs_childrens_eng.pdf?fbclid=IwAR0_V8jnadhY1A-Cc4G-VJ4hJzC363dBoXv8UEKIF7AUuxFEGEkC-FXZWg

²⁸ Хүний Эрхийн Үндэсний Комисс, “Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны удирдамж тайлан” 2006 он, 42.

²⁹ Хүний Эрхийн Үндэсний Комисс, Эрх зүйн судалгааны төв, Монголын Хуульчдын Холбоо, ОУХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, “Хурдан морины хаврын уралдаан ба Хүүхдийн эрх” 2016 он.

хүүхдийн эрхийн талаарх тойм судалгааг анх хийж байжээ. Уг судалгаанд хурдан морь унуулах нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэл дагуулж байдаг, ийм эрсдэл тогтмол гарч байгааг дурдаад хүүхдээр хурдан морь унуулахыг аль болох хязгаарлах, унуулсан тохиолдолд эрсдэлээс хамгаалах арга хэмжээг сайтар зохион байгуулах, эрсдэл гарсан тохиолдолд эрүүл мэндийг нь бүрэн сэргээх оновчтой механизм бий болгох шаардлагатай³⁰ хэмээн дүгнэж байжээ. Үүнээс хойш ХЭҮК-ын хэд хэдэн тайланд хурдан морь унаач хүүхдийн эрхийн зөрчлийн талаар онцлон тусгажээ. 1996-2019 онд хурдан морины уралдааны явцад нийт 40 хүүхэд амь насаа алдсан бол зөвхөн 2018 онд 491 уралдаан болж 11328 хүүхэд унаж уралдсанаас 661 хүүхэд мориноос унаж, 98 хүүхэд бэртэж гэмтсэнээс хоёр нь хөгжлийн бэрхшээлтэй болж, нэг хүүхэд амиа алджээ.³¹ Харин 2019 онд улсын хэмжээнд уралдааны мориноос 172 хүүхэд унасан бол 2020 онд энэ тоо 896 болтлоо өсжээ. Унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд зарим ахиц, өөрчлөлт гарч байгаа³² хэдий ч хууль, тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг олон тайлан, судалгаанд онцолжээ. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол	дүнтэй хэрэгжүүлэх, хяналт, дүн шинжилгээ тогтмол хийх, хууль, тогтоомж зөрчсөн холбогдох гэмт буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой хуульчлах шаардлагатай. Тухайлбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол болон холбогдох бусад стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хянан шалгаж, дүн шинжилгээ хийх шаардлагатай. - Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т Баяр наадмын хурдан морийг 7-оос дээш насны хүүхэд унахаар хуульчилсан хэдий ч дээрх насны хязгаарлалт нь зөвхөн Үндэсний баяр наадмын морины уралдаанд үйлчлэхээр байгааг цаашид анхаарч Хүүхдийн эрхийн тухай хууль гэх зэрэг нийтлэг үйлчлэлтэй хуульд уралдааны морь унах насны доод хязгаарыг хуульчлах шаардлагатай. - Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т Баяр наадмын хурдан морийг 7-оос дээш насны хүүхэд унахаар хуульчилсан хэдий ч дээрх насны хязгаарлалт нь зөвхөн Үндэсний баяр наадмын морины уралдаанд үйлчлэхээр байна. Иймд Хүүхдийн эрхийн тухай хууль гэх зэрэг нийтлэг үйлчлэлтэй хуулиар бүсийн, даншиг зэрэг хурдан морины уралдаан тэмцээнд унаач хүүхдийн насны доод хязгаарыг Үндэсний баяр наадмын тухай хуулиас нэмэгдүүлэн тогтоох, эсхүл бүр мөсөн хориглох. - Бооцоот бүх төрлийн уралдаанд хүүхдийг морь унуулахыг хориглож, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх үр нөлөөтэй хариуцлагыг бий болгох нь зайлшгүй бөгөөд Монголын ард түмний төрт ёсны өв соёлын агуулгатай зөрчилдөхгүй хэмээн үзлээ. - Хурдан морь унаач хүүхдэд зөвхөн насаар нь шалгуур тогтоож байгааг өөрчилж биеийн жин, өндрийн хэмжээ зэргийг харгалзан үзэх. Тухайлбал, Баяр наадмын хурдан морийг 12-оос дээш насны, эрэгтэй бол 38 кг, 130 см, эмэгтэй бол 34 кг жинтэй, 132 см өндөртэй хүүхэд унаж
---	--

³⁰ ХЭҮК, Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны удирдамж тайлан, (2006),

18. https://nhrcm.gov.mn/media/documents/1431397991_2006-hurdan-mor-unaach-hhldiyn-erhiyn-he.pdf

³¹ <https://mlsp.gov.mn/content/detail/450>

³² Тухайлбал, Засгийн газрын “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 57 тоот тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон бөгөөд дээрх үйдлийг Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-д оруулжээ.

Улсын тавдугаар тайлан, илтгэлд хурдан морь унаач хүүхдийг ослын хариуцлагын даатгалд бүрэн хамруулдаггүй, урамшууллыг бүрэн олгодоггүй, унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, хэрэгслээр бүрэн хангадаггүй зэрэг нийтлэг зөрчил байгааг онцолсон³³ бөгөөд хуульд зааснаас доош насны хүүхдийг хурдан морины уралдаанд морь унуулсан зэрэг зөрчил цөөнгүй гарч байгааг зарим судалгаанд онцолжээ. НҮБ-ын Монгол Улс дахь удирдлагын баг НҮБ-ын Хүний эрхийн шинжээчдээс ирүүлсэн удаа дараагийн ажиглалт, зөвлөмжид үндэслэн 2019 оны 12 дугаар сарын 20-нд мэдэгдэл гаргасан бөгөөд мөн оны 12 дугаар сарын 23-нд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргад албан захидал илгээж байжээ. Уг мэдэгдэл, албан захидалд хурдан морины уралдаан нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул учруулдгийг санан 18 наснаас доош хүүхдийг жилийн аль ч улиралд хурдан морь унуулж уралдуулахгүй байхыг хууль тогтоомж, зохион байгуулалтын үйл ажиллагаанд тусган нэн яаралтай хэрэгжүүлэхийг мэдэгджээ.³⁴ Хүний эрх болон хүүхдийн эрхийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, хүний эрхийн хамгаалагчдын олон жилийн	уралдах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байх гэх мэт.
--	--

³³ Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан, 160-166.

³⁴ НҮБ Монгол Улс, Хурдан морь унаач хүүхдүүдийн талаар НҮБ-ын Монгол Улс дахь удирдлагын багийн мэдэгдэл, <https://mongolia.un.org/mn/134277-khurdan-mor-unaach-khuukhduudin-talaar-nub-yn-mongol-uls-dakh-udirdlagyn-bagiyn-medegdel>

	хичээл зүтгэлийн үр дүнд Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд зарим ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний сүлжээ, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ, Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний зөвлөл зэрэг байгууллагын Монгол Улсын Засгийн газрын эсрэг Захиргааны хэргийн шүүхэд өдүүлсэн хэрэг маргааны үр дүнд Засгийн газар 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолыг баталж Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хоригложээ.	
9.	Гомдол гаргах эрхийн хэрэгжилт: Хүүхдийн эрхийн өргөн хүрээний зөрчилтэй тэмцэх чухал механизмын нэг нь хүүхдийн гомдол гаргах эрхийг бодитоор хангаж, өргөдөл, гомдлыг үр нөлөөтэй шийдвэрлэх явдал юм. Хүүхдийн эрхийн хорооноос хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, гомдол хүлээж авах механизмыг бүрдүүлэх, хүүхдийг өөрсдийг нь гомдол гаргах эрхтэй, чадвартай болгох талаар шаардлагатай арга хэмжээ авахыг Монгол улсад зөвлөсөн. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.4-т хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлд	Цаашид төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагад гаргасан хүүхдийн гомдол, түүнийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаарх практик иж бүрэн дүн шинжилгээ хийж, хүүхдээс төрийн зохих байгууллагад өргөдөл, гомдол гаргах журмыг хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчимд нийцүүлэн хүртээмжтэй, ойлгомжтой болгох шаардлагатай

	насанд хүрээгүй буюу 14-өөс 18 хүртэлх насны иргэн өөрийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлоо шүүхэд хамгаалах эрхтэй хэмээн хуульчилсан хэдий ч насанд хүрээгүй хүүхдүүдэд өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитоор дэмжлэг, туслалцаа үзүүлэх тухайлбал, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, хариу мэдэгдэх онцгой журам байхгүй, шаардлагатай тохиолдолд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлдэггүй зэрэг нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулах гомдол гаргах хүүхдийн эрх бодитоор хэрэгжихэд нөлөөлж байна.	
10.	Хүүхдийн амралт, чөлөөт цаг, зугаа цэнгэл, соёл, урлагийн арга хэмжээ Хүүхдийн нас, сэтгэцийн онцлогт тохирсон соёл, урлаг, амралт, чөлөөт цагийн арга хэмжээг явуулах газар, боломжууд дутагдаж байгаад НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо санаа зовниж байгаагаа илэрхийлсээр байна. Ялангуяа, нийгэм, эдийн засгийн эмзэг бүлгийн хүүхдүүд, төв суурин газраас алслагдсан болон орон нутагт амьдарч буй хүүхдүүдэд энэ төрлийн хэрэгцээг хүртээмжтэй, хүрэлцээтэй хангахад чиглэсэн нийтээр үнэ төлбөргүй ашиглах хөгжих чөлөөт орчин бүхий байгууламж, үйл ажиллагаа, арга хэмжээ маш дутмаг, хангалтгүй байна.	Энэ асуудлаар төр болон орон нутгийн байгууллагаас тусгайлсан бодлого хэрэгжүүлэх
11.	Эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон хүүхэд. Улсын хэмжээнд 2020 онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэрэг 811 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс	Үүний тулд: - Хүүхэд холбогдсон болон хохирогч болсон эрүүгийн болон зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийн тогтолцоог бий болгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.

	257 хэргээр буюу 24,1 хувиар буурчээ. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэм хэргийн 631 буюу 77,8 хувийг хөнгөн, 180 буюу 22,2 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн 68,8 хувь нь Улаанбаатар хотод, 31,2 хувь нь орон нутагт тус тус бүртгэгдсэн. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэхдээ Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг сайтар хэрэгжүүлэх шаардлагатай байна.	Тухайлбал, ердийн эрүүгийн хэргийн шүүхэд дагнасан шүүгчийг бий олгох, эсхүл дагнасан танхим байгуулах, эсхүл Улаанбаатар хотод хүүхдийн эрүүгийн болон зөрчлийг хэргийг шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулах - Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар зохицуулалтыг бий болгох - Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар нарийвчилсан зохицуулалтыг бий болгох - Мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө буюу сэжигтнээр тооцогдохоос өмнө хийгдэх хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцуулах, хувийн байдлыг тогтоох ажиллагааны явцад насанд хүрээгүй хүүхдийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалтыг бий болгох Хүүхдээс “гэрч” гэж мэдүүлэг авдаг байдлыг таслан зогсоох. Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагаанд зөвхөн “хууль ёсны төлөөлөгч”-өөр дамжуулан оролцохоор байгааг өөрчлөх, хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй, хүүхдийг хамгаалах боломжгүй хууль ёсны төлөөлөгчийн оронд хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжтой бусад субъект оролцох бололцоог бий болгох
12	Эрүүгийн гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хууль тогтоомжийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.	- Хохирогч, холбогдогч эмэгтэй болон эрэгтэй хүүхдээс /ялангуяа хүчингийн гэмт хэргийн үед/ мэдүүлэг авах ажиллагааг зайлшгүй ижил хүйсийн алба хаагчаар гүйцэтгүүлэх, энэ чиглэлийн хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх - Хохирогч хүүхдийн “хууль ёсны төлөөлөгч”-өөр зөвхөн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилохоос гадна хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадах сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын алба хаагчийг томилох эрх зүйн зохицуулалтыг бий болгох - Хохирогч хүүхдийг зайлшгүй хууль зүйн туслалцаагаар хангаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгдөг байх талаар хуульд тусгайлан хуульчлах Хохирогч хүүхдийг хамгаалах тогтолцоог зөвхөн “түр хамгаалах байр” гэдгээр хязгаарлах бус хүүхдийн тав тухтай, айдасгүй байх бүхий л бололцоог хангаж, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг тусгаарлах арга хэмжээ авдаг байх эрх

		зүйн орчныг бий болгох
Цаашид шийдвэрлэх нийтлэг асуудал		
13.	Мэдээлэл цуглуулах тогтолцоог сайжруулах.	Хүүхдийн эрх хамгааллын чиглэлийн хууль тогтоомж, бодлого, стратегийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхэд хүүхдийн талаарх үндсэн суурь мэдээлэл, ялангуяа нийгмийн эмзэг, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх иж бүрэн, үнэн зөв мэдээллийн тогтолцоог бий болгож, тогтмол шинэчлэл хийж холбогдох байгууллагууд нэг эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа төлөвлөх, зохион байгуулах шаардлагатай. Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжид энэ талаар тодорхой тусгасан. ³⁵
14.	Санхүү, нөөцийн тогтвортой хөрөнгө оруулалт	Хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан хууль, тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийн хуваарилалтын тогтвортой байдлыг хангах, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулсан төсвийн задаргааг тусгайлан тогтоож эдийн засгийн тогтворгүй байдал, байгалийн гамшиг болон онцгой нөхцөл байдлын үед тэрхүү төсөв, хөрөнгө оруулалтыг танахгүй байх баталгааг хуульчлах шаардлагатай. ³⁶ Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах
15.	Хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэх	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хүүхдийн эрхийн болон нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг гэх зэрэг байгууллагын үйлчилгээ чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний нөөц болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, мэргэжилтнүүдийг байнга чадавхжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
16.	Хүүхдийн эрхийн байцаагч –	Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн

³⁵ Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Тавдугаар тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж 2010 он (10); Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж 2017 он (19); Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт протоколын 12(1) дүгээр зүйлийн дагуу гишүүн орны өргөн барьсан анхдугаар тайлангийн зөвлөмж 2010 он, (6-7).

³⁶ Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөвдүгээр илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмж 2017 он (8-9).

	Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, мэдээлэл хүлээн авах, шалгах, хүүхдийн эсрэг зөрчлийг шалган шийдвэрлэхэд Хүүхдийн эрхийн улсын байцаагч чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч Монгол Улсын нийт хүн амын 15.1 хувь буюу 1 сая гаруй хүүхдэд 70 орчим³⁷ Хүүхдийн эрхийн улсын байцаагч (эдгээрээс нэлээд хувийг удирдах албан тушаалтан эзэлдэг) ажиллаж байгаа нь маш хангалтгүй бөгөөд үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг бууруулж, хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.	үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор орон тоог орон нутгийн хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тархалт, хүүхдийн эрхийн зөрчлийн нөхцөл байдал зэргийг харгалзан нэмэгдүүлэх шаардлагатай. Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, орон нутгийн ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн ажилтан, улсын байцаагч гэсэн албан тушаалын чиг үүргийг нарийвчлах, мэргэжлийн хүнийг тогтвортой ажиллуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын ажилтны эрүүл мэнд, сэтгэл зүйг хамгаалахын зэрэгцээ хүүхдийн эрхийг хангах ажлын байрны шаардлагын дагуу тасралтгүй сургаж, мэргэшүүлэх, урамшуулж дэмжих, нийгмийн хамгааллыг нь сайжруулах шаардлагатай.
17.	Хүүхдийн нийгмийн ажилтан: 2021 оны байдлаар улсын хэмжээнд 3188 нийгмийн ажилтан ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, сум хороо, халамж, хорих газар, эмнэлэг, хүүхдийн хамгааллын салбар ажилладаг ч тэдний 56 хувь нь мэргэжлийн бус байна.³⁸ Боловсрол, эрүүл мэндийн салбарын анхан шатанд ажиллаж буй сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын 73-аас 85 хувь нь мэргэжлийн нийгмийн ажилтан бол нийгмийн хамгаалал, халамж шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хүүхэд, залуучуудад нийгмийн ажлын	Иймд хуульч, эмч, багштай адил хүний амьдралд нөлөөлдөг, өндөр ёс зүй мэргэжилтэнд тооцдог нийгмийн ажилтны хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс Нийгмийн ажлын тухай хуулийг боловсруулан батлах шаардлагатай.

³⁷ Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглалын тайлан, (2021.09.), 34.

³⁸ Х.Өлзийтунгалаг, Монголын нийгмийн ажлын боловсролын тогтолцоо, хөгжил сэдэвт илтгэл, (2021). хэвлэгдээгүй

үйлчилгээ үзүүлдэг сум хороо, халамж, хорих анги, мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв, хүүхэд хамгааллын салбарын нийгмийн ажилтнуудын 50-иас 80 хувь нийгмийн ажлын мэргэжлийн боловсрол эзэмшээгүй ч нийгмийн ажилтны орон тоон дээр ажиллаж байна.^{39, 40} Нийгмийн ажлын үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахад анхан шатанд ажиллаж буй нийгмийн ажилтны мэргэжлээрээ өсөж дэвших, мэргэжлийн удирдлагаар хангагдах боломж нөхцөл, нөгөө талаас мэргэжлийн үйл ажиллагааг удирдах зохион байгуулах бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт чухал нөлөөтэй. Гэвч төрийн анхан шатанд ажиллаж буй нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах дунд шатны мэргэжилтнүүдийн дийлэнх нь мэргэжлийн бус, улс төрийн нөлөө томилгооны улмаас нийгмийн ажилтны ажлын байр тогтворгүй, мэргэжлийн удирдлага хангалтгүйтэй зэрэгцээд ажиллах орчин хийгээд нийгмийн хамгаалал баталгаа сул байна. Эдгээр шалтгааны улмаас сургаж бэлтгэгдсэн нийгмийн ажилтан байнга солигддог, нийгмийн ажилтан нь ахлах, удирдах ажилтнаасаа мэргэжил арга зүйн дэмжлэг авч чаддаггүй, үйлчлүүлэгчтэй уулзаж ярилцах өрөө тасалгаа байдаггүй, үйлчилгээний зардал, төсөв байхгүй, хөдөлмөрийн үнэлэмж бага,	
---	--

³⁹ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сургалт, судалгаа, мэдээллийн төв, Төсвийн зарим байгууллагын нийгмийн ажилтнуудын ажлын туршлага, сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа, (2019). Албан хэрэгцээнд.

⁴⁰ Х.Өлзийтунгалаг, (2021). Монголын нийгмийн ажлын боловсролын тогтолцоо, хөгжил сэдэвт илтгэл

хүчирхийлэл, зөрчил үйлдэгчийн заналхийлэл зэрэг хүндрэл бэрхшээлтэй байнга тулгардаг, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл буурахгүй, аюулгүй байдлыг бүрэн хангаагүй байгаа нь тэдний үйлчилгээний чанар хүртээмжид муугаар нөлөөлж байна.⁴¹	
--	--

Хавсралт №2. Хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаанаас хэсэгчлэв

Улаанбаатар хот болон аймаг, орон нутагт хүүхдийн тоглоомын талбай барихдаа стандарт хангаагүй байх нь элбэг байдаг бөгөөд тоглоомын талбайн бэхэлгээ муу хийснээс тоглож байсан хүүхдийн дээрээс унаж, амь насыг нь хохироосон тохиолдол байдаг.

Хэдэн жилийн өмнө хөл бөмбөгийн талбай дээр тоглож байсан хүүхэд хаалганд нь даруулж нас барсан. Тэр үйл явдал хэдэн сарын турш нийгмийг цочроосон хэр нь одоо энэ асуудал хаягдсан. Дахин тийм асуудал үүсэх эрсдэл байсаар байна. Манай байрны гадаа баригдаж байгаа хөл бөмбөг, тоглоомын бэхэлгээг шалгаж үзэхээр бэхэлгээ нь муу байсан. Энэ мэтээр хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Эцэг, эхийн анхаарал сул байна.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-24 настай, Бакалаврын зэрэгтэй, эмэгтэй

Улсын цэцэрлэгийн хүрэлцээгүй, хүртээмжгүй, ерөнхий боловсролын сургуулийн боловсролын чанарын ялгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэг бүрд ээлтэй гэрт нь ойр сургууль болон сургуулиас гадуур хөгжих сургалтын төвийн хүрэлцээгүй байдал, хүүхдийн эцэг, эхийн эдийн засгийн чадамжгүй байдал, КОВИД-19-ийн үеийн нөхцөл байдал нь хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна. Тодруулбал

- Улсын сургууль, цэцэрлэгт хүүхэд оруулахдаа авлига өгдөг бөгөөд эдийн засгийн чадамжгүй гэр бүлийн хүүхэд бол бүх шатны улсын сургалтын байгууллагад суралцах боломжгүй байдал үүсдэг, хавчигддаг;

- Аймаг, орон нутаг, алслагдсан дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль байдаггүй, нөгөө талаар эцэг эхчүүд нь суралцах чадваргүйд тооцож, цэцэрлэг, сургуульд хамруулдаггүй;

- Хүүхдийн чөлөөт цаг өнгөрөөх газар, хичээлээс гадуурх сургалтын төвийн хүртээмж бага, эдийн засгийн чадамжгүй өрхийн хүүхэд хамрагдах нөхцөл бүрдээгүй;

- Сүүлийн 2 жилд КОВИД-19 халдварын улмаас хөл хорио тогтоож, цэцэрлэг, сургуулийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлсэн ч хичээл чанартай бус, бүх хүүхэд тэгш байдлаар сургалтад хамрагдах хязгаарлагдмал байдал үүссэн тул сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байдалд хүргэж байна.

⁴¹ Монгол Улсын Их Сургууль, Японы Хүүхдийг ивээх сан. (2018). *Хамтарсан багийн өнөөгийн байдал: Суурь судалгааны тайлан*. УБ: Японы Хүүхдийг ивээх сан; UNICEF & GSSWA. (2019). *Guidelines to strengthen the social service workforce for child protection*. NY: UNICEF; Апланд, К., Хамилтон, К., Бурке., & Арнадт, Ж. (2021). *Үнэлгээний тайлан: Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ*. Лондон: Корам интернейшнл & UNICEF.

Нөгөө талаар авлигаас ангид байх, үүгээр дамжуулан нийгэм, эдийн засгийн шинжтэй эрхээ эдлэхэд эерэг таатай нөхцөл бүрдэх боломжтойг оролцогчдын ярилцлагаас цохон тэмдэглэх боломжтой. Эдийн засгийн тэгш бус байдлаас үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, хавчлага, хүчирхийлэл улам гаарч байгааг фокус бүлгийн ярилцлагад хот, хөдөө үл хамааран онцгойлон дурдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Бүх нийтийн үнэ төлбөргүй, чанартай боловсрол эзэмших эрх нь өргөн хүрээтэй ч төрийн зүгээс явцуу байдлаар анхаардаг, хууль тогтоомжоо хэрэгжүүлдэг туршлага байгаа эсэхийг нарийвчлан судалж болох юм.

Сурч боловсрох эрх зөрчигдсөн тохиолдол

Сурч боловсрох эрхтэй гэсэн мөртлөө сургууль цэцэрлэгт оруулахад заавал хахууль өгдөг. Багшид нь бас мөнгө өгч гарыг нь цайлгаж байж гайгүй ханддаг.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 18-24 настай, Бүрэн дунд боловсролтой, эмэгтэй

Сургуульд сурах эрхтэй гэдэг хэр нь мөнгөгүй шалтгаанаар төлбөрөө төлөхгүй бол онц сурдаг байсан ч сургууль хөөдөг.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 50-аас дээш настай, Тусгай дунд боловсролтой, эмэгтэй

Аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн сургууль байхгүй тул энгийн хүүхдүүдтэй нэг ангид оруулдаг. Багш сурагчдын хичээлийн үнэлгээгээр урамшуулал цалин авдаг тул хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дүнгээс болж цалин бага авдаг. Тиймээс багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ангидаа авахаас их цааргалдаг.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 30-39 настай, Бакалаврын зэрэгтэй, эмэгтэй

Хүүхдүүдийг чөлөөт цагаар нь спорт, секц дугуйланд явуулъя гэхээр байхгүй байна. Заалны төлбөр нь цагийн 30000 төгрөг байдаг. Тэгсэн хэр нь байрны гаднах сагсны талбайд сагс тоглолоо гэж цагдаа баривчилсан.

Дархан-Уул аймаг, Дархан сум, 50-аас дээш настай, Бүрэн дунд боловсролтой, эрэгтэй

Коронагаас болж сурч боловсрох боломж зөрчигдөж байна

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-24 настай, Бакалаврын зэрэгтэй, эмэгтэй

Хавсралт №3. Хүүхэд хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн саналаас хавсаргав.

2022 ОНЫ 05 САРЫН 12 –НИЙ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛСАН
“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ”
БОЛОН 2022 ОНЫ 05 САРЫН 26-НЫ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛСАН “ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ”
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕД ГАРСАН СУДЛААЧ, ОРОЛЦОГЧДЫН САНАЛ

Тус хоёр хэлэлцүүлгийн оролцогчдын санал, өмнө хийгдсэн судалгааны үр дүнд тулгуурлан хэлэлцэж гарсан саналыг нэгтгэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Хүүхэд хамгааллын тогтолцоо, удирдлага зохион байгуулалтын хүрээнд

1. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол аливаа хэлбэрээр хөндөгдөж буй иргэн, захиргаа, эрүүгийн хэрэг маргааны тоо, хүүхдийн тоо, хүйс, нас зэрэг шаардлагатай мэдээлэл агуулсан статистик мэдээг бүрэн гаргадаг болох

2. Гэр бүл нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллын хүрээнд

1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагаа сул. ИХТХШтХ 129-р зүйлийн зохицуулалтыг хүүхдийн эрхийг хамгаалахад түлхүү хэрэглэх, хэргийн ажиллагааны явцад хүүхдийг эцэг, эхтэй нь уулзуулах, эсвэл уулзуулахгүй байх талаар арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргах

2. Худал мэдүүлэг өгөх эсвэл хэрэгт ач холбогдол бүхий зүйлийг мэдүүлэхээс татгалзаж байгаагаа бүрэн ухамсарлаж, үүнийг хүссэн, 16 насанд хүрсэн гэрч, хохирогч худал мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах нь гэмт хэргийн субъект болохоор заасан байгааг өөрчлөх

3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шууд болон дам байдлаар хүүхдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах, оролцогчдын хувийн байдлыг сайтар тогтоох, оролцогч нарт авсан аливаа арга хэмжээ, хязгаарлалтын улмаас хүүхдийн эрх зөрчигдөж болзошгүй байдлыг зайлшгүй харгалзан үзэх

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хамтын ажиллагаа сул. ИХТХШтХ 129-р зүйлийн зохицуулалтыг хүүхдийн эрхийг хамгаалахад түлхүү хэрэглэх, хэргийн ажиллагааны явцад хүүхдийг эцэг, эхтэй нь уулзуулах, эсвэл уулзуулахгүй байх талаар арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргах

5. Насанд хүрээгүй хүнд Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдолд насанд хүрэгч нартай яг адил нөхцөл, орчинд хорьж байгааг өөрчлөх

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Хүүхдэд оногдуулсан нийтэд тустай ажил хийлгэх ялыг эдлүүлэхэд хүүхдэд зориулсан ажил, түүнд тавигдах тусгай шаардлагын талаар тодорхойлоогүй, насанд хүрэгчтэй адил ажил хийдэг зөрчлийг даруй арилгах. Тухайлбал өвөл гадаа цас цэвэрлэх зэрэг хүйтэн, хүнд орчин нөхцөлд нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлж байгааг өөрчлөх.

7. Хүүхдэд “зорчих эрхийг хязгаарлах” ял эдлүүлэх тохиолдолд хэрхэн зохицуулах, насанд хүрэгчдээс ялгаатай, хөнгөвчилсөн нөхцөлөөр хангах эсэх талаар нарийвчлан зохицуулах

8. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагаа бүрд бүрэн хамгаалж чаддаггүй бөгөөд зарим процесст хүүхэд оролцох тохиолдолд хэрхэн эрхийг нь хамгаалах нь тодорхойгүй байгааг өөрчлөх

3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд

1. Хамтын амьдралтай байсан хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд дундын эд хөрөнгөнөөс өмчлөх, эзэмших эрхтэй байх, тусдаа амьдрах тохиолдолд хүүхдэд ногдох хэсгийг гаргуулах боломжтой байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

2. Хууль ёсоор өв залгамжлах харилцаан дах дагавар хүүхдийн эрхийг хангах талаар Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

3. Гэр бүлийн хүчирхийлэл болон Хүүхдийн эрхийг зөрчсөнтэй холбоотой дуудлага мэдээллийн дагуу газар дээр нь очиж ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдын энгэрийн камерын бичлэгийг бэхжүүлж, дуу-дүрсний бичлэгт үзлэг хийж тэмдэглэл хөтлөн материалд хавсаргах,

4. Хэргийн газарт очсон алба хаагчдын илтгэх хуудсанд эрх зөрчигдсөн хүүхдүүдийн талаарх мэдээллийг нас, хүйс, нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй тусгадаг болох

5. Хүүхэд дам байдлаар эрүү болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хохирч байгаа байдлыг өөрчлөх, тухайлбал: хүүхдийг хамтад нь удаан хугацааны туршид машинд хол зайд авч явсан, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүн хүүхдээрээ орчуулга хийлгэсэн, 2 сартай эхийг цагдан хорьсон зэрэг хүнлэг бус хүүхдэд ээлгүй ажиллаж байгаа нөхцөл байдлыг өөрчлөх

4. Хүүхэд хамгааллын кейс менежментийн хүрээнд

1. Хүүхдийн саналыг эцэг, эхэд аль болох үзүүлэхгүй байх, нууцлах талаар тусгайлан зохицуулах, Хүүхдийн санал асуух өрөө, орчин нөхцөлийг сайжруулах,
2. Биечлэн болон оршин байгаа газрыг шилжүүлэх хамгаалалтыг хүүхэд дээр хэрхэн авах, хэр оновчтой талаар судлах, энэ төрлийн аргыг хүүхдэд аюулгүй, нөхцөл байдлыг дордуулахгүй байдлаар хэрэглэх
3. Цагдаагийн байгууллагад дуудлага, мэдээлэл өгсөн хүний нэр, байршлыг нууцалдаг байх,
4. Хохирогч хүүхдийн нөхөн сэргээх үйлчилгээг урт хугацааны мөн хохирогчид ээлтэй байлгах нөхцөлийг сайжруулах
5. Хүүхдийг гэр бүлээс гадуур тусгаарлах зохицуулалтыг дэлгэрэнгүй тусгах

5. Хамтын шинжилгээ үнэлгээ санхүүжилтийн хүрээнд

1. Хүүхдийн санал асуух ажиллагаанд багш, нийгмийн ажилтан эсвэл сэтгэл зүйчийг оролцуулах, зардлыг шүүхийн төсвөөс гаргадаг болох

---oOo---

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛ

Хугацаа: 2022 оны 3 сарын 18

Санал ирүүлсэн байгууллага: НҮБ-ын Хүүхдийн сан, Японы Хүүхдийг Ивээх сан, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Норвегийн тусламжийн байгууллага, Дэлхийн зөн Монгол ОУБ, Холт олон улсын байгууллага, Гүүд Нейборс Монгол ОУБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар;

№	Ирсэн санал	Саналыг тусгасан байдал
1.	1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, Хүүхдийн эрхийн конвенцтой нийцүүлэх. Улс хооронд Монгол Улсын харьяат хүүхдийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд энэ хууль болон бусад хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох. 2. Хүүхдийн эрхийн тухай хуулиар 18 нас хүртэлх насны хүнийг хүүхэд гэнэ гэж заасан. Өөрийгөө бүрэн хамгаалах, аливаа асуудлыг илэрхийлэх чадамжгүй, хөгжлийн тулгамдсан асуудалтай, нийгмийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай хүнд 21 нас хүртэл нь хамгааллын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байдаг. Хуульд тодорхой тусгах.	1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр түр болон байнга оршин сууж байгаа хүүхэд Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хуулийн үйлчлэлд хамаарна. 2. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд энэ хууль үйлчилнэ. 3. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18-аас 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно. 4. Үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах талаар Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулаагүй бусад харилцааг энэ хуулиар зохицуулна. гэж өргөжүүлэв.
2.	1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хэсэгт Салбар дундын зохицуулалтыг хангах үүднээс хамааруулах шаардлагатай хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бүх байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, Хуулийн этгээдийг оролцуулах шаардлагатай (хууль шүүх, боловсрол, эрүүл мэндийн байгууллага гэх мэтээр оруулах)	1. Хуулийн төсөлд Хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлсэн. 2. Хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлд “”4. Аж ахуйн нэгж, байгууллага нь дотооддоо хэрэгжүүлэх байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.” гэж заав. 3. Хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хуульд шинээр тусгасан. 4. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллын талаар илүү тодорхой болгож хуульд тусгасан.
3.	1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт “хүүхэд хамгаалал” энэ нэр томьёо нь урьдчилан сэргийлэх гэсэн ойлголтыг агуулж байдаг. НҮБ болон бусад олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенцын тодорхойлолтуудыг харж үзэх	1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгт шаардлагатай Хуулийн нэр томьёоны тодорхойлолтыг бүрэн тусгав.

	Хүүхэд хамгааллын үндсэн нэр томъёог нэмэлтээр оруулж өгөх. Үүнд: Хүүхдийн хамгааллын тогтолцоо гэж ... Бэлгийн хүчирхийлэл гэж... Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр гэж... Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл гэж... Бэлгийн мөлжлөг гэж... Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл гэж... Нийгмийн ажлын үйлчилгээ гэж... Шуурхай тусламжийн үйлчилгээ гэж... Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ гэж... Урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэж... Хүүхэд хамгааллын бодлого гэж ... Хүүхэд хамгааллын кейс менежмент гэж... Мэргэжлийн удирдлага гэж... Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм гэж ... Хүүхэд хамгааллын төсөв гэж... Хүүхэд хамгааллын хүний нөөц гэж ... Хүүхэд хамгааллын байгууллага гэж... Нийгмийн орчин гэж... Хүүхдийн аюулгүй байдал гэж... Хүүхдэд ээлтэй гэж... Хохирогч төвтэй хандлага гэж...	Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо 1. 1.Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ. 2.Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно. 3.Төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгааллыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэгтэй. гэж тусгав. Нэр заан оруулах шаардлагагүй гэж үзсэн болно. 2. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал, Гамшиг онцгой нөхцөл байдлын үе дэх хүүхэд хамгааллын зохицуулалтыг шинээр тусгасан. Гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл цахим орчин, жагсаал цуглааны үе дэх хүүхэд хамгааллын зохицуулалтыг илүү боловсронгуй болгон шинэчилсэн.
4.	1.6 дугаар зүйл. Хүүхэд хамгаалал. Хүүхэд хамгааллын тогтолцоо нь салбар дундын болон хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжих бөгөөд дараах хэсгээс бүрдэнэ: Эдгээр байгууллагуудыг нэр заан оруулах шаардлагатай. Хүүхэд хамгаалал, Эрүүл мэнд, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Шүүх, прокурор, Нутгийн захиргааны байгууллага, Цагдаа, Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс/	

5.	2. Хүүхэд ихэвчлэн гэр бүлийн, хөдөө аж ахуйн, жижиг гэх мэт албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг бөгөөд албан бус салбарт ажлын байр нь тогтмол бус, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа сул, хязгаарлагдмал эрх чөлөө, хөдөлмөрийн мөлжлөг, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал их. Албан бус салбарт ажилладаг эцэг эх урт цагаар ажилладаг учир хүүхдэдээ тавих анхаарал халамж тавих боломж бага. Тиймээс гишүүн орон нь бизнесийн үйл ажиллагаа нь хэмжээ, салбараас үл хамааран хүүхдийн эрхийн хүндэтгэж, хангаж ажиллаж байгааг баталгаажуулна. Ингэхдээ хүүхдийн эрхийг таниулах, албан бус салбар, хөдөлмөр эрхлэлтийн хүүхдийн эрхэд үзүүлэх нөлөөллийг судалж, гарсан үр дүнг хууль тогтоомжид тусгаж ажиллана. Мөн хөдөлмөр эрхэлж буй эцэг, эхийн ажлын цагийн хязгаарлалт, эмзэг бүлгийн эрхийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах, мэргэжил үр чадвар олгох, хүртээмжтэй, үр дүнтэй зээл болон банкны үйлчилгээг нэвтрүүлэх, зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, татварын уян хатан тогтолцоог бий болгож ажиллана.	Хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, Дөрөв болон Тавдугаар бүлгийн хүрээнд зохицуулагдана. Мөн хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6-д ““Байгууллага, аж ахуйн нэгж нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.”” гэж заав.
5.	ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 2.1 дүгээр зүйл. Салбар дундын хамтын ажиллагаа Төрийн байгууллага, аж ахуйн нэгж үйл ажиллагааны хүрээнд хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан орчныг бүрдүүлнэ. Төрийн байгууллага, аж ахуйн нэгж хүлээсэн үүргийн хүрээнд хүүхэд хамгааллын асуудлаар салбар дундын хамтын ажиллагааг хангаж ажиллана. Өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгж нь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгж мөн адил хамаарна.	1. Хуулийн хоёрдугаар бүлэгт; 2. Хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлж, хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг шинээр тодорхойлсон. 3. Сум, хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны бүтэц, орон тоотой болох зохицуулалтыг тусгаж, нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох, сургаж мэргэшүүлэхээр зааж өгөв. 4. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг шинээр тусгасан. 5. Хүүхэд хамгаалалд иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагын оролцоог өөрчлөн нэмсэн.

	Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэхийг хуульчилж өгөх нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ач холбогдлыг нэмэгдүүлнэ. Салбар дундын хамтын ажиллагаанд хамаарах төрийн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр нь оруулж өгөх шаардлагатай байна.	
6	2.9 дүгээр зүйл. Хамтарсан баг Боловсрол, эрүүл мэндийн, төрийн захиргааны байгууллага, шүүх, прокурор, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хүний эрхийн үндэсний комисс байгууллагууд энэ хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэлээр мэргэшсэн хамтарсан багийг байгуулж болно. Манай санал төрийн байгууллагууд үйл ажиллагааны цар хүрээнээс үл шалтгаалан байгууллага бүрд хүүхэд хамгааллын хамтарсан багтай байх нь хүүхэд хамгааллыг өргөн хүрээнд аваачна. Нөгөө талаас гамшиг онцгой нөхцөлд үзүүлэх хүүхэд хамгааллын бэлэн байдлыг бүрэн хангахад түлхэц болно. Тухайн байгууллага доторх энэ хамтарсан баг ажиллахад төрөөс ямар нэг нэмэлт санхүүжилт шаардагдахгүй, зөвхөн мэргэшсэн мэргэжилтнүүд дотооддоо ажиллана.	1. Хуулийн төслийн Гуравдугаар бүлгийг бүхэлд нь сайжруулж, шинээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгааллын талаар тусгав.
7.	2.10 дугаар зүйл. Салбар дундын хамтын ажиллагаа 6.Энэ зүйлийн 5-д заасан байгууллага нь Монгол Улсад хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын төсөл, хөтөлбөрийн мэдээллийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж, үйл ажиллагааны хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг байгуулна. гэж тусгах.	Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах асуудлыг хуулиар зохицуулах шаардлагагүй. Сайн дурын үндсэн дээр хийх боломжтой.
8.	ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ Нийгмийн орчин гэж нийгмийн бодлого хөтөлбөр бөгөөд бүх салбарыг хамруулан ойлгох чухал байна. Тиймээс төрийн байгууллагуудыг салбар салбараар нь томьёолон оруулах санал өгч байна. 3.1 дүгээр зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал Асран хамгаалагч гэж оруулах. Эцэг, эх, асран хамгаалагч энэ	Саналыг дараах байдлаар тусгав. 3.1 дүгээр зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал; 3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал; 3.3 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал; 3.4 дүгээр зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал; 3.5 дугаар зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал; 3.6 дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал 3.7 дугаар зүйл. Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал;

	хуулийн 1.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн дагуу авсан бүх арга хэмжээ, үйлчилгээний талаар мэдээлэл авах, зөвлөгөө авах эрхтэй. Эцэг, эх, асран хамгаалагч нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг цуцлуулах, өөрчлүүлэх хүсэлтийг гаргаж болно. 3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал Боловсролын салбар дээр нэмээд бусад салбаруудыг оруулах дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал Эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг анхаарах шаардлагатай. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд эрүүл мэндийн үйлчилгээ чухал байр суурь эзэлдэг тул энэ салбарыг заавал оруулах шаардлагатай. ... дүгээр зүйл. Хөдөлмөрийн салбар дахь хүүхэд хамгаалал Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) д хүүхдийн хөдөлмөр эрхлэлт байгаа тул энэ салбарыг заавал оруулах шаардлагатай. Мөн түүнчлэн Мэргэжлийн боловсролын сургалтын төвд (МСУТ) суралцагч хүүхдүүдийн асуудлыг анхаарах шаардлагатай	3.8 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал
9.	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 4.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хэрэг (кейс) нээх 1.Энэ хуулийн 4.1, 4.2, 4.3 дугаар зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, эсхүл өөрөө илрүүлсэн, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан тохиолдолд орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, нийгмийн ажилтан нь мэдээллийг Хамтарсан баг руу шилжүүлнэ. Хамтарсан баг мэдээллийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хүүхэд хамгааллын хэрэг (кейс) нээх эсэхийг шийдвэрлэнэ. 7 хоног урт хугацаа байна. ОУ-ын стандартад нийцүүлэх 72 цагийн дотор 2.Хамтарсан баг хүүхэд хамгааллын хэрэг (кейс) нээх шийдвэр гаргаснаас хойш 7 хоногийн дотор тухайн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч эд энэ тухай мэдэгдэнэ. Хэрэв хүүхэд хамгааллын хэргийг шалгах	1. Хамтарсан баг нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан. 2.Саналыг хүлээн авч хуулийн төслийн 2.15-2.74-т хамтарсан багийн чиг үүрэг, зохион байгуулалтыг тусгасан.

	ажиллагаанд саад учруулж болзошгүй гэж үзвэл эцэг, эхэд нь өгөх мэдэгдлийг хойшлуулж болно.	
10.	4.6 дугаар зүйл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх 2.Нөхцөл байдлын үнэлгээнд хүүхдийн бие махбод, сэтгэл санаа болон гэр бүлийн нөхцөл байдал, хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчтай харилцах харилцаа, хүүхдийн сургуулийн орчин, нөхцөл байдал, хүүхдийн зан байдал, хүмүүжил, эрүүл мэнд зэрэг хүүхэдтэй холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж, тусгана. Асран хамгаалагч гэж оруулах.	1. Саналыг судлан хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт Хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлж, шинээр нэмж боловсруулсан.
11.	4.7 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн төлөвлөгөө 2.Нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд хүүхдэд энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх шаардлагатай гэж дүгнэсэн тохиолдолд Хамтарсан баг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч боломжтой бол хүүхэд (14-өөс дээш насны)-тэй зөвшилцөн хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийн төлөвлөгөөг бичгээр гаргана. Эцэг, эх, асран хамгаалагч, хүүхэдтэй зөвшилцөлд хүрэх боломжгүй тохиолдолд Хамтарсан баг төлөвлөгөөг дангаар гаргаж хэрэгжүүлнэ. Асран хамгаалагч гэж оруулах.	1. Саналыг судлан хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт тусгав.
12.	Төлөвлөгөөний хугацаа дууссаны дараа Хамтарсан баг хүүхэд хамгааллын хэрэг (кэйс)-ийг хаах шийдвэр гаргавал хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч тухайн шийдвэрийг эс зөвшөөрч тухайн орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагад гомдол гаргаж болно. Асран хамгаалагч гэж оруулах.	Саналыг тусгав. Асран хамгаалагч гэж нэмж тусгав.
13.	ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ 5.1. дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр 1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь тодорхой шат дараалалтай, хоорондоо холбоотой дараах гурван түвшний үйлчилгээнээс бүрдэнэ: /Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх 2021-12-28-ны өдрийн А/218 тоот журам дээр түвшин гэж оруулсан./	Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг “Хүүхэд хамгааллын үйлчилгээ”, Тавдугаар бүлэг “Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага” шинээр боловсруулж, агуулга, саналыг бүрэн тусгасан.

14.	ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, САНХҮҮЖИЛТ 6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт 4. Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тандалт, судалгаа хийхийг хориглоно. Судалгаа болгон дээр зөвшөөрөл авна гэж ойлгох уу? Хэт хүнд сурталтай явцуу харагдаж байна. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22.3-д “Яам нь гадаад улсын болон олон улсын байгууллагатай сайдын өгсөн чиглэл, удирдамж, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар харилцана.” гэж заасантай зөрчилдөж байна. Эсвэл үүнийг “Ес зүйн зөвшөөрөл” гэж ойлгох уу?	Хуулийн төслийн 2.18 дугаар зүйлийн “8.Иргэн, хуулийн этгээд хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагааны тодорхой хэсгийг санхүүжүүлэх, хандив өгөх, бусад хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлж болно. 9.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдээр хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар хөндлөнгүйн хяналт, шинжилгээ хийлгэж болно. 10.Олон улсын болон гадаад улсын байгууллага нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тандалт судалгаа хийхийг хориглоно. 11.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон гадаад улсын байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлага, стандартад нийцсэн байна.” гэж тусгав. Хуулийн төсөлд хяналт, шинжилгээ үнэлгээг лийн Зургадугаар бүлгийн 6.2-6.4 дэх хэсгээр зохицуулагдахаар тусгав.
15.	1. 6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт, зарцуулалт. /Зарцуулалт гэж оруулах/. Салбар бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх санхүүжилттэй байх зохицуулалтыг тусгах.	Хуулийн төсөлд 6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт -санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой заасан. 6.Байгууллага, аж ахуйн нэгж нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна. “ гэж шинээр тусгав.

16.	1.Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хуваарилагдсан төсвийг төрийн захиргааны байгууллага, Хороо, Хамтарсан баг болон хорооноос хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тэдэнд хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсний дараа хяналт тавихтай холбогдох үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулна. “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” нь хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хэсэг тул санхүүжилтэд оруулах шаардлагатай.	1. Хуулийн төслийн Зургаадугаар бүлэгт Хүүхэд хамгааллын хэрэгжилт, санхүүжилтийн зохицуулалтыг тусгасан. 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейст тулгуурлаж, дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтооно. 3. Хүүхэд хамгаалалд хуваарилагдсан төсвийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн байгууллага, хууль зүйн хороо, хамтарсан багаас эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэмжлэг, урьдчилан сэргийлэх, тусалцаа үзүүлэхтэй холбогдох үйл ажиллагаанд зарцуулна.
17.	Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй, Хүүхэд хамгааллын тухай хуулийн одоогийн зохицуулалтад боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамтай байх зохицуулалт байхгүй. Сургуулийн орчинд үе тэнгийнхний дээрэлхэлт (bullying) маш их болсон. Дээрэлхэлт гэж юуг ойлгох вэ гэдэг ойлголт, тодорхойлолтыг хуулинд тусгах. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хохирсон хүүхдийн боловсролын орчин дахь хамгааллыг тодорхойл болгосон зохицуулалт шаардлагатай. 2018 онд БШУЯ-аас Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын бодлого баталж, 2020 онд хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх сургуулийн хүүхэд хамгааллын баг байгуулсан хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй байна. Учир нь боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээг журамласан зохицуулалт байхгүйтэй холбоотой. Ийм учраас хуульд тусгах.	1. Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлд “Боловсролын сургалтын байгууллага нь хүүхэд сургалтын орчин, дотуур байранд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, авч хэмжээг арга хэмжээ”-үүдийг зааж өгсөн. Үүнд “сургалтын орчны нөхцөл байдлын зураглал гарган эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх” талаар тусгасан. 7-д “Гадаад улсад шашны байгууллага /сургууль/-д суралцаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.” гэж тусгав.
18.	Сүм хийдэд шавилан суралцаж байгаа хүүхдийн эрхийн асуудал, боловсрол эзэмших асуудал, хамгааллын асуудлууд аль ч хуульд тодорхой тусгаагүй. /Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Боловсролын тухай, Төр сүм хийдийн тухай хууль гэх мэт/ Гадаадад ламхайгаар 500 гаруй хүүхэд шавилан суралцаж байгаа. Эдгээр хүүхдийн эрхийн хэрэгжилт, нөхцөл байдлыг хэн үнэлж, хянаж, эрх ашгийг хамгаалахыг тодорхой тусгах.	1.Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлд Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгасан. Хуулийн төслийн 7-д “Гадаад улсад шашны байгууллага /сургууль/-д суралцаж байгаа хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.” гэж тусгав.
19.	Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, хамгааллын асуудал, уралдаан санаачлан зохион байгуулж байгаа	1. Саналыг тусган авч, дараах байдлаар оруулсан.

	оролцогчдыг үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалт байхгүй. 2022 онд баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулиар уралдаанч хүүхдийн насыг 8 болгосон. Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалт тусгасан боловч бусад уралдаан, сунгаа, морины бэлтгэлийн үеийн хүүхэд хамгааллын асуудал энэ хуулиар зохицуулагдаагүй. Мөн жилдээ 2-3 хүүхэд хурдан морины уралдаан, сунгаа, бэлтгэлийн үед мориноос унаж ам насаараа хохирч байна. 2022 онд морины бэлтгэл ажлын үед болон ахуйн шинжтэйгээр 6 хүүхэд амь насаараа хохирсон. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын зөвлөмжид уралдаанч хүүхдийн насыг 16 болгох, үндэсний их баяр наадмын үеэс бусад үед зохион байгуулагдаж байгаа морин уралдаанд хүүхэд оролцуулахгүй байх, хязгаарлаж хориглох, хяналт тавьж хариуцлага тооцох механизмаа тодорхой болгохыг зөвлөмжлснөөр байгааг анхаарна уу. Уламжлал, ёс заншлаа гажуудуулсан, хүүхдийн эрх ашгийг ноцтой зөрчсөн наадам, уралдаан, аливаа үйл ажиллагааг хориглох эрх зүйн зохицуулалтаа сайжруулах. Хүүхэд хамгааллын тухай хуулийн Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал хэсэгт уралдаанч хүүхдийн хамгааллын асуудлыг оруулах.
2. Хуулийн төслийн хамрах хүрээг өргөжүүлж, 1.3 дугаар зүйлийн 4-т Үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах талаар Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.; 3. Хуулийн төслийн 3.6 дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал. 3.6 дугаар зүйлийн 5.Хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах хүрээнд дараах үүргийг хүлээнэ: 5.1.уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байх; 5.2.уралдаанч хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж, өсөлт, хөгжлийн талаар дүгнэлт гаргуулах; 5.3.уралдаанч хүүхдийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасны дагуу батлагдсан стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангах; 5.4.уралдаанч хүүхдийг хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан ослын даатгалд даатгуулах;	

---oOo---

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ХУУЛИЙН ТӨСӨЛД
ИРҮҮЛСЭН САНАЛУУДЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

Хугацаа: 2021 оны 12 дугаар сараас 2022 оны 02 дугаар сард

Оролцогчид: 21 аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, сум, хорооны нийгмийн ажилтан 365 хүн, аймаг, дүүргийн Нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөллүүдэд хэлэлцүүлж санал авсан.

д/д	Ирүүлсэн санал	Саналыг төсөлд тусгасан байдал
1.	Хуулийн төслийн 8/18 дугаар зүйлийн 18.5 дах хэсэгт “18.5. Аймгийн сум, нийслэлийн хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон тооны” гэдгийн дараа “мэргэжлийн” гэж нэмэх;	1.Хуулийн төслийн 2.2 болон 2.6 дугаар зүйлд тусган боловсруулсан.
2.	1. Хуулийн төслийн 4/9 дүгээр зүйлийн 9.5 хэсэгт “9.5. Байгууллага, аж ахуй нэгж бүр хүүхэд хамгааллын бодлоготой байна.”шинээр заалт нэмж, дараагийн заалтын дугаарлалтыг “9.6. Байгууллага, аж ахуй, нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллана. 9.7.Байгууллага, аж ахуй, нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.”гэж өөрчлөх, 9.8 дах хэсэгт “9.8.Байгууллага, аж ахуй, нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл ажиллуулах журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж шинээр нэмж тусгах;	2.Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт тусган боловсруулсан.
3.	2. Хуулийн төслийг дагалдах Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн “2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.4 дэх заалтын “гэр бүлийн” гэсний дараа “болон хүүхдийн эсрэг” гэж, “энэ хуулийн 37.38.1.1, 40. 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээ” гэсний дараа “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үйлчилгээ” гэж нэмсүгэй” гэж нэмэх саналтай байна.	Саналыг тэмдэглэв.
НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Хүүхэд хамгааллын тухай хуульд үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн дагуу уг хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээний төрлүүдийг нарийвчлан зохицуулах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн үзүүлэх, үйлчилгээний хувьсах зардлыг тооцох, хяналт үнэлгээний механизмыг сайжруулах шаардлагатай байна гэж үзсэн. Иймд хуулийн төслийн хуулийн үзэл баримтлалд дээрх асуудал туссан байгаа тул үзэл баримтлалд нийцүүлэн уг төсөлд шинээр хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын бодлого гэсэн нэр томьёоны тодорхойлолтыг 4 дүгээр зүйлд тусгах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар бүлгийг “Хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж өөрчилж, уг бүлгийг бүхэлд нь шинэчлэн найруулах саналтай байна. Үүнд:		

4.	1. Хуулийн төсөлд 4 дүгээр зүйлийн "4.1.8 Хүүхэдтэй зүй бус харьцах гэж санаатайгаар хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг" гэж, "4.1.10. "хүүхэд хамгаалал" гэж гэр бүл, нийгмийн бүхий л орчинд хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдал, мөлжлөгөөс хамгаалахыг" гэж, "4.10.11. "хүүхэд хамгааллын бодлого" гэж хүүхдэд учрах эрсдэл, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлж, хамгаалах, хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнуудын үйл ажиллагаандаа анхаарч ажиллах баримт бичиг"-ийг гэж нэмж оруулах; 2. "Гуравдугаар бүлэг. Хүүхэд хамгааллын үйлчилгээ 10 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл 10.1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, шуурхай тусламжийн хариу үйлчилгээ гэсэн төрөлтэй байна. 10.1.1.Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүүхэдтэй зүй бус харьцах эрсдэлийн түвшин бага болон эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд чиглэсэн байнгын шинжтэй байна. Энэ үйлчилгээг нийт хүүхэд хүртэх эрхтэй. 10.1.2. Хүүхэд хамгааллын хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ нь хүүхэдтэй зүй бус харьцах эрсдэлийн түвшин дунд болон хүүхэд, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн, урт хугацааны байна. 10.1.3.Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн хариу үйлчилгээ нь хүүхэдтэй зүй бус харьцах эрсдэлийн түвшин өндөр, шуурхай таслан зогсоох, хянах, хамгаалан байрлуулах, богино хугацааны байна.	Хуулийн төслийн 1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 1.1, 1.2-т тусгав.
5.		Дөрөвдүгээр бүлэг. Хүүхэд хамгааллын үйлчилгээ хэсэгт агуулгаар нь тусгав
6.	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. ...1.1. Хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас сэргийлэх, сургалтын бүх шатны байгууллагын сургалтын хөтөлбөрт оруулна. ...1.2. Төрийн байгууллагын анхан шатны нэгж сум, багт хүүхдийн эсрэг хүчирхийлэлгүй хөдөлгөөн, санаачилга өрнүүлнэ. ...1.3. Бүх хүн амын дунд хүүхэдтэй зүй бус харьцах явдлын хор уршгийн талаарх ойлголт нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулна. ...1.4. хүүхэд хүмүүжүүлэх арга зүйн сургалт, үйлчилгээг хороо, сум, багт зохион байгуулна.	Хуулийн төслийн 4.9 дүгээр зүйл. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ 1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан кейс менежмент, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлж, үр дүнг үнэлнэ. 2.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 2.1.зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;

	...1.5. эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн гишүүдэд үйлчлэх үйлчилгээ	2.2.олон талт, хамтарсан арга хэмжээ. 3.Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь төрийн захиргааны төв, нутгийн захиргаа, шүүх эрх мэдэл болон хууль сахиулах, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай уялдсан байна. 4.Аж ахуйн нэгж, байгууллага бүр хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээнд оролцох, сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй. 5.Урьдчилан сэргийлэх үйлчилгээг сайн дурын ажилтны тусламж, оролцоотойгоор зохион байгуулж болох ба уг ажилтныг бүртгэх, сургах ажлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага зохион байгуулна. гэж найруулж тусгав.
7.	... дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ ...1. Хүүхэд хамгааллын хамгаалах үйлчилгээ хүүхэдтэй зүй бус харьцах эрсдэлийн дунд түвшинд байгаа хүүхэд, тэдний гэр бүлд чиглэсэн хүүхдийн аюулгүй байдал, гэр бүлийн харилцааны хэвийн байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.	Хуулийн төслийн 4.3 дугаар зүйл. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ 1.Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ гэр бүлийн орчинд болон гэр бүлээс нь тусдаа орчинд гэсэн хэлбэрээр үзүүлнэ. 5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага болон 18-аас дээш 21 хүртэл насны хүн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд түүнд 21 нас хүртэл нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлж болно. 6.Сэтгэл зүйн үйлчилгээний болон бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. гэж тусгав.
8.	... Хохирогч хүүхдэд чиглэсэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний төрөл ...1.1. Хүчирхийлэл, дарамт, үйл хайхралтын улмаас хүүхдэд үүссэн сэтгэл санааны цочрол, бие махбодын гэмтэл, шарх сорвийг илааршуулах, хүүхдийг хэвийн амьдралд оруулахад туслах урт хугацааны нийгэм-сэтгэл зүйн эмчилгээ үйлчилгээ ...1.2 Сэтгэл зүйн цочрол, хямрал, гэмтлийг даван туулахад туслах сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ	Хуулийн төслийн 4.3 дугаар зүйлд оруулсан.

	...1.3 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ ба нөхөн сэргээх арга хэмжээ ...1.4 Хүүхэдтэй зүй бус харьцсанаас улбаатай хүүхдийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр ...1.5 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ	
9.	... дугаар зүйл.. Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн хариу үйлчилгээ ... Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн хариу үйлчилгээг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ. - Хүүхдийн тусламжийн утсаар мэдээлэл авч, шуурхай таслан зогсоох багийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Хуулийн төслийн 4.2 дугаар зүйл. Шуурхай тусламжийн үйлчилгээ 4.2 дугаар зүйл. Шуурхай тусламжийн үйлчилгээ 1.Энэ хуулийн 4.11 дүгээр зүйлд заасны дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авсан, өөрөө илрүүлсэн сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн алба хаагч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан хүүхэд аюултай нөхцөлд байдалд орсон бол хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлж аюулыг зайлуулах, аюул учруулах нөхцөл байдлыг арилгах арга хэмжээг нэн даруй авна. Шаардлагатай гэж үзвэл хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийнх нь зөвшөөрөлгүйгээр аюултай нөхцөл байдал арилах хүртэл аюулгүй газар түр байрлуулж болно. 2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.3-д заасан арга хэмжээний аль нэгийг авч, хүүхдийг гэр бүлээс нь түр хугацаагаар тусгаарлах арга хэмжээг авна. Энэ тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамгаалагчийн зөвшөөрлийг шаардахгүй. 3.Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, эмнэлгийн яаралтай тусламж, сэтгэл зүйн болон хууль зүйн анхан шатны зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг нэн даруй холбон зуучилна. Шаардлагатай тохиолдолд хүүхдийг хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

	4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүүхэд аюултай нөхцөл байдалд ороогүй бол хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэн өгнө” гэж тусгасан.
--	---

**ХҮҮХДИЙН ЭРХИЙН УЛСЫН БАЙЦААГЧДАД
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛЫН ТОВЬЁГ**

Хугацаа: 2021 оны 12 сарын 14
Оролцогчид: Хүүхдийн эрхийн улсын байцаагч 51 хүн

№	Ирүүлсэн санал	Тусгасан байдал
1.	1. Хуулийн хамрах хүрээг өргөжүүлэх шаардлагатай. Монгол Улсад байнгын оршин суугаа хүний хүүхдийн эрх зөрчигдсөн үед Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болдог. Жишээ нь Тува улсын харьяат хүүхэд Увс аймагт амьдарч байх хугацаандаа хулгайн хэрэгт холбогдсон. Хүүхдэд хууль ёсны төлөөлөгч томилж, түр хамгаалах байранд байрлуулсан. Энэ хугацаанд маш их хүндрэлүүд үүссэн. Зохицуулах хуулийн заалт нь хангалттай биш. 2. Хүүхдээс мэдүүлэг, тайлбар авахдаа орчуулагч хэлмэрч ажиллуулах гэж мөн тусгамаар байна. 3. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11.4-т "Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 11.1, 11.3-т заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хүүхэд, гэр бүл, нийгмийн асуудал хариуцсан ажилтнаар дүгнэлт гаргуулна." гэж заасан. Энэ заалтын дагуу аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хүүхдийн эрхийн улсын байцаагчид үрчлэлтийн хүсэлтээ гаргасан гэр бүлд үнэлгээ хийж, дүгнэлт гаргадаг. Энэ зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуульд нэмж оруулах, мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр бүлэгт "нөхцөл байдлын үнэлгээ хийх" гэх хэсэгтээ тусгах хэрэгтэй.	1. Хуулийн хамрах хүрээг өргөжүүлсэн. 2. Хуулийн 2.5 дугаар зүйлд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүргийг хуульчилсан. 3. Хуулийн 3.8 дугаар зүйл Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллыг шинээр тусган найруулсан. 4. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороон чиг үүргийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрхийг хамгаалж ажиллана.
	1. Нэр томьёонд Орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага гэж 2 нэр томьёо байна. Нэр томьёог тодорхой болгох. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн төрийн захиргааны төв байгууллага гэж оруулах ёстой байх. 2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэнэ. Энэ хуульд хүүхэд хамгааллын гээд заагаад байна. Хүүхэд хамгааллын гэдэг үгийг энэ хуулиас хасах, Хамтарсан баг гэдгээр оруулах. 2 хуулиар хамтарсан баг зохицуулагдахаар болоод байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиар зохицуулагдах болоод байна. 3. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын хэсэг, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх зохицуулалт тусгах.	1. Хүүхэд хамгааллын үйлчилгээг анхан шатанд үзүүлэх хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг тусгав.

	4. Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина. Хүүхэд хамгааллын бодлого гэдгийг юу гэж ойлгож байгаа юм бол. Хүүхэд хамгааллын бодлого гэдгийг нэр томъёоны тайлбар хэсэгт нэмж оруулж өгөх. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хүүхдийн эрхийн улсын байцаагч бид давхар хяналт тавих хэрэгтэй байх.	
2.	1. Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн талууд нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг нь байх хэрэгтэй. 2. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх төв түр хамгаалах байр, сүм хийдийн байгууллага, сургууль, дотуур байр, Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байранд хяналт, шалгалт хийж байна. Энэ хуулийг дагалдуулан Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хүүхдийн эрхийн байцаагчдын эрх зүйн байдал, чиг үүргийг тодорхой хуульчлах хэрэгтэй. 3. Хүүхэд хамгааллын хууль тогтоомж, мэргэжлийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хүүхэд хамгааллын нөөц чадавх, хүүхэд хамгааллын үйлчилгээ, төсөв, санхүүжилт, хуваарилалт, мэдээллийн сан, хяналт, шинжилгээ үнэлгээ, хүчирхийллийг үл тэвчих олон нийтийн хандлагыг хэрхэн сайжруулах талаар огт тусаагүй байна. 4. Орон нутагт салбар дундын хамтын ажиллагаа маш сул байна. Хүүхдийн эрхийн хуулиар төрийн бүх шатны байгууллага, иргэн хуулийн этгээд нь хүүхдийн эрхийг хангах чиг үүрэгтэй. Гэхдээ хүүхэд хамгаалалд яаж оролцох вэ, тодорхой болгоё. 5. Аж ахуйн нэгж, байгууллагын чиг үүрэг, хүүхэд хамгааллын бодлоготой байх, ажилтны хүүхэд болон тухайн байгууллагаар үйлчлүүлдэг шууд ба шууд бус үр шим хүртдэг хүүхдийн асуудалд ямар хариуцлага хүлээх талаар зохицуулалт хэрэгтэй. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжтэй уялдуулан боловсруулах. 6. Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг Хүүхэд хамгааллын хуулиар зохицуулж өгөх хэрэгтэй. Хөдөө орон нутагт хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн 30 гаруй хувь нь гэрээсээ тусдаа хөлстэй болон хөлсгүйгээр хөдөлмөр эрхэлж байна. Боловсролоос хөндийрсөн байдаг. Эцэг эхийн хариуцлага хэсэгт хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон заалт тусгах зайлшгүй шаардлагатай. 7. Хүүхдийн төлөө зөвлөлийн чиг үүрэг Хүүхдийн эрхийн тухай хуульд байдаг. Гэхдээ Хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүргийг нь хуулийн төсөлд тусгах. 8. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог Засаг даргын орлогч биш Тамгын даргаар ахлуулмаар байна. үүнийг бусад хуулийн зохицуулалттай уялдуулан тусгах хэрэгтэй.	1. Хуулийн төсөлд хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, хүүхэд хамгааллын үйлчилгээ, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төсөв, санхүү бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ. гэж тусгасан. 2. "Аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагынхаа хүрээнд хэрэгжүүлэх энэ хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.2-т заасан баримт бичгийг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана." 3. "Иргэн, аж ахуйн нэгж нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэд бүтцийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, хандив тусалцаа үзүүлэх, төрийн байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжин оролцож болно." гэж тусгав. 4. Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдал, чиг үүргийг тусган найруулсан. Саналуудыг бүрэн тусгасан.

9. Аймаг орон нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан хаагчид шинжээч хууль ёсны төлөөлөгчөөр ажиллана гэж нэмж оруулах гэсэн санал оруулах.	1. Сургуулийн орчин, олон нийтийн үйлчилгээ, гудамж талбайд хүүхдийн дээрэлхэлтийн асуудал маш их байна. Цахим орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дээрэлхэлт, зөрчлийн асуудал цөөнгүй гарч байна. Эдгээр асуудлыг хэрхэн зохицуулах талаар хуульд тусгах. 2. Боловсролын байгууллагын гадна болон дотор орчин дахь эрсдэлийг үнэлэх, бууруулах, таслан зогсоох талаар зүйл заалт нэмж оруулах. Боловсролын байгууллагын боловсролын сан дахь мэдээлэлд хүүхэд хамгааллын мэдээллийн сан гэж оруулж өгөх. 3. Сургуулийн орчин дахь камержуулалтын шүүлтийн асуудлын талаар нэмж оруулж өгөх. 4. Залуучуудын тухай хуульд 15-34 насны хүн гэж томьёолсон. Эрсдэлт нөхцөлд орсон 15-аас дээш насны хүүхдийн кейс төлөвлөгөөнд залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээнд хамруулах гэсэн төлөвлөлт тусгахад энэ хэрэгждэггүй. Зорилтот бүлгийн залуучууд гэсэн нэр томьёо, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэх нэр томьёог яаж уялдуулах вэ. Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод тусгамаар байна. 2хуулийн уялдааг эргэн харах хэрэгтэй.
4.	1. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал, чиг үүргийг хуульд оновчтой тодорхой тусгах хэрэгтэй. 2. Анхан шатанд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн байдаггүй нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон хууль, тогтоомж бүхэлдээ хэрэгжихгүй байна. Кейс шийдвэрлэлт хангалтгүй байгаа нь хүүхдээ хамгаалж чадахгүй байна гэсэн үр дүн юм. Анхан шатанд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай байх зохицуулалтыг энэ хуульд тусган яаралтай батлуулах хэрэгтэй.
	1. Гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах харилцаан дээр нэмж сургуулийн орчинд гардаг үе тэнгийнхний дээрэлхэлт (bullying), хурдан морины уралдаанч хүүхдийг хамгаалах, жагсаал цуглааны үе дэх хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын зохицуулалтыг шинээр тусгасан. Хуулийн төслийн 2.6 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан 1. Нийгмийн ажилтны мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийгмийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан иргэнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна. 2. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ёс зүйн дүрэмтэй байна. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг мэргэжлийн холбоодтой зөвшилцөн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 3. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах асуудлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ. гэж тусган найруулсан.

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ**

Хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 03

Байршил: Олон Улсын Хүүхдийн Найрамдал цогцолбор

Оролцогчид: ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, харьяа байгууллагуудын дарга нар нийт 44 хүн

Хэлэлцүүлгийн зорилго: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал авах;

№	Хуулийн заалт	Санал	Тусгасан байдал
1	Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт заасан “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд”	1. Нэр томьёог сайтар задалж оруулах 2. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд гэдэгт бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, хараа хяналтгүй хүүхдийг оруулах саналтай байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын тайлангаар Хүүхэд хамгааллын үйлчилгээнд гэмт хэргийн тэр тундаа бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамруулах шаардлагатай талаар зөвлөсөн. 3. ЭХХШТ-иар болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиар гэмт хэргийн хохирогч бүх хүүхэд хамгаалагдаж чаддаггүй ба гагцхүү хуульд заасан аюул занал, үндэслэл бий болсон тохиолдолд л хамгаалагддаг. Иймээс гэмт хэргийн гэрч хохирогч хүүхэд Эрүүгийн процессын аль ч шатанд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдах ёстой ба уг процессын явцад хүүхэд ахин гэмт хэргийн хохирогч болох эрсдэлтэй, бие махбод сэтгэл зүйн эрүүл мэндийн хувьд үйлчилгээ авах шаардлагатай гэж үздэг. Өнөөдрийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Нэр томьёог задалж оруулсан. 1.4 дүгээр зүйлийн 1.4-т “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан; хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөлд байгаа; эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй; гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг

	явцад тулгамдаад байгаа асуудлын нэг хэсэг нь энэ байдаг юм. 4. Хүүхдийн эрхийн конвенцын 34-р зүйл Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна: (а) хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх; (b) хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих; (c) хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах. 35-р зүйл Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу хил дамжуулан худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна. гэж тус тус заасан. 5. Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг хүүхэдтэй зүй бус харьцах байдалд хүргэсэн ба хүргэх эрсдэлтэй эцэг эх, асран хамгаалагч нь ихэнх тохиолдолд хүүхдийн хууль ёсны асрамж хамгаалагч байдаг. Тиймээс хүүхдийн эрхийг тэр дундаа хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах эрхийг хангах үүргийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцод нэгдсэн улс орнуудын ТӨР нь хүлээж, хүүхдийн аюулгүй байдал, дээд ашиг сонирхлыг хангах хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхдээ зайлшгүй хөндлөнгөөс шууд оролцох шаардлагатай болдог. Ийм учраас энэ хуулийн шинэчлэл дотор гэр бүл дэх хүүхэд хамгааллыг илүү тодорхой тусган сайжруулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллыг нэмж тусган боловсруулах хэрэгтэй байна.	“санамсаргүй” гэсэн үгийг хасах.
2	Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтаар	Санамсаргүй гэдэг үгийг хассан. 1.4 дүгээр зүйлийн 11.3.“хүүхдийн эсрэг хүчирхийлэл” /цаашид “хүчирхийлэл” гэж/ гэж

тайлбарласан “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдэг ойлголт дотор байгаа	хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц үл хайхрах, сэтгэл санаа, бие махбод, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;
“Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал”	Хуулийн төслийн 3.2 дугаар зүйлд 1.Боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллага, сүм, хийд, түүний дэргэдэх шашны сургууль нь боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна. гэж заасан. 1. Сургалтын байгууллагын багш, ажилтнууд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна. 2. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, хамтарсан багийн дүгнэлт, гэр бүлийн гишүүдийн саналыг үндэслэн харьяалал харгалзахгүй хамгийн ойр сургуульд хамруулах. 3. Сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг нь байгууллагын гадна, дотно орчинд эрсдэлийн үнэлгээг улирал тутам хийж дүгнэн, түүний мөрөөр эрсдэлийг бууруулах, таслан зогсоох арга хэмжээг тогтмол авч ажиллах. 4. Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа хүүхэд хүүхдээ дээрлэх, хүчирхийлэх асуудал сүүлийн жилүүдэд тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд боловсролын газар, хэлтсийн дарга нар байдаг хэдий ч сургуулийн орчинд гарсан гэмт, хэрэг зөрчлийг дахин гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, ялаас бусад төрлийн шийтгэл авсан хүүхдийн зан байдлыг засах ажлыг зохион байгуулахгүй, хүүхдээ буруутгасан хандлага л их байдаг. Ийм учраас боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамтай байх гэсэн зохицуулалтуудыг нарийн тусгах.

4	“Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал”	1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын асуудлыг тодорхой болгож хуульчлах хэрэгтэй. Хуульд эмч, эмнэлгийн ажилтан хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан бол заавал мэдээлнэ гэж үүрэгжүүлсэн боловч энэ талаар мэдээлдэггүй. Жилдээ 20-30 тохиолдол л мэдээлэгдэж байгаа. Баг, сумын эмч, өрхийн эмч нарыг боломжоороо сургаж чадавхжуулдаг. Гэхдээ ажлын байрны тодорхойлолтод нь тусгагдаагүй учраас хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх ажил ахицтай явахгүй байна. 2. Эрсдэлт нөхцөлд байгаа болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг хариуцсан албан тушаалтныг томилох. 3. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг хүүхдийн байгууллагатай хамтран шуурхай үзүүлэх, дүгнэлт гаргах 4. Хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үнэ төлбөртэй байдаг шинжилгээ /MRI PCR маркер томограф/, тусламж үйлчилгээг шууд үзүүлэх 5. Эрүүл мэндийн үйлчилгээнд мөрдөх хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамтай байх гэсэн зохицуулалт тусгах.	Хуулийн төслийн 3.3 дугаар зүйлийн “1.Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.” “2.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй мэдээлнэ.” гэж тусгав.
5	“Хэвлэл мэдээлэл дэх хүүхэд хамгаалал”	1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь хүүхэд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын чиглэлээрх мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах	1.Хамтын ажиллагаа, сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой тул хуульд тусгах шаардлагагүй гэж үзэв.
6	Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасан	2. Хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгасан.

	хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа	3. Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлага хангалтгүй гэж тайланд бичжээ. Хуульдаа мэргэжлийн удирдлагын зохицуулалтыг тусгах 4. Нийгмийн ажлын кейс менежментийг мөн тусгах.	2.6 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүрэг 1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 1.1.хүүхэд хамгааллын талаарх судалгаа, тайланд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тодорхойлох; 1.2.хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх; 1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, тандалт, судалгаа явуулах, бүртгэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллага болон бусад холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах; гэж тусгасан.
7	11 дүгээр зүйл. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах 11.5.Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд	1. Стандартын шаардлага хангасан түр хамгаалах байртай байх /хүүхэд хөгжих, салхилах боломжийг бүрдүүлсэн талбайтай г.м/, түр хамгаалах байрны стандартыг боловсруулж батлуулах. 2. Түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, эмч, багшийг байнгын орон тоонд ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй ажиллах мэргэжлийн сувилагчийг ажиллуулах. 3. Хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг хүлээн авах зориулалтын сувиллын газар, асрамж халамжийн төв байгуулах. 4. Орон нутагт хүчирхийллийн хохирогчоос мэдүүлэг, байцаалт авах үед хэлмэрч олддоггүй, хэлмэрч бэлтгэдэггүй, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаагийн алба хаагчид дохионы хэл заах хэрэгтэй байна. Орон тооны ямар ч боловсон хүчин байхгүй.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баталсан. 1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд “хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлах”-аар нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулсан.

	аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.	5. Хүүхэд хамгааллын зарчимдаа хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадваргүй бол хэлмэрч заавал оролцуулах гэж оруулж өгөх. 6. Мөн хэл соёлын ялгаатай хохирогч хүүхдэд орчуулагч заавал байлгах хэрэгтэй тул хуульд тусгах	
8	18 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа 18.2.4. нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	1. Хорооны нийгмийн ажилтан нь мэргэжлийн нийгмийн ажилтан байх, тоог нэмэх 2. Хороодын нийгмийн ажилтан хамтарсан багтай нууцлалын гэрээг байгуулах, нийгмийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллахад анхаарах 3. Хүн ам олонтой дүүргийн ГБХЗХХ-т мэргэжилтэн, хорооны нийгмийн ажилтны орон тоог нэмэх. /УИХ сонгуулийн дараа мэргэшүүлсэн нийгмийн ажилтнуудыг сольдог, нийгмийн ажилтан бол улс төрийн албан тушаал биш/	Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгасан. 2.5 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг: 1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын асуудлаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 1.1.хүүхэд хамгааллын талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө жил бүр хариуцан тайлагнах;

		1.2.хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах; 1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих; 1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, хүүхэд харагч, өдөр өнжүүлэх төв, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах; Хуулийн төслийн 2.7 дугаар зүйл.
9	20 дугаар зүйл. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал 20.1.Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, дүүрэг, баг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна	1.Нийгмийн ажилтны мэргэжлээр дээд боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан иргэнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна. 2.9.нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх. 6.Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална. 7.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр

			бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална. 8.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга хуульд заасны дагуу томилж, чөлөөлнө.” гэж тодорхой тусгасан.
10	8 дугаар зүйл. Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал 8.6.Интернэтийн орчинд эрх эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай сувгийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.	Интернэт, РС тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам боловсруулж батлуулах	Хуулийн төслийн 3.4 дүгээр зүйлийн зохицуулалтыг сайжруулж, тусгасан.
9² дугаар зүйл			

11	Мөрдөн байцаах ажиллагаа дахь хүүхэд хамгаалал 9^{2.1} Хүүхдийн эрх ашиг, сонирхлыг нэн тэргүүнд хангана. 9^{2.2} Хүүхдийн нас, хувийн онцлогийг ямагт харгалзана. 9^{2.3} Хүүхдийн өмгөөллөөр хангагдах эрхийг бүрэн хангана. 9^{2.4} Хүчирхийлэл, шийтгэл, доромжлол, эрүү шүүлттэй ямар ч хэлбэрийг үл хэрэглэнэ. 9^{2.5} Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчтэй байнгын холбоотой байлгах	9^{2.1} Хүүхэд ямар ч тохиолдолд өмгөөлөгчөөр бүрэн хангагдсан байна. 9^{2.2} Хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд анхаарч хамгаалуулах боломжоор бүрэн хангана. 9^{2.3} Хүүхдийн нас, төлөвлөлийн байдлыг харгалзан, хүндэтгэлтэй хандана. 9^{2.4} Хүүхдэд хүчирхийллийн болон доромжлол, эрүү шүүлттэй ямар ч хэлбэрийг үл хэрэглэнэ. 9^{2.5} Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх; 9^{2.6} Гэмт хэргийн хохирогч, гэрч болон бусад хэлбэрээр холбогдуулан шалгагдаж байгаа тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчид хэргийн талаар заавал мэдээлэх үүрэг хүлээнэ.	Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт “3.8 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал” гэсэн зүйлийг шинээр оруулсан.
----	---	---	--

	боломжоор хангана. Тайлбар: “Хүүхдийн нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэн, хууль, журмыг баримтлан, дарамт шахалтгүй, хүнлэг хандах дадал хэвшил, арга барилын зарчим хэлнэ.”		
--	--	--	--

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ

Зөвлөх: Др. А. Батхишиг, МУИС
Др. Т. Цэндсүрэн, МУБИС

Улаанбаатар хот
2021.08.23

АГУУЛГА

Хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай ерөнхий ойлголтууд	3
Хүүхэд хамгаалал	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох нь	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хэлбэрүүд	4
Хүүхэд хамгааллын шүүрхай тусламжийн үйлчилгээ	4
Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ	5
Гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	5
Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ	6
Зорилтот урьдчилан сэргийлэх (шүүд биш) үйлчилгээ	7
Кейс менежмент	7
Тохиолдлын кейс менежмент	7
Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежментийн асуудлууд	8
Мэргэжлийн удирдлага	8
Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх үйл явц ба оролцогч талууд	8
Шүүрхай тусламжийн үйлчилгээ	9
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	13
Гэр бүлд суурилсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	13
Явуулын үйлчилгээ	14
Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ	14
Зорилтот урьдчилан сэргийлэх шүүд биш үйлчилгээ	15
Нэр томъёоны тайлбар	16

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал

Хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай ерөнхий ойлголтууд

Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх, асран хамгаалагч, бусад хуулийн этгээд, иргэн хүүхэд хамгаалах үүргээ биелүүлэхгүй тохиолдолд төр хөндлөнгөөс оролцож хүүхдийг хамгаалахыг хэлнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь нэгдүгээрт хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах шуурхай тусламжийн үйлчилгээ, хоёрдугаарт, хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлын улмаас үүссэн сэтгэл санаа цочрол, бие махбодийн гэмтэл, шарх сорвийг эдгээх, хүүхдийг хэвийн амьдралд ороход нь туслах төрөл бүрийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, гуравдугаарт хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон талт шууд биш үйлчилгээ гэсэн гурван түвшний цогц үйлчилгээ, үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох нь

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг. Хүүхэд хамгааллын тогтолцоо нь үндсэн долоон дэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин
2. Зохицуулагдсан эрх бүхийн байгууллага, бүтэц зохион байгуулалт
3. Хүүхэд хамгааллын ажиллах хүч - мэргэжлийн боловсон хүчин
4. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ
5. Хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт
6. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ, өгөгдөл
7. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үл тэвчдэг олон нийт (хүүхдийн амьдарч буй орон нутгийн иргэд, байгууллага, хүүхдийн дан ба өргөтгөсөн гэр бүл, хүүхэд өөрөө бас олон нийтийг нэг хэсэг болно)

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь дээр дурдсан хамгааллын бүрэлдэхүүн дэд хэсгүүдтэй нягт холбоотой. Хамгааллын тогтолцооны аль нэг дэд хэсэг нь ажиллахгүй эсхүл үйл ажиллагаа нь хэвийн биш байхад хүүхэд хамгааллын үйлчилгээнд шууд ба дам байдлаар нөлөөлнө.

Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг хүүхэдтэй зүй бус харьцах байдалд хүргэсэн ба хүргэх эрсдэлтэй эцэг эх, асран хамгаалагч нь ихэнх тохиолдолд хүүхдийн хууль ёсны асрамж хамгаалагч байдаг. Тиймээс хүүхдийн эрхийг тэр дундаа хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах эрхийг хангах үүргийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн улс орнуудын ТӨР нь хүлээж, хүүхдийн аюулгүй байдал, дээд ашиг сонирхлыг хангах хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхдээ зайлшгүй хөндлөнгөөс шууд оролцох шаардлагатай болдог.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хэлбэрүүд

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь 1-рт хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ, 2-рт хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, 3-рт зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэж гурван түвшний үйлчилгээнээс бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ

Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээнд дараах үйлчилгээг багтаана. Үүнд:

- Хүүхдийн тусламжийн утас-108
- Хүүхдийн тусламжийн утаснаас бусад сувгаар тухайлбал 102, 103, 105, 107-ын дуудлага, сум, хорооны засаг даргын тамгын газар, сургууль, эмнэлэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага зэрэг сувгаар ирэх дуудлага, мэдээллийг Хүүхдийн 108 утсанд шилжүүлэх, дуудлага мэдээлэл нэгтгэн шуурхай үйлчилгээн хамруулах зохицуулалт
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн хяналтын болон шуурхай дуудлагын дагуу хүүхдийн байгаа газар дээр очиж хийх эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ. Хүүхэд аюултай нөхцөл байдалд байгаа тухай 108 утсанд ирсэн хяналтын болон шуурхай дуудлагын үед эрсдлийн үнэлгээ буюу аюулын зэрэг тогтоох үнэлгээг дуудлага авснаас хойш 24 цагийн дотор, харин нөхцөл байдлын үнэлгээг 72 хүртэлх цагийн дотор хийнэ. Харин аюулын түвшин бага гэж эрсдлийн үнэлгээгээр тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг гурваас тав хүртэлх өдрийн дотор хийнэ.
- Хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсэх, хүүхдийн амь нас, эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд байгааг тогтоох эрсдлийн үнэлгээ, аюулын зэргийн түвшний үнэлгээний

үед хүчирхийллийн улмаас хүүхэд бэртэл гэмтэл авч хохирсон гэж илэрвэл хүүхдийг дараах мэргэжлийн байгууллагын шуурхай тусламжтай тухайлбал

- Эмнэлгийн шуурхай тусламж
 - Хууль эрх зүйн шуурхай тусламж
 - Нийгмийн ажлын шуурхай үйлчилгээ
 - Сэтгэл зүйн зөвлөгөө, засал зэрэг мэргэжлийн шуурхай тусламжтой холбоно.
- Эрсдлийн үнэлгээний үед аюулын зэргийн түвшин бага гэж үзэн хүүхдийг гэрээс нь эсхүл амьдарч буй газраас тусгаарлан авч явахгүй үлдээх тохиолдолд хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөхөөс хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг хүүхдийг хамгаалж чадах эцэг, эх асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх заавар зөвлөгөөг өгөх нь шуурхай тусламжийн нэг хэсэгт тооцогдоно.
 - Эрсдлийн үнэлгээний үед хүүхэд хүчирхийлэлд дахин өртөх, амь насанд аюултай байх эрсдэлтэй хүүхдийг гэрт нь үлдээх боломжгүй тохиолдолд хүүхдийг түр байрлуулах хамгаалах нэг цэгийн үйлчилгээний болон хүүхэд хамгаалах түр хамгаалах байранд хүргэж өгнө.

Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг хүүхэд, түүний гэр бүлд нөлөөлөх хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хүргэнэ.

Гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ зэрэг шууд үзүүлэх үйлчилгээнээс гадна бусад салбарын багтана. Гэр бүлд суурилсан хамгааллын үйлчилгээнд хүүхэд, гэр бүлийн гишүүдийн амьдралын үечлэл, хөгжилд чиглэсэн хөгжлийн, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх гэсэн олон талт үйлчилгээг хамруулна

Хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн хамгаалах, гэр бүлийг дэмжих гэж хоёр хуваана.

- *Гэр бүлийг хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна.*
Үүнд: эцэг эх хүүхдээ хамгаалах, зэрэг хүмүүжлийн аргад суралцахад нь туслах,, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах зэрэг үйлчилгээг багтана.
- *Гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна.*
Үүнд: эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ойлголт мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд туслах, гэр бүлд чиглэсэн бусад салбарын болон орон нутгийн нөөц боломжтой холбогдоход туслах зэрэг үйлчилгээний хэлбэрүүд багтана.

Мөн гэр бүлийн хамгаалах болох дэмжих үйлчилгээний аль ч хэлбэрийн үед хүүхэд, түүний гэр бүлийг гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүйн үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.

Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ

Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртсөн үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг эрсдэлт нөхцөл бүхий гэр бүлийн орчноос тусгаарлан, эрх бүхий байгууллагын шууд оролцоо, хяналт удирдлага дор түр хамгаалах байр, асрамж халамжийн төв, асралт гэр бүл, болон төрөл садангийн асрамжинд үр байрлуулан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийг хүүхдийг гэр бүлийн орчноос нь тусдаа хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэнэ (CWIG, 2020).

Хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээнд дараах хэлбэрүүд хамаарна. Үүнд

- Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ
- Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах
- Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ
- Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж гм)
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

Хүүхдийг түр болон удаан хугацаагаар асран халамжлах тохиолдолд асрамж халамжийн төвд үзүүлэх хүүхэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ, хүүхдийн хөгжил, амьдрах ухааны мэдлэг, ур чадвар, дадал олгоход чиглэсэн үйлчилгээнээс гадны хүүхдийг түр хамгаалах байр, асрамж халамжийн төвийн гадна үзүүлэх

боловсролын, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн, сэтгэл зүйн засал эмчилгээ үйлчилгээнд хамруулна.

Зорилтот урьдчилан сэргийлэх (шууд биш) үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн дахин өртөхөөс сэргийлэх, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, гэр бүлд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх шууд биш үйлчилгээг хэлнэ. Шууд бус үйлчилгээ гэдэгт нийгмийн ажлын макро практикт өргөн хэрэглэдэг сургах, нөлөөлөл хийх, чадавхи бэхжүүлэх, хөрөнгө босгох, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх зэрэг хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөр хамаарна.

Зорилтот урьдчилан сэргийлэх шууд үйлчилгээний дараах чиглэлээр байна. Үүнд:

- *Хүүхэд хамгааллын үйлчилгээний оролцогч талууд болох бусад салбарын (хүчирхийлэлд өртсөн хүүхдэд чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй үйлчилгээ үзүүлэх) мэргэжлийн байгууллага, ажилтнууд чиглэсэн хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн ажил*
- *Хүүхдэд чиглэсэн: Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон төрөл бүрийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөрүүд (Дээрхэлт, хүчирхийллээс сэргийлэх, зөрчил шийдэх, зэрэг харилцаанд суралцах гэх мэт)*
- *Эцэг эх, хамгаалагчид чиглэсэн эцэг эхийн ба тэдний дагуулах сургах хөтөлбөр, эцэг эхийн хүүхэд өсгөх мэдлэг чадварыг хөгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, дэмжих бүлэг зэрэг үйлчилгээ, үйл ажиллагааг багтаасан зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээг*
- *Олон нийтэд чиглэсэн: хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас сэргийлэх хөтөлбөрүүд, нөлөөллийн ажил*
- *Хүүхэд хамгааллын байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэднийг чадавхижуулах төрөл бүрийн сургалт, нөлөөллийн ажил зэрэг хамаарна.*

Кейс менежмент

Тохиолдлын кейс менежмент

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдлын үед тухайн тохиолдлыг хариуцан ажиллаж буй нийгмийн ажилтан/кейс менежер нь дангаараа буюу хамтарсан багийн гишүүд, бусад мэргэжилтэнтэй хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх,

хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээ хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх буй байгууллага мэргэжилтнүүдтэй холбох, тэдний уялдаа холбоог зохицуулах, хянах, үнэлэх, хаах үйл явцыг бүхэлд нь кейс менежмент гэнэ. Энэ нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдолд чиглэсэн шууд практикийн мөрдөх кейс менежмент юм.

Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежментийн асуудлууд

Харин шууд практикийн буюу хувь хүн гэр бүлтэй ажиллах тодорхой нэг тохиолдолд мөрдөх кейс менежментийг үр дүнтэй хийхийн тулд кейс менежментийн тогтолцооны түвшинд анхаарч удирдан зохион байгуулахыг тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент гэнэ. Тогтолцооны түвшний кейс менежментийн бүрэлдэхүүнд 1) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэж буй хүний нөөц- ажиллах хүч; 2) шууд үйлчилгээ хүргэж буй ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах зохион байгуулалт, бүтэц; 3) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт; 4) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхэд бодлого, хууль, журам, дүрэм заавар; 5) хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх хүүхэд, гэр бүлийн оролцоо; 6) хүүхдийн хамгааллын дэмжих олон нийтийн хандлага, үнэт зүйлс зэрэгт чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ зэрэг багтана. Анхан шатанд хүүхэд хамгааллын кейс менежментийг үр дүнтэй, сайн удирдан чиглүүлэхийн тулд аймаг, дүүрэг, нийслэл, үндэсний түвшний хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд кейс менежментийг тогтолцооны түвшинд бүтэн зургаар нь харж анхаарах хэрэгтэй болно.

Мэргэжлийн удирдлага

Мэргэжлийн удирдлага (supervision) гэж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд оролцогч байгууллагууд нийгмийн үйлчилгээний байгууллага үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхийн тулд тодорхой зохион байгуулалттай, хуульд зааснаас бусад нөхцөлд нууцыг хадгалах үүрэгтэйгээр тулгарч буй асуудлаа ярилцаж, мэргэжлийн дэмжлэг тусалцааг авах мэргэжилтнүүдийн ажлаа товч танилцуулах, зөвлөлдөх, заавар зөвлөгөө өгөх, эргэцүүлэн тунгаах боломж олгох, манлайлах, ажлаа эргэн дүгнэх зэрэг хэлбэрээр явагдах албан ёсны ярилцлагыг хэлнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх үйл явц ба оролцогч талууд

Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ гэдэг хоорондоо уялдаа холбоотой, тодорхой шат дараалалтай хүргэх үйл явц юм. Үйлчилгээ шат, түвшин бүрт үйлчилгээг хүргэх оролцогч талууд нь хоорондоо нягт холбоотой ажиллах хэрэгтэй болно.

Шуурхай тусламжийн үйлчилгээ

1. Хүүхдийн 108 утас болон 102, 103, 105, 107 зэрэг яаралтай тусламжийн утас, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын харъяа байгууллагуудад хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөх өндөр эрсдэлтэй байгаа тухай дуудлага мэдэлэл ирэхэд бүх дуудлага 108 утас дээр төвлөрч дуудлага бүрийн (шугамын дуудлагын) анхны мэдээлэлд Хүүхдийн тусламжийн утасны зөвлөгч болон ээлжийн ахлах нийгмийн ажилтан нар дүн шинжилгээ хийж хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх эрсдэлтэй байна гэж дүгнэвэл дуудлагыг хяналтын дуудлага гэж бүртгэн орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
2. Дуудлага мэдээллийн дагуу цагдаагийн албан хаагч газар дээр нь эрсдлийн үнэлгээ хийн аюулын түвшинг тогтооно. Аюулын түвшин дунд ба дундаас дээш тохиолдолд Хүүхдийн 108 утас руу эргэн мэдэгдэн, харин 108 утаснаас хүүхдийн амьдарч буй газрын харъяалагдах аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст дуудлагыг мэдэгдэнэ. Хүүхэд гэртээ үлдэх боломжгүй, хүүхдэд аюултай тохиолдолд цагдаагийн ажилтан хүүхдийг цагдаагийн тасаг, хэсэгтээ авчирч ГБХЗХХ-ийн мэргэжилтэнг эсхүл хамтарсан багийн нийгмийн ажилтанг дуудан, холбогдох бичиг баримтын хамт хүүхдийн байгууллагын мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
3. Хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл ажлын бус цагаар ирвэл Хүүхдийн тусламжийн утасны шуурхай дуудлагын шугамаар 108 утасны зөвлөх, эсхүл зөвлөх нийгмийн ажилтан хоёр цагдаагийн тасаг, хэсгээс хүүхдийг дагалдах бичиг баримтын хамт авч Хүүхдийн 108 утасны дэргэдэх түр хамгаалах байранд түр байрлуулна. Харин хүүхэд орон нутагт байгаа тохиолдолд тухайн аймгийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан газар, хэлтэст утсаар мэдэгдэнэ.
4. Хүүхдийн 108 утаснаас хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл авсан дүүрэг, аймгийн ХГБЗХ-ийн газар, хэлтсийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэнд дуудлага мэдээллийг хүлээн авч бүртгээд мэдээллийн дагуу хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийх ажлыг дагуу зохицуулна.


5. Хүүхдийн болон түүний гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хорооны нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдийн оролцоотой гардан хийнэ. Ихэнх тохиолдолд хорооны нийгмийн ажилтан хийнэ.
6. Орон нутагт аймгийн ХГБЗХГ-ын хамгааллын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. Алслагдсан орон нутагт хүрч үйлчлэх шуурхай тусламжийн явуулын үйлчилгээ мөн шуурхай тусламжийн үйлчилгээнд хамаарна.
7. Алслагдсан сум, хорооны айл өрхийн хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай шуурхай дуудлага мэдээлэл авсан тохиолдолд тухайн хороо, сумын нийгмийн ажилтан очих боломжгүй тохиолдол орон нутагт бол сумын нийгмийн бодлогын хэлтэст, төв суурин газарт дүүргийн ГБХЗХХ-ийн хүүхэд хамгааллын хэлтэс хорооны нийгмийн ажилтан, засаг даргад мэдэгдэнэ. Зарим тохиолдолд 108-ын хяналтын дуудлагын мөрөөр ХГБЗХХ-ийн хамгааллын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.
8. Аймгийн ХГБЗХГ, дүүргийн ХГБЗХХ-ийн хамгааллын мэргэжилтнүүд, сум, хорооны нийгмийн ажилтнууд хүүхэд, гэр бүлийн нөхцлийг судалж хүүхэд гэртээ үлдэх боломжгүй, дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бол хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулж хамгаалах үйлчилгээ хүргэнэ.
9. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас гэмтэж бэртсэн хүүхдийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбох, хууль эрх зүйн туслалцаа шаардлагатай хүүхдийг хууль зүйн тусламж үйлчилгээтэй холбох, мөн боловсролын үйлчилгээтэй холбох зэрэг үйлчилгээг Шуурхай тусламжийн үйлчилгээний үед мөн хүргэнэ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН ЗУРАГЛАЛ

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ 14-Р ЗҮЙЛ

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ – 13-Р ЗҮЙЛ

Шуурхай тусламжийн үйлчилгээ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ- 12-Р ЗҮЙЛ



Зураг 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТӨД ТУСГАХ- ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТЫН ХЭЛБЭРҮҮД

I. ТОХИОЛДОЛ-КЕЙСЭД ТУЛГУУРЛАСАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОДОРХОЙ НЭГ ТОХИОЛДЛЫН КЕЙС МЕНЕЖМЕНТ ХИЙХ



I. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, КЕЙС МЕНЕЖМЕНТИЙГ УДИРДЛАГААР ХАНГАХ

Хүний нөөц- Ажиллах хүч	Мэргэжлийн улсирдлага	Эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт	Бодлого, хууль, журам, стандарт	Мэдээллийн нэгдсэн тогтолцоо	Нотомтоонд суурилсан хөтөлбөрүүд	Хүүхэд, гэр бүлийн оролцоо	Хүчирхийллийг үл тэвчих олон тэвчийн хандлага, нийтийн зүйлс
----------------------------	--------------------------	--	------------------------------------	---------------------------------	--	-------------------------------	---

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Гэр бүлд суурилсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ зэрэг хүүхэд, гэр бүлд шууд үзүүлэх үйлчилгээнээс гадна хүүхдийг бусад салбарын тухайлбал эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээ хамаарна.

Гэр бүлд суурилсан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг анхан шатанд ажиллаж буй хорооны хөгжлийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлтэй тулж ажиллаж буй төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан зэрэг шууд практикийн үйлчилгээ хүргэх нийгмийн ажилтан, хамгааллын ажилтан хүргэхийн зэрэгцээ бусад үйлчилгээтэй холбон зуучилна. Өөрөөр хэлбэл хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг бүртгэн авч хүүхэд гэр бүлтэй ажиллах кейс файл нээхээс эхлэх хаах хүртэл бүх үйлчилгээг гардан хүргэх, өөргөө хүргэх боломжгүй тохиолдолд бусад салбарын үйлчилгээнд холбон зуучлах ажлыг тухай тохиолдлыг хариуцсан нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийн хамт хүргэнэ.

Хүчирхийллийн хэлбэр, гэр бүлийн дэмжих тогтолцооноос хамаарч хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хугацаа харилцан адилгүй 6 долоо хоногоос жил хүртэл үргэлжилнэ. Бэлгийн хүчирхийлэл, хүний наймаа, үе дамжсан ядуурал зэрэг асуудалд өртсөн хүүхэд, түүний гэр бүлтэй ажиллах хугацаа илүү удаан хугацаанд үргэлжлэх магадлал өндөр байна.

Хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн хамгаалах, гэр бүлийг дэмжих гэж хоёр хуваана.

- *Гэр бүлийг хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээнд* дараах үйлчилгээ хамаарна. Үүнд: эцэг эх хүүхдээ хамгаалах, эерэг хүмүүжлийн аргад суралцахад нь туслах,, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах зэрэг үйлчилгээг багтана.
- *Гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээнд* дараах үйлчилгээ хамаарна. Үүнд: эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ойлголт мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд

туслах, гэр бүлд чиглэсэн бусад салбарын болон орон нутгийн нөөц боломжтой холбогдоход туслах зэрэг үйлчилгээний хэлбэрүүд багтана.

Мөн гэр бүлийг хамгаалах болон дэмжих үйлчилгээний аль ч хэлбэрийн үед тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллаж буй нийгмийн ажилтан нь кейс менежерийн хувьд хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, халамж, хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээтэй холбон зуучлах ажлыг хийнэ.

Явуулын үйлчилгээ нь гэр бүлд чиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хэлбэр. Ялангуяа хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүрч чадахгүй байгаа төвөөс алслагдсан сум, баг, хороонд амьдарч буй хүүхэд, түүний гэр бүлд зориулсан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ юм. Явуулын үйлчилгээгээр өмнө дурдсан гэр бүлийг хамгаалах, гэр бүлийн дэмжих үйлчилгээний бүх хэлбэрүүдийг аймаг, сум, дүүргийн ГБХЗХХ-ын хамгааллын мэргэжилтнүүд эсхүл төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэж буй төрийн бус байгууллагын ажилтнууд хүргэж болно.

Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ

Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртсөн үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг гэр бүлийн орчноос тусгаарлах, хохирогч хүүхдийг хамгаалах үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын тухайлбал хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага хяналт дор гэр бүлийн орчноос тусад нь хүүхдэд үзүүлэх асрамж халамжийн үйлчилгээг гэр бүлээс нь тусад нь хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ гэнэ (CWIG, 2020).

Хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээнд дараах үйлчилгээний хэлбэрүүд хамаарна. Үүнд

- Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ
- Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах
- Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ
- Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж гм)
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

Хүүхдийг түр болон удаан хугацаагаар асран халамжлах, хамгаалах үйлчилгээг асрамж халамжийн төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд асрах багш, туслах ажилтнууд хүргэнэ. Тодруулбал, халамжийн төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүй нар төв байрлах

хүүхэд бүрийн хөгжлийн төлөвлөгөөг гарган хүүхэд бүрт чиглэсэн дараах үйлчилгээ үзүүлнэ. Үүнд: хүүхдийг асран халамжлах, хүүхдийн хөгжил, амьдрах ухааны мэдлэг, ур чадвар, дадал олгоход чиглэсэн хөгжлийн үйлчилгээнээс гадны төвийн гадна байрлах хүүхдийг боловсролын, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн, сэтгэл зүйн засал эмчилгээ үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээ зэрэг үйлчилгээ хүргэнэ.

Зорилтот урьдчилан сэргийлэх шууд биш үйлчилгээ

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөхөөс сэргийлэх, мөн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдийг хүчирхийлэлээс сэргийлэхээс гадна эцэг асран хамгаалагчийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хамгааллын тогтолцооны бүх оролцогч талуудын чадавхийг нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээтэй шууд биш үйлчилгээ юм. Шууд бус үйлчилгээ гэдэгт нийгмийн ажлын макро практикт өргөн хэрэглэх нөлөөлөл хийх, чадавхи бэхжүүлэх, хөрөнгө босгох, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх зэрэг хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөр хамаарна.

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй бүлэг, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн, албан хаагч, байгууллагад голлон чиглэнэ. Хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй бүлэгт, хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй хүүхэд, бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үрчлэгдсэн, асрамж халамж тогтоолгон бусдын асрамж халамжинд байгаа хүүхэд, эцэг эх асран хамгаалагчаасаа тусдаа амьдарч байгаа хүүхэд, гэрч хохирогч хүүхэд, хууль зөрчсөн хүүхэд зэрэг хамаарна.

Өмнө дурдсанчлан хүүхэд хамгааллын тогтолцоо, хамгаалын үйлчилгээний оролцогч талууд, хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, олон нийтэд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг хүүхэд хамгааллын бүх шатны байгууллага, хамгааллын үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, хүүхэдтэй ажилладаг боловсрол, эрүүл мэнд, халамж, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байгууллагууд хэрэгжүүлнэ.

Нэр томъёоны тайлбар

- *Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх, асран хамгаалагч, бусад хуулийн этгээд, иргэн хүүхэд хамгаалах үүргээ биелүүлэхгүй тохиолдолд төр хөндлөнгөөс оролцож хүүхдийг хамгаалахыг хэлнэ.*
- *Хүүхэд хамгааллын тогтолцоо нь дараах долоон дэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:*
 - Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин
 - Зохицуулагдсан эрх бүхийн байгууллага, бүтэц зохион байгуулалт
 - Хүүхэд хамгааллын ажиллах хүч - мэргэжлийн боловсон хүчин
 - Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ
 - Хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт
 - Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ, өгөгдөл
 - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үл тэвчдэг олон нийт (хүүхдийн амьдарч буй орон нутгийн иргэд, байгууллага, хүүхдийн дан ба өргөтгөсөн гэр бүл, хүүхэд өөрөө бас олон нийтийг нэг хэсэг болно)
- *Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь дээр дурдсан хамгааллын бүрэлдэхүүн дэд хэсгүүдтэй нягт холбоотой. Хамгааллын тогтолцооны аль нэг дэд хэсэг нь ажиллахгүй эсхүл үйл ажиллагаа нь хэвийн биш байхад хүүхэд хамгааллын үйлчилгээнд шууд ба дам байдлаар нөлөөлнө.*
- *Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, зорилтот урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нөлөөллийн ажлаас бүрдэнэ.*
- *Шуурхай тусламжийн үйлчилгээ гэдэг нь хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүчирхийллийн улмаас үүссэн сэтгэл санаа, бие махбодын хямралыг даван туулахад туслах яаралтай тусламжийн үйлчилгээг хэлнэ.*
- *Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэдэг нь хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлын улмаас үүссэн сэтгэл санаа, бие махбодын цочрол, гэмтэл, шарх сорвийг эдгээх, хүүхэд амар тайван, аюулгүй өсөж хөгжих хэвийн амьдралд ороход нь туслах төрөл бүрийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ гэж хуваана.*

- *Явуулын үйлчилгээ* гэж алслагдсан хороо, багийн хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй гэж мэдээлэгдсэн хүүхдэд хүрч үйлчлэх шуурхай тусламжийн болон нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ.
- *Зорилтот урьдчилан сэргийлэх хөтөлбөр гэдэг* нь тодорхой газар нутаг, олон нийт, зорилтот бүлгийн дунд түгээмэл тохиолдох эсхүл анхаарал татах хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийн тархалтыг бууруулах, таслах зогсоох зорилго, зорилт бүхий тусгайлан боловсруулсан стратеги, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, төсөл хөрөнгийн урьдчилан тооцоолж боловсруулсан цогц төлөвлөгөө.
- *Тохиолдлын кейс менежмент гэдэг* нь Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдлын үед тухайн тохиолдлыг хариуцан ажиллаж буй нийгмийн ажилтан/кейс менежер нь дангаараа буюу хамтарсан багийн гишүүд, бусад мэргэжилтэнтэй хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээ хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх буй байгууллага мэргэжилтнүүдтэй холбох, тэдний уялдаа холбоог зохицуулах, хянах, үнэлэх, хаах үйл явцыг бүхэлд хэлнэ.
- *Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент.* Хүүхэд, гэр бүлтэй ажиллах тодорхой нэг тохиоллын кейс менежментийг үр дүнтэй хийхийн тулд кейс менежментийг тогтолцооны түвшинд анхаарч удирдан зохион байгуулахыг тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент гэнэ. Тогтолцооны түвшний кейс менежментийн бүрэлдэхүүнд 1) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэж буй хүний нөөц- ажиллах хүч; 2) шууд үйлчилгээ хүргэж буй ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах зохион байгуулалт, бүтэц; 3) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт; 4) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхэд бодлого, хууль, журам, дүрэм заавар; 5) хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх хүүхэд, гэр бүлийн оролцоо; 6) хүүхдийн хамгааллын дэмжих олон нийтийн хандлага, үнэт зүйлс зэрэгт чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ зэрэг багтана.
- *Нөлөөлөл* гэж хувь хүн, бүлэг, байгууллага, олон нийтэд нөлөөлөх бодлого, хууль дүрэм, практик үйл ажиллагаа, хандлагад өөрчлөлт хийхэд чиглэсэн үйл явц. Нөлөөллийн ажил нь хүмүүст нөлөөлөх бодлого, дүрэм, практик үйл ажиллагаа, хандлагад нөлөөлөх зорилготой үе шат, алхам бүрээр нь бодож боловсруулсан төлөвлөгөөт ажил.

- *Явуулын аян* гэж алслагдсан хороо, багт хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэлнэ.
- *Үйл ажиллагаа* гэж төлөвлөгдсөн ба төлөвлөгөөт бус нэг удаагийн үйл ажиллагаа
- *Мэргэжлийн үйлчилгээ* гэж нийгмийн үйлчилгээний байгууллагын мэргэжлийн удирдлага дор үйлчилгээ үзүүлэх чиглэлээрээ бэлтгэгдсэн мэргэжилтний бодож боловсруулсан үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, амьдралд эерэг өөрчлөлт авчрах мэргэжлийн үйл ажиллагаа.
- *Мэргэжлийн удирдлага (supervision)* гэж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд оролцогч байгууллагууд нийгмийн үйлчилгээний байгууллага үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхийн тулд тодорхой зохион байгуулалттай, хуульд зааснаас бусад нөхцөлд нууцыг хадгалах үүрэгтэйгээр тулгарч буй асуудлаа ярилцаж, мэргэжлийн дэмжлэг тусалцааг авах мэргэжилтнүүдийн ажлаа товч танилцуулах, зөвлөлдөх, заавар зөвлөгөө авч өгөх, эргэцүүлэн тунгаах боломж олгох, манлайлах, ажлаа эргэн дүгнэх зэрэг хэлбэрээр явагдах албан ёсны ярилцлагыг хэлнэ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ СУДАЛГААНЫ ДҮН

Зөвлөх А. Батхишиг, МУИС-ийн дэд профессор, доктор
Т. Цэндсүрэн, МУБИС-ийн дэд профессор, доктор

2021.07-08 сар

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Тоон судалгаанд оролцогчдын байршил, хувиар (N=324).	5
---	---

Дүрсийн жагсаалт

Дүрс 1. Судалгаанд оролцогчдын байршил, хувиар (N=323)	6
Дүрс 2. Судалгаанд оролцогчдын хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллага, (N=324).	7
Дүрс 3. Судалгаанд оролцогчдын албан тушаал, эзлэх хувиар (N=324)	8
Дүрс 4. Судалгаанд оролцогчдын мэргэжил, эзлэх хувиар (N=324)	8
Дүрс 5. Мэдээлэл авснаас хойш эрсдлийн үнэлгээ хийх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувь	9
Дүрс 6. Хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх өндөр эрсдэлтэйг тогтоосны дараа нөхцөл байдлын үнэлгээ хийх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар	10
Дүрс 7. Нөхцөл байдлын үнэлгээний дараа шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар	11
Дүрс 8. Түр хамгаалах байранд үзүүлж буй мэргэжлийн үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь	11
Дүрс 9. Шуурхай тусламжийн үйлчилгээний нэг тохиолдол дээр ажиллах мэргэжилтнүүд	12
Дүрс 10. Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг байдал, эзлэх хувиар	13
Дүрс 11. Түр хамгаалах байрны харуул хамгаалалтын хэлбэрүүд, эзлэх хувь	14
Дүрс 12. Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувь	15
Дүрс 13. Оролцогчдын үзүүлдэг нөхөн сэргээх үйлчилгээний хэлбэрийн давтамж	16
Дүрс 14. Нөхөн сэргээх үйлчилгээнд оролцох ажилтан, албан хаагчдын эзлэх хувь	17
Дүрс 15. Нөхөн сэргээх үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар	18
Дүрс 16. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлдэг зорилтот хөтөлбөрүүд,	21
Дүрс 17. Урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нөлөөллийн ажил хэрэгжүүлэхэд оролцох мэргэжилтэн, албан хаагчид	22

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт.....	3
Дүрсийн жагсаалт.....	3
Судалгааны дүн	4
1. Оролцогчдын талаарх мэдээлэл.....	4
2. Шуурхай тусламжийн үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол	9
3. Нөхөн сэргээх үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол.....	15
4. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол	20
Судалгааны дүгнэлт.....	23
Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын Хүүхэд хамгаалах тухай хуульд оруулах санал	26

Судалгааны дүн

2021 оны 8 дугаар сарын 2-ны өдрөөс 8 дугаар сарын 9 хооронд долоо хоногийн хугацаанд хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харъяа болон түүний салбар, нэгжүүдтэй хамтран ажилладаг байгууллагын ажилтнуудаас “Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх цахим асуумж судалгаа”-г авлаа. Асуумж судалгааг авахдаа оролцогчдод дараах хүсэлт бүхий линкийг ГБХЗХГ-ын байгууллагын албаны цахим шуудангаар дамжуулан оролцогчдод илгээсэн.

Энэхүү асуумж судалгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгах, үйлчилгээний хувьсах зардал, стандарт боловсруулахтай холбоотой мэдээллийг цуглуулах зорилготой. Асуумж судалгааны дүнг үйлчилгээний хувьсах зардал, стандарттой холбоотой баримт бичигт тусгах учир аль болох тодорхой, бодитой, шударга бөглөнө үү. Та асуумж судалгаанд хариулж дууссны дараа Submit товчийг заавал дарж хариултыг илгээнэ үү. Баярлалаа.

Судалгаанд нийт 324 хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй ажилтан, албан хаагчид оролцов. Оролцогчдын талаарх мэдээллийг дараах дэд бүлэгт дэлгэрэнгүй харуулав. Мөн сонгосон дөрвөн аймгийн ГБХЗХГ-ын удирдах ажилтан, хүүхдийн эрхийн байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, хамтран ажилладаг аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, хууль зүйн хэлтсийн дарга, мэргэжилтэн, хамтарсан багийн гишүүд болох хүүхэд хамгааллын үйлчилгээ хариуцсан удирдах ажилтан, ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлагын тухай аймагт очиж хийж чанарын мэдээллийг цуглуулж мэдээллийг нягталсан.

Онлайн асуумж судалгаагаар дөрвөн үндсэн чиглэлийн мэдээлэл авахыг зорьсон. 1-рт судалгаанд оролцогчдын хүн ам зүй, ажлын байршил, боловсрол, мэргэжлийн талаар, 2-р хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээний талаар, 3-р хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээний талаар, эцэст буюу 4-р хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаарх тоон мэдээлэл авахыг зорьсон.

1. Оролцогчдын талаарх мэдээлэл


Онлайн асуумж судалгаанд Монгол Улсын 21 аймаг, Улаанбаатар хотын бүх дүүргийн хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид, 324 хүн оролцов. Оролцогчдын хүйсийн хувьд 324 оролцогчийн 67 буюу 20.7 хувь нь эрэгтэй, 257 буюу 79.3 хувь нь эмэгтэй оролцогчид байв. Насны хувь оролцогчдын дундаж нас нь 35, хамгийн залуу оролцогч 21 настай, хамгийн ахмад оролцогч нь 60 настай байлаа.

324 оролцогчийн 105 буюу 32.4 хувь нь УБ хотод ажилладаг, 219 буюу 67.6 хувь нь аймаг орон нутагт хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Тоон судалгаанд оролцогчдын байршил, хувиар (N=324).

Нэрс	N	%
Архангай	14	4.3
Баян-Өлгий	11	3.4
Баянхонгор	14	4.3
Булган	9	2.8
Говь-Алтай	24	7.4
Говьсүмбэр	3	0.9
Дархан-Уул	11	3.4
Дорноговь	14	4.3
Дорнод	13	4.0
Дундговь	6	1.9
Завхан	11	3.4
Орхон	19	5.9
Өвөрхангай	10	3.1
Өмнөговь	16	4.9
Сүхбаатар	6	1.9
Сэлэнгэ	1	0.3
Төв	13	4.0
Увс	4	1.2
Ховд	2	0.6
Хөвсгөл	13	4.0
Хэнтий	4	1.2
Багануур, УБ	12	3.7
Багахангай, УБ	10	3.2
Баянгол, УБ	9	2.8
Баянзүрх, УБ	22	6.8
Налайх, УБ	13	4.1
Сонгинохайрхан, УБ	1	0.3
Сүхбаатар, УБ	14	4.3
Хан-Уул, УБ	18	5.7
Чингэлтэй, УБ	6	1.9
	324	100.0

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, түвшин, үйл явцын талаарх төсөөлөл, санал бодлыг судлах тоон судалгаанд 323 оролцогч оролцсон. Оролцогчдын ажиллаж, амьдарч буй аймаг дүүрэг, хотын байршлын эзлэх хувь, тархалтаас харахад Говь-Алтай, Орхон, Өмнөговь аймгууд, УБ-ын Баянзүрх, Хан-Уул аймгийн оролцогчид нийт оролцогчдын 5-аас 7.8 хүртэл хамгийн их хувийг эзэлж байна. Харин Говь-Сүмбэр, Ховд, Сэлэнгэ аймаг, УБ хотын Сонгинохайрхан дүүргийн оролцогчид нэг хүртэлх хамгийн бага хувийг эзэлж байв (Дүрс 1).



Дүрс 1. Судалгаанд оролцогчдын байршил, хувиар (N=323)

Тус судалгаанд хүүхэд хамгааллын үйлчилгээг үндэсний, нийслэл, аймгийн, сум, дүүргийн хороо, багийн түвшинд, мөн хүүхэдтэй тулж ажилладаг асрамж халамжийн төв, газруудын төлөөлөгчид оролцсон. Үүнээс сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн 26.3 хувь, сум, баг, хорооны хамтарсан багийн гишүүд 18 хувь, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)-ын удирдах ажилтан, мэргэжилтэн 14.9 хувь, хорооны Засаг даргын тамгын газрын ажилтан 10.5 хувь, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс (ГБХЗХХ)-ийн удирдах ажилтан, мэргэжилтэн, ажилтнууд 9.9 хувь, асрамж халамжийн төвийн удирдах ажилтан, ажилтан 7.1 хувь, түр хамгаалах байрны зохицуулагч, ажилтан 4 хувь, ГБХЗХГ буюу үндэсний агентлагийн удирдах ажилтан, мэргэжилтэн 2.8 хувь, нэг цэгийн үйлчилгээний зохицуулагч, ажилтан 2.2 хувь, нийслэлийн ГБХЗХГ-ын удирдах ажилтан, мэргэжилтэн 1.5 хувь, аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн 1.2 хувь, Хүүхдийн 108 утасны ажилтан 0.6 хувь, бусад байгууллагын ажилтнууд 0.9 хувийг тус тус эзэлж байна (Дүрс 2).



Дүрс 2. Судалгаанд оролцогчдын хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллага, (N=324).

Аймаг, сум дүүрэг, хороо, багийн хамтарсан багийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагын ажилтан албан хаагчид тус тоон судалгаанд түлхүү оролцсон байна. Судалгаанд оролцогчдын эрхэлж буй албан тушаалын хувьд нийгмийн ажилтны орон тоон дээр ажиллаж буй оролцогчид хамгийн их 48 хувийг эзэлж байв. Мөн хүүхэд хамгааллын мэргэжилтний албан тушаал дээр ажиллаж буй оролцогч 10 хувь, бусад албан тушаал дээр ажиллаж буй оролцогчид 11.5 хувь, хэлстийн дарга 5.9 хувь, сургуулийн нийгмийн ажилтан 4.3 хувь, газрын дарга 3.7 хувь, хүүхдийн эрхийн улсын байцаагч 3.1 хувь, сэтгэл зүйч 2.8 хувь, хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн 2.2 хувь, санхүүгийн ажилтан 2.2 хувь, халамж, асрамжийн төвийн багш 2 хувь, бүртгэл мэдээллийн ажилтан 1.2 хувь, халамж асрамжийн төвийн зохицуулагч нэг хувь, хяналт үнэлгээний ажилтан нэг хувь, халамжийн мэргэжилтэн, хууль зүйн хорооны гишүүн тус тус 0.3 хувийг тус тус эзэлж байв (Дүрс 3).

Ажилласан туршлагыг судалгаанд оролцогчид одоо ажиллаж байгаа албан тушаал дээр ажилласан жилээр бодож судалж үзэхэд оролцогчид дундажаар 5 жил тухайн албан тушаал дээрээ ажиллаж, хамгийн удаан ажилласан оролцогч 38 жил, хамгийн богино хугацаанд ажиллаж байгаа оролцогч тухайн албан тушаал дээр ажиллаад хэдхэн хонож байгаа нилээдгүй ажилтан албан хаагчид байлаа.



Дүрс 3. Судалгаанд оролцогчдын албан тушаал, эзлэх хувиар (N=324)

Хүүхэд хамгааллын үйлчилгээг үндэсний, нийслэл, аймаг, сум, дүүрэг, хороо, багийн түвшинд үзүүлж байгаа болон үйлчилгээг удирдан чиглүүлж, үнэлж дүгнэж, бүртгэж буй судалгаанд оролцсон 324 оролцогчийн 80 хувь бакалаврын, 18 хувь магистрийн үлдсэн хоёр хувь нь бүрэн дунд, тусгай дунд, докторын боловсролтой мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид байлаа. Эзэмшсэн мэргэжлийн хувьд нийт оролцогчийн 24.8 хувь нь нийгмийн ажилтан, 15.5 хувь нь багш, 12.7 хувь нь эрх зүйч, хуульч, нягтлан бодогч, эдийн засагч, 7.1 хувь нь сэтгэл зүйч, 3.1 хувь нь инженер, 2.8 хувь сэтгүүлч, 1.5 хувь нь улс төр судлаач, 0.6 хувь статистикч, программист, 19.2 хувь бусад мэргэжлийн боловсрол эзэмшсэн оролцогчид байв (Дүрс 4).




Дүрс 4. Судалгаанд оролцогчдын мэргэжил, эзлэх хувиар (N=324)


Судалгаанд оролцогчдын мэргэшлийн талаарх нэмж тодруулах асуултад оролцогчид нийгмийн ажил, хүүхэд хамгаалал, төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн удирдлага, эрх зүй, сэтгэл судлал, сэтгүүл зүй, нягтлан бодох эдийн засаг, сэтгүүл зүй, хүүхдийн эмч, сэтгэл засал, гэр бүл судлал, орчуулагч, санхүү, социологи, аялал жуулчлал, олон улсын харилцаа, олон улс судлал, газар зүй, угтах үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, удам зүй зэрэг хүүхэд хамгаалалтай холбоотой болон холбоогүй олон янзын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн гэж хариулжээ.

2. Шуурхай тусламжийн үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэсэн мэдээлэл хүлээн авснаас эхлээд шуурхай тусламжийн үйлчилгээ хүргэж хүүхдийн аюулгүй байдлыг хангах хүртэлх мэдээлэл хүлээн авах, аюулгүй байдал, эрсдлийн үнэлгээ хийх, шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэх эсхүл холбон зуучлах, хүүхдийг аюулгүй газар байрлуулах зэрэг үйлчилгээг хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээнд хамруулна. Судалгаанд хамрагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж буй 300 ажилтны 65.7 хувь нь хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэсэн мэдээлэл хүлээн авснаас 24 цагийн дотор хүүхдийн эрсдлийн үнэлгээ хийдэг гэж хариулсан бол 16 хувь 48 цагийн дотор, 16 хувь нь 72 цагийн дотор, 1.3 хувь нь долоо хоногийн дотор, 0.7 хувь нь 14 хоног дотор, 0.3 хувь нь 30 хоног дотор эрсдлийн үнэлгээ хийж хүчирхийлэлд өртснийг тогтоодог гэж хариулжээ.




Дүрс 5. Мэдээлэл авснаас хойш эрсдлийн үнэлгээ хийх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувь



Дүрс 6. Хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх өндөр эрсдэлтэйг тогтоосны дараа нөхцөл байдлын үнэлгээ хийх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар


Хүчирхийлэлд өртсөн ба өртөх эрсдэлтэйг тогтоосны дараа хэдийн хугацаанд нөхцөл байдлын үнэлгээ хийдэг тухай хэрхэн хариулсныг Дүрс 6-д харууллаа. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг ажилтан албан хаагчид эрсдлийн үнэлгээний дараа хүүхэд хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэйг тогтоосны 24 цагийн дотор нөхцөл байдлын үнэлгээ гэж оролцогчдын 67 хувь нь хариулсан байна. Оролцогчдын 13 хувь нь 25 цагаас 48 цаг дотор буюу нэгээс хоёр өдөрт нөхцөл байдлын үнэлгээ хийдэг, 9 хувь нь 49-өөс 72 цаг дотор хоёроос буюу гурван өдрийн дотор нөхцөл байдлын үнэлгээ хийдэг гэж хариулсан байна. Харин долоо хоног дотор нөхцөл байдлын үнэлгээ хийдэг гэж хоёр хувь, 7 дээш 14 хоног дотор гэж нэг хувь, 15-аас 30 хоног дотор нөхцөл байдлын үнэлгээ хийдэг гэж оролцогчдын нэг хувь тус тус хариулсан.

Харин нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хугацааг хамгийн хурдандаа 24 цаг дотор үзүүлдэг гэж судалгаанд оролцогчдын 59 хувь нь үзсэн байна. Шуурхай тусламжийн үйлчилгээг нөхцөл байдлын үнэлгээний дараа хоёр хоногийн дотор хийдэг гэж 14 хувь, гурав хоногийн дотор шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг гэж 14 хувь, долоо хоног дотор үзүүлдэг гэж 4 хувь, 14 хоног, нэг сар, нэг сар хагасын дотор гэж тус тусад 1 хувийн хариулт өгсөн байна (Дүрс 7).



Дүрс 7. Нөхцөл байдлын үнэлгээний дараа шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хугацаа, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар

Судалгаанд оролцсон хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй ажилтнууд Дүрс 8-д үзүүлсэнчлэн сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээ, кейс менежмент, эмнэлгийн шуурхай тусламжийн үйлчилгээ, хууль эрх зүйн туслалцаа, үйлчилгээ хамгийн түгээмэл үзүүлдэг гэж оролцогчдын 50 хувиас дээш тооны оролцогчид мэдээлсэн байна.




Дүрс 8. Түр хамгаалах байранд үзүүлж буй мэргэжлийн үйлчилгээ тус бүрийн эзлэх хувь

Халамжийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээг мөн оролцогчдын 44-өөс 49 хувь түр хамгаалах байранд үзүүлдэг гэсэн бол оролцогчдын 12.7 хувь нь бусад үйлчилгээ үзүүлдэг гэж хариулан, мөн 12.7 хувь миний ажлын байрны тодорхойлолтонд түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх талаар дурдаагүй гэж тус тус хариулжээ.

“Танай тасаг, хэлтэс, тасаг өнгөрсөн нэг жилийн хугацаанд хэдэн хүүхдийн кейс/тохиолдол дээр шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн бэ?” асуултад судалгаанд оролцогчид нийт 31627 кейс дээр шуурхай тусламж ийн үйлчилгээ үзүүлжээ. Шуурхай тусламжийн үйлчилгээг нэг жилийн хугацаанд үзүүлсэн кейсийн дундаж тоог тооцвол нэг тасаг, хэлтэст дундажаар 106 кейсэд шуурхай тусламж үзүүлсэн байна. Харин Улаанбаатар хотыг хамарсан шуурхай тусламж үзүүлэх байгууллагад хамгийн ихдээ 3950 хүүхдийн кейс дээр шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг тухай мэдээлжээ.


Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн нэг тохиолдол дээр ямар ямар мэргэжилтэн оролцож хамтран ажилладаг тухай асуухад нийт оролцогчдын 69 хувь нь хороо, сумын нийгмийн ажилтан оролцдог, 61 хувь нь ГБХЗХГ эсхүл ГХБЗХХ-ийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн оролцдог, 57 хувь нь сургуулийн нийгмийн ажилтан оролцдог, 56 хувь нь хороо, сумын засаг дарга, 53 хувь нь хороо, сумын хэсгийн байцаагч гэсэн хамтарсан багийн болон хүүхэд хамгааллын мэргэжилтэн оролцдог гэж хариулжээ (Дүрс 9).



Дүрс 9. Шуурхай тусламжийн үйлчилгээний нэг тохиолдол дээр ажиллах мэргэжилтнүүд

Сум хорооны нийгмийн ажилтан, ГБХЗХГ эсхүл ГХБЗХХ-ийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан, хороо, сумын хэсгийн байцаагч, халамжийн мэргэжилтэн, сум, дүүргийн цагдаагийн хэлтсийн ажилтан, өрхийн эмч зэрэг 11 мэргэжилтэн, албан хаагч шуурхай тусламжийн үйлчилгээнд оролцдог гэж нийт оролцогчдын 30-аас 70 хувь нь хариулжээ.

Шуурхай тусламжийн үйлчилгээнд хамаарах үйлчилгээний хэлбэрүүдийг хир давтамжтай үзүүлдэг тухай асуухад эрсдлийн үнэлгээ хийх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, кейс файл нээж, кейс менежментийг хийж эхлэх гэх мэт нийгмийн ажлын үйлчилгээний эхний шатны үйл ажиллагаануудыг үргэлж үзүүлдэг гэж нийт оролцогчдын 55-иас их хувь нь тэмдэглэсэн байна (Дүрс 11).




Дүрс 10. Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг байдал, эзлэх хувиар

Мөн Хүүхдийн тусламжийн 108 утсаар мэдээлэл хүлээн авах, мэдээллийн дагуу шуурхай арга хэмжээ авах, эмнэлгийн яааралтай тусламжтай холбох, түр байршуулан хамгаалах, хууль зүйн тусламж, үйлчилгээтэй холбох, сэтгэл зүйн эмчилгээ, засал хийх зэрэг үйлчилгээ үргэлж үзүүлдэг гэж оролцогчдын 40-өөс 47 хувь нь хариулсан. Нийт оролцогчдын 35.2 хувь буюу оролцогчдын гуравны нэг нь явуулын шуурхай тусламжийг байнга үзүүлдэг гэж үзсэн.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах байр тухайн дүүрэг, орон нутагт байдаг эсэх талаарх асуултад оролцогчдын 77.5 хувь ($n=251$) нь түр хамгаалах байртай, 22.5 хувь ($n=73$) нь түр хамгаалах байргүй гэж хариулсан байна. Түр хамгаалан байруудад дундажаар 6 орон тооны ажилтан ажилладаг бөгөөд хамгийн их орон тооны байр нь 30 хүртэлх ажилтан, ажилчидтай байна. Харин орон тооны ажилтангүй түр хамгаалах байр хэд хэд байдаг тухай судалгаанд оролцогчид орон нутгийнхаа түр хамгаалах байрны жишээн дээр тулгуурлан мэдээлжээ.

Түр хамгаалах байрны харуул хамгаалалтын талаар 210 оролцогч хариулж 114 оролцогч миний ажлын байрны тодорхойлолтонд энэ талаар тусгагдаагүй тул хариулж мэдэхгүй гэжээ.




Дүрс 11. Түр хамгаалах байрны харуул хамгаалалтын хэлбэрүүд, эзлэх хувь

Харуул хамгаалалтын талаар хариулсан 210 оролцогчийн 38 буюу 18.1 хувь нь түр хамгаалах байр гэрээт харуул хамгаалалттай, 116 буюу 55.2 хувь цагдаагийн байгууллагын хамгаалалтанд байдаг гэж, 56 буюу 26.7 хувь түр хамгаалах байр нь орон тооны харуул хамгаалалттай гэж хариулжээ (Дүрс 11).

Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийн талаар судалгаанд оролцогчдын санал бодлыг Дүрс 12-үзүүллээ.

Шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслэл




Дүрс 12. Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувь

Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд тээврийн хэрэгсэл (77%), бичиг хэрэгсэл (74%), хүүхдийн бие сэтгэл санааг үнэлэх тест, багаж хэрэгсэл (72%), диктофон-дуу хураагуур (67%), хүүхдийн хоол, унд (66%), харилцаа холбооны хэрэгсэл (62%), хүүхдийн ариун цэвэр, ахуйн хэрэгсэл (61%), хүүхэдтэй харилцах тоглоом наадгай, хүүхдийн дотуур болон гадуур хувцас (56%), энгэрийн камер (48%), үзүүлэн таниулах материал (47%) зэргийг ашиглах шаардлагатай гэж оролцогчдын 47-оос 77 хувь нь үзсэн байна.

3. Нөхөн сэргээх үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хэв амьдралд эргэн оруулахад нь туслах нөхөн сэргээх үйлчилгээ судалгаанд оролцсон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг 319 ажилтан, албан хаагчдын 82 хувь нь үзүүлдэг, 18 хувь нь үзүүлдэггүй гэж хариулсан. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх олон талт нөхөн сэргээх үйлчилгээг хир давтамжтай хүргэдэг талаар оролцогчдын хариултыг Дүрс 13-т харуулав.



Дүрс 13. Оролцогчдын үзүүлдэг нөхөн сэргээх үйлчилгээний хэлбэрийн давтамж

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд кейс менежментийн үйлчилгээг үргэлж үзүүлдэг гэж хамгийн олон оролцогч буюу 59.3 хувь илэрхийлсэн бол 47.2 хувь нь эмнэлгийн үйлчилгээтэй үргэлж холбон зуучилдаг, 46.9 хувь хүүхэд, гэр бүлийн дэмжих ба хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээ байнга хүргэж, сэтгэл зүйн засал, эмчилгээ үзүүлэх эсхүл холбон зуучилдаг, 45.4 хувь хууль зүйн тусалцаа, үйлчилгээтэй холбох, 43.8 хувь нь халамжийн үйлчилгээтэй холбодог, 42.3 хувь нь хууль зөрчсөн хүүхэд ба түүний гэр бүлд чиглэсэн үйлчилгээ байнга гэж хүргэдэг тус тус тэмдэглэсэн байна. Мөн гэрч хохирогч хүүхэд, түүний гэр бүл, хүүхдийг гэр бүлээс нь тусад асран халамжлах үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих үйлчилгээ байнга үзүүлдэг гэсэн оролцогчдын хувь харьцангуй бага 30-аас 40 хувь дотор байв. Харин алслагдсан сум, баг, хорооны хүүхэд, гэр бүлд чиглэсэн явуулын үйлчилгээ


үргэлж үзүүлдэг гэж илэрхийлсэн оролцогчдын хувь 30 хүрэхгүй хамгийн бага хувьтай байлаа (Дүрс 13).

Танай байгууллага, тасаг, хэлтэс сүүлийн нэг жилийн хугацаанд хүчирхийлэлд өртсөн хэдэн хүүхдийн кейс/тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлсэн бэ гэсэн асуултад судалгаанд оролцсон 324 оролцогчийн байгууллага, тасаг хэлтэст нийт 2048 тохиолдол, нэг тасаг хэлтэст дундажаар нэг жилийн хугацаанд 6 кейсэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг бол, хамгийн их тохиолдол 70 тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүчирхийлэлд өртсөн нэг хүүхдийг хүчирхийлэлд өртсөн хэлбэрээс хамаарч нөхөн сэргээх үйлчилгээг хүргэж кейс нээхээс хааж дуусгах хүүртэлх хугацаа дундажаар 104 ажлын хоног буюу 5 сар зарцуулдаг гэж оролцогчид хариулсан байна. Хамгийн урт хугацаа нь 720 ажлын хоног буюу 3 жил гэж хариулсан байна.

Нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлтэй ажиллаж кейс нээхээс хаах хүртэл хэдэн удаа уулздаг гэсэн асуултад оролцогчид нэг уулзахдаа дундажаар нэг цаг гаруй уулзана. Кейс нээхээс хаах хүртэл дундажаар 10 удаа уулзана гэж оролцогчид хариулсан байна.


Нэг кейс буюу нэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн нэг тохиолдлын хүүхэд, гэр бүлд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын ямар ямар мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид оролцдог вэ гэдэг асуултад хороо, сумын нийгмийн ажилтан оролцдог гэж нийт оролцогчдын 82 хувь хариулжээ. Мөн сум, хорооны хамтарсан багийн ахлагч болон гишүүд болох засаг дарга, өрхийн эмч, хэсгийн байцаагч, халамжийн мэргэжилтэн сум хорооны цагдаагийн хэлтсийн ажилтан нарыг оролцдог гэж нийт оролцогчдын 50-иас илүү хувь нь үзжээ. Түүний дотор аймаг, дүүргийг ГБХЗХ-ын газар, хэлтсийн хүүхэд хамгааллын ажилтнууд оролцдог гэж нийт оролцогчдын 65 хувь нь хариулжээ.



Дүрс 14. Нөхөн сэргээх үйлчилгээнд оролцох ажилтан, албан хаагчдын эзлэх хувь

Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сум, дүүргийн ЭМТ-ийн эмч, халамж, асрамжийн төвийн нийгмийн ажилтан, ТББ-ын мэргэжилтэн, бусад мэргэжилтний оролцоо харьцангуй бага гэж судалгаанд оролцогчид үзсэн байна. Ерөнхийдөө нөхөн сэргээх үйлчилгээнд сум, хорооны хамтарсан багийн гишүүд, аймаг, дүүргийн ГБХЗХ-ийн газар, хэлтсийн хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд зэрэг найман ажилтан, албан хаагч оролцдог байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх үйлчилгээнд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, хэрэглэгдэхүүн ашиглах шаардлагатай асуултад хамгийн түрүүнд хүүхдийн бие махбод, сэтгэл санааг үнэлэх төрөл бүрийн тест, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн (76%), хүүхэд эцэг эхтэй уулзаж ярилцах тусгай өрөө (75%), хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэрээс нь түр хамгаалах байранд аваачих хүртэл, эсхүл эрсдэлт бүлгийн хүүхэдтэй ажиллах явцад хүүхдэд өгөх хоол, унд (75%) хэрэгтэй гэж оролцогчдын дөрөвний гурав нь тодорхойлжээ (Дүрс 15).



Дүрс 15. Нөхөн сэргээх үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн, оролцогчдын тодорхойлсон эзлэх хувиар

Мөн Дүрс 15-д үзүүлснээр кейс менежмент хийх, хүүхдийн хавтаст хэрэгт шаардлагатай бичиг хэрэг, бичгийн хэрэгсэл (71%), эрсдэлт бүлгийг хүүхэдтэй ажиллах явцад хүүхдэд хэрэгтэй ариун цэвэр, ахуйн хэрэгсэл (68%), компьютер (68%), хүүхдийн хувцас (67%), хүүхэдтэй харилцах тоглоом наадгай (65%), принтер (65%), дуу хураагуур (65%), үзүүлэн таниулах материал (64%), харилцаа холбооны хэрэгсэл (64%), явуулын үйлчилгээнд шаардлагатай тээврийн хэрэгсэл (64%), түгжээтэй шүүгээ (64%), ширээ сандал (60%) шаардлагатай гэж оролцогчдын дийлэнх хувь нь хариулжээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах тэдэнд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ямар тусгай заалтыг хууль, дүрэм, журам, стандартад тусгах шаардлагатай тухай оролцогчид дараах саналыг хэлж байна. Үүнд:

Хамгааллын үйлчилгээний хувьд үйлчилгээний стандарт арга техникийг тодорхой болгож, заавал мөрдөхийг шаардах, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг заавал мэдээллэх, мэдээллийн мөрөөр шуурхай тусламжийн үйлчилгээг заавал хүргэх, нэг нийгмийн ажилтны хариуцах кейсийн тоог тодорхой болгох, түр хамгаалах байранд хүүхэд байрлах хугацааг уртасгах, түр хамгаалах байранд ажиллах ажилтан, ажилчдын орон тоог тодорхой болгох, мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, хүүхэд хамгааллын бодлогыг тодорхой болгох, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг дугаар харгалзахгүй хүргэх, нөхөн сэргээх үйлчилгээг хүүхдийг сэргэтэл гүйцэд урт хугацаагаар үзүүлэх, үйлчилгээнд эцэг эх гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зэрэг санал өгсөн байна.

Хамтарсан баг болон ГБХЗХГ-ын харъяа хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтанг сум, хороонд ажиллуулахтай холбоотой дараах саналыг тусгасан. Хамтарсан нарийн бичгийн даргыг ГБХЗХГ-ын үндсэн орон тоогоор ажиллуулах, хамтарсан багийн бусад гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллуулах үүрэг оруулах, хамтарсан баг мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, сум хорооны хүүхдийн хамгаалал асуудал хариуцсан мэргэжилтэнг хүүхдийн эрхийн байцаагч болгох саналтайгаа илэрхийлсэн байна. Мөн ГБХЗХГ-ын болон хамтарсан багийн гишүүдийн үүргийг тодорхой болгох, нөхөн сэргээх үйлчилгээг мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээр хүргэх, сум хороо, цэцэрлэгт сэтгэл зүйчийг ажиллуулах, нэг үйлчилгээний орон тоог нэмэгдүүлэх, хамгаалах байрны ажилтнуудыг чадавхижуулах, сум бүрт хоёр хүнтэй тасаг байдаг шиг хоёр орон тоотой нийгмийн асуудал хариуцсан тасагтай байх зэрэг саналыг бичсэн байна.

Сум хороонд хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхийн тулд сум хороо бүрт хүүхэд, түүний гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан байх, хүүхэд гэр бүлтэй уулзаж ярилцах тусгай өрөөтэй болох, хүүхдийн бие махбод, сэтгэл санааны байдлыг үнэлэх тест хэрэглэгдхүүн болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэслээр хангах, сум бүрт түр хамгаалах байртай болох, сум хороонд ажилладаг шуурхай тусламжийн болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтны болон бусад ажилтны ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын ажилтан хариуцсан ажилтан хүчний байгууллагын хамгаалалтанд авах, ажилтны аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах зэрэг саналуудыг гаргажээ.

Хүүхэд хамгааллын санхүүжилтын хувьд нөхөн сэргээх үйлчилгээний нэгдсэн жишиг үнэ тарифтай болох, хүүхэд хамгааллын үйлчилгээний тарифыг батлуулах, хамгааллын ажилтнуудын цалин хоорондын уялдаа холбоог сайжруулах, хамтарсан багийн үйлчилгээг санхүүжүүлэх, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтыг батлуулах, сургуулийн нийгмийн ажилтан болон бусад хамтарсан багийн гишүүдийг хамтарсан багийн нарийн бичгийн даргаар

Судалгааны дүгнэлт


Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой мэдээлэл цуглуулах зорилготой онлайн асуумж судалгааг 2021 оны 8 сарын 2-ноос 9 хооронд ГБХЗХГ-ын албаны цахим шуудангаар дамжуулан түүний харъяа болон хамтран ажилладаг байгууллагуудын удирдах ажилтан, мэргэжилтэн, ажилтнуудаас авсан. Цахим судалгаа нийт 324 оролцогчтой. Судалгаанд оролцогчдоос үндсэн дөрвөн чиглэлийн мэдээллийг авсан. Үүнд оролцогчдын талаарх мэдээлэл, хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээний тухай, хамгаалал нөхөн сэргээх үйлчилгээний тухай, урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаарх оролцогчдын санал бодлыг тус тус судалсан.

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн өгөгдлийн хувьд 21-ээс 60 насны нийт 324 оролцогч оролцсон бөгөөд тэдний дундаж нас нь 35 байв. Хүйсийн хувьд 324 оролцогчийн 20.7 хувь нь эрэгтэй, 79.3 хувь нь эмэгтэй оролцогчид байв. Судалгаанд оролцогчдын ажилладаг байгууллага, албан тушаал, ажлын туршлагын хувь хүүхэд хамгааллын үйлчилгээг үндэсний, нийслэл, аймгийн, сум, дүүргийн хороо, багийн түвшинд, мөн хүүхэдтэй тулж ажилладаг асрамж халамжийн төв, газруудын төлөөлөгчид оролцсон. Гэхдээ судалгаанд оролцогчдын 60 гаруй хувийг сум, баг, хорооны хамтарсан багийн ахлагч, гишүүд, сумын дүүргийн ЗДТГ-ын мэргэжилтэн, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)-ын удирдах ажилтан, мэргэжилтнүүд эзэлж байв. Ажилласан туршлагын хувьд оролцогчид дундажаар 5 жил тухайн албан тушаал дээрээ ажиллаж, хамгийн удаан ажилласан оролцогч 38 жил, хамгийн богино хугацаанд ажиллаж байгаа оролцогч тухайн албан тушаал дээр ажиллаад хэдхэн хонож байлаа.

Судалгаанд оролцогчдын боловсролын хувьд 324 оролцогчийн 80 хувь бакалаврын, 18 хувь магистрийн үлдсэн хоёр хувь нь бүрэн дунд, тусгай дунд, докторын боловсролтой мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид байлаа. Эзэмшсэн мэргэжлийн хувьд оролцогчдын дөрөвний нэг нь нийгмийн ажилтан, 15.5 хувь нь багш, 12.7 хувь нь эрх зүйч, хуульч, 7 хувь сэтгэл зүйч үлдсэн хувь инженер, сэтгүүлч, улс төр судлаач зэрэг мэргэжилтэй байв. Тэдний ихэнх нь эрхэлж буй ажлын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн гэж хариулсан байна.


Шуурхай тусламжийн үйлчилгээний хувьд 1-рт Хүүхэд хүчирхийлэл өртсөн мэдээлэл хүлээн авснаас хойш шуурхай тусламжийг 24 цагийн дотор хүргэж, эрсдлийн үнэлгээ хийдэг. 2-рт эрсдлийн үнэлгээ хийсний дараа 24 цагийн дотор нөхцөл байдлын үнэлгээ хийдэг гэж оролцогчдын 67 хувь хариулсан. 3-рт нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа хамгийн хурдан шуурхай тусламжийг 24 цаг дотор гэж оролцогчдын 59 хувь харин нэг сарын дотор гэж нэг хувь нь хариулсан байв. Шуурхай тусламжийн үйлчилгээнд нийгмийн ажлын үйлчилгээ, кейс менежмент, сэтгэл зүйн үйлчилгээ, эмнэлгийн шуурхай тусламжийн үйлчилгээ, хууль эрх зүйн туслалцаа хамгийн түгээмэл үзүүлдэг гэж мэдээлсэн. 4-рт Шуурхай тусламжийн үйлчилгээг нэг жилийн хугацаанд дундажаар 106 кейсэд үзүүлдэг гэж хариулсан бол хамгийн их хүн амтай УБ хотод байрладаг үндэсний хэмжээнд үйлчилгээ хүргэдэг байгууллагад 3950 хүүхдийн кейс дээр шуурхай

Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажилд оролцдогч
ажилтан, албан хаагчид



Дүрс 17. Урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нөлөөллийн ажил хэрэгжүүлэхэд оролцох
мэргэжилтэн, албан хаагчид

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, үнэлэх, урьдчилан сэргийлэх явуулын аян хир ач холбогдолтой болохыг 1 гэсэн ач холбогдол маш багаас 10 буюу хамгийн их ач холбогдолтой гэсэн онооны хооронд үнэлэхийг хүсэхэд оролцогчид ач холбогдлоор 8 оноо өгч өндөр ач холбогдолтой гэж үнэлсэн байна.



Дүрс 16. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлдэг зорилтот хөтөлбөрүүд,

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд судалгаанд оролцсон 324 оролцогчийн байгууллага, хэлтэс тасаг нийт 2318 нөлөөллийн ажил, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулжээ. Үүний хамгийн олон урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байгууллага, тасаг, нэгж 250 арга хэмжээ зохион байгуулсан байна. Харин нэг байгууллага, тасаг, хэлтэс дундажаар долоон урьдчилан сэргийлэх хөтөлбөр эсхүл нөлөөллийн ажил хэрэгжүүлсэн байна.

Зорилтот урьдчилан сэргийлэх нэг хөтөлбөр, үйлчилгээ зохион байгуулж хэрэгжүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагчид оролцдог тухай асуухад судалгаанд оролцогч дундажаар 7 ажилтан албан хаагч, хамгийн ихдээ 54 оролцогч оролцдог гэж хариулжээ.

Нэг зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ, нөлөөллийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд танай байгууллагаас ямар ямар мэргэжилтэн албан хаагчид оролцдог тухай асуухад хороо, сумын нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан, аймаг, дүүргийн ГБХЗХГ ба ГБХЗХХ-ийн хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн хэлтсийн ажилтан, эцэг эх асран хамгаалагчид, хороо сумын хэсгийн байцаагч, халамжийн мэргэжилтэн, өрхийн эмч, хүүхэд залуучууд, дүүргийн ЭМТ-ийн эмч, хэвлэл мэдээллийн ажилтан, ТББ-ын мэргэжилтэн, олон нийтийн төлөөлөгч, хяналт үнэлгээний ажилтан, Үндэсний болон нийслэлийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн, мэдээлэл технологийн ажилтан нар оролцдог гэж хариулжээ (Дүрс 17).

ажиллаж буй тохиолдолд урамшуулах, санхүүжилтийг орон нутгийн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоогоор бодож олгох, охидын нөхөн сэргээх төвийг төрөөс дэмжих, ТББ-ы оролцоо, үйлчилгээг санхүүжүүлэх зэрэг саналыг өгсөн байна.

Хүүхэд хамгааллын тухай болон бусад хууль оруулах өөрчлөлтийн хувьд гэр бүлийн тухай хуульд эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдээ үл хайхарсан эцэг эхэд оногдуулах шийтгэлийг чангатгах, эцэг эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хуулиудын уялдаа холбоог сайжруулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах шийтгэл, хариуцлагыг чангатгах, архинд донтсон хүнийг албадан эмчлүүлэх, хүүхдээ үл хайхарсан, байнга архи уудаг, эцэг эх байх эрхийг түтгэлзүүлэх, хувь хүний нууцлалыг чухалчла, халамжийн тухай хуульд хүүхдийн мөнгөний тэтгэмжийг олгохтой холбоотой өөрчлөлт оруулах, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл өгсөн хүнийг нууцлах, хамгаалах зэргээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах санал гаргажээ.

4. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаарх ойлголт, санал бодол

Хүчирхийлэлд өртсөн эсхүл эрсдэлтэй хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөх, хүүхэдтэй зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх ажил хийдэг эсэхийг асуухад асуумж судалгаанд оролцсон 324 оролцогчийн 315 нь урьдчилсан сэргийлэх чиглэлээр ажилладаг, 9 оролцогч энэ чиглэлээр ажилладаггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Танай байгууллага, хэлтэс, тасгаас хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ямар зорилтот үйлчилгээ үзүүлдэг, хөтөлбөр хэрэгжүүлдэг тухай асуухад нийт оролцогчдын 84 хувь нь эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан тухайлбал эерэг хүмүүжлийн аргууд, хүүхдийн нас сэтгэхүй, хөгжлийн онцлог, гэр бүлийн харилцаанд тохирсон үйлчилгээ, хөтөлбөрүүд; 73 хувь нь хүүхдэд чиглэсэн тухайлбал зөрчил шийдэх, эерэг харилцаанд суралцах, хорт зуршлаас сэргийлэх зэрэг урьдчилан нөлөөллийн ажил, хөтөлбөр; 60 хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих олон нийтэд чиглэсэн хөтөлбөр; 58 хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх аян; 54 хувь хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллага, оролцогч талуудад тухайлбал цагдаа, эмч, багш, хуульч, бусад мэргэжлийн байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан нөлөөллийн ажил; 47 хувь хүүхэд хамгааллын байгууллагын ажиллах хүчийг чадавхижуулах ажил, үйлчилгээ; 39 хувь нь олон нийтийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээг үзүүлдэг гэж хариулсан байна (Дүрс 16).

тусламжийн үйлчилгээ үзүүлжээ. 5-р шуурхай тусламжийн нэг кейс дээр ойролцоогоор 11 мэргэжилтэн ажилладаг гэж оролцогчид тэмдэглэсэн.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлээс нь тусдаа түр хамгаалах байранд хамгаалах байртай эсэх талаар оролцогчдын дөрөвний гурав нь тэдний орон нутагт түр хамгаалах байртай, үлдсэн хувь нь түр хамгаалах байргүй гэж хариулсан байна. Түр хамгаалах байрны харуул хамгаалалтын хувьд харуул хамгаалалтын талаар хариулсан 210 оролцогчийн 38 буюу 18.1 хувь нь түр хамгаалах байр гэрээт харуул хамгаалалттай, 116 буюу 55.2 хувь цагдаагийн байгууллагын хамгаалалтанд байдаг гэж, 56 буюу 26.7 хувь түр хамгаалах байр нь орон тооны харуул хамгаалалттай гэж хариулжээ

Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд хамгийн их шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийн хувьд тээврийн хэрэгсэл (77%), бичиг хэрэглэл(74%), хүүхдийн бие сэтгэл санааг үнэлэх тест, багаж хэрэгсэл (72%), диктафон-дуу хураагуур (67%), хүүхдийн хоол, унд (66%), харилцаа холбооны хэрэгсэл (62%), хүүхдийн ариун цэвэр, ахуйн хэрэгсэл (61%), хүүхэдтэй харилцах тоглоом наадгай, хүүхдийн дотуур болон гадуур хувцас (56%), энгэрийн камер (48%), үзүүлэн таниулах материал (47%) зэргийг ашиглах шаардлагатай гэж оролцогчид үзжээ.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, хэв амьдралд эргэн оруулахад нь туслах нөхөн сэргээх үйлчилгээний хувьд судалгаанд оролцсон хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг 319 ажилтан, албан хаагчдын 82 хувь нь үзүүлдэг, 18 хувь нь үзүүлдэггүй байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд кейс менежментийн үйлчилгээ, эмнэлгийн үйлчилгээтэй холбон зуучлах, хүүхэд, гэр бүлийн дэмжих ба хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ үзүүлэх эсхүл холбон зуучлах хууль зүйн туслалцаа, үйлчилгээтэй холбох, халамжийн үйлчилгээтэй холбох, хууль зөрчсөн хүүхэд ба түүний гэр бүлд чиглэсэн үйлчилгээ зэргийг оролцогчдын дийлэнх үзүүлдэг байна. Харин алслагдсан сум, баг, хорооны хүүхэд, гэр бүлд чиглэсэн явуулын үйлчилгээг оролцогчид хамгийн бага буюу оролцогчдын 30 хүрэхгүй хувь нь эзэлдэг байна.

Хүүхэд хамгааллын нэг тасаг хэлтэст дундажаар нэг жилийн хугацаанд 6 кейсэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг бол, хамгийн их тохиолдол 70 тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна. Хүчирхийлэлд өртсөн нэг хүүхдийг хүчирхийлэлд өртсөн хэлбэрээс хамаарч нөхөн сэргээх үйлчилгээг хүргэж кейс нээхээс хааж дуусгах хүүртэлх хугацаа дундажаар 104 ажлын хоног буюу 5 сар зарцуулдаг гэж оролцогчид хариулсан байна. Хамгийн урт хугацаа нь 720 ажлын хоног буюу 3 жил гэж хариулсан байна.

Нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл дундажаар 10 удаа уулздаг байна. Нэг кейс буюу нэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн нэг тохиолдлын хүүхэд, гэр бүлд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд хороо, сумын нийгмийн ажилтан оролцдог гэж дийлэнх оролцогчид тэмдэглэж, сум, хорооны хамтарсан багийн ахлагч болон гишүүд болох засаг дарга, өрхийн эмч, хэсгийн байцаагч, халамжийн мэргэжилтэн сум хорооны цагдаагийн хэлтсийн ажилтан нарыг оролцдог гэж нийт оролцогчдын 50-иас илүү хувь нь үзсэн. Мөн аймаг, дүүргийг ГБХЗХ-ын газар, хэлтсийн хүүхэд хамгааллын ажилтнууд оролцдог гэж нийт оролцогчдын 65 хувь нь хариулжээ. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх үйлчилгээнд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, хэрэглэгдэхүүн ашиглах шаардлагатай асуултад хамгийн түрүүнд

хүүхдийн бие махбод, сэтгэл санааг үнэлэх төрөл бүрийн тест, багаж хэрэгсэл, хэрэглэгдэхүүн (76%), хүүхэд эцэг эхтэй уулзаж ярилцах тусгай өрөө (75%), хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэрээс нь түр хамгаалах байранд аваачих хүртэл, эсхүл эрсдэлт бүлгийн хүүхэдтэй ажиллах явцад хүүхдэд өгөх хоол, унд (75%), бичгийн хэрэгсэл (71%), эрсдэлт бүлгийг хүүхэдтэй ажиллах явцад хүүхдэд хэрэгтэй ариун цэвэр, ахуйн хэрэгсэл (68%), компьютер (68%), хүүхдийн хувцас (67%), хүүхэдтэй харилцах тоглоом наадгай (65%), принтер (65%), дуу хураагуур (65%), үзүүлэн таниулах материал (64%), харилцаа холбооны хэрэгсэл (64%), явуулын үйлчилгээнд шаардлагатай тээврийн хэрэгсэл (64%), түгжээтэй шүүгээ (64%), ширээ сандал (60%) шаардлагатай гэж оролцогчдын дийлэнх хувь нь үзсэн.

Хамгааллын үйлчилгээг стандарттай болгох, мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллуулах, үйлчилгээг гүйцэд урт хугацаанд үзүүлэх гэж нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой саналуудыг хуульд тусгахыг санал гаргасан бол ГБХЗХГ-ын харъяа хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтанг сум, хороонд ажиллуулахтай холбоотой, эцэг эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчийн шийтгэлийг чангатгах гэх мэт тодорхой саналуудыг хуульд тусгахыг оролцогчид санал болгосон.

Хүчирхийлэлд өртсөн эсхүл эрсдэлтэй хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөх, хүүхэдтэй зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх ажлыг 9 оролцогчоос бусад бүх оролцогч хийдэг, харин 9 оролцогч энэ чиглэлээр ажилладаггүй болохоор хариулт өгөөгүй байн. Нийт оролцогчдын 84 хувь нь эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан, 73 хувь нь хүүхдэд чиглэсэн, 60 хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих олон нийтэд чиглэсэн, 58 хувь нь хүүхдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх аян; 54 хувь хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллага, оролцогч талуудад чиглэсэн; 47 хувь хүүхэд хамгааллын байгууллагын ажиллах хүчийг чадавхижуулахад чиглэсэн, 39 хувь нь олон нийтийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагаа явуулдаг гэж хариулсан байв. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд судалгаанд оролцсон 324 оролцогчийн байгууллага, хэлтэс тасаг нийт 2318 нөлөөллийн ажил, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулжээ. Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд дундажаар 7 ажилтан албан хаагч, хамгийн ихдээ 54 оролцогч оролцдог. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, үнэлэх, урьдчилан сэргийлэх явуулын аян хир ач холбогдолтой болохыг 1 гэсэн ач холбогдол маш багаас 10 буюу хамгийн их ач холбогдолтой гэсэн онооны хооронд үнэлэхийг хүсэхэд оролцогчид ач холбогдлоор 8 оноо өгч өндөр ач холбогдолтой гэж үнэлсэн.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх оролцогчдын хариултууд хүүхэд хамгааллын хуульд шинээр тусгах шуурхай тусламжийн, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээний хэлбэрүүдийг ямар нэг хэмжээгээр үзүүлдэг болохыг илтгэж байна. Гэхдээ оролцогчид хамгааллын үйлчилгээний хэлбэрүүдийг ямар шат дарааллаар хэрхэн хүргэдэг арга техникийг энэ асуумж судалгааны хүрээнд нарийвчлан судлах боломжгүй байсан нь энэ судалгааны хязгаарлагдмал тал байв.

Хавсралт 1. Судалгаанд оролцогчдын Хүүхэд хамгаалах тухай хуульд оруулах санал

Хамгааллын үйлчилгээ	ГБХЗХГ-хүүхэд хамгааллын хөлтэй болох	Санхүүжилт	Боловсон хүчин	Хэвлэл мэдээлэл, гарын авлага	Ажиллах нөхцөл	Сумын үйлчилгээ	Бусад хуульд өөрчлөлт оруулах
Хохирогч хүүхдийн сэтгэл зүйн үйлчилгээний стандарт, арга техникийг тодорхой болгох	Хамтарсан багийн нарийн бичгийг ГБХЗХГ-ын үндсэн орон тоон дээр авах	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд бүрийг нөхөн сэргээх үйлчилгээний нэгдсэн жишиг үнэ тарифтай болох	Үйлчилгээ үзүүлж мэргэжлийн үүргийг тодорхой болгох	Нөлөөллийн арга техникийг хэвлэлд ашиглах хууль эрх зүйн орчинг сайжруулах	Тусгай өрөөтөй болох	Суманд хамгаалах байртай болох	Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах (2)
Нэг нийгмийн ажилтны ажиллах кейсийн тоог тодорхой болгох	Хүүхэд хамгааллын ажилтан бүр хүүхдийн эрхийн байцаагч байх			Суманд тохиолдож буй хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдолтой ажиллах дүрэм журам, гарын авлагатай байх	Хүүхдийн бие махбод,сэтгэл санааны байдлыг үнэлэх тест, хэрэглэгдхүүнтэй болох	Суманд хамгаалах байр байгуулах	Хариуцлагын хэлбэрийг олон болгож, чангатгах

Сүргүүлийн
орчин, нийгмийн
ажилтны үүргийг
тодорхой болгох

Хамтарсан
багийн
гишүүдийн
АБТ-д
хүүхэд
хамгааллын
чиглэл
ажиллах гэж
оруулах

Хүүхдийн
эрхийн
мэдээллийг
санг
болгох

Нийгмийн
ажилтан хүүхэд,
гэр бүлтэй уулзах
ерөөтэй байх

Сум
хамгаалах
байртай
болох

Хүүхдээ үйл
хайхарсан эцэг
эхэд өгөх
шийтгэлийг
чангатгах, эцэг
эхийн
хариуцлагыг
нэмэгдүүлэх
(8)

Хүүхэд хамгааллын үйлчилгээний стандарт тодорхой болгож, заавал мөрдөхийг шаардах	Хамтарсан багийн гишүүдийн уялдаа холбоо сайжруулах талаар оруулах	Хамтарсан баг, хаагчдын нийгмийн хамгааллын сайжруулах	Сумын нийгмийн ажилтны ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх	Хүүхдүүд уялдаа холбоог сайжруулах
---	---	--	--	--

Хүүхдийн болон
үйлчилгээ үзүүлж
буй оролцогч
талуудыг хувийг
нууцыг чандлан
хадгалах

Нөхөн сэргээх
үйлчилгээ
хүргэдэг
ажилтан, албан
хаагчдыг цалинг
нэмэх, ажиллах
нөхцлийг
сайжруулах

Сум бүр
хамгаалах
байртай
болох

Сумын
хүүхдийн
эрхийн
байцаагчийн
эрх өгөх

Түр хамгаалах байранд байх хүүхдийн хугацааг уртасгах, орчинг сайжруулах (3)	Нөхөн сэргээх үйлчилгээнд шаардлагатай багаж, хэрэгслээр хангах	Суманд хамгаалах байртай болох	Хүчирхийлэл үйлдэгчид хатуу хариуцлага тооцох (4)
--	---	--------------------------------	---

Стандартуудыг нарийвчлан тодруулах

Хүүхэд хамгааллын байгууллагын ажилтныг хүчний байгууллагын хамгаалалтанд авах	Суманд мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтантай болох	Үл хайхрах хүчирхийллийн талаар тодорхой нэмэх
--	--	--

Хамгаалах байранд орон тооны мэргэжлийн хүн ажиллуулах	Ажилтны аюулгүй байдлыг хангах	Засаг даргын үүрэг хариуцалгыг нэмэгдүүлэх
--	--------------------------------	--

Хүүхэд хамгааллын бодлогыг тодорхой болгох

Хүүхэд үзүүлж буй ажилтнуудын нийгмийн баталгааг хангах	Хүүхдээ үл хайхарсан, байнга архи уудаг эцэг эх байх эрхийг түдгэлзүүлэх
---	--

Нэн эмнэлгийн тусламж үзүүлэх	даруй	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээ төсөвтэй болох	Архинд донтсон хүнийг албадан эмчлүүлэх
-------------------------------------	-------	--	--

Эцэг оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөлөл	эхийн	Төхиолдол бүрийг тусгасан үйлчилгээний зардлыг тусгах	ГБХЗХГ-ын анхан шатанд нийгмийн ажилтантай болох	Хүүхэд хамгааллын үйлчилгээний тарифыг батлуулах	Мэргэжлийн сэтгэл зүйчийг сургууль, цэцэрлэгт ажиллуулах	Хувь хүний нууцлалыг чухалчлах (2)
--	-------	---	--	--	--	---

Урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйлчилгээнүүдийн тодорхой болгох	Нөхөн ажлын санхүүжилтийг хангах	Хамтарсан багийн нарийн бичгийг ГБХЗХГ-ын үндсэн орон тоон дээр авах	Цалин хоорондын уялдаа холбоог сайжруулах	Нөхөн сэргээх үйлчилгээ хүргэх мэргэжлийн нийгмийн ажилтан болох	Сэтгэл асуудалд анхаарсан хууль дүрэм гаргах	зүйн
---	---	---	--	---	--	------

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дугаар харгалзахгүй үйлчилгээ	Нөхөн сэргээх үйлчилгээг төсөвтэй болгох	Хүүхэд хамгааллын ажилтан бүр хүүхдийн эрамйэ байцаанч байа	Үйлчилгээнд шаардлагатай жишиг зардлыг батлах	Суманд мэргэжлийн сэтгэл зүйчтэй болох	Халамжийн тухай хуульд хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой өөрчлөлт оруулах
---	--	---	--	---	---

Хүүхдийн хамгаалалтыг сайжруулах, эргэн сэргэтэл үйлчилгээ хүргэх	Санхүүжилтийг орон нутгийн эрсдэлт хүүхдийг тоогоор бодож олгох	Хамтарсан багийн гишүүдийн АБТ-д хүүхэд хамгааллын чиглэл ажиллах гэж оруулах	Хамтарсан багийн үйлчилгээг санхүүжүүлэх (5)	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудал зөвхөн хариуцсан нийгмийн ажилтанг хороо бүр лээр хөгжлийн нийгмийн ажилтнаас тусад нь ажиллуулах	Гэр бүлд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хууль тусгах
Хүүхдэд хүчээр тулгах, шаардахгүй байх	Нөхөн сэргээх үйлчилгээг төсөвтэй болгох	Хамтарсан багийн гишүүдийн уялдаа холбоо сайжруулах талаар оруулах	Нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилт зайлшгүй хэрэгтэй	Хороо бүр дээр сэтгэл зүйч ажиллуулах	Хүүхдийн эсрэг мэдээлэл өгсөн хүнийг нууцлах, хамгаалах

Урьдчилан сэргийлэх ажиллагааг сайжруулах	Нөхөн сэргээх охидын төвийг төрөөс дэмжих	Нийгмийн ажилтнаас бусад Хамтарсан багийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Төсөв санхүүг шийдэх орон тоог нэмэгдүүлэх	Нэг цэгийн үйлчилгээний нэмэгдүүлэх	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг заавал мэдээлэх
--	---	---	---	---	--

рт	хугацааны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	ТББ-ын оролцоо, үйлчилгээг санхүүжүүлэх	Хороонд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллуулах	Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багийн нарийн бичгээр ажиллаж буй тохиолдолд урамшуулах	Хамгаалах байрны ажилтан, ажилчдыг чадавхижуулах
----	---	--	--	---	--

Эцэг эхчүүд, гэр
бүлийн оролцоог
нэмэгдүүлэх
сургах

Сэтгэл зүйн
үйлчилгээний
зардал
Суманд хөдөө
аж ахуйн 2
хүнтэй тасаг
байдаг шиг 2
орон тоотой
нийгмийн
салбарын
тасагтай байх

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ

Зөвлөх: Др. А. Батхишиг, МУИС
Др. Т. Цэндсүрэн, МУБИС

Улаанбаатар хот
2021.08.23

АГУУЛГА

Хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай ерөнхий ойлголтууд	3
Хүүхэд хамгаалал	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээ.....	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох нь	3
Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хэлбэрүүд	4
Хүүхэд хамгааллын шүүрхай тусламжийн үйлчилгээ	4
Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ	5
Гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	5
Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ	6
Зорилтот урьдчилан сэргийлэх (шүүд биш) үйлчилгээ.....	7
Кейс менежмент.....	7
Тохиолдлын кейс менежмент.....	7
Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежментийн асуудлууд	8
Мэргэжлийн удирдлага	8
Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх үйл явц ба оролцогч талууд	8
Шүүрхай тусламжийн үйлчилгээ.....	9
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ.....	13
Гэр бүлд суурилсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	13
Явуулын үйлчилгээ	14
Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ	14
Зорилтот урьдчилан сэргийлэх шүүд биш үйлчилгээ	15
Нэр томъёоны тайлбар.....	16

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал

Хүүхэд хамгааллын үйлчилгээний тухай ерөнхий ойлголтууд

Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх, асран хамгаалагч, бусад хуулийн этгээд, иргэн хүүхэд хамгаалах үүргээ биелүүлэхгүй тохиолдолд төр хөндлөнгөөс оролцож хүүхдийг хамгаалахыг хэлнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь нэгдүгээрт хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах шуурхай тусламжийн үйлчилгээ, хоёрдугаарт, хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлын улмаас үүссэн сэтгэл санаа цочрол, бие махбодийн гэмтэл, шарх сорвийг эдгээх, хүүхдийг хэвийн амьдралд ороход нь туслах төрөл бүрийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, гуравдугаарт хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон талт шууд биш үйлчилгээ гэсэн гурван түвшний цогц үйлчилгээ, үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох нь

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг. Хүүхэд хамгааллын тогтолцоо нь үндсэн долоон дэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин
2. Зохицуулагдсан эрх бүхийн байгууллага, бүтэц зохион байгуулалт
3. Хүүхэд хамгааллын ажиллах хүч - мэргэжлийн боловсон хүчин
4. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ
5. Хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт
6. Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ, өгөгдөл
7. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үл тэвчдэг олон нийт (хүүхдийн амьдарч буй орон нутгийн иргэд, байгууллага, хүүхдийн дан ба өргөтгөсөн гэр бүл, хүүхэд өөрөө бас олон нийтийг нэг хэсэг болно)

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь дээр дурдсан хамгааллын бүрэлдэхүүн дэд хэсгүүдтэй нягт холбоотой. Хамгааллын тогтолцооны аль нэг дэд хэсэг нь ажиллахгүй эсхүл үйл ажиллагаа нь хэвийн биш байхад хүүхэд хамгааллын үйлчилгээнд шууд ба дам байдлаар нөлөөлнө.

Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг хүүхэдтэй зүй бус харьцах байдалд хүргэсэн ба хүргэх эрсдэлтэй эцэг эх, асран хамгаалагч нь ихэнх тохиолдолд хүүхдийн хууль ёсны асрамж хамгаалагч байдаг. Тиймээс хүүхдийн эрхийг тэр дундаа хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас хамгаалах эрхийг хангах үүргийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид нэгдсэн улс орнуудын ТӨР нь хүлээж, хүүхдийн аюулгүй байдал, дээд ашиг сонирхлыг хангах хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхдээ зайлшгүй хөндлөнгөөс шууд оролцох шаардлагатай болдог.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хэлбэрүүд

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь 1-рт хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ, 2-рт хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, 3-рт зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ гэж гурван түвшний үйлчилгээнээс бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ

Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээнд дараах үйлчилгээг багтаана. Үүнд:

- Хүүхдийн тусламжийн утас-108
- Хүүхдийн тусламжийн утаснаас бусад сувгаар тухайлбал 102, 103, 105, 107-ын дуудлага, сум, хорооны засаг даргын тамгын газар, сургууль, эмнэлэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага зэрэг сувгаар ирэх дуудлага, мэдээллийг Хүүхдийн 108 утсанд шилжүүлэх, дуудлага мэдээлэл нэгтгэн шуурхай үйлчилгээн хамруулах зохицуулалт
- Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн хяналтын болон шуурхай дуудлагын дагуу хүүхдийн байгаа газар дээр очиж хийх эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ. Хүүхэд аюултай нөхцөл байдалд байгаа тухай 108 утсанд ирсэн хяналтын болон шуурхай дуудлагын үед эрсдлийн үнэлгээ буюу аюулын зэрэг тогтоох үнэлгээг дуудлага авснаас хойш 24 цагийн дотор, харин нөхцөл байдлын үнэлгээг 72 хүртэлх цагийн дотор хийнэ. Харин аюулын түвшин бага гэж эрсдлийн үнэлгээгээр тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг гурваас тав хүртэлч өдрийн дотор хийнэ.
- Хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсэх, хүүхдийн амь нас, эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд байгааг тогтоох эрсдлийн үнэлгээ, аюулын зэргийн түвшний үнэлгээний

үед хүчирхийллийн улмаас хүүхэд бэртэл гэмтэл авч хохирсон гэж илэрвэл хүүхдийг дараах мэргэжлийн байгууллагын шуурхай тусламжтай тухайлбал

- Эмнэлгийн шуурхай тусламж
 - Хууль эрх зүйн шуурхай тусламж
 - Нийгмийн ажлын шуурхай үйлчилгээ
 - Сэтгэл зүйн зөвлөгөө, засал зэрэг мэргэжлийн шуурхай тусламжтой холбоно.
- Эрсдлийн үнэлгээний үед аюулын зэргийн түвшин бага гэж үзэн хүүхдийг гэрээс нь эсхүл амьдарч буй газраас тусгаарлан авч явахгүй үлдээх тохиолдолд хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөхөөс хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг хүүхдийг хамгаалж чадах эцэг, эх асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх заавар зөвлөгөөг өгөх нь шуурхай тусламжийн нэг хэсэгт тооцогдоно.
 - Эрсдлийн үнэлгээний үед хүүхэд хүчирхийлэлд дахин өртөх, амь насанд аюултай байх эрсдэлтэй хүүхдийг гэрт нь үлдээх боломжгүй тохиолдолд хүүхдийг түр байрлуулах хамгаалах нэг цэгийн үйлчилгээний болон хүүхэд хамгаалах түр хамгаалах байранд хүргэж өгнө.

Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг хүүхэд, түүний гэр бүлд нөлөөлөх хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хүргэнэ.

Гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ зэрэг шууд үзүүлэх үйлчилгээнээс гадна бусад салбарын багтана. Гэр бүлд суурилсан хамгааллын үйлчилгээнд хүүхэд, гэр бүлийн гишүүдийн амьдралын үечлэл, хөгжилд чиглэсэн хөгжлийн, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх гэсэн олон талт үйлчилгээг хамруулна

Хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн хамгаалах, гэр бүлийг дэмжих гэж хоёр хуваана.

- *Гэр бүлийг хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна.*
Үүнд: эцэг эх хүүхдээ хамгаалах, эерэг хүмүүжлийн аргад суралцахад нь туслах,, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах зэрэг үйлчилгээг багтана.
- *Гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна.*
Үүнд: эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ойлголт мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд туслах, гэр бүлд чиглэсэн бусад салбарын болон орон нутгийн нөөц боломжтой холбогдоход туслах зэрэг үйлчилгээний хэлбэрүүд багтана.

Мөн гэр бүлийн хамгаалах болох дэмжих үйлчилгээний аль ч хэлбэрийн үед хүүхэд, түүний гэр бүлийг гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүйн үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.

Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ

Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртсөн үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг эрсдэлт нөхцөл бүхий гэр бүлийн орчноос тусгаарлан, эрх бүхий байгууллагын шууд оролцоо, хяналт удирдлага дор түр хамгаалах байр, асрамж халамжийн төв, асралт гэр бүл, болон төрөл садангийн асрамжинд үр байрлуулан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийг хүүхдийг гэр бүлийн орчноос нь тусдаа хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэнэ (CWIG, 2020).

Хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээнд дараах хэлбэрүүд хамаарна. Үүнд

- Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ
- Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах
- Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ
- Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж гм)
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

Хүүхдийг түр болон удаан хугацаагаар асран халамжлах тохиолдолд асрамж халамжийн төвд үзүүлэх хүүхэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ, хүүхдийн хөгжил, амьдрах ухааны мэдлэг, ур чадвар, дадал олгоход чиглэсэн үйлчилгээнээс гадны хүүхдийг түр хамгаалах байр, асрамж халамжийн төвийн гадна үзүүлэх

боловсролын, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн, сэтгэл зүйн засал эмчилгээ үйлчилгээнд хамруулна.

Зорилтот урьдчилан сэргийлэх (шууд биш) үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн дахин өртөхөөс сэргийлэх, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, гэр бүлд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх шууд биш үйлчилгээг хэлнэ. Шууд бус үйлчилгээ гэдэгт нийгмийн ажлын макро практикт өргөн хэрэглэдэг сургах, нөлөөлөл хийх, чадавхи бэхжүүлэх, хөрөнгө босгох, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх зэрэг хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөр хамаарна.

Зорилтот урьдчилан сэргийлэх шууд үйлчилгээний дараах чиглэлээр байна. Үүнд:

- *Хүүхэд хамгааллын үйлчилгээний оролцогч талууд болох бусад салбарын (хүчирхийлэлд өртсөн хүүхдэд чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй үйлчилгээ үзүүлэх) мэргэжлийн байгууллага, ажилтнууд чиглэсэн хүүхэд хамгааллын сургалт, нөлөөллийн ажил*
- *Хүүхдэд чиглэсэн: Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон төрөл бүрийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөрүүд (Дээрхэлт, хүчирхийллээс сэргийлэх, зөрчил шийдэх, зэрэг харилцаанд суралцах гэх мэт)*
- *Эцэг эх, хамгаалагчид чиглэсэн эцэг эхийн ба тэдний дагуулах сургах хөтөлбөр, эцэг эхийн хүүхэд өсгөх мэдлэг чадварыг хөгжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, дэмжих бүлэг зэрэг үйлчилгээ, үйл ажиллагааг багтаасан зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээг*
- *Олон нийтэд чиглэсэн: хүүхэдтэй зүй бус харьцах явдлаас сэргийлэх хөтөлбөрүүд, нөлөөллийн ажил*
- *Хүүхэд хамгааллын байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэднийг чадавхижуулах төрөл бүрийн сургалт, нөлөөллийн ажил зэрэг хамаарна.*

Кейс менежмент

Тохиолдлын кейс менежмент

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдлын үед тухайн тохиолдлыг хариуцан ажиллаж буй нийгмийн ажилтан/кейс менежер нь дангаараа буюу хамтарсан багийн гишүүд, бусад мэргэжилтэнтэй хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх,

хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээ хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх буй байгууллага мэргэжилтнүүдтэй холбох, тэдний уялдаа холбоог зохицуулах, хянах, үнэлэх, хаах үйл явцыг бүхэлд нь кейс менежмент гэнэ. Энэ нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдолд чиглэсэн шууд практикийн мөрдөх кейс менежмент юм.

Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежментийн асуудлууд

Харин шууд практикийн буюу хувь хүн гэр бүлтэй ажиллах тодорхой нэг тохиолдолд мөрдөх кейс менежментийг үр дүнтэй хийхийн тулд кейс менежментийн тогтолцооны түвшинд анхаарч удирдан зохион байгуулахыг тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент гэнэ. Тогтолцооны түвшний кейс менежментийн бүрэлдэхүүнд 1) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэж буй хүний нөөц- ажиллах хүч; 2) шууд үйлчилгээ хүргэж буй ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах зохион байгуулалт, бүтэц; 3) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт; 4) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхэд бодлого, хууль, журам, дүрэм заавар; 5) хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх хүүхэд, гэр бүлийн оролцоо; 6) хүүхдийн хамгааллын дэмжих олон нийтийн хандлага, үнэт зүйлс зэрэгт чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ зэрэг багтана. Анхан шатанд хүүхэд хамгааллын кейс менежментийг үр дүнтэй, сайн удирдан чиглүүлэхийн тулд аймаг, дүүрэг, нийслэл, үндэсний түвшний хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, мэргэжилтнүүд кейс менежментийг тогтолцооны түвшинд бүтэн зургаар нь харж анхаарах хэрэгтэй болно.

Мэргэжлийн удирдлага

Мэргэжлийн удирдлага (supervision) гэж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд оролцогч байгууллагууд нийгмийн үйлчилгээний байгууллага үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхийн тулд тодорхой зохион байгуулалттай, хуульд зааснаас бусад нөхцөлд нууцыг хадгалах үүрэгтэйгээр тулгарч буй асуудлаа ярилцаж, мэргэжлийн дэмжлэг тусалцааг авах мэргэжилтнүүдийн ажлаа товч танилцуулах, зөвлөлдөх, заавар зөвлөгөө өгөх, эргэцүүлэн тунгаах боломж олгох, манлайлах, ажлаа эргэн дүгнэх зэрэг хэлбэрээр явагдах албан ёсны ярилцлагыг хэлнэ.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх үйл явц ба оролцогч талууд


Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ гэдэг хоорондоо уялдаа холбоотой, тодорхой шат дараалалтай хүргэх үйл явц юм. Үйлчилгээ шат, түвшин бүрт үйлчилгээг хүргэх оролцогч талууд нь хоорондоо нягт холбоотой ажиллах хэрэгтэй болно.

Шуурхай тусламжийн үйлчилгээ

1. Хүүхдийн 108 утас болон 102, 103, 105, 107 зэрэг яаралтай тусламжийн утас, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын харъяа байгууллагуудад хүүхэд хүчирхийлэлд өртсөн, өртөх өндөр эрсдэлтэй байгаа тухай дуудлага мэдэлэл ирэхэд бүх дуудлага 108 утас дээр төвлөрч дуудлага бүрийн (шугамын дуудлагын) анхны мэдээлэлд Хүүхдийн тусламжийн утасны зөвлөгч болон ээлжийн ахлах нийгмийн ажилтан нар дүн шинжилгээ хийж хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх эрсдэлтэй байна гэж дүгнэвэл дуудлагыг хяналтын дуудлага гэж бүртгэн орон нутгийн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
2. Дуудлага мэдээллийн дагуу цагдаагийн албан хаагч газар дээр нь эрсдлийн үнэлгээ хийн аюулын түвшинг тогтооно. Аюулын түвшин дунд ба дундаас дээш тохиолдолд Хүүхдийн 108 утас руу эргэн мэдэгдэн, харин 108 утаснаас хүүхдийн амьдарч буй газрын харъяалагдах аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст дуудлагыг мэдэгдэнэ. Хүүхэд гэртээ үлдэх боломжгүй, хүүхдэд аюултай тохиолдолд цагдаагийн ажилтан хүүхдийг цагдаагийн тасаг, хэсэгтээ авчирч ГБХЗХХ-ийн мэргэжилтэнг эсхүл хамтарсан багийн нийгмийн ажилтанг дуудан, холбогдох бичиг баримтын хамт хүүхдийн байгууллагын мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
3. Хэрэв хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл ажлын бус цагаар ирвэл Хүүхдийн тусламжийн утасны шуурхай дуудлагын шугамаар 108 утасны зөвлөх, эсхүл зөвлөх нийгмийн ажилтан хоёр цагдаагийн тасаг, хэсгээс хүүхдийг дагалдах бичиг баримтын хамт авч Хүүхдийн 108 утасны дэргэдэх түр хамгаалах байранд түр байрлуулна. Харин хүүхэд орон нутагт байгаа тохиолдолд тухайн аймгийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан газар, хэлтэст утсаар мэдэгдэнэ.
4. Хүүхдийн 108 утаснаас хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай мэдээлэл авсан дүүрэг, аймгийн ХГБЗХ-ийн газар, хэлтсийн хүүхэд хамгааллын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэнд дуудлага мэдээллийг хүлээн авч бүртгээд мэдээллийн дагуу хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийх ажлыг дагуу зохицуулна.

5. Хүүхдийн болон түүний гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хорооны нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдийн оролцоотой гардан хийнэ. Ихэнх тохиолдолд хорооны нийгмийн ажилтан хийнэ.
6. Орон нутагт аймгийн ХГБЗХГ-ын хамгааллын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээг хийнэ. Алслагдсан орон нутагт хүрч үйлчлэх шуурхай тусламжийн явуулын үйлчилгээ мөн шуурхай тусламжийн үйлчилгээнд хамаарна.
7. Алслагдсан сум, хорооны айл өрхийн хүүхэд хүчирхийлэлд өртсөн тухай шуурхай дуудлага мэдээлэл авсан тохиолдолд тухайн хороо, сумын нийгмийн ажилтан очих боломжгүй тохиолдол орон нутагт бол сумын нийгмийн бодлогын хэлтэст, төв суурин газарт дүүргийн ГБХЗХХ-ийн хүүхэд хамгааллын хэлтэс хорооны нийгмийн ажилтан, засаг даргад мэдэгдэнэ. Зарим тохиолдолд 108-ын хяналтын дуудлагын мөрөөр ХГБЗХХ-ийн хамгааллын мэргэжилтнүүд нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.
8. Аймгийн ХГБЗХГ, дүүргийн ХГБЗХХ-ийн хамгааллын мэргэжилтнүүд, сум, хорооны нийгмийн ажилтнууд хүүхэд, гэр бүлийн нөхцлийг судалж хүүхэд гэртээ үлдэх боломжгүй, дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй бол хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулж хамгаалах үйлчилгээ хүргэнэ.
9. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас гэмтэж бэртсэн хүүхдийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбох, хууль эрх зүйн туслалцаа шаардлагатай хүүхдийг хууль зүйн тусламж үйлчилгээтэй холбох, мөн боловсролын үйлчилгээтэй холбох зэрэг үйлчилгээг Шуурхай тусламжийн үйлчилгээний үед мөн хүргэнэ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН ЗУРАГЛАЛ



Зураг 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТӨД ТУСГАХ- ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТЫН ХЭЛБЭРҮҮД


I. ТОХИОЛДОЛ-КЕЙСЭД ТУЛГУУРЛАСАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОДОРХОЙ НЭГ ТОХИОЛДЛЫН КЕЙС МЕНЕЖМЕНТ ХИЙХ



I. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРТ СУУРИЛСАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, КЕЙС МЕНЕЖМЕНТИЙГ УДИРДЛАГААР ХАНГАХ



Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Гэр бүлд суурилсан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ зэрэг хүүхэд, гэр бүлд шууд үзүүлэх үйлчилгээнээс гадна хүүхдийг бусад салбарын тухайлбал эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээ хамаарна.

Гэр бүлд суурилсан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг анхан шатанд ажиллаж буй хорооны хөгжлийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, хүүхэд, гэр бүлтэй тулж ажиллаж буй төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан зэрэг шууд практикийн үйлчилгээ хүргэх нийгмийн ажилтан, хамгааллын ажилтан хүргэхийн зэрэгцээ бусад үйлчилгээтэй холбон зуучилна. Өөрөөр хэлбэл хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг бүртгэн авч хүүхэд гэр бүлтэй ажиллах кейс файл нээхээс эхлэх хаах хүртэл бүх үйлчилгээг гардан хүргэх, өөргөө хүргэх боломжгүй тохиолдолд бусад салбарын үйлчилгээнд холбон зуучлах ажлыг тухай тохиолдлыг хариуцсан нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүдийн хамт хүргэнэ.

Хүчирхийллийн хэлбэр, гэр бүлийн дэмжих тогтолцооноос хамаарч хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хугацаа харилцан адилгүй 6 долоо хоногоос жил хүртэл үргэлжилнэ. Бэлгийн хүчирхийлэл, хүний наймаа, үе дамжсан ядуурал зэрэг асуудалд өртсөн хүүхэд, түүний гэр бүлтэй ажиллах хугацаа илүү удаан хугацаанд үргэлжлэх магадлал өндөр байна.

Хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг гэр бүлийн хамгаалах, гэр бүлийг дэмжих гэж хоёр хуваана.

- *Гэр бүлийг хамгаалах нийгмийн ажлын үйлчилгээнд* дараах үйлчилгээ хамаарна. Үүнд: эцэг эх хүүхдээ хамгаалах, эерэг хүмүүжлийн аргад суралцахад нь туслах, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах зэрэг үйлчилгээг багтана.
- *Гэр бүлийг дэмжих нийгмийн ажлын үйлчилгээнд* дараах үйлчилгээ хамаарна. Үүнд: эцэг эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх ойлголт мэдлэг, чадвараа хөгжүүлэхэд

туслах, гэр бүлд чиглэсэн бусад салбарын болон орон нутгийн нөөц боломжтой холбогдоход туслах зэрэг үйлчилгээний хэлбэрүүд багтана.

Мөн гэр бүлийг хамгаалах болон дэмжих үйлчилгээний аль ч хэлбэрийн үед тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллаж буй нийгмийн ажилтан нь кейс менежерийн хувьд хүүхэд, түүний гэр бүлийн гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, халамж, хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээтэй холбон зуучлах ажлыг хийнэ.

Явуулын үйлчилгээ нь гэр бүлд чиглэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хэлбэр. Ялангуяа хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүрч чадахгүй байгаа төвөөс алслагдсан сум, баг, хороонд амьдарч буй хүүхэд, түүний гэр бүлд зориулсан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ юм. Явуулын үйлчилгээгээр өмнө дурдсан гэр бүлийг хамгаалах, гэр бүлийн дэмжих үйлчилгээний бүх хэлбэрүүдийг аймаг, сум, дүүргийн ГБХЗХХ-ын хамгааллын мэргэжилтнүүд эсхүл төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэж буй төрийн бус байгууллагын ажилтнууд хүргэж болно.

Гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ

Хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах явдалд өртсөн үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг гэр бүлийн орчноос тусгаарлах, хохирогч хүүхдийг хамгаалах үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын тухайлбал хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага хяналт дор гэр бүлийн орчноос тусад нь хүүхдэд үзүүлэх асрамж халамжийн үйлчилгээг гэр бүлээс нь тусад нь хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ гэнэ (CWIG, 2020).

Хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээнд дараах үйлчилгээний хэлбэрүүд хамаарна. Үүнд

- Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ
- Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах
- Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ
- Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж гм)
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

Хүүхдийг түр болон удаан хугацаагаар асран халамжлах, хамгаалах үйлчилгээг асрамж халамжийн төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд асрах багш, туслах ажилтнууд хүргэнэ. Тодруулбал, халамжийн төвийн нийгмийн ажилтан, сэтгэл зүй нар төв байрлах

хүүхэд бүрийн хөгжлийн төлөвлөгөөг гарган хүүхэд бүрт чиглэсэн дараах үйлчилгээ үзүүлнэ. Үүнд: хүүхдийг асран халамжлах, хүүхдийн хөгжил, амьдрах ухааны мэдлэг, ур чадвар, дадал олгоход чиглэсэн хөгжлийн үйлчилгээнээс гадны төвийн гадна байрлах хүүхдийг боловсролын, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн, сэтгэл зүйн засал эмчилгээ үйлчилгээтэй холбон зуучлах үйлчилгээ зэрэг үйлчилгээ хүргэнэ.

Зорилтот урьдчилан сэргийлэх шууд биш үйлчилгээ

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөхөөс сэргийлэх, мөн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдийг хүчирхийллээс сэргийлэхээс гадна эцэг асран хамгаалагчийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, хамгааллын тогтолцооны бүх оролцогч талуудын чадавхийг нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээтэй шууд биш үйлчилгээ юм. Шууд бус үйлчилгээ гэдэгт нийгмийн ажлын макро практикт өргөн хэрэглэх нөлөөлөл хийх, чадавхи бэхжүүлэх, хөрөнгө босгох, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх зэрэг хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөр хамаарна.

Зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй бүлэг, тэдэнтэй ажилладаг мэргэжилтэн, албан хаагч, байгууллагад голлон чиглэнэ. Хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй бүлэгт, хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй хүүхэд, бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үрчлэгдсэн, асрамж халамж тогтоолгон бусдын асрамж халамжинд байгаа хүүхэд, эцэг эх асран хамгаалагчаасаа тусдаа амьдарч байгаа хүүхэд, гэрч хохирогч хүүхэд, хууль зөрчсөн хүүхэд зэрэг хамаарна.

Өмнө дурдсанчлан хүүхэд хамгааллын тогтолцоо, хамгаалын үйлчилгээний оролцогч талууд, хүүхэд, эцэг эх асран хамгаалагч, олон нийтэд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хөтөлбөрүүдийг хүүхэд хамгааллын бүх шатны байгууллага, хамгааллын үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх мэргэжлийн төрийн бус байгууллага, хүүхэдтэй ажилладаг боловсрол, эрүүл мэнд, халамж, хууль сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байгууллагууд хэрэгжүүлнэ.

Нэр томъёоны тайлбар

- *Хүүхэд хамгаалал гэдэг нь* хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх, асран хамгаалагч, бусад хуулийн этгээд, иргэн хүүхэд хамгаалах үүргээ биелүүлэхгүй тохиолдолд төр хөндлөнгөөс оролцож хүүхдийг хамгаалахыг хэлнэ.
- *Хүүхэд хамгааллын тогтолцоо* нь дараах долоон дэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:
 - Хүүхэд хамгааллын хууль эрх зүйн орчин
 - Зохицуулагдсан эрх бүхийн байгууллага, бүтэц зохион байгуулалт
 - Хүүхэд хамгааллын ажиллах хүч - мэргэжлийн боловсон хүчин
 - Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ
 - Хангалттай нөөц хөрөнгө, зөв хуваарилалт
 - Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сүлжээ, өгөгдөл
 - Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үл тэвчдэг олон нийт (хүүхдийн амьдарч буй орон нутгийн иргэд, байгууллага, хүүхдийн дан ба өргөтгөсөн гэр бүл, хүүхэд өөрөө бас олон нийтийг нэг хэсэг болно)
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь дээр дурдсан хамгааллын бүрэлдэхүүн дэд хэсгүүдтэй нягт холбоотой. Хамгааллын тогтолцооны аль нэг дэд хэсэг нь ажиллахгүй эсхүл үйл ажиллагаа нь хэвийн биш байхад хүүхэд хамгааллын үйлчилгээнд шууд ба дам байдлаар нөлөөлнө.
- *Хүүхэд хамгааллын үйлчилгээ* нь шуурхай тусламжийн үйлчилгээ, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, зорилтот урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нөлөөллийн ажлаас бүрдэнэ.
- *Шуурхай тусламжийн үйлчилгээ гэдэг нь* хүчирхийлэлд өртсөн, өртөх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүчирхийллийн улмаас үүссэн сэтгэл санаа, бие махбодын хямралыг даван туулахад туслах яаралтай тусламжийн үйлчилгээг хэлнэ.
- *Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ гэдэг нь* хүчирхийлэл, дарамт, үл хайхрах явдлын улмаас үүссэн сэтгэл санаа, бие махбодын цочрол, гэмтэл, шарх сорвийг эдгээх, хүүхэд амар тайван, аюулгүй өсөж хөгжих хэвийн амьдралд ороход нь туслах төрөл бүрийн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ. Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг гэр бүлд суурилсан хүүхэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, хүүхдийг гэр бүлээс тусад нь хамгаалан нөхөн сэргээх үйлчилгээ гэж хуваана.

- *Явуулын үйлчилгээ* гэж алслагдсан хороо, багийн хүчирхийлэлд өртсөн ба өртөх өндөр эрсдэлтэй гэж мэдээлэгдсэн хүүхдэд хүрч үйлчлэх шуурхай тусламжийн болон нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ.
- *Зорилтот урьдчилан сэргийлэх хөтөлбөр гэдэг* нь тодорхой газар нутаг, олон нийт, зорилтот бүлгийн дунд түгээмэл тохиолдох эсхүл анхаарал татах хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрийн тархалтыг бууруулах, таслах зогсоох зорилго, зорилт бүхий тусгайлан боловсруулсан стратеги, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, төсөл хөрөнгийн урьдчилан тооцоолж боловсруулсан цогц төлөвлөгөө.
- *Тохиолдлын кейс менежмент гэдэг* нь Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдлын үед тухайн тохиолдлыг хариуцан ажиллаж буй нийгмийн ажилтан/кейс менежер нь дангаараа буюу хамтарсан багийн гишүүд, бусад мэргэжилтэнтэй хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээ хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх буй байгууллага мэргэжилтнүүдтэй холбох, тэдний уялдаа холбоог зохицуулах, хянах, үнэлэх, хаах үйл явцыг бүхэлд хэлнэ.
- *Тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент.* Хүүхэд, гэр бүлтэй ажиллах тодорхой нэг тохиолдлын кейс менежментийг үр дүнтэй хийхийн тулд кейс менежментийг тогтолцооны түвшинд анхаарч удирдан зохион байгуулахыг тогтолцооны түвшинд анхаарах кейс менежмент гэнэ. Тогтолцооны түвшний кейс менежментийн бүрэлдэхүүнд 1) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэж буй хүний нөөц- ажиллах хүч; 2) шууд үйлчилгээ хүргэж буй ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах зохион байгуулалт, бүтэц; 3) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт; 4) хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэхэд бодлого, хууль, журам, дүрэм заавар; 5) хүүхэд хамгааллын үйлчилгээн дэх хүүхэд, гэр бүлийн оролцоо; 6) хүүхдийн хамгааллын дэмжих олон нийтийн хандлага, үнэт зүйлс зэрэгт чиглэсэн хөтөлбөр, үйлчилгээ зэрэг багтана.
- *Нөлөөлөл* гэж хувь хүн, бүлэг, байгууллага, олон нийтэд нөлөөлөх бодлого, хууль дүрэм, практик үйл ажиллагаа, хандлагад өөрчлөлт хийхэд чиглэсэн үйл явц. Нөлөөллийн ажил нь хүмүүст нөлөөлөх бодлого, дүрэм, практик үйл ажиллагаа, хандлагад нөлөөлөх зорилготой үе шат, алхам бүрээр нь бодож боловсруулсан төлөвлөгөөт ажил.

- *Явуулын аян* гэж алслагдсан хороо, багт хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг хэлнэ.
- *Үйл ажиллагаа* гэж төлөвлөгдсөн ба төлөвлөгөөт бус нэг удаагийн үйл ажиллагаа
- *Мэргэжлийн үйлчилгээ* гэж нийгмийн үйлчилгээний байгууллагын мэргэжлийн удирдлага дор үйлчилгээ үзүүлэх чиглэлээрээ бэлтгэгдсэн мэргэжилтний бодож боловсруулсан үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, амьдралд эерэг өөрчлөлт авчрах мэргэжлийн үйл ажиллагаа.
- *Мэргэжлийн удирдлага (supervision)* гэж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд оролцогч байгууллагууд нийгмийн үйлчилгээний байгууллага үйлчилгээгээ мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхийн тулд тодорхой зохион байгуулалттай, хуульд зааснаас бусад нөхцөлд нууцыг хадгалах үүрэгтэйгээр тулгарч буй асуудлаа ярилцаж, мэргэжлийн дэмжлэг тусалцааг авах мэргэжилтнүүдийн ажлаа товч танилцуулах, зөвлөлдөх, заавар зөвлөгөө авч өгөх, эргэцүүлэн тунгаах боломж олгох, манлайлах, ажлаа эргэн дүгнэх зэрэг хэлбэрээр явагдах албан ёсны ярилцлагыг хэлнэ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг:...Төв
Сум:.....Зуунмод сумын 1-р баг -Номт баг

Огноо: 2021.08.01
Эхэлсэн цаг: 11.30
Дууссан цаг: 13.20

Ярилцагчийн нэр: А. Нарангэрэл (Хэсгийн ахлагч-ХА)
Д. Энхтуул (ХА), Б. Наранхүү-Зохион байгуулагч, Б. Жигжиддорж. Засаг дарга
Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр:...1-р багийн хамтарсан баг
Ярилцагчийн албан тушаал. ХА, ЗБ, ЗД
Зөвлөх/судлаачийн нэр: А. Батхишиг, Б. Бүжинлхам

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг Төв аймгийн ГБХЗХГ-аас мэдээлэл авна. Аймгийн төвд болохоор 1-2 цагийн дотор гэр бүлийн гишүүдтэй утсаар холбогдож. Хамтарсан багийн хурал хийнэ. 24 цагийн дотор гэрт нь очно. Хэрэв зодож шийтгэсэн мэдээлэл байвал цагийн дотор гэрт нь очно.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ? 7 сар 1 кейс гарсан Сард 1-2 кейс. Хамгийн сүүлд эцэг нь архины хамааралтай, гэр бүлийн орчин дахь хүчирхийллийн кейс байсан. 108- дуудлага ГБХЗХГ дамжиж ирнэ. Хөршүүд цагдаа руу дуудахад хэсгийн байцаагч дуудлагын дагуу ирнэ.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ? 5-6 хүн оролцоно. 1. Засаг дарга 2. Зохион байгуулагч- Баг учраас нийгмийн ажилтан байхгүй 3. Хэсгийн байцаагч 4. Өрхийн эмч 5. Хэсгийн ахлагч 6. Сумын хамтарсан багийн НА
4	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү? 1. Мэдээлэл ирэнгүүт, багийн хэмжээнд хамтарсан багийн хурлаа хийнэ. 2. Зуунмодын хамтарсан баг руу мэдэгдэнэ. 3. Хэсгийн ахлагч нар өрхийн мэдээлэл цуглуулна.

		4. Зуунмод сумын хамтарсан баг- нийгмийн бодлогын мэргэжилтэн мэдээлэл авч цагдаа, ГБХЗХГ- мэргэжилтэн ярилцана. 5. Сумын хамтарсан багийн гишүүд оролцсон хамтарсан багийн гишүүд гэр бүлийн гишүүд, эцэг эхтэй уулзаж гэр бүлийн нөхцөл байдлын дүгнэнэ. 6. ГБХЗХГ-ын мэргэжилтэн хүүхэдтэй уулзана. 7. Дүгнэлт гаргана. 8. Аюулгүй төлөвлөгөө- Үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө 9. Зуунмод сумын мэргэжилтэн кейс файл нээнэ.
5	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	Аймгийн хэмжээнд түр хамгаалах байр байхгүй.
6	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Тоног төхөөрөмж байхгүй Өөрсдийн утас, хувийн ажлын хэрэгслийг ашиглана.
7	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Байхгүй
8	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Хэсгийн ахлагч, зохион байгуулагчид хуулийн мэдлэгтэй байх шаардлагатай. Анхан шатны сэтгэл зүйн мэдлэгтэй байх ёстой.
ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Хувийн туршлага дээрээ тулгуурлан үйлчлүүлэгчтэй ярилцана. Эсхүл сэтгэл зүйчтэй уулзуулна. Зуун мод сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн- НА биш 1692 хүүхэдтэй, үүний 170 гаруй хүүхэд сэтгэл зүйн асуудалтай. 10 хүүхдийг нэг нь.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ?	
	Нэг тохиолдол (нэг кейс) д	Нөхөн сэргээх үйлчилгээнд оролцох хүн бол

3	хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ?	хэсгийн ахлагч, ГБХЗХГ
4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?...	Дундажаар 3 удаа уулзана. Үл хайхрах дээр 7 хоног зарцуулсан Бие махбодын тохиолдол ирээгүй Цагдаагийн дуудлагаар 6 сард ирсэн. Одоо ажиллаж л байгаа.
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Дундажаар 3-4 удаа уулзана. Багийн Засаг даргын өрөөнд л ганцаарчилж уулзана.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Дэлхийн Зөнгийн дэмжлэгээр Гэрээр айлчлал хөтөлбөрт хамрагддаг. 7-8 айлчлагчтай. Сайн дурын үндсэн дээр явагдана. ДЗ-аас хантааз, гэр чийдэн, өгдөг.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Утас, бал, дэвтэр

8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	1. Мэргэжлийн дэмжлэг, мэргэжлийн НА байхгүй, Сэтгэл зүйч багт байхгүй. 2. Хүүхэд хамгааллын чиглэлээр ГБХЗХГ 3. Орон нутгийн хөгжлийн сангаас дэмжлэг авах хэрэгтэй. Одоо орон нутгийн хөгжлийн сангаас зөвлөх завсар, барилга байгууламж, тохижилтонд зарцуулах ёстой гэсэн буруу ойлголттой.
9	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	ДЗ-ын хамтарсан багийг дэмждэг. Жилд 15-20 сая төгрөгийн дэмжлэгээр сургалт сурталчилгаа хийдэг. Үүний 7-8 сая нь охидын сургалт, эцэг эхийн сургалт, эерэг хүмүүжлийн сургалтанд зарцуулагдана.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Хөтөлбөр гэж байхгүй, жилийн эхэнд төлөвлөгөө гаргаад л сургалт, сурталчилгааны ажил хийнэ.
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	7 хүн- 1-р багийн албан хаагчид оролцдог. Дэлхийн зөв болон бусад байгууллагын төлөөлөгчид нэмбэл 10-12 хүн 20 хүн иргэн дундажаар оролцоно.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	20 цаг зохион байгуулсан 3 хүн гэвэл 60 хүн цаг
	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр	Зөөврийн компьютер, дэлгэц, проектор, принтер

5	хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	нийт 8-10 сая төгрөгийн тусламж ДЗ орон нутгийн хөтөлбөрөөс уувуулан цувуулан авсан. Бид авна гэж хүсэлт гаргаад хөөцөлдвөл тусламж авдаг. Хөөцөлдөхгүй бол өгөхгүй.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	Өндөр- 9-10 оноо
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	Хүүхдийн мөнгөтэй холбоотой өөрчлөлт- Хүүхдээ асарч байгаа эцэг эхэд мөнгийг нь өгөх гм
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	ГБХЗХГ Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн ДЗ
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	Хэсгийн ахлагч нар- Багийн ЗД-аас авна БЗД-Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн, ГБХЗХГ Хамт олонтойгоо ярилцана.
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	Дахин дуудлага, мэдээлэл ирэхгүй бол гайгүй байна болсон гэж үздэг
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ	Хэсгийн ахлагч, зохион байгуулагч ЗД Өрхийн эмч, хэсгийн байцаагч

3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ	
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ	

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

- Айлаар – Ковидын үед айлаар очиж болохгүй байсан.
- Хоол тэжээлийн асуудал их байсан учир Номт багийн айлуудын дунд хандивын аян өрнүүлсэн 110 айлд хүнсний тусламж үзүүлсэн. Багт 27 хүнсний талон авдаг. Гэсэн ч тэдэнд хүрэлцдэггүй.
- Манай баг 1400 өрхөөс 27 өрх л хүнсний талон авдаг.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс мөнгө авдаггүй.
- Орон нутгийн хөгжлийн сангийн шалгуурт оруулж авах боломжтой. Өмнө хэлсэнтэй адил.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг: Төв

Сум: Зуун мод

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: Пүрэвжаргал

Ярилцагчийн албан тушаал: ГБХЗХГ-ын ХХ-ын мэргэжилтэн, ХЭУБ

Зөвлөх/судлаачийн нэр: А. Батхишиг, Б. Бүжинлхам

Огноо: 2021.08.01

Эхэлсэн цаг: 14.17

Дууссан цаг: 16:10

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг 108-аас дуудлага аваад тухайн сумын ХБ-д мэдээлээд кейсийг шилжүүлээд 72 цагийн дотор явцын мэдээлэл өг гэдэг. Алслагдсан сум жишээ Батсүмбэр сум гэх мэт гол устай газар 72 цаг дотор амжихгүй тохиолдолд байдаг.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ? Аймгийн төв дэмжих баг ажилладаг. Мэргэжлийн зөвлөн дэмжих зорилготой. Дэмжих багийн ахлагч нь газрын дарга, нарийн бичиг нь ХХ-ийн мэргэжилтэн. Дэмжих баг аюулгүй төлөвлөгөө зэргийг хийхгүй, асуудал хүндэрсэн бол зөвлөн туслах зорилгоор ажиллана. Аймаг дээр бэлгийн хүчирхийллийн бүх тохиолдыг шийддэг учир өөрсдөө бэлгийн хүчирхийллийн тохиолдолд дээр ажиллана.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ? Аймгийн хэмжээнд бол ГБХЗХГ-ын дарга, мэргэжилтэн Дэмжих багаас цагдаа, эмнэлгийн үйлчилгээ үзүүлнэ.
4	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү? 1. Мэдээлэл авна. 2. Нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. 3. Аюулын зэргийн үнэлгээ 4. Хамтарсан баг, дэмжих баг хуралдана. 5. Кейстэй ажиллах төлөвлөгөө хийнэ. 6. Эмнэлгийн дүгнэлтэд үндэслэн өмгөөлөгчтэй авна. 7. Дахин хуралдана_ 8. Шүүхээс нэхэмжлэл гаргахад хууль ёсны төлөөлөгч болно. 9. Сэтгэл зүйчтэй уулзуулна.
5	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгчийн

	орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	байранд байдаг. Хэсгийн төлөөлөгч нар бараг ирэхгүй. Харуул хамгаалалтын хувьд цагдаагийн байранд учир цагдаагийн харуул хамгаалалтанд байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид- ээж хүүхэд байна. Хүүхдийг бол 108 түр хамгаалах байр луу явуулна.
6	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Төв аймагт Ногоон картын үйлчилгээ гэдгийг нэвтрүүлсэн. Эмнэлэгт шууд оочергүй үйлчлүүлнэ. Дуу хураагуур хэрэгтэй. Унаатай боловч жолооч байхгүй, Харуулын ээлжгүй өдрөөр машинаар явах боломжтой.
7	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Унаатай. Гол нь хүн хүчний асуудал их. Үйлчилгээтэй хамт боловсон хүчнийг төсөвлөх хэрэгтэй. Нээлттэй хаалганы өдрөөр л хөдөө явуулын үйлчилгээ хийдэг. Гэхдээ нэг удаа бүтэн аймгаа тойрч амжихгүй. Хоёр жилд 1 удаа л аймгаа бүтэн тойрно. Нэг мэргэжилтэн тул хөдөө явсан хойгуур ард ажил нь үлддэг.
8	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Байхгүй
ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Сэтгэл зүйн үйлчилгээ Эцэг эхэд нь нөлөөлөх Аюулгүй байдлыг хангах Түр байрлуулах Хуулийн заалттай холбоотой зөвлөгөөг сумдын мэргэжилтнүүдэд өгдөг
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ?	Эргэн хяналт хийх талаар утасдаж асууна. Эргэн хэвийн амьдралд нь ороход туслах хяналттай байх ёстой.
3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ?	Дарга Мэргэжилтэн Бичиг хэрэг

4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?...	Архины хамааралтай эцэг эхтэй хүүхдийн кейс хаагдахгүй- нээлттэй байх явдал их. Аав ээж зодохгүй. Гадны хүн зодох тохиолдол хурдан 30 хоногийн дотор Зөрчлийн хуулиар шийдэгдэнэ. Эцэг эх зодсон тохиолдолд ойлгуулах хэрэгтэй болно. Харин Эрүүгийн хуулиар асуудал шийдэх тохиолдолд 1.5-2 жилийн дотор шийдэгдэнэ. Энэ нь ихэвчлэн бэлгийн хүчирхийлэл байдаг. 30 хоног дотор бол нэг удаа уулзахдаа 1-2 цаг уулзана. Нийт 4 удаа уулзана. Ойролцоогоор 8-10 цаг уулзана. Бэлгийн хүчирхийллийн үед эхний 1-2 сард байнга уулзана. Хамгийн багадаа 10 удаа 10 хоног хүртэл уулзах жишээтэй.
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	1 цаг уулзана- хамгийн багадаа 3 удаа уулзана Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 1 цагаар 10 удаа уулзана.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Хэрэгтэй, гэвч нөхцөл боломж байхгүй. Бүх шийдвэр гаргах байгууллага, шүүх, эмнэлэг аймагт байдаг. Явуулын үйлчилгээ хийж туршиж үзсэн. 60 гаруй хүнд үйлчилсэн.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Нэг цэгийн үйлчилгээн дээр, мөн кейс менежер зэрэг хүүхэдтэй уулзах үед цай хоол өгөх хэрэгтэй. Манайд боловсон хүчний нөөц боломж муу. Манай байгууллагад машин өгсөн боловч жолоочийн орон тоо байхгүй болохоор жижүүрийг ээлжгүй өдөр жолоочоор авч явдаг.
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	
	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг	Нөхөн сэргээх үйлчилгээ гэж тийм зүйлийг хэлнэ

9	хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	гэдэг тодорхойлолт бичээд, ямар ямар үйлчилгээ үүнд багтахыг зааж өгөх хэрэгтэй.
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	Цагдаагийн газар- осол гэмтэл, хулгайтай холбоотой ажил зохиоход хамтарна. Гэр бүлийн өдөр-5 сарын 15, хүүхэд зодож шийтгэхгүй ОУ-ын өдөр -4 сарын 30, ХЭК-ийн өдөр -12 сар зэрэг тэмдэглэлт өдрүүдээр нөлөөллийн ажил хийдэг.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Эцэг эхийн зан үйлийг өөрчлөх сургалтуудыг оруулах хэрэгтэй болов уу.
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	2-3 ажилтан оролцоно. Үүнд: гэр бүл хариуцсан мэргэжилтэн, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, дарга гээд бид гурав ихэвчлэн урьдчилан сэргийлэх ажлыг хийхэд оролцоно.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	1 сар 15 хоног буюу ажлын 38 хоног зарцуулна.
5	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Сургалтын хэрэглэгдэхүүн, баннер хийх цаас, хулдаас Сургалт, уулзалтын зардал- цай хоол гэх мэт зүйл хэрэгтэй. Сургалт дээр нэг оролцогчид 3000, бичгийн хэрэглэл 4,000, хэвлэх материал 1500 х 2000 гэх мэтээр тооцно.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний	

	хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	8 оноо
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	Урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль дээр заасал оруулах
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Тогтвор суурьшилтай ажиллахад нь анхаарах хэрэгтэй. 5 жил ажиллабал сургалт, мэргэжил дээшлүүлэхийг дэмжих, ажлын орчин сайжруулах хэрэгтэй. Нийгмийн баталгаа муу. ы
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	Гадны судлаач, мэргэжилтнээр сургалт хийлгэдэг. Даргадаа зовлон тоочихгүй өөрөө бүгдийг хийхийг боддог.
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	ГБХЗХГ-ын дарга Агентлагийг хамгааллын ахлах мэргэжилтнээс заавар зөвлөгөө авдаг. Мэргэжлийн удирдлагаар хангахад зөвлөн тусалж буй хүний арга барил их чухал.
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	Үр дүнгийн гэрээгээр үнэлнэ. Ажилтныг үнэлнэ.
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ	Байгууллагын дотоод хяналтын багт хяналт үнэлгээний мэргэжилтэн, нягтлан нэмээд хоёр мэргэжилтэн энэ багт ордог.
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ	Хяналт үнэлгээний мэргэжилтэн үнэлдэг.
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ	

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой
зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

.....

.....

.....

.....

.....

.....

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг: Архангай

Огноо: 2021 оны 8 сарын 5

Сум: Эрдэнэбулган сум

Эхэлсэн цаг: 14.00

Ярилцагчийн нэр: Э. Батхуяг, А.Рэгзидмаа

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр, албан тушаал: Э.Бартхуяг нь Эрдэнэбулган сумын Засаг даргын орлогч, А.Рэгзидмаа нь Эрдэнэбулган сумын ЗДТГ хүн ам зүйч сататистикч-хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, хамтарсан багийн гишүүн, эдийн засагч мэргэжилтэй.

Дууссан цаг: 15.20

Зөвлөх/судлаачийн нэр: А.Батхишиг, Т.Цэндсүрэн

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг	24 цаг. Цагдаагийн дуудлагаар эсвэл 108-ын дуудлага ирсэн тохиолдолд очдог. Сүүлийн 1 сарын хугацаанд 1 дуудлага ирсэн байна, он гарснаас хойш 13 дуудлага ирсэн байна.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ?	1 сарын хугацаанд 3-4 шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлж байна. Түр хамгаалах байранд 3 хүүхэд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 1, хараа хяналтгүй болон хойд эцэг эхдээ зодуулсан 8 хүүхдийн кейс ирсэнийг 1 сараас хойш хамгаалах байранд байрлуулсан.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ?	2-3 хүн оролцдог. Суман дээр хүн ам зүйч статистикч, багийн нийгмийн ажилтан, цагдаа 3 хүн очдог.
4	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар ямар албан тушаалын	Шуурхай тусламжийн үйлчилгээний дуудлагын үед зарим тохиолдолд хуульч, сэтгэл зүйч оролцох тохиолдол байдаг.

	ажилтан, албан хаагч оролцдог вэ	
5	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү?	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ээж хүүхэд цагдаа болон багийн нийгмийн ажилтан надруу утсаар мэдэгдэхэд аюулгүй байдал эрсдлийн үнэлгээ хийгээд хэрвээ үнэлгээр аюулгүй байдал нь өндөр гарвал хамгаалах байранд байрлуулдаг. 3-5 хоног хамгаалах байранд байлгаад гаргадаг.
6	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	Түр хамгаалах байртай, шаардлагатай (аюулгүй байдлын үнэлгээгээр) хүүхдээ хамгаалах байранд байршуулдаг.
7	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Нөхцөл байдлын үнэлгээний мяагтын асуултууд хоорондоо давхцдаг, сайжруулах хэрэгтэй. Шууд маягтан дээр бөглөхөд хүндрэлтэй байдаг, бид нарт дуу хураагуур, зургийн аппарат хэрэгтэй байдаг. Одоогоор гар утсаараа л бичээд л явж байна. Одоо таблеттай болсон нь цаг хугацаа их хэмнэж, мэдээллийг шууд дамжуулж байна.
8	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Яаралтай тохиолдолд Засаг даргын унаа, цагдаагийн машинд л дайгдаж, дуудлагаар явдаг. Бид шууд явах гэхээр унаа байхгүй, хэрвээ унаатай бол өөрсдөө шууд явчихна. Унааны мөнгө энэ тэр авч байгаагүй, хамтарсан баг дээр бензины мөнгө бараг авч байгаагүй, журмын дагуу тах бариад жолоочоор өргөдөл бичүүлээд явна гэвэл хүндрэлтэй.
9	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ? Хамтарсан багийн шидвэрээр хүүхдийн асран хамгаалагч тогтоох, удаан	Кейст зориулсан зардлыг тусгаж өгөх хэрэгтэй. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байхад шаардлагатай ахуйн болон хоол хүнсний мөнгийг бид нар өөрсдөөсөө хувиасаа гаргаж байсан. Түр хамгаалах байранд бага насны хүүхдийг асран хамгаалагчтай нь байлгах гэхээр ээж нь согтуу, хүүхдээ эмнэлэгт хэвтүүлэх гэхээр сахиургүй гээд хүндрэлтэй л байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харж хандах хүнгүй бол хамгаалах байранд авахгүй гээд байдаг нь хэцүү байдаг, энийг л өөрчлөх хэрэгтэй. Тухайлбал ээж нь архины хамааралтай 3 хүүхэд байна. Итгэмжлэгдсэн төлөөлөлөгч томилоод хүүхдийг асрамжийн газар явуулъя гэхээр одоогоор энэ асуудлыг шийдэж чадахгүй байна. Ээж хүнсний талоноор авсан хүнс будаагаа зараад архи аваад уучихдаг. Энэ хэцүү байдлаас болоод 7 настай хүү нь дэлгүүрээс хүнсний зүйл хулгайлсан явдал гарсан.

ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ? Холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байсан.Үүнд: хамтарсан баг хамгаалах байранд өгсөн, дараа нь Өнчин төвд өгсөн, тэндээсээ зусланд амраасан. Ингэж байх хугацаандаа хүүхдийн асуудлыг шийдэж байсан. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах байранд байрлуулъя гэхээр эцэг эхчүүд нь дургуйцдэг. Тухайлбал бэлгийн хүчирхийлэлд өртсөн охин хүчирхийлэгчтэйгээ хамт амьдрах тохиолдол байна. Үүнээс болоод хүүхэд сэтгэл зүйн дарамтанд өртсөн. (хуулийн хүрээнд энэ асуудлыг цаг алдахгүй хурдан шийдвэрлэдэг байх) Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг батлан даалтаар гаргадаг нь буруу байна, бас хэрэг шийдэх процес хэтэрхий удаан яваад байна. 14 нас гэлгүйгээр хүүхэд л бол хүүхэд тул ингэж нас заалгүйгээр 18 насаар нь хүүхэд гэж тооцох. Ээж нь өнгөрсөн эмээ дээрээ байдаг, тэтгэмжийн мөнгө нь аавынх нь дансанд ороод байдаг. Гэтэл эмээ нь өсгөөд байгаа тиймээс эмээд тэтгэмжийн мөнгийг нь олгодог баймаар байна. Өөрөөр хэлбэл гэр бүл салсан тохиолдолд эсвэл хүүхдээ хаяад явсан мөртлөө хүүхдийнхээ мөнгийг аваад яваад байдаг асуудал байна. Иймэрхүү эцэг эхийг цагдаатайгаа хамтраад албадан дуудуулж ирүүлдэг.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ? Түр хамгаалах, асрамжлах үйлчилгээний асуудлыг оруулах хэрэгтэй. Гэхдээ тэр үйлчилгээ нь хамгаалах байр биш хүүхдийн хэрэгцээнд нийцсэн, асуудлыг нь шийдвэрлэдэг байх хэрэгтэй.
3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ? Хамтарсан багийн бүх гишүүд 7 гишүүд оролцдог. Мөн шаардлагатай бол өмгөөлөгч, сэтгэл зүйч оролцдог.
4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн Үл хайхрагдсан- 1 жилийн хугацаатай ажилладаг, заримдаа 1 жилээс ч илүү удаан хугацаанд ажиллаж байна. Бие махбодийн хүчирхийлэл-Хүүхдийн гэмтэл бэртлээс шалтгаалан ялгаатай, ихэвчлэн 24

	кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?... ..	цагийн хугацаанд хөнгөн асуудлыг шийддэг. Харин хүнд бэртэж гэмтсэн тохиолдолд уднаа. Сэтгэл санааны хүчирхийлэл- 3сар хүртэл явна, 7 хоногт 2 удаа уулзана. Бэлгийн хүчирхийлэл- 1 жил болноо.
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Аав, ээжтэй болон хохирогчтой тус тусад нь уулздаг. Гэр бүлийн хичнээн гишүүн байдаг тэр болгонтой л уулздаг. 1 гишүүнтэй 1 уулзахдаа хамгийн багадаа 30 минут уулздаг, дараа нь эцэг эхтэй, хохирогч хүүхэдтэй 10-15 удаа уулзана. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй өдөр болгон уулзах шаардлагатай байдаг. Хамгийн багадаа хөнгөн кейс дээр 4-5 уулздаг.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	ГБХЗХГ-ын 1 мэргэжилтэн нь хүүхэд хамгааллынхаа асуудлаар ажилладаг энэ нь давуу талтай байдаг. Гэтэл миний хувьд олон асуудалруу ороод явах нь хүндрэлтэй байдаг. ГБХЗХГ-ын хүн хүч нь хүрдэггүй юмуу эсвэл яг кейс дээр гардаж ажиллаж очсон тохиолдол ховор байдаг. Эрдэнэбулган төвийн мэргэжилтэн нь улс төрийн шалтгаанаар 4 жил болоод л солигдчихдог. Багийн нийгмийн ажлалтнууд ихэвчлэн эмэгтэйчүүд шууд дуудлагаар очиход хүндрэлтэй. Цагдаа бол 3 багийн дунд 1 ажилладаг.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Шинэ оноор хамгаалах байрнаас хүүхдийг гаргачихсан байсан. Энэ байдлаас болоод хохирогч хүүхдийн асуудал улам хүндэрсэн байдлыг Багийн засаг дарга, нийгмийн ажилтан, сумын статистик хүүхдийн асуудал хариуцсан миний бие очиж харсан, уулзсан, хүүхэд бараг сэтгэцийн өвчтэй болсон байсан, хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд оруулсан эцэг нь шоронд ороогүй хамт амьдарч байсан.
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Оношлогоо, хэмжүүр тестүүд бидэнд байхгүй. Тоглоом энэ тэр хэрэгтэй байдаг ч байдаггүй.
	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх	Хүчирхийлэлд өртсөн тусламж дэмжлэг шаардлагатай хүүхдийг улс шууд хяналтандаа,

9	үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	хамгаалалтандаа авдаг л баймаар байна. Аав ээжийн эсэргүүцлийг анхааралгүйгээр төр шууд л хүүхдээ хамгаалдаг баймаар байна. ГЭХДЭЭ ХҮҮХДИЙГ БАЙЛГАХ ГАЗАР НЬ тохь тухтай, анхан шатны хэрэгцээг нь хангасан байдаг баймаар байна.
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	Эцэг эхчүүдийг сургалтанд хамруулдаг. Суман дээрээ багуудаас судалгаа гаргуулж аваад цагдаа дээр гэхэд архины хамааралтай эцэг эхийг сургалтанд хамруулдаг.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Эцэг эхчүүдэд сургалт мэдээлэл өгөх зэргээр ажиллаж байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо илрүүлэлт сайжирсан байгаатай холбоотой нэмэгдэж байна. Жилд 3-4 гарч байна.
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	Дэлхийн зөн, Хүүхдийг ивээх сангаас сургалт авдаг. Төрөөс нийгмийн ажилтнуудаа чадваржуулах сургалт зохион байгуулах мөнгө төрд байдаггүй, олон улсын байгууллагатай хамтрахгүй бол сургалт хийх мөнгө байхгүй.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	Ажлын 5-10 өдөр зарцуулнаа.
5	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Бичиг хэргийн материал, дуу хураагуур шаардлагатай байдаг.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	Алслагдсан сумын төвийн иргэдийн үйл ажиллагаанд хамруулахад төвөгтэй байдаг. Санхүүжилт шийдэгддэггүй, бензин авах гээд бөөн чирэгдэл болдог.
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	Олон улсын байгууллагуудтай хамтардаг. 4-5 байгууллага хамтраад нэг ажлыг хамтран зохион байгуулдаг.
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээний хэлбэрүүдийг тусгаж, санхүүжилт

	хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	тодорхой баймаар байна.
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Өөрөө өөртөө л анхаарал тавьж тайвшруулдаг.
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	Яг тэгж хангадаг хүн байхгүй.
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ?	Энэ талаар хуулинд тусгуулж өгөх нь зүйтэй, тэгвэл бид нар ажилдаа сэтгэл хангалуун хариуцлагатай ажиллах нэг нөхцөл болно.
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	ГБХЗХГ-ын удирдамж, сургалтаар заасан зарим аргуудыг ашиглан үнэлдэг.
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ?	Хамтарсан баг хүүхэд хамгааллын үйлчилгээгээ хянаж үнэлдэггүй, гэхдээ шаардлагатай тохиолдолд ажлаа үнэлүүлдэг.
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ?	
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ?	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хяналт үнэлгээ тодорхой байвал ядаж л хамтарсан багийн ажлыг үнэлэх явц тодорхой шударга болно.

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

.....

.....

.....

.....

.....

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2021 оны 8 сарын 5

Аймаг: Архангай аймаг

Сум: Эрдэнбулган

Эхэлсэн цаг: 9.35

Ярилцагчийн нэр: Эрдэнэболдын Дайриймаа Түр хамгаалах байрны Нийгмийн ажилтан

Шүрэнцэмцын Бямбасүрэн албан тушаал нь нийгмийн ажилтан, үндсэн мэргэжил нь багш

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: ГБХЗХГ-ын дэргэдэх Түр хамгаалах байр

Дууссан цаг: 11.00

Ярилцагчийн албан тушаал дарга: нийгмийн ажилтан

Зөвлөх/судлаачийн нэр: А.Батхишиг, Т.Цэндсүрэн

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг	24 цаг дотор үйлчилгээ үзүүлдэг. Кейс файлаа нээнэ, эмнэлэгийн анхан шатны үйлчилгээ үзүүлнэ, эрүүл мэндийн болон ахуйн үйлчилгээ үзүүлнэ, нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ?	Хэсгийн байцаагч аюулгүй байдлын зэргийн үнэлгээ хийгээд аваад ирсэн байдаг. Засаг даргын тодорхойлт, хамтарсан багийн тодорхойлолтоор хамгаалах байранд ирдэг.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ?	3 ээлжийн нийгмийн ажилтантай, насанд хүрээгүй хүн байвал итгэмжлэгдсэн төлөөлөлчийг хамт байлцуулдаг. Шаардлагатай гэвэл сэтгэл зүйч орно. 6 хүн оролцдог.
4	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар ямар албан тушаалын	Хүүхдээ байх хугацаанд нь хөгжүүлэх ажил хийнэ, хөтөлбөрүүдийн дагуу хичээл заана. Хүүхдийн нас сэтгэл зүйн онцлогт тохирсон мэдээлэлүүд өгдөг. Нийгмийн ажлын төлөвлөгөө гаргадаг. Долоо хоногт 2 удаа дэмжих бүлэгт ажиллуулна. Боловсролын үйлчилгээг нь тасралтгүй хүргэхэд

	ажилтан, албан хаагч оролцдог вэ	анхаардаг. Хүүхдийг тайвшруулахын тулд ярилцлага хийнэ. Хөгжимт дасгалууд, хөгжиимт засал хийдэг. Нийгмийн ажилтан- өдөр тутам хүүхэдтэйгээ хамт байдаг, асрагчын үйлчилгээгээ ч хамт хийнэ, кейс файлаа ч бүрдүүлнэ. Сэтгэл зүйч- 8 цаг ажиллана.
5	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү?	Хүүхдээ хүлээж аваад ПСР шинжилгээ аваад, хооллож амраачаад кейс файлаа бүрдүүлдэг. Бүх маягтуудаа бүрдүүлж авдаг. Ээжийгээ дагаад хүүхэд ирэх тохиолдол байна. 1 хүүхэд хамгийн багадаа 1 хононо. Хамгийн ихтэй 3 сар болох тохиолдол байсан. Дунджаар 1 сар болдог.
6	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	3 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч. Хүүхдийнхээ хоол ундыг бэлтгэх, цэвэрлэгээг бид өөрсдөө хийдэг.
7	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Бичиг цаас, камер зургийн аппарат, ком шаардлагатай байдаг. Хүүхэдтэй ажиллахад тоглоом хэрэгтэй. Нэмэлт зарим шаардлагатай бичиг хэргийн бараа зэргийг ГБХЗХГ шийдвэрлэж өгдөг.
8	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Бид бараг явдаггүй.
9	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Тулгараагүй.
ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Ганцаарчилсан, дэмжих бүлгийн ярилцлагууд. Хөгжүүлэх дасгалууд, сургалтууд хийж байна. үйлчлүүлэгчид ямар нөөц боломж байна, тэрийг нь дэмжиж ажиллана. Эндээс гараад үйлчлүүлэгч хот явна, ах дүү хамаатан садандаа очдог.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ?	Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг хамтарсан баг хийнэ, бид бас давхар судалж, баримтжуулалт хийгээд хамтарсан багдаа хүлээлгэн өгдөг. Дараа нь бас гэр бүлтэй нь очиж танилцдаг. Заримдаа кейс 2 удаа буцаж ирэх

		тохиолдол байна. Хамтарсан багтайгаа хамт эргэн нэгтгэх үйлчилгээг үзүүлдэг.
3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ?	Кейс менежментээ өөрсдөө хийдэг. Миний ээлжин дээр ирсэн хүүхдийн кейсыг би нээж, хааж хөтлөөд явдаг. 2019-2020 оныг дуустал нийт 35 үйлчлүүлэгч ирсэн, бид 4-лээ ажилласан. Хуульчийн оролцоо бага, шүүх дээр эсвэл хүүхэд өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд уулздаг. Нөхөн сэргээх үйлчилгээ- Дэмжих бүлгийн ярилцлага л их хийдэг. Бичиг баримт нь дутуу бол бид тусалж хүүхдийн мөнгө авах зэрэгт нь тусалдаг. Сургуульд хүүхдийн харъяалал харгалзахгүйгээр авахгүй байх тохиолдол гарч байгаагүй.
4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?...	Үл хайхрах- энэ онд 2 хүүхэд ирсэн, 6 хоносон. 2 настай хүүхдээ хоол тэжээлийн дутагдалд оруулсан байсан. Ээжийнх нь эгч дүүгээ 2 хүүхэдтэйгээ хамт байлгана, би өөрөө эсрсдлээ хариуцаад асран халамжлана гээд хүсэлт гаргаад хүүхдүүдийг авсан, хамтарсан баг шийдвэрлэсэн. Дунджаар 10 хононо. 2019 онд 3 хүүхэд ирсэн, 10 гаруй хоносон. Бие махбодийн хүчирхийлэл- ээждээ зодуулсан охин 2 дахин ирж байсан бараг 3 сар болсон. Сумаас ирсэн 2 хүүхэд 10 гаруй хоносон. Ээжийнх нь эгч зоддог байсан. Сэтгэл санааны хүчирхийлэл- 1 хүүхэд ирсэн 77 хоносон, ээж нь хамтран амьдрагчтай, энэ хүүхэд бас бие махбодийн хүчирхийлэлд өртсөн байсан. Бэлгийн хүчирхийлэл- 3-4 сар болсон, шүүхээр ортол уддаг.
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Нэг удаагийн уулзалт 45 минутаас 1 цаг хүртэл болдог. 1 хүүхэдтэй дунджаар 7 хоногт 2 удаа уулзана, энд байх хугацаанд нь 9-10 удаа уулздаг. Гэр бүлтэй нь уулздаг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охины хувьд гэр бүлтэй нь 7 хоногт 2 удаа уулзаж байсан.

6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Явдаггүй. Хэрвээ түр хамгаалах байранд үйлчлүүлэгч байхгүй тохиолдолд ГБХЗХГ-хаа бүхий л ажилд оролцох, бас сумаар явах тохиолдол байна.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Хөгжим ашигладаг. Ном, тараах материал ашигладаг. Өнгийн цаас, харандаа шаардлагатай байдаг. Эмэгтэйчүүд даалин оёдог, үүнтэй холбоотойгоор шаардлагатай хэрэглэгдэхүүнийг авсан. 1 хүүхдэд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тооцож байгаагүй, ГБХЗХГ-таа шаардлагатай зүйлээ хэлээд авахуулдаг.
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Эмч их хэрэгтэй байдаг байсан, шаардлагатай тохиолдолд ирээд хамтран ажилладаг гэрээт эмчтэй байвал зүгээр байдаг. Хүүхдийг тайвшруулахад эмч ирдэг 103 л дууддаг.
9	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	Дахиж хүчирхийлэлд өртүүлэхгүйн тулд- энд ирж байсан үйлчлүүлэгчдээ цуглуулаад зөвлөгөө сургалт өгсөн 1 удаагийн уулзалт зохион байгуулсан. Аюулгүй байдлын төлөвлөгөөгөө үйлчлүүлэгчтэй хамт хийдэг. Эрсдэл гарвал хэнтэй ярих уу? гэх ч юмуу зааварчилгааг өгч төлөвлөгөө боловсруулдаг.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Аюулгүй байдлын төлөвлөгөө хийдэг.
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	Өдөрт доод тал нь 3 постер хийх зэргээр ажилласан. ГБХЗХГ-тай хамтраад постер, нөлөөллийн хуудсууд хийсэн. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, ГБХЗХГ-ын мэргэжилтэн, заримдаа цагдаа оролцдог.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас	Ажлын 14 хоног байна.

	эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	
5	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Ком, өнгөт принтер цаас өнгийн харандаа хэрэгтэй.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	Гардаггүй. Ажилдаа одоо гаршаад байна.
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжаар ажлаа үнэлдэг. 5 сарын 15 болон тэмдэглэлт үйл явдлаар аян хийдэг.
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Хүний нөөц хангалтгүй гэж боддог. Манайх нэг доор 8 үйлчлүүлэгч авах хүчин чадалтай. Манай нийгмийн ажилтнууд тогооч, цэвэрлэгч, асрагч зэрэг ажлаа бид өөрсдөө хийдэг, ачаалалттай байдаг. Цэвэрлэгч эсвэл асрагч гэрээт байдлаар ажиллуулдаг баймаар байдаг.
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ?	Хоорондоо л бие биентэйгээ ярилцдаг. Үйлчлүүлэгчтэй харилцахад хүндрэлтэй, сэтгэл зүйн хувьд таагүй бол ажлаасаа чөлөө өвч байгаагүй, өөрсдөө гүрийгээд л ажлаа хийдэг. Мэргэжлийн болон Хувийн ажлын ялгаа гэж бодоод л ажилдаа л анхаарлаа хандуулдаг.
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	Дэмжин тусалдаг ахлах нийгмийн ажилтан хэрэгтэй. Хэрвээ байдаг бол зүгээр. Бүртгэл судалгаа- мэдээлэл тайлангаа эндээ гаргаад аймгийнхаа ГБХЗХГ-ын мэргэжилтэндээ өгдөг, шаардлагатай бол агентлагт мэдээллээ явуулдаг. Анхан шатны хүмүүсийн ажил дээр тулгуурлаад ажлаа төлөвлөдөг байх ёстой.
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		

1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	ГБХЗХГ-ын гаргасан шалгуурын дагуу үнэлдэг. Би өөрийгөө зарим мэргэжлийн ном хараад үнэлдэг. Шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд гайгүй л гэж боддог.
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ?	Аймгийн ГБХЗХГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн үнэлдэг.
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ?	
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ?	

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

.....

.....

.....

.....

.....

Бусад санал:

Энэ цаг хугацаанд мэргэжлийн тусламж үйлчилгээ авмаар байдаг. Найман сарын эх бол их тохиромжтой байдаг, цахимаар ч сургалт авмаар байдаг. Үйлчлүүлэгчийнхээ асуудлыг маш сайн үнэлэхийн тулд оношлогоо, хэмжүүр тестүүд ашиглах талаар сэтгэл зүйч ажилана гэдгийг уламжилж өгөөрэй.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг: Архангай

Сум: Эрдэнэбулган сум

Ярилцагчийн нэр: Ивановын Амартүвшин

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: Архангай Аймгийн засаг даргын тамгын газар

Ярилцагчийн албан тушаал: Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга

Зөвлөх/судлаачийн нэр: А.Батхишиг, Т.Цэндсүрэн

Дууссан цаг: 12.20

Огноо: 2021 оны 8 сарын 5

Эхэлсэн цаг: 11.10

Миний хувьд аймгийнхаа Хүүхэд, залуучуудын зөвлөлд албан тушаалынхаа дагуу гишүүнээр ажилладаг, аймгийн төрийн албанд ажиллаж байгаа дарга, сумдын дарга нар энэ зөвлөлийн гишүүн. Тэр ч утгаараа бид нар бүх талаар хамтарч ажиллаж байна. Өнгөрсөн жилийн хувьд аймгийн Хүүхэд, залуучуудын зөвлөлийн хурал 2 удаа болсон ба зөвлөлийн ажлын төлөвлөгөө болон цар тахлын үед ажиллах чиглэлээ баталсан. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өнгөрсөн жил бид цахимаар голдуу ажилласантай холбоотой хүүхдэд үзүүлэх үйлчилгээ чанартай сайн байсан гэж хэлэх боломжгүй, бид цахимаар ажиллахад суралцах дасан зохицох асуудал олон тулгамдсан.

Хүүхэд хамгааллын асуудал бүх нийтийн оролцоон дээр суурилж, хамтран ажиллах зарчимтай хэдий ч бид энэ тойргоос эцэг эхийг гаргаад байна уу? гэж харж байна. Эцэг эхчүүдийн хүүхдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлдэг, мөрддөг баймаар байна. Алдарт эх болж алдаршихын зэрэгцээ хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлдэг байх шаардлагатай байна, олон хүүхдүүд эцэг эхийн хайхрамжгүй байдлаас болон гэмтэж бэртэхээс гадна, эрх нь зөрчигдсөөр байна. Хүүхэд хамгааллын тухай хуулинд эцэг эх асран хамгаалагчийн хүлээх үүрэг хариуцлагыг хуульчилсан хэдий ч хэрвээ энэхүү үүргээ биелүүлэхгүй бол ямар хариуцлага хүлээх талаар тодорхой оруулж өгөх хэрэгтэй гэж бодож байна. мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн талаар олон нийт, эцэг эх асран хамгаалагчийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхгүй бол тэд өөрсдийн буруу, хариуцлаггүй байдлаа төрийн үйл ажиллагаанаас болж байгаа мэтээр ойлгож тайлбарлах байдал түгээмэл байна.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээг холбогдох байгууллага мэргэжилтнүүд нь хүргэж байна, тэдгээр байгууллага хүмүүсийг би муулж ажиллаж байна гэж хэлэхгүй учир нь өөрсдийн хүрээнд төлөвлөсөн болон хуулиар хүлээсэн бүхий л ажлуудыг гүйцэтгэж, төрийн ажил, бодлогыг хэрэгжүүлэх байна. Орон нутаг өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжтой ажлуудыг ч санаачлан хийж байна. Тухайлбал манай аймаг "1+1 Хүүхдийн авъяас" хөтөлбөрийг маш амжилттай хэрэгжүүлж, бүх хүүхдийг хамруулж чадсан. Энэ ажлын хүрээнд хүүхдийнхээ хөгжилд цаг зав гаргах эцэг эх, байгууллага хамт олны хандлага сайжирсан гэж бид үздэг.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нэмэлт санхүүжилт зардлыг аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж шийдвэрлэдэг хэдий хуулинд оруулах эсвэл журмаар зохицуулах шаардлагатай нэг ажил байна. Энэ нь аймгийн засаг дарга нарын сайдтай хийдэг гэрээнд төсвийн хөрөнгөнөөс Хүүхэдтэй холбоотой үйл ажиллагаа болон Хүүхэд хамгааллын зарим нэг үйлчилгээнд хичнээн төгрөг зарцуулна гэдэг заалтыг гэрээнд нь мөнгөн дүнтэй нь тодорхой тусгадаг байх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол аймгийн засаг дарга нөөц хөрөнгийг хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд төдийлөн зарцуулахгүй, хэрвээ нарийвчлан зааж тусгаж өгөхгүй бол хойшдоо ч энэ чиглэлээр зардал мөнгө гаргахгүй, шийдвэрлэх боломжтой зүйлийг шийдвэрлэхгүй байх эрсдэлтэй гэдгийг анхаарч

ажлын хэсгийнхэн холбогдох ажлууддаа тусгах хэрэгтэй.

Хүүхэд хамгаалал бол Монгол хүүхдийн хамгаалал байх ёстой гэдгийг та бүхэн анхаарч ажиллах хэрэгтэй шүү. Учир нь хүүхдийн хөгжил оролцооны асуудлыг төлөвлөхдөө өв уламжлалаа анхаарсан, ёс заншлаа дээдэлсэн хүүхдийг төлөвшүүлэхэд дэмжлэг болохуйц ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлдэг байхад холбогдох байгууллагууд нь анхаарч ажилладаг байх, энэ чиглэлээр удирдамж чиглэл өгдөг байх хэрэгтэй. Өв уламжлал, соёлыг орчин үеийн нийгмийн хөгжилтэй уялдуулан хүүхдийн асуудалд анхаарах шаардлагатай. Ингэснээр бид Монгол хүний онцлог, давтагдашгүй чанарыг хадгалан үлдэх болно. Тухайлбал хүүхдийн хүмүүжилд зөвхөн ээж нарын үүрэг оролцоог онцлох бус эцэг, эх хоёулаа үүрэг хариуцлага хүлээдэг тийм гэр бүлийг бий болгоход бодлого зохицуулалтын хувьд анхаарах хэрэгтэй юм шиг надад санагддаг.

Цаашид аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахын тулд бүх талын хамтын ажиллагаа дэмжлэг оролцоо чухал гэдгийг хэлмээр байна. Би эцэг хүний хувьд үр хүүхдийнхээ хүмүүжилд санаа зовсон, чилээсэн олон асуудлууд байна. Миний ажил, тэр байгууллагын ажил гэж хандахаас илүүтэй орон нутгийн хэмжээнд санаачлагтай хамтран ажилладаг, дээрээс чиглэл заавар хүлээлгүйгээр тулгамдсан асуудлаа өөрсдөө шийдвэрлэдэг баймаар байна. Тэгэхээр хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад тугамдаж буй асуудал бол санхүү хөрөнгө мөнгө гэхээсээ илүү идэвхи санаачлаггүй явдал л гэж хэлмээр байна. Хүүхэд хамгааллын хуулийн хүрээнд заасан үүргээ бүх талууд л хүлээж, хариуцлагатай санаачлагатай ажиллах юм бол бид асуудлыг амаррхан шийдвэрлэж чадна.

Хэдийгээр нийгмийн бодлогын хэлтэс нийгмийн үйлчилгээтэй холбоотой бүхий л асуудлыг хамруулан төлөвлөж, гүйцэтгэлийг хянаж ажиллаж байгаа хэдий ч төсвийн захиран зарцуулалт, үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой тэр бүр нарийвчилсан ажлуудад оролцож амжихгүй байна, гэхдээ манай хэлтэсээр байгууллагын төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлтэй холбоотой тайланг хянагдаж, дамжигдаж байгаа. Тэгэхээр бид огт ажлуудад нь оролцдоггүй гэсэн үг бид хяналтаа тавиад холбогдох асуудлаар санал хүргүүлээд, хамтраад ажиллаад яваад байна.

Цаашид бид мэргэжлийн хүмүүсийг мэргэшсэн салбарт нь ажиллуулахад анхаарна гэхдээ манайд мэргэжлийн хүн гэж харахаас илүүтэй улс төр болон бусад асуудлууд хүний нөөцийн сонголтод нөлөөлдөг дутагдалтай зүйлүүд мэр сэр гардаг. Нийгмийн салбарт хамгийн түрүүнд анхаарах зүйл бол хүний нөөцийн тогтвортой байдал, мэргэшсэн байх нь чухал гэж би боддог. Хэдийгээр миний хувьд нийгмийн чиглэлээр ажилласан туршлага хомс хэдий ч мэдэхгүй чадахгүй зүйл дээр холбогдох хүмүүс, мэргэжилтэн, байгууллагуудын саналыг авч харилцан ярилцаж асуудлыг шийдвэрлэхийг хичээдэг. Цаашид ч энэ чиглэлээ баримтлан ажиллах болно.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг: Архангай
Сум Цэцэрлэг хот

Ярилцагчийн нэр: Д. Саран

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: Японы ХИС

Ярилцагчийн албан тушаал: Архангай аймаг дахь салбарын зохицуулагч

Зөвлөх/судлаачийн нэр: А. Батхишиг

Огноо: 2021.08.05

Эхэлсэн цаг: 11:15

Дууссан цаг: 12:50

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг	Шуурхай тусламжийн арга зүйн зөвлөгөө өгдөг. 24 цагийн дотор шуурхай тусламж үзүүлдэг гэж боддог, ойлгож байна. Гайгүй боломжийн гэж үзэж байна.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ?	Дурдсан үйлчилгээ бүгд үзүүлдэг. Сард хэд гэдгийг мэдэхгүй байна. 6-7 сард Чулуут, Хайрхан, Батцэнгэл, Эрдэнэбулган 4-р багт дуудлага ирээгүй байна. Илрүүлэлт бага байна бодож байна. 108-аас бас гэр бүлийн газар, цагдаагаас тус тус дуудлага ирдэг.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ?	Хамгийн багадаа 8 хүн оролцдог Хамтарсан багийн ахлагч ЗД, сумын нийгмийн ажилтан, багийн нийгмийн ажилтан хэсгийн байцаагч, эрүүл мэндийн төвийн ажилтан, сна, арга зүйч, халамжийн нийгмийн ажилтан Аймгийн ХЭУБ,
5	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү?	Кейс менежментийн 6 алхам- арга зүйн зөвлөгөө өгч байгаа газар болж байна. Хамтарсан багийн үйл ажиллагаа сул байна. Төсөл өгч байгаа болж байна. Улс төрийн томилгооноос болоод сурсан хүмүүс бүгд солигдсон. Ажлын байрны халаа сэлээ тогтвортой биш байдлыг үүсгэж байна.
6	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн	

	орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	
7	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Хамтарсан багт ажиллаж байхад камер байхгүй, бензин шатахууны зардал байхгүй, хамгаалах байр байхгүй байхад бүр их тулгамдсан асуудал байж байсан.
8	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Явуулын үйлчилгээ-тухайн баг сум, багийн засаг даргын удирдлагаар төсөв хөрөнгө гаргуулж явдаг. 4-р багийн орон гэргүй ээж төрөөд ах дүү нар дээр нь аваачихад унаа хэрэгтэй болсон. Ээж нь орон гэргүй байсан. Төрөхөд 7-8 хоноход засаг дарга руу нь эмнэлгээс гаргаж авахыг шаардаж яриад, багаас тухайн эмэгтэйг хамаатнууд дээр аваачаад өгөхөд эргээд хүүхэд нь өвдөөд гээд эмнэлэгт хүргүүлсэн.
9	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Шатахуун хангах хэрэгцээ шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн байрлал, цаг хугацаатай холбож санхүүжилт өгөх ёстой. Хууль, журам их гардаг ч хэрэгжилт муу байдаг. Хэрэгжилтийг хангах механизм, уялдаа холбоонд анхаарах хэрэгтэй. Багийн нийгмийн ажилтан ГБХЗХГ-ын харъяа байвал зүгээр. Хариуцлага тооцох механизм сул
ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	ХИС-аас хамтарсан багт арга зүйн зөвлөгөө өгч байна. Хууль байхгүй болохоор орохгүй байна Холбон зуучлах үйлчилгээ-үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авч орон гэртэй болгох, архины хамааралтай үйлчилгээтэй холбож ажил хийж байсан. Хорооны нийгмийн ажилтан их солигдож байгаа учраас хамтарсан багийн чадамж сул Аймгийн ГБХЗХГ- мэргэжилтнүүдийн чадамж сайн, нөхөн сэргээх үйлчилгээн дээр ажиллаж байна.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ?	Амьдрал дээр зөрчилдөж байна. Кейс нээгдээд 1 жил болоход нөхцөл хэвээрээ байна. Хүүхэд өөрөө анхан шатны чадварт сайн суралцсан ч хүүхдийн амьдрах гэр бүлийн орчин хэвээр байна.

3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ?	Кейс менежер- нийгмийн ажилтан, ЗД, ГБХЗХГ-ын мэргэжилтэн, сургуулийн нийгмий ажилтан
4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?... ..	Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэл 1 -3 сарын хугацаа Бие махбодын хүчирхийлэл- 3 сар болоход хангалттай Сэтгэл санааны дарамтанд мөн ижил 3 сар Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 1 жил, түүнээс илүү байж болох байх. Хамгаалах ажил, эрүүл мэнд, сэтгэл засал 1 жил болох байх
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Хамгийн багадаа 20 минут- бага насны хүүхэд бол 9 дээш насны хүүхэд бол 30 минут 18 хүртэл насны хүүхэд бол 45 минут тус тус уулзах хэрэгтэй. Хамгийн багадаа 7 удаа уулзана гэж бодож байна.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Алслагдсан сумд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хүрэх үйлчилгээ байх ёстой. Алслагдсан газар явуулын үйлчилгээ маш хэрэгтэй.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Ахуйн хэрэглээний- нөхөн сэргээх үйлчилгээнд захиран зарцуулах ёстой- дотуур хувцас, цайны зардал, тайван сууж ярилцах орчин зэрэг санхүүжилт хэрэгтэй.

8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Боловсон- мэргэжсэн боловсон Санхүүжилт- үйлчилгээний санхүүжилт- хоолны зардал, уулзалт Мэргэжлийн зөвлөгөө өгөх- сэтгэл зүйч, дэмжлэг өгөх мэргэшсэн хүн дутмаг байна.
9	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	Байхгүй
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	Бүгдийг хийж байсан. Сүүлийн хоёр жил ковидын улмаас жаахан сул байна.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Хүүхдийн оролцоог идэвхжүүлэх хэрэгтэй. Хүүхэд хүүхдэдээ итгэдэг. Охидын бүлгэм, хөвгүүдийн бүлгэм байвал их зүгээр. Багаас нь чадавхижуулах чухал. Сургууль түшиглэсэн хүүхэд хамгааллын хөтөлбөр, нөлөөллийн ажил: эрүүл мэндийн хөтөлбөр
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	ЯХИС, ГБХЗХГ, Аймгийн хүүхдийн зөвлөл, хамтарсан багууд, аймгийн цагдаагийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөх 10 хүн байна.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	Томоохон нөлөөллийн ажил дээр Ажлын таван өдөр хэрэгтэй.
	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр	Талбайн зөвшөөрөл, дуу өсгөгч, дэм дэмэндээ

5	хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	явна. Ер нь иймэрхүү зардлыг орон нутгаас үнэгүй гаргаж өгч байх хэрэгтэй.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	10 оноо өгнө
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	Хүүхэд хамгааллын чиглэлээр ямар нэг соён гэгээрүүлэх ажил хийх гэж байгаа тохиолдолд нутгийн захиргааны ордон, бусад төхөөрөмж үнэ төлбөргүй хэрэглэгдэнэ гэж оруулах ёстой.
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Мэргэжлийн мэргэшсэн хүмүүсийг улс төрийн томилгооноос ангид байлгах Төрийн албаны хүний бүтээмжийг зөв үнэлэх-санал санаачлагатай- үр дүнгийн үнэлгээг сайн хийхэд анхаарах хэрэгтэй.
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	ГБХЗХГ-ын харъяа нийгмийн ажилтнууд байвал зүгээр, арга зүйн зөвлөгөөг өгдөг байвал зүгээр. Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг ч хариуцлага, сургах тогтолцоо уялдаагүй.
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	Бүртгэл мэдээлэл, кейс файльтай танилцана. Үйлчилгээ хүртсэн хүний сэтгэл ханамж, үйлчилгээ авсан хүний амьдралд гарсан эерэг өөрчлөлт үзэх ёстой.

		Хамтарсан багт гарч буй эерэг дүнг харах хэрэгтэй
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ	Хөндлөнгийн үнэлгээ хийхэд хамтарсан баг хариуцсан мэргэжилтэн, Засаг дарга, үйлчилгээ авсан үйлчлүүлэгч нарыг оролцуулна.
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ	Сайн мэдэхгүй
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ	Хөндлөнгийн, олон улсын байгууллагаар үнэлгээг хийлгэвэл бодитой гарна. Мэргэжлийн байгууллага, өөрөө өөрийгөө үнэлж чадахгүй, хөндлөнгийн үнэлгээ сайн гаргаж чадна. Үнэлгээний дараах хариу хэмжээг хэрэгжүүлэх, хянах, эргэн мэдээлэх , эргэх холбоог сайжруулах талаар тусгах

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

.....Байхгүй байна

.....
.....
.....
.....

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймаг Архангай
Сум: Цэцэрлэг хот
Ярилцагчийн нэр:
Ярилцагчийн албан тушаал:

Огноо: 2021. 08.05
Эхэлсэн цаг: 15.15
Дууссан цаг: 16.30

Эрдэнэбулган сумын 4 багийн 3Д С.Жавхлан
Хөдөлмөр эрхлэлт, халамжийн багийн мэргэжилтэн М. Эрдэнэ-Оюун

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр:...Эрдэнэбулган сумын 4-р багийн 3Д-ын албан

Зөвлөх/судлаачийн нэр: А. Батхишиг, Т. Цэндсүрэн

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг Хамгийн багадаа 1 цаг дотор амжина, 24 цаг дотор үйлчилгээ үзүүлнэ. Хүчирхийлэлд өртсөн дотор 1 цагийн дотор гэрт нь очно. Кейс 3 шатнаас хамаарна.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ? Танай хамтарсан баг 1 сарын дотор хоёр кейс-нэг гэр бүлийн хүчирхийлэл, нөгөө нь эгч дүү хоёрын маргаан. Манай баг зорилтот баг, архидалт- сумын дайны хүн ам ихтэй. Хамгийн багаар бодоход хоёр хоноод нэг дуудлага ирнэ.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ? Нэг тохиолдолд 2-3 хүн оролцоно. Нийгмийн ажилтан, цагдаа, багийн дарга оролцоно. НА- нь НБҮ хийнэ, цагдаа аюулгүй зэргийн үнэлгээ хийнэ. НА, цагдаа их солигдоно. Багийн дарга зөвлөнө.
4	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын Шуурхай тусламжийн үед түргэн, цагдаагийн дуудлага зэрэг очно. Дуудлага янз бүрийн шугамаар ирдэг.

	дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ	
5	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү?	Дуудлага ирнэ. Газар дээр нь очно. Хамгийн түрүүнд НА нь хүлээн авах анкетаа бөглөнө. Эрүүл мэндийн тусламж, цагдаагийн тусламжийн дараа НБҮ хийнэ. Амьдралд дээр эхлээд яаралтай эмнэлгийн тусламжаа үзүүлсний дараа НБҮ хийсний дараа хамтарсан багийн хурал дээр бөглөнө. Бичлэг, зургаа аваад гараад ирнэ.
6	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	Ямар тохиолдолд түр хамгаалах байранд Хүчирхийлэл, архидалт, бэлгийн хүчирхийлэл зэрэгт түр хамгаалах байранд байрлуулна. Бичиг баримтын асуудал гардаг. Тэнэмэл эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлд өртсний хамгаалах байр авсангүй. Тэр айлын гишүүн биш учир коридорт хоносон.
7	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Нөхцөл байдлын үнэлгээ – тухайн нөхцөл байдал Гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ- гэр бүлийн нөхцөл байдал Аюулгүйн зэргийн үнэлгээ Гар утсаараа бичлэг, дуу хураана. Бөглөх зүйл, гутал, гар утсаа цэнэглэх ёстой. Хүнд мэдэгдэхгүй энгэрийн камер хэрэгтэй. Бодит үнэн ярихгүй тохиолдол гардаг. Заримдаа цагдаа олдохгүй.
8	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Явуулын үйлчилгээ шуурхай тусламж үзүүлэх тохиолдол гардаг. Хөдөө орон нутагт их байдаг. Хөл гар хугарсан,
9	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Гэр бүлийн хүчирхийлэлд байгаа хүүхдийн асран хамгаалагч тогтоолгох явдал их байдаг. Хамтарсан багийн дарга, шүүхийн шийдвэрээр асран хамгаалагч тогтоолгоход их цаг хугацаа тогтооодог. Өрхийн тэргүүнд хамаг юм яваад байдаг. Баривчласан ч хүчирхийлэгчийн асран халамжлагчийн эрхийг түр түдгэлзүүлэх эрхийг ГБХЗХГ, хамтарсан баг түр хугацаагаар эрхийг түдгэлзүүлэх эрх олгох хэрэгтэй байна.

ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ? Хүчирхийлэл хүчирхийлэлд өртсөн, эргэн хэвийн амьдралд оруулахыг тулд сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх, гэр бүлийн эерэг уур амьсгалын бий болгоход анхаарна. ХБ-ийн төлөвлөгөө боловсруулаад Сэтгэл зүйн зөвлөгөөг ГБХЗХГ, тайвшруулах- эмч эмнэлэгт хэвтүүлэхэд эмч анхаарах хэрэгтэй.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ? Хэвийн байдалд оруулахад туслах сэтгэл зүйн зөвлөгч байхгүй байна. Бэлгийн хүчирхийлэлтэй хүүхдийг шар хадаг хэвтүүлэхэд бараг дарамт болно. Багийн дарга, нийгмийн ажилтан нарт сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвартай болгох хэрэгтэй. Мэргэжлийн бус хүмүүс их гардаг. Мэргэжлийн хүнийг л ажиллах хэрэгтэй. Багийн нийгмийн ажлын янз бүрийн Эрдэнэбулганд сумын асран хамгаалагчийн талаар бол мэднэ.
3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ? Хамтарсан багийн 7 гишүүн, Ээж охин гэвэл 9 хүн оролцоно. Салбар луу хандсан үйлчилгээ бол салбарын мэргэжилтнүүд орж ирнэ.
4	Дараах хүчирхийллийн хэлбэрт өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?... Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд бол кейс нээхээс хаах хүртэл асуудал шийдэгдэхгүй бол ОУ-ын хүүхэд хүчирхийлэл 2 жил өртсөн бол 1 жил ноцолдох ёстой, 5 жил болсон үед 5 жил Асралт гэр бүл хийж байсан. 5 -6 жил хүүхэдтэй ажиллаж хэвийн Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй бол хүнд кейс 1 жил болно. Сэтгэл санааны дарамтанд хүүхдийн хувьд 1.6 сар эсхүл 2 жил орно. Сэтгэл санааг илээршуулахад 2 жил орно. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд 2017 онд өртсөн. Тэр хүүхдийг кейсийг хааж чадахгүй л байна. Завдал нилээн гардаг. Үйлдэл 3 гарсан. Нэг тохиолдлыг хоёр жил явсан. Эргэж буцаад 2 жил шийдсэн.

5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Доод тал нь нэг удаа. 3-4 удаа уулзана. Уулзах хугацаа нь 1 их байдаггүй. Аав ээжтэй уулзах бол 4-5 цаг болно.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Нэг удаа ногоот баг явж байсан. Өглөө яваад шөнө очиж байсан. Цагдаатай явсан учир хуулийн зөвлөгөө, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн өртсөн ээж охин хоёрыг хамаатан саданд авчирч өгсөн. Төлөвлөгөөний дагуу ажиллана. 14-30 хоногийн баривчилгаа
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Хэдэн үнэлгээний хуудас, гар утас, машин Айл гэрт нөхцөл байдлын үнэлгээ хийхэд тоног төхөөрөмж хэрэггүй. Бензин тос, хоол унд, памперсийн зардал хэрэгтэй. Хамтарсан багийн гишүүдийг хамгаалах асуудал их анхаарах хэрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэй нас барахад тэр асуудлаа нуухын тулд тэнсэн ял авсан, байнга заналхийлж байдаг. Хамтарсан багийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Багийн дарга хэлсэн гэж цагдаа нар хэлдэг байсан. Хүүхэд хамгааллын ажилтнууд, хамтарсан багийн аюулгүй байдлыг хангах, заналхийллээс хамгаалах хэрэгтэй талаар хуульд оруулах хэрэгтэй.
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	
9	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	Хүүхэд хамгааллын ажилтнууд, хамтарсан багийн аюулгүй байдлыг хангах, заналхийллээс хамгаалах хэрэгтэй талаар хуульд оруулах хэрэгтэй.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ? Ганцаарчилсан зөвлөгөө их хэрэгтэй байдаг. Жилдээ 3 удаагийн хөтөлбөр, арга хэмжээ хийдэг. Багийн хувьд айл өрх бүрт хууль тараасан. Хогийн зар, эмч, багийн даргатай холбогдох гарын авлагын даргаа манайд маш олон кейс илэрсэн. Архинд донтсон иргэдэд сургалт хийж байсан. Эмнэлэгтэй хамтраад архины хор уршиг, дондолтоос хамтарч хийдэг. Цагдаа, ОУ-ын төлөвлөгөөнд хамруулж хийнэ.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ? Нийгмийн ажилтан, багийн дарга хийдэг.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ? 7 хоног хийсэн. Ажлын 7 өдөр хийсэн.
5	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Урьдчилан сэргийлэхэд комьютер принтер ашиглана. Тараах материал, шторк хийх хэрэгтэй болно. Хувцасны захиалах гээд чадаагүй. Хүүхдийн тоглоом, хувцас
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ? Салбар хоорондын уялдаа холбоо их хэрэгтэй. Сургуулийн захирал, боловсролын газрын дарга, халамжийн хэлтсийн дарга нар өөр ажил гэж боддог. Тэдний ажлын нэг хэсэг гэж гэж ойлгуулах хэрэгтэй. Удирдах ажилтнуудад сургалт семинар хэрэгтэй. Хол явахад томилолт хэрэгтэй. Дуудлагаар хэдэн төгрөг аваарай гээд 10,000 төгрөгийн хэдэн сар болоод авна. 2,000 такси унаад явахад дараагийн шат шатны

		арга хэмжээнд нэргүй зардал хийх гардаг Утасны зардал өгөхгүй.
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	Хүүхдээ бахархан дуурайх аав ээж байа гэж аян зарлаж байсан. Захидал бичиж байсан. Эцэг эх төрийн албан хаагчдад танилцуулж байсан.
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт, өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	Иргэдийн мэдээлэл их муу байна. Мэдээллийн хэрэгслийг хууль сурталчлахад оруулах Сургууль, цэцэрлэг, сургал мэдээллийг ажлыг их хэрэгтэй. Боловсон хүчин их дулимаг байна.
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Хүнд асуудал болоход ХБ-гийн гишүүд өөрөө өөрийгөө л болгоно. Хоорондоо үзэж тарсан болохоор буруу хараад гарна. Жайка- төслөөр хоорондоо харилцах, эвлэрүүлэх арга хэмжээ сургалт зохион байгуулсан.
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	Үр дүнг харна. Үйлчлүүлэгчийн асуудал сайн шийдэгдсэн сайн гэж үзнэ. Улсын хэмжээнд хамтарсан багийн шалгаруулалттай харьцуулахад манайх болчих л байсан юм байна.
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ	

3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ	
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ	Жилд нэг удаа хамтарсан багийг шалгаруулах үнэлгээ хийх хэрэгтэй. Гишүүд 4 жилд 1 удаа Сумын хамтарсан баг нь Эрдэнэбулган сумын багийн хамтарсан багаас сул, мэргэжлийн бус, үндсэн ажил дээр хамтарсан хариуцуулдаг. Аймгийн төвийн сумд орон тооны нийгмийн ажилтан байхгүй, давхар ажил хийлгэж байна.

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

Нэг гэр бүлийг л өөрчилж чадсан. Шалтгаан нь салбар хоорондын уялдаа холбоо хангаж чадсан учраас хийсэн. Халамжийн асуудлыг халамжаар гаргуулсан. Цагдаагийн газар, ГБХЗХГ нь асуудлаа бүрэн дүүрэн хийх ёстой.

Төлөвлөгөө боловсруулаад арга барилд сургасан. Асуудлыг бүрэн шийдэхэд бүрэн дэмжлэг санхүү мөнгө байхгүй байна.

Халамжийн тэтгэмж тэтгэвэр нэмэгдсэн. Хуулийн цоорхой ашиглаад эхнэртэй явж байгаад өөрсдөө жүжиглээд улсаас мөнгө авдаг. Үүнийг зохицуулах хэрэгтэй.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2021 оны 8 сарын 5

Эхэлсэн цаг: 17.20

Аймаг: Архангай

Сум: Эрдэнэбулган сум

Ярилцагчийн нэр: Ганболдын Оюуннаран

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: ГБХЗХГ

Ярилцагчийн албан тушаал: Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, сэтгэл судлаач сэтгэл судлалын багш, 2007 оноос эхлэн ажиллаж байна.

Зөвлөх/судлаачийн нэр: А.Батхишиг, Т.Цэндсүрэн

Дууссан цаг: 18.40

ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллага, хэлтэс, тасаг, хамтарсан баг хүүхэд хүчирхийлэлд өртсөн гэдэг мэдээлэл аваад хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ хир хугацаанд үзүүлдэг вэ? 24, 48, 72 цаг	24 цагийн дотор үйлчилгээ үзүүлдэг.ажлын өдрөөр 3 өдөр. Амралтын өдөр дуудлага ирвэл шаардлагатай бол очно.
2	Танай баг, тасаг, хэлтэс, газар нэг сарын хугацаанд хэдэн хүүхдийн ямар тохиолдлуудад шуурхай тусламжийн үйлчилгээ (дуудлага мэдээлэл хүлээн авах, эрсдлийн үнэлгээ хийх, түр хамгаалах байранд байрлуулах, гэртээ үлдсэн тохиолдолд аюулгүй төлөвлөгөө хийх, эмнэлэг, цагдаа гэх мэт бусад яаралтай тусламжтай холбох зэрэг) үзүүлдэг вэ?	Сүүлийн 1 сарын хугацаанд 5 гэр бүлийн 8 хүүхдийн асуудал дээр ажиллаж байна: хүүхдийн мөнгөтэй холбоотой асуудлууд, эцэг эхийн үүргээ биелүүлэхгүй, архидалттай холбоотой асуудлууд дээр ажиллаж байна.
3	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог вэ? Ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ?	Хүүхэдтэй холбоотой асуудал орж ирэхэд сэтгэл зүйч оролцоно, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, цагдаа, өмгөөллийн байгууллагаас, боловсрол, халамжийн байгууллагаас мэргэжилтэн оролцдог. Голдуу сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн 2 ажилладаг. Бид бас боловсролын нийгмийн ажилтнуудаа их түшиж хамтран ажилладаг.
4	Шуурхай тусламжийн үйлчилгээний үед нэг тохиолдолд танай байгууллага, хэлтэс, тасаг, бусад байгууллага (хамтарсан баг, гэрээт байгууллага гэх мэт)-ын дундажаар хэдэн хүн оролцдог	Хүүхэдтэй холбоотой асуудал дээр хүүхэд хамгааллын болон хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн голдуу оролцож ажилладаг.

	вэ? Ямар ямар албан тушаалын ажилтан, албан хаагч оролцдог вэ?	
5	Шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг дараалал, үйл явцыг нэг бүрчлэн бичнэ үү?	Утсаар мэдээлэл ирэхэд хамтарсан багтаа зөвлөмж өгөөд өөрсдөө очдог. Дуудлага мэдээллийг хүлээн авна, мэдээллийг батлагдсан маягтын дагуу бүртгэн авна, хүүхдийн амь нас хорисон охиолдолд цагдаагийн байгууллагад, эмнэлэгт мэдээлнэ. Хүүхэдтэй үйлчилгээний дарааллын дагуу ажилладаг.
6	Түр хамгаалах байр байдаг уу. Хэдэн орон тоотой, ямар үйлчилгээ үзүүлдэг, харуул хамгаалалтаа хэрхэн шийдсэн бэ?	Хамгаалах байранд байрлуулах хүүхдийг ХНХЯ-ны сайдын журмыг баримталдаг. Хүүхдийг түр хамгаалах байранд эмчийн дүгнэлт онош чухал байдаг юм байна лээ. Хүүхдийн суурь өвчлөл, халдварт өвчний асуудал байна.
7	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ? Ер нь ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл хэрэгтэй байдаг вэ?	Зургийн аппарат, дуу хураагуур ашигладаг. Зөөврийн ком, хэвлэх машин шаардлагатай.
8	Орон нутагт дуудлагын мөрөөр явуулын шуурхай тусламжийн үйлчилгээг хүргэдэг үү. Явуулын үйлчилгээ хүргэх шаардлага гардаг уу. Жишээ гарган тайлбарлана уу	Жилдээ 3-4 удаа онгой тохиолдолд шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлдэг. Сэтгэл зүйч хамт очиж үйлчилгээ үзүүлдэг.
9	Шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд зайлшгүй тусгах ёстой заалт байна уу. Яагаад ийм заалт оруулах ёстой гэж бодож байна вэ?	Очоод яаралтай авах арга хэмжээний талаар хуулинд оруулах хэрэгтэй. Суманд хамгаалах байр ганцхан Чулуут суманд байдаг, үүнтэй холбоотой хуулинд түр хамгаалах байр гэхээсээ өрөө байдаг бол хэрэгтэй л юм байна лээ.
ХАМГААЛАХ БА НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ		
1	Танай байгууллагад хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь оруулах нөхөн сэргээх ямар үйлчилгээ үзүүлдэг вэ?	Сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг Үжин төвийн үйлчилгээнд хамруулсан.
2	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эргэн хэвийн амьдралд нь оруулахад туслах ямар үйлчилгээг зайлшгүй хуульд тусгах шаардлагатай вэ?	Сэтгэл зүйч хүүхдэд сэтгэл зүйн даалгавар өгч ажиллуулдаг. Цахимаар хүүхэд, эцэг эхтэй ажилладаг. Зуных нь амралтаар хүүхдэддээ сэтгэл зүйч дээр очин зөвлөгөө авах санал тавьдаг.
3	Нэг тохиолдол (нэг кейс) д хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн хүн оролцдог вэ?	Хамгааллын болон хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гэр бүлийн мэргэжилтэн, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байрны мэргэжилтэн 7 хүн оролцоно.
	Дараах хүчирхийллийн хэлбэрт	Үл хайхрах-1 жил

4	өртсөн нэг хүүхэдтэй кейс нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ • Үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ? • Сэтгэл санааны дарамтад өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ ? • Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн кейсийг нээхээс хаах хүртэл хир хугацаа зарцуулдаг вэ?... ..	Бие махбодийн хүчирхийлэл- 2-3 сар Сэтгэл санааны хүчирхийлэл- :2. Сар, 2 жил хүртэл ажиллах тохиолдол байна Бэлгийн хүчирхийлэл- хамгийн багадаа 1-2 жил, шүүхээр шийдвэрлүүлэх хугацаа энэ тэр нөлөөлнө. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах байрнаас гаргасан тохиолдол гарсаан. Ээжид нь туслуулах зорилгоор гаргасан. 7-12 сар хүртэл байсан, түр хамгаалах байранд.
5	Хүүхэдтэй, эсхүл түүний гэр бүлийн гишүүдтэй хийх нэг удаагийн уулзалтыг 30 минут гэж үзвэл кейс нээхээс хаах хүртэл тухайн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй нийт хэдэн удаа уулздаг вэ.	Кейс дээр ажиллахад 1 хүүхэдтэй 7 хогогт 2-3 удаа уулздаг.
6	Алслагдсан сум, багийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хэрхэн хүрч хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг?	Энэ тохиолдол ховор. Хамтарсан багдаа арга зүйн дэмжлэг үзүүлдэг. Жилд нэг удаа сумдаа тойроод үйлчилгээ үзүүлдэг.
7	Хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног, төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Дуу хураагуур ашигладаг. Оношлуур тест байхгүй.
8	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?	Хүний нөөцийн мэргэшсэн байдал чухал байна, хүний нөөцийн тогтвортой байдал чухал байна.
9	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээтэй холбоотой ямар заалтыг хуульд зайлшгүй тусгах шаардлагатай вэ. Яагаад заавал хуулиар зохицуулах гэж бодож байна вэ?	Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний төрлүүдийг оруулах. Өмгөөлөгч ажиллуулах зардлыг оруулж өгөх хэрэгтэй. Хүүхэд хамгааллын хууль шинэчилсэн найруулгаар батлагдахад нэмэлт чадвар шаардагдана. Улсын байцаагч, мэргэжилтэн өөрөө үйлчилгээ үзүүлдэг байхад чиглүүлж

		хууль өөрчлөгдөхөд энэ ажлыг хийж чаднаа.
	УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	
1	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дахин өртөх, хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ямар хөтөлбөр, нөлөөллийн ажлыг танай байгууллага хэрэгжүүлдэг вэ?	Эцэг эх, гэр бүлийн асран хамгаалагчид нөлөөллийн сургалт зохион байгуулна. Нөлөөллийн ажлын давтамж долоо хоног бүр хийдэг байсан одоо цаг үеийн байдлаас шалтгаалан хийхгүй байна. Цахимаар сая зарим нэг ажлуудыг хийсэн ч үр дүн ямар байгааг мэдэхгүй байна.
2	Хүүхэд хамгааллын өөр ямар чиглэлийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ, орхигдсон урьдчилан сэргийлэх чиглэл байна уу	Улсын бүртгэлийн газартай гэрээ хийгээд 6 модуль сургалтанд хамруулаад гэр бүл бологчдыг андгай өргүүлээд гэр бүлийг баталж байсан, энэ нь залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр байсан.
3	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулахаас хэрэгжүүлж дуусах хүртэл танай байгууллага, хэлтэс, тасгаас хэдэн ажилтан, албан хаагч оролцдог вэ?	4 мэргэжилтэн оролцсон.
4	Нэг урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулахаас эхлээд хэрэгжүүлж дуусгах хүртэл хэдэн ажлын өдөр зарцуулдаг вэ?	1 жил болсон, жилийн ажлын 10 хувийг л эзэлж байна.
5	Урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар тоног төхөөрөмж, хэрэгсэл, материал ашигладаг вэ?	Цахим орчинд зөвлөмжүүд гаргаж байна. сурталчилгааны самбаруудад мэдээлэл байршуулдаг. Бүх сумдад мэдээлэл байршуулсан нь 108-ын дуудлага ихэссэн. Гарын авлага ашиглаж байна.
6	Зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарах вэ?	Үйлчлүүлэгчтэй цахимаар холбогдоход л төвөгтэй (үйлчлүүлэгч болгон ухаалаг утасгүй) байдаг.
	Хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд илрүүлэх, эрт үнэлгээ хийх явуулын аян хийж байсан уу? Хэрэв тийм бол ийм аян хэр ач холбогдолтой вэ? 0-10 хооронд үнэлнэ үү.	Хүүхдийн асуудлуудад ховч байа аян өрнүүлэхээр бэлтгэл ажлаа хийж байна. 1 хэрэглэгдэхүүнийг 50 000 хийлгээд байгууллагуудад өгөх, байршуулахаар төлөвлөж байна.
7	Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Хүүхэд хамгааллын хуульд ямар заалт,	Хүүхэд хамгааллын хуулинд хамтарсан багтаа холбоотой асуудлууд их тусгасан байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны асуудлууд орсон байдаг. Цаашид хуулинд хүний нөөцийг

	өөрчлөлт оруулах хэрэгтэй вэ?	тогтвортой ажиллуулах асуудлыг тусгаж өгмөөр байна.
АЖИЛЛАХ ХҮЧ-МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА		
1	Салбарын хүний нөөц- ажиллах хүчний тогтвортой байдал, мэргэжлийн өсөлт хөгжилтийг хангах чиглэлээр хуульд хэрхэн тусгах хэрэгтэй гэж бодож байна вэ	Сэтгэл санаа тавьгүй үед дэмжлэг хэрэгтэй үедээ хамтран ажилладаг хүмүүсээсээ дэмжлэг туслалцаа авч хоорондоо л ярьдаг. Албан ёсоор дэмжлэг үзүүлдэг тогтолцоо манайд байхгүй.
2	Танай байгууллагад үйлчлүүлэгчтэй тул ажилладаг ажилтныг мэргэжлийн удирдлагаар хэрхэн хангадаг вэ	Дарга энэ чиглэлийн дэмждэг туслалцаа үзүүлдэггүй.
3	Хүүхэд хамгааллын салбарт мэргэжлийн удирдлагыг (professional supervision_захиргааны, зөвлөн туслах, дэмжих) хөгжүүлэх талаар хууль хэрхэн тусгах вэ	Хуулинд энэ асуудлыг тусгаж байгаа нь сайшаалтай байна, дэмжиж байна.
ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ		
1	Хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар ямар үзүүлэлтээр үнэлдэг вэ?	
2	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хянаж, үнэлэхэд танай байгууллага, бусад оролцогч талуудаас хэн хэн хэрхэн оролцдог вэ	
3	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтыг хэрхэн хянаж үнэлдэг вэ?	
4	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хяналт үнэлгээний талаар хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатай вэ?	

Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилттэй холбоотой, хуульд зайлшгүй өөрчлөх ёстой зүйл, заалтын талаарх нэмэлт мэдээлэл

.....
.....
.....
.....
.....

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2021 оны 8 сарын 5, 2021 оны 8 сарын 6-ны өдрүүд

Эхэлсэн цаг: 9.00

Аймаг: Архангай аймаг

Сум: Эрдэнэбулган сум

Ярилцагчийн нэр: Уранцэцэг

Ярилцагчийн ажилладаг байгууллагын нэр: ГБХЗХГ

Ярилцагчийн албан тушаал: ГБХЗХГ-ын дарга

Зөвлөх/судлаачийн нэр: А.Батхишиг, Т.Цэндсүрэн, Оюунболд

Дууссан цаг: 9.30, 13.00

Бид Хүүхэд хамгааллын зураглал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэлттэй холбоотой газар дээр нь танилцаж, нөхцөл байдлыг судлан, дүн шинжилгээ хийх зорилгоор танай аймагт ажиллаж байна. Хүүхэд хамгааллын хууль тогтоомжын дагуу шинэчилсэн найруулга хийх гэж байна. Одоо байгаа нөхцөл байдалтай холбоотой шинэчлэл хийхэд шаардлагатай мэдээлэл чухал байна.

Хүүхэд хамгааллын асуудлыг асуудалд төвлөрөх биш, тогтолцооны хүрээнд харж байна. Хуулийн дагуу ажиллахад хүний нөөцийн асуудлыг тодорхой тавьж өгөөгүй асуудал өмнөх хуулинд байгааг анхаарч шинэчилсэн найруулгатаа анхаарч тусгаарай. Архангай аймгийн хэмжээнд 34000 хүүхэдтэй, ГБХЗХГ хүүхдийн асуудал хариуцсан 3 мэргэжилтэнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Хөгжил, оролцоо, хамгаалал гэсэн байдлаар хуваагдаж ажиллаж байна. Төрийн албанаас ирсэн албан тушаалын нэршлийн дагуу энэ байдлаар хуваагдаад ажиллаж байна. Хөгжлийн асуудал хариуцсан хүн нь урьдчилан сэргийлэх үйлчилгээгээ давхар үзүүлээд явж байна.

Суманд анхан шатанд хүүхдийн асуудал хариуцсан хүн байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр боловсруулахад хүүхэд гэр бүлтэй ажиллах мэргэжилтэн ажиллуулъя гэхээр нийгмийн хөгжлийн мэргэжилтэн хариуцаж ажиллах л болдог (төрийн албаны зөвлөлийн тодорхойлсон). Зорилтот хүүхэд, гэр бүлтэй ажиллана гээд ажлын байрны тодорхойлолтонд орсон байна. Гэтэл энэ хүн нь бидний хүсээд байгаа мэргэжлийн үйлчилгээний хүрээнд асуудлыг харах боломжгүй байдаг.

Үйлчилгээний хувьд салбарын хүүхэд хамгааллын асуудлыг оруулсан боловч манай газрын хүлээх үүрэг, авах арга хэмжээ нь тодорхойгүй байна. Тухайбал иргэнээс мэдээлэл авч байж эмнэлэгт хүүхдийн эрх зөрчигдөөд ирсэн тухай мэдээлэл авч байна. Манай байгууллагаас байгууллагуудад очиж мэдээлэл, сургалт хийж байна. Хүүхдийн эрхийн асуудлаар мэдээллийг нууцлаад, эсвэл тохиролцоод мөнгөөр асуудлыг шийдээд байгаа тохиолдлыг яаж шийдвэрлэх тухай Хүүхэд хамгааллын тухай хуулинд байхгүй байна.

ГБХЗХГ-аас ирж байгаа төсвийн төлөвлөлт нь орон нутагт хүүхэд, залуучууд, гэр бүл 3 нэгжээр ирж байна. Хүүхэд хамгааллын зардлыг яагаад залуучуудад зараад байна гэдэг асуудал гардаг. Сум дүүргийн түвшинд хамтарсан баг байхад аймгийн түвшинд байхгүй байна. Засаг даргын тамгын газрын дарга хамтарсан багийн дарга хийдэг байтал аймгийн гэдэг үгийг нь аваад сум, дүүргийн гэж оруулсан нь буруу байна. Манай аймгийн хувьд хамтарсан багийг дэмжих зөвлөлийн даргаар нь аймгийн ЗДТГ-ын даргыг оруулж ажиллаж байна.

Дэмжих баг нь арга зүйн дэмжлэг үзүүлдэг, мэргэжлийн баг байх ёстой. Одоо бол ахлах зөвлөх нь ахлаад ажиллаж байна.

Кейс шийдвэрлэлт ямар байна?, цаг хугацаандаа асуудлыг шийдвэрлэж байна уу?, үйл ажиллагаа тогтмолжсон уу?, гэсэн ГБХЗХГ-аас гаргасан удирдамжын дагуу үнэлдэг. Манай байгууллага хамтарсан багаа арга зүйгээр хангаж ажиллаж байна. Байгууллагын хүрээнд аян өрнүүлж ажиллаж байна. Хүүхдийн элч нарыг идэвхижүүлж ажиллуулж байна.

Түр хамгаалах байр шинээр бий байгуулсан. Уур амьсгалыг өөрлөх чиглэлээр ажилладаг Францын байгууллагад төсөл өгч, эко 160 000 000 төгрөгийн өртөгтэй байшин бариулаад үйл ажиллагааг нь бид хариуцан ажиллах болсон. Аймгийн засаг даргад хүсэлт тавиад үйлчилгээнд шаардлагатай 20 000 000 төгрөгний төсвийг тавиулан шийдвэрлүүлсэн. Дарга нарт хуулийн заалтын дагуу тайлбарлаад үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг хүсэхэд аймгийн хэмжээнд шийдвэрлээд л өгдөг. Өөрөөр хэлбэл бид нөлөөллөө сайн хийвэл хамтраад хүүхдийн асуудлаа шийдвэрлэж чадаж байна.

Үйлчилгээ, үйл ажиллагааг тусад нь ялгаж өгмөөр байна. Үүнийг хуулинд тодорхой оруулах хэрэгтэй байна.

ГБХЗХГ нь 6 нийгмийн ажилтан, 3 сэтгэл зүйч, 2 эрх зүйч ажиллаж байна. Байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал чухал байдаг, хүний нөөцийн бодлогын хувьд мэргэшсэн, хүүхэд хамгааллын асуудлаар нарийвчлан бэлтгэгдсэн байдаг. Мэргэжилтнүүдээ чадваржуулахад онцгой анхаардаг. Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулахын тулд мэргэжилтнүүдээ мэргэжлийн ажил үйлчилгээ явуулахыг дэмждэг, мэргэжлийн нарийвчилсан төлөвлөгөөтэй байхыг шаарддаг.

Нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах тогтолцооны хувьд 3 нэгжүүд дотроо ахлах мэргэжилтэнтэй, тэдний хувьд арга зүйгээр хангаж ажиллах ёстой байдаг.

Цахим уулзалтын хэлэлцүүлгийн тэмдэглэл

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 1

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 5 өдрийн 10 цагаас 12 цагийн хооронд болов.

Цахим хэлэлцүүлэгт ГБХЗХГ-ын ГБХХХГ-ын дарга Н. Өлзийхутаг, ГБХЗХГ-ын ГБХХХГ-ын ахлах мэргэжилтэн Ж. Азжаргал, Хүүхдийн тусламжийн утас 108 төвийн захирал О. Лхагвасүрэн, Түр хамгаалах байхны зохицуулагч Э. Батбаяр, Нийслэлийн ГБХЗХГ-ын дарга Ө. Ган-Өлзий, Нийслэлийн ГБХЗХГ-ын ахлах мэргэжилтэн Ариунгэрэл нар

Зөвлөх А. Батхишиг, Бүжинлхам, Оюунболд, Х. Өлзийтунгалаг, ХНХЯ-ын Газрын дарга Н. Баярмаа, зөвлөх С. Болорцэцэг нар оролцлоо.

Уулзалтын эхэнд зөвлөх А. Батхишиг- хэлэлцүүлгийн зорилгыг танилцуулж Хүүхэд хамгааллын зураглалын төслийн танилцуулав. Танилцуулгын дараа оролцогчидтой хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар танилцуулав.

А. Батхишиг: Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийг хэдий хугацаанд хийдэг вэ, 24, 48, 72 цагуудын хувьд хир боломжтой хугацаа вэ.

Ж. Азжаргал:

- 72 цагийн дотор эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээг хийх журам байдаг. Зарим алслагдсан газар орон нутагт энэ цаг дотор хийх боломжгүй байдаг.
- Үйлчилгээний хувьд ингэж шуурхай тусламж, үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилсан сэргийлэх үйлчилгээ гэж хуваах нь зүйтэй.
- Явуулын үйлчилгээг Хөөрхөн зүрх ТББ-аар дамжуулж хийлгэсэн- урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил хийх явцдаа мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг илрүүлж байсан.
- Цагдаагийн байгууллагын тээврийн хэрэгслийг ашиглах журамд өөрчлөлт оруулж Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн 108 -ийн утасны нэг машиныг дуут дохиотой ашиглах боломжтой болсон.
- Цагдаагийн байгууллагаас- цагдаа нар 7 хүртэлх хүүхдийн аюулын зэргийн үнэлгээг хийхгүй шууд илтгэх хуудсаар орлуулах шийдвэр гарган одоо мөрдөж байна. Гэхдээ энэ нь хүүхэд хамгааллын байгууллагын хувьд цаашид ашиглах нотлох баримт болж чадахгүй, баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй гэж үзэх эрсдэлтэй байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээг хуульчлах
- Жишиг зардлыг зохицуулалт хийх хийх хэрэгтэй байна.
- Түр хамгаалах байранд нэг дор янз бүрийн насны, янз бүрийн асуудалтай хүүхэд цуг орж байгаа учраас бие биенээ муу нөлөө үзүүлж байна. Ойролцоо насны, асуудал ижил хүүхдүүдээр нь тусгаарлах хэрэгтэй байна.
- Орон нутгийн түр хамгаалах байрны боловсон хүчин хангалтгүй
- Улсын хэмжээнд 19 түр хамгаалах байрны зардлыг хүүхэд хамгааллын зардлаас гаргаж байна.
- Нийгмийн ажлын үйлчилгээг мэргэжлийн хүн хийх хэрэгтэй.

- Кейс менежментийг сайн хийхэд мэдлэг туршлага хэрэгтэй.
- Мэргэжлийн удирдлагын талаар бас салбарын удирдах хүмүүс зөв ойлголттой болох хэрэгтэй.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад Хүүхэд хамгааллын асуудлыг анхаарах талаар тусгах хэрэгтэй байна.

А. Батхишиг- За манай оролцогчид цагаа хуваагаад хүн бүр ярихыг бодоорой.

Н. Өлзийхутаг- Би сая уулзалттай байж байгаад Батхишиг багшийн яриаг гүйцэд сонссонгүй. Гэхдээ хуульд оруулах өөрчлөлттэй холбоотой дараах саналыг хэлье.

- Хамтарсан багийн чиг үүргийг хангахтай холбоотой анхан шатанд ГБХЗХГ-ийн харъяа нийгмийн ажилтан байлгах хэрэгтэй байна. Бид энэ талаар Гэр бүлийн тухай хуулийн өөрчлөлтөнд саналаа тусгасан. Энэ хуульд мөн тусгах хэрэгтэй байх.
- Нийгмийн ажлын мэдээллийн системийг ашиглах боломжтой болгох
- Хамтарсан багийн ажиллах журам шинэчлэх
- Кейс менежер тодорхой нэг кейсийг хариуцдаг болгох хэрэгтэй байна.
- Боловсон хүчин тогтворгүй учраас Агентлагийн мэргэжилтэн байнга сургах, кейсээ яаж нээхээс эхлээд дуустал нь заах хэрэгтэй болдог.
- Кейс менежмент дээр эрх зүйн зөвлөгөө тусламж хэрэгтэй болдог.

А. Батхишиг: Кейс менежер гэдэг анхан шатанд нэг кейсийг эхнээс нь кейс хаатал хариуцдаг хүнийг хэлнэ тээ.

Н. Өлзийхутаг: Тийм. Гэхдээ нийгмийн ажилтан, анхан шатанд ажиллаж буй хүмүүс тогтворгүй болохоор манай ажилтнууд дахин сургах хэрэгтэй болдог.

А. Батхишиг- Мэргэжлийн хүмүүсийн тогтвортой ажиллуулахын тулд мэргэжлийн өсөж дэвших, мэргэжлийн зэрэг цолын дагуу ажиллах замнал нь тодорхой байх хэрэгтэй болов уу. Бусад оронд нийгмийн ажилтны бакалавр анхан шатанд, дүүрэг хотын түвшинд ажиллах хүн магистр байх, мөн төв байгууллагуудад үйлчилгээ, асуудлын талаар зөвлөн туслах доктор ажиллах жишээтэй.

Н. Өлзийтунгалаг: Тийм. Хүүхэд хамгааллын салбарт нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүл судлаач зэрэг хүмүүж ажиллана гэдэг ч юм уу мэргэжлээр нь тодорхой заах хэрэгтэй болов уу.

Ө. Ган-Өлзий: Салбарын хамтын ажиллагаа үүрэгжүүлэх, ялангуяа эрүүл мэнд, цагдаагийн байгууллагын ажилтнуудыг үүрэгжүүлэх хэрэгтэй.

- Түрүүн тэр слайд дээр бичсэн бага насны хүүхэд гэдэг шиг бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусламж дээр эрүүл мэндийн тусламж хэрхэн үзүүлэх гэдэг нь маш тодорхой байх
- Хүүхдийн эрхийн байцаагчийн орон тоог нэмэх
- Цахим бүртгэлийн системийн боловсруулалт, хөгжүүлэлт, ашиглалт дээр санхүүжилт байх хэрэгтэй. Мэдээллийн системийг боловсронгуй болгох их чухал Үндэсний, аймгийн, нийслэл, дүүрэг, хорооны түвшинд юу хийх вэ гэдгийг үүрэгжүүлэх- Тохиолдол бүрийн бүртгэлийг цахимжуулах тухай хуульд тусгах.

Оюунболд: Хүүхэд хамгааллын тухай хуульд эрх үүргүүдийг нэмж болно. Гол асуудал нь үйлчилгээг хүргэж чадах уу. Дэд бүтэц нь байна уу гэдэг асуудал тулгарч байна. Эдгээр олон үйлчилгээг энэ байгууллагууд хүргэж чадах уу.

Азжаргал: Мэргэжлийн ТББ-ыг магадлан итгэмжилэгдсэн байгууллагууд үйлчилгээг хүргэх боломжтой.

Мөн салбаруудын хүүхэд хамгааллын үүрэг оролцоог тодорхой зааж өгч, хэрэгжүүлэх боломжтой байх. Тухайлбал эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын чиглэлээр эрх зүйн зохицуулалтаа хийгээгүй байна.

Оюунболд- Урьдчилан сэргийлэх ажлыг – Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулиар зохицуулах боломжтой.

О. Лхагвасүрэн: Шуурхай дуудлагын баг хүүхэд зөөвөрлөх багт хэдэн зөвлөх явах ёстой гэх мэт зүйлийг тодорхой заах хэрэгтэй болов уу

А. Батхишиг- Хүүхэд хамгааллын үйлчилгээний стандарт бас зэрэг боловсруулж байгаа түүнд шуурхай тусламжийг хэрхэн хүргэх талаар оруулж өгч болох байх гэж бодож байна.

Азжаргал: Архивын нэгж үүсгэх тухай оруулах, хэдэн жил хүүхдийг хувийн хэргийг хадгалах вэ, кодлох- архивын нэгжийг кодлох тухай оруулах хэрэгтэй.

Оюунболд: нэг томъёолол бичээд түүнийгээ ийм агуулгатай гэдгийг сайн тэмдэглээд ард нь ямар захиргааны хэм хэмжээ, актаар зохицуулах вэ гэдгээ тэмдэглээд протокол дурдуулах нь зүйтэй.

- Архивын хуульд оруулахдаа судалгааны нэгжтэй болгох, хэдэн жил болгоод хадгалах вэ, салбарын хувьд судлах нэгжтэй байж, архивын мэдээлэлд дүн шинжилгээ хийх гэсэн зүйл орох хэрэгтэй болно.

А. Батхишиг- ГБХЗХГ-ын дэргэд Сургалт, судалгааны хэлтэс нэгж байдаг. Энд судалгаа шинжилгээ хийх боломж байж болох юм.

Бүжинлхам: ТББ-г яаж санхүүжүүлж байна вэ. Нэг хүүхдэд үйлчилгээ хүргэх үйлчилгээний тариф байдаг уу

Азжаргал: Тарифийн хувилбар байдаг. Гэхдээ албажаагүй.

- ТББ-уудын чадавхи сул байна. ТББ-ыг сайн сургах хэрэгтэй байна. Тендэрийн шалгаруулалтыг давах ТББ-ууд ховор байна. Нөгөө талаас ТББ-ууд нь тариф санхүүжилтыг голоод материалаа тендэрт өгөхгүй тохиолдолд байна.
- ТББ-ийн бүртгэлийг сайн хийж, хохирогчийг хохироосон бол дахин санхүүжилт өгөхгүй гэж бүртгэх, дахин гэрээлэхгүй байх гэсэн заалтууд байвал зүгээр.

А. Батхишиг-Мэргэжлийн үйлчилгээг ёс зүйтэй хүргэх талаар тусгах хэрэгтэй гэж бодлоо.

Оюунболд: Хүүхэд хамгааллын үйлчилгээг нэг бүлэг болгож болно. Гэхдээ эрх зүйн зохицуулалт хийхэд, түүний хэрхэн ойлгох нь хандлагаас хамаарна. Тиймээс сургалт хэрэгтэй.

Ган-Өлзий: Босоо удирдлагатай байх их чухал. Одоо жишээ нь Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25.5.5-д хүн амд үзүүлэх үйлчилгээ дотор манай зарим үйлчилгээ орсон байна.

Оюунболд: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд урьдчилан сэргийлэх ажлын оруулах боломжтой- хүүхдийн зан үйлийг өөрчлөх гээд. Учир нь энэ хууль бол мөнгөтэй хууль.

- Гэмт хэрэг, зөрчлийн торгуулын орлогын 40-өөс дээш хувийг энэ хуулийн хэрэгжилтийг хангахад зарцуулах ёстой.
- Үзэл санаагаа бичээд- хэрэгжүүлэлтийг тусгах
- Мэдээллийн системийг цахимжуулах гэдэг чухал.
- Сая Ковидын үед цаасан дээр явагддаг ажил үндсэндээ зогссон. Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргийг шүүх ажил зогссон. Хүн амины хэрэг 10 хувь өссөн.
- Уул нь мэдээлэл тоотыг явуулах гарын үсгийг цахимжуулах
- Цахим мэдээлэл солилцох, зөвшөөрлийг цахимаар өгөх хэрэгтэй болж байна.
- Та бүхний тоо баримт, мэдээлэл их хэрэгтэй. Бид энэ хуулийн төслийг тоо баримт, судалгаагаар л хамгаална. Тиймээс хуульд юуг өөрчлөх хэрэгтэйгээ тодорхой бидэнд хэлнэ үү.

Азжаргал жилд дундажаар 5600-7850 кейс нээж ажиллаж байна.

А. Батхишиг: Та бүхэн энэ ярилцлагын дараа хуультай холбоотой зүйлийг санавал бидний емейл хаяг руу мэдээллээ явуулаарай.

Цаг гарган уулзсан та бүхэнд баярлалаа.

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 2

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 5 өдрийн 14 цагаас 16 цагийн хооронд болов.

Цахим хэлэлцүүлэгт 108 төвийн захирал О. Лхагвасүрэн, 108 дуудлагын утасны ээлжийн ахлах нийгмийн ажилтан С. Солонго, ээлжийн ахлах нийгмийн ажилтан Б. Азжаргал, зөвлөх нийгмийн ажилтан С. Эгэлзаяа, ахлах сэтгэл зүйч Э. Булганчимэг, Нийслэлийг ГБХЗХГ-ын хамгаалал шаардлагатай хүүхэд хариуцсан ажилтан Ц. Энхцэцэг, хүүхдийн эрхийн байцаагч Б. Батчимэг нар,

Зөвлөх А. Батхишиг, Бүжинлхам, Х. Өлзийтунгалаг, С. Болорцэцэг нар оролцлоо.

Зөвлөх А. Батхишиг- цахим хэлэлцүүлгийг зорилгыг танилцуулж зорилгыг танилцуулж хүүхэд хамгааллын зураглалыг төслийг танилцууллаа.

Дараа нь оролцогчдоос шуурхай тусламж үйлчилгээний талаарх тэдний ажлын дэс дараалалтай танилцлаа.

Азжаргал, Солонго нар хамтдаа хариулав:

- 108 дуудлага мэдээлэл ирэхэд зөвлөх нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын дуудлага бол цагдаад мэдээлж харъяа дүүрэг, хорооны эргүүлийн цагдаа цагдаа газар дээр очиж аюулын зэргийн үнэлгээ хийнэ. Аюулын зэргийн үнэлгээний 90 гаруй хувь нь түр хамгаалах байранд хүүхдийг байрлуулах шаардлагатай гэсэн үнэлгээ өгдөг.
- Эргүүлийн цагдаа, цагдаагийн албан хаагч 1-рт хүүхэд гэмтэл бэртэлтэй бол, мөн Ковидын үед эцэг эх асран хамгаалагч нь харах чадваргүй болсон үед 103 эмнэлгийн дуудлага руу утасдаж хүүхдийг үзлэг шинжилгээнд оруулна. 2-рт 7 наснаас доош хүүхдийн хувьд илтгэх хуудас бичнэ, 3-рт 7 наснаас дээш хүүхдэд аюулын зэргийн үнэлгээ хийнэ. Аюулын зэргийн үнэлгээ нь 11 асуулттай бөгөөд эхний 3 асуултад тийм гэж хариулбал шууд аюултай гэж үзэж хүүхэд хамгааллын байгууллагад буюу 108-д мэдэгдэнэ.
- 108 утасны шуурхай дуудлагыннхан цагдаагийн хэлтэс, хэсэг, хорооны хэсгийн байцаагч дээрээ хүүхдийг авна.
- Ковидын цар тахлын улмаас 108 утасны түр хамгаалах байр ажиллахгүй УБ хотод ЧД, БГД, ХУД, СБД-ийн түр хамгаалах байруудад хүүхдийг түр байрлуулан хамгаалж байна.
- ЧД-ийн түр хамгаалах байр арай том боломжтой учраас тэнд түр хамгаалах байранд байрлуулах бүх хүүхдийг 1-2 хоног PCR шинжилгээний хариу гартал байрлуулж, хариуг нь гарахаар БГД, ХУД, СБД-ийн түр хамгаалах байруудад шилжүүлнэ.
- Хүүхдийг тэнд байрлаж байхад Дүүргийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн 3-5 хоногт НБҮ хийж харж хандах хүнгүй бол асрамж халамжийн төвүүд рүү шилжүүлнэ.

А. Батхишиг: Би зөв ойлгосон бол цагдаа хүүхдийг түр хамгаалах байранд аваачих уу үгүй юу гэдгийг шийддэг гэсэн үг үү.

Аззаяа & Солонго:

- Ер нь бол тийм. Гэхдээ зөвлөх өөрийн мэдрэмжээрээ хэрвээ хүүхэд, эмэгтэй хүн уйлж айсан шинжтэй бол дүүргийг ГБХЗХХ-ын мэргэжилтнүүдийг очиж НБҮ-хийхийг хүсдэг.
- Цагдаагийн албан хаагчийн мэдлэг, хандлага их чухал. Зарим цагдаагийн албан хаагч аюулын түвшинг үнэлэх явцдаа 108 дуудлагын утаснаас мэдээллээ гэж хэлээд тэр хүмүүс нь манай руу утас хэн дуудсан гэж хэлүүлэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл хүүхэд хамгааллын нууцлалыг хадгалж чадахгүй байх тохиолдол гардаг.
- Гэр бүлийн маргаан гэж гэмт хэргийн зөрчилгүй гэж мэдээлбэл хүүхэд эрсдэлтэй нөхцөлд байна гэж үзэхгүй тохиолдол гарах эрсдэлтэй.
- Зөвлөгчийн үнэлгээнээс үндэслээд дүүрэг рүү шилжүүлдэг.
- Эх нялхасын эрүүл мэндийн төвд нийгмийн ажилтан ажилладаг, тэндээс тбэлгийн хүчирхийлэл байж болзошгүй гэж
- Гэмтэл согогийн эмнэлгээс бие махбодын хүчирхийлэл байж болзошгүй гэж дуудлага ирдэг.
- Ховор тохиолдолд өрхийн эмч дуудлага өгнө. Гэхдээ тэд ихэнхдээ ажлын ачаалал их, мэдлэг хомс учраас хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага өгдөггүй.
- Үл хайхрах явдлын үед хамаатан, иргэдээс дуудлага ирдэг.
- Хорооны нийгмийн ажилтан- хүүхдийг түр хамгаалах байранд байрлуулах хэрэгтэй бол манай руу (108)-руу дуудлага өгдөг.
- Сард 7500 гаруй хяналтын дуудлага ирдэг. Холбон зуучлах шаардлагатай дуудлага ирнэ.
- Шугамын дуудлага- гэдэг нь нийт ирсэн дуудлага, үүнээс хүүхэд хамгааллын чиглэлээр хянах ёстой дуудлагыг хяналтын дуудлага гэнэ. Хяналтын дуудлага дотор 108-ийн зөвлөх нийгмийн ажилтан очиж
- Үүний 70-80 нь шуурхай дуудлагаар түр хамгаалах байранд авчирсан хүүхэд байдаг.

А. Батхишиг: Нэг кейс-тохиолдлыг түр хамгаалах байранд авчрахад хэдэн хүн оролцдог вэ?

- Зөвлөх дуудлага аваад ахлахад хэлнэ. Ахлах зөвлөгч, жолоочийг дуудлагад томилно. Шаардлагатай тохиолдолд ахлах НА, зөвлөх НА- хоёр цуг явна. Учир нэг машинаар хэд хэдэн хүүхдийг авчрах тохиолдол байдаг. 108-аас 4-5 хүн оролцоно.Түр хамгаалах байранд 4 ээлжийн нийгмийн ажилтан, зохицуулагч, тогооч, дүүргийн хоёр мэргэжилтэн гээд нийт 8-9 хүнд түр хамгаалах байранд байгаа хүүхдэд үйлчилнэ. Дүүргийн ГБХЗХХ-ийн 2 мэргэжилтэн, Цагдаагийн 2 албан хаагч. Хамтарсан багийн 5 гишүүн гээд нийт 20 гаруй хүн оролцдог байна.

А. Батхишиг: Нийслэлийн түвшинд ажилладаг кейстэй ажиллахад хэдэн хүүхэд оролцдог вэ

Энхцэцэг: Нийслэлийн ГБХЗХГ-ээс дүүргүүдэд арга зүйн зөвлөгөө өгнө

- Асран хамгаалагчгүй хүүхдийг дүүргүүд шилжүүлнэ
- Эсхүл холбон зуучилдаг.
- Хараа хяналтгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөдөлмөр эрхлэдэг хүүхдэд чиглэсэн илрүүлэлт, үйлчилгээг зэрэг үзүүлнэ.
- Газар дээр нь илрүүлэлт хийнэ. Тэндээсээ эрүүл мэнд, боловсрол, бичиг баримттай болгох туслалцааг үзүүлнэ.

А. Батхишиг- Үрчлэгдсэн хүүхдийн хамгаалал яадаг вэ

Энхцэцэг: нийгмийн бодлогын хэлтэс хариуцдаг.

А. Батхишиг- танай байгууллага хэлтэс жилд хэдэн хүүхдийн тохиолдолд дээр ажилладаг вэ

Энхцэцэг- 11 мэргэжилтэн байдаг. Тус тусдаа кейс дээр ажиллана. Би 8-10 кейс дээр ажиллана.

А. Батхишиг- Нэг кейсийг дуусгахад хэдийн хэмжээний хугацаа зарцуулдаг вэ

Энхцэцэг- 1 сар орчим болно.

А. Батхишиг- Нэг кейс дээр хэдэн хүн ажилладаг вэ

Энхцэцэг-

- Манай байгууллагаас 4 мэргэжилтэн Хүүхдийн эрхийн байцаагч, хамгааллын мэргэжилтэн, хөгжил, оролцооны мэргэжилтэн, гэр бүл хөгжлийн хэлтсийн ажилтан
- Дүүргээс хоёр мэргэжилтэн нийт 6 мэргэжилтэн, Нэг мэргэжилтний ард 2 гэвэл бараг л 10 гаруй мэргэжилтэн оролцоно.

А. Батхишиг: Шуурхай тусламж, хамгаалах нөхөн сэргийлэх үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж юу байдаг вэ

Азжаргал Солонго- 108 утасны ахлах нийгмийн ажилтнууд:

- 9 дүүргийн дунд нэг машин байдаг, энэ нь хүртээмжгүй.
- Шуурхай тусламжийн ажилтан, зөвлөх-п энгэрийн видео камер их хэрэгтэй.
 - Нөхцөл байдлыг тодруулах, баримтжуулахад хэрэгтэй.
 - Дуу хураагуур мөн хэрэгтэй. Хүүхдийн хэлсэн ярьсан зүйлийг орхигдуулахгүй бичихэд хэрэгтэй.

Азжаргал, Солонго-

- **Хуульд 108 утас ажиллаж болно гэдэг- энэ нь салаа утгатай. 108 хүүхдийн утас ажиллах ёстой гэж оруулах нь зүйтэй.**

108 утасны чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхой хуульчлах-журамлах

АБ- Дуу хураагуурын яриаг хөрвүүлэгч машин нэг байгууллагад байх хэрэгтэй

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 3

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 6 -ны өдрийн 10 цагаас 12 цагийн хооронд болов.

Цахим хэлэлцүүлэгт СБД ГБХЗХХ-н Хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Г. Шүрэнцэцэг, ЧД-ийн ГБХЗХ-ийн эрсдэлт нөхцөл дэх хүүхдийн асуудал мэргэжилтэн Дашням, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын асуудал, шуурхай үйлчилгээ, хороод хариуцсан ахлах мэргэжилтэн Б. Оюун-Эрдэнэ, БГД-ийн хөгжил хамгаалал хариуцсан Г. Юмжирдулам, хүүхдийн утас, хороод хариуцдаг Хүүхдийн эрхийн улсын байцаагч, ахлах мэргэжилтэн Б. Оюун-Эрдэнэ нар

Зөвлөх А. Батхишиг, Бүжинлхам, Х. Өлзийтунгалаг, С. Болорцэцэг, Т. Цэндсүрэннар оролцлоо.

Юмжирдулам & Оюун-эрдэнэ

- 108 дуудлага мэдээлэл орж ирсний цагдаагийн эрсдлийн үнэлгээ, манайхаас гаргаж ирсэн үнэлгээн дээр үндэслэн илтгэх хуудас, аюулын зэргийн үнэлгээг эх хувиар хүүхэдтэй хамт түр хамгаалах байранд аваачна. 103 – дуудлага-Ковидын шинжилгээ хийлгэнэ

А. Батхишиг: Түр хамгаалах байранд ямар үйлчилгээ үзүүлдэг вэ. Түр хамгаалах байранд хир уддаг вэ?

Юмжирдулам & Оюун-Эрдэнэ:

- Хүчирхийллийн хэлбэрээс Бэлгийн хүчирхийлэл бол хүүхдээ шүүхийн шийдвэр гартал түр хамгаалах байранд хоног байлгана. Прокурор – хамгийн хурдандаа 3 сар, хагас жил болтол кейс болно. Хүүхдийн ар гэрт буцаагаад өгвөл хүүхэд нөлөөлөлд автахаас сэргийлж түр хамгаалах байранд байрлуулна.
- Үл хайхрах хүчирхийлэлд- дуудлагаа хамтарсан багт шинжүүлнэ. Хамтарсан баг асуудлыг судална. Архидалт асран хамгаалах асрамж, халамжийн төв рүү шилжүүлнэ.
- 7-10 хоногт асрамжийн төв рүү шилжүүлнэ.
- Хамгийн эцсийн шийдвэр бол асрамжийн халамжинд өгөх.
- Төрөл асрамжинд өгөхийн тулд тухайн гэр бүлийн НБҮ хийнэ.
- НБҮ хийгээд эрсдэлт хүчин зүйлийг судална. Хамгийн гол нь хүүхдийг нь өөрсдөө авах хүсэлтэй эсэхийг үзнэ. Хүүхдийн аваад хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлэх вий гэсэн эрсдлийг тооцоолдог, эрсдлийн хүчин зүйлийг анхаарна. байгаа эсэхийг
- Хамтарсан багийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хөдөө орон нутагт шилжүүлэхэд их анхаардаг. Уралдаанч хүүхэд болгох эрсдэлтэй. Хамтарсан багийн шийдвэрийг үндэслэн шилжүүлнэ. Зарим тохиолдолд 30 хүртэл зарцуулна.

А. Батхишиг: Эцэг эх байх эрхийг шилжүүлдэг үү

Юмжирдулам: Асран хамгаалах эрх нь шилжүүлэх- эрх хүүхдээ авах боломжтой боломжгүйг нь шилжүүлэхгүй 7-30 хоногийн баривчилгаа авч байгаа тохиолдолд хүүхэд хамгаалах эрхийг шилжүүлэхгүй.

Оюунболд – Та бүхний ярьж байгаа зүйлийг сонсохоор гэмт хэргийн шинжтэй зүйл ярьж байна. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний талаар санаагаа илэрхийлбэл зүгээр байна.

Юмжирдулам:

- Архины хамааралтай эцэг эхийн хүүхдийг хамгаалах дахин дахин давтагддаг. Гал унтраах байдлаар явагдаж байна. Хамтарсан байдлаас ар гэрт нь сайн тусалбал, дэмжихэд эргээд сөргөөр нөлөөлнө. Манай дүүрэг дээр байж байгаад өөр дүүрэг рүү шилждэг.
- Хамтарсан багийн ур чадвартай холбоотой, эцэг эхийн хандлагатай холбоотой

Оюунболд: Зөрчлийн хууль, эрүүгийн хуульд дээр өөрчлөлт оруулах боломжтой.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнээс болоод ажиллаж чадахгүй тохиолдолд байна уу Хүүхэд хамгааллын хуулийн ямар зүйл заалтыг өөрчлөх хэрэгтэйгээ хэлэх хэрэгтэй байна.

А. Батхишиг: Хүүхэд хамгааллын үйлчилгээнд гурван түвшинд үзүүлэх талаар оруулахаар төлөвлөж байна.

Дашням: Хамгаалах байранд байхад нь хүүхдэд дараах үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Хөгжлийн үйлчилгээ – 12-14 насны хүүхдийн хувьд хүүхдийн асуудал, дуудлага нас сэтгэхүйн онцлогт тохирсон танин мэдэхүйн болон болон ковидын мэдлэг олгох, амьдрах ухааны ухааны сургалт
- Бага насны хүүхдийг хөгжлийн хоцрогдлоос сэргийлэх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлдэг. Гурван НА- сонгон ажилладаг- танин мэдэхүй, урлаг- сийлбэр хийдэг хүмүүсийг сонгож авдаг. Мэргэжлийн нийгмийн ажилтан- мэргэжлийн бус хүн улс төрийн нөлөөгөөр орж ирнэ. Түр хамгаалах байранд -төрийн үйлчилгээний албанд орж байгаа учраас заавал төрийн албаны шалгалт өгөх албагүй.

А.Батхишиг: Танай дарга, дүүрэг, хэлтсийн дарга нар эрх мэдлийн хүрээнд сонгодог юм байна тээ. Эдгээр үйлчилгээг хэн хүргэж байна вэ.

Дашням: Ер нь хороон дээр ч ялгаагүй. Хорооны нийгмийн ажилтнуудын ихэнх нь мэргэжлийн бус хүмүүс.

- Хорооны хамтарсан баг голлон гэр бүлийн хүчирхийлэл- дээр илүү их ажиллаж байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр мэдлэг сул байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар дийлэнх нь мэдэхгүй учраас кейс нээгээд ажиллаж байгаа хамтарсан баг гэвэл их эргэлзээтэй.
- Манай дүүргийн хувьд кейс хэлтэс дээр төвлөрдөг. Хорооны нийгмийн ажилтан , хамтарсан багууд хүчээр шахуу ажлыг хийдэг. Дүүрэг дээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гээд мэргэжлийн хүмүүс ажилладаг учраас хэлтэс дээр төвлөрч байна. Хороон дээр ажилладаг хүмүүс, хамтарсан багт ордог хүмүүс дүүргийн шийдвэрийг дагах ёстой. Дүүргийн ажлыг засаг даргын ажлыг л давхар хийдэг. Алдарт эхийн одон модон гээд маш их ажилтай. Эрүүл мэндийн ажилтан, цагдаа нарыг сугалж аваад хамтарсан багийн хурлыг хүчээр шахуу ам муруйж байж хийдэг. Тиймэрхүү хүндрэлтэй нөхцөл байдал байгаа.
- Хуулийн дагуу хорооны хамтарсан багийн шийдвэрийн дагуу дүүрэг үйлчилгээ хүргэх ёстой. Гэхдээ тэнд мэргэжлийн биш хүн байдаг, цаг хугацаагаа үндсэн, хүүхдийн асуудалд хандуулж чадахгүй байна.

А. Батхишиг: Мэргэжлийн нийгмийн ажилтан хороо, дүүргийн түвшинд ажиллана гэдэг газар дээрээ өөр байна тээ.

Дашням:

Харин тиймээ дүүргийн судалгаа, одонгийн ажил хүүхдийн асуудлаас дээгүүр тавигддаг

Оюунболд: Харин тиймээ. Энэ яриад байгаа асуудал чинь салбарын онцлог, газартай холбоотой. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан гээд асуудал нь их олон асуудалтай. Өнөөдөр хүүхдийн асуудалтай төвлөрч байна. Энэ асуудлыг тусгаад гарахад та бүхэнд хир их тусах вэ. Хуулиасаа бус зохион байгуулалтаасаа болоод байна гэж харж байна.

А. Батхишиг- Засаг даргын харъяа болохоор илүү олон захиргааны ажил хийж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаас илүү асуудал руу чиглэж байна. Гэр бүлийн асуудал руу анхаараад хүүхдийн асуудлыг орхигдуулж байна. Магадгүй Дашнямын хэлсэнчлэн мэдлэг чадвар дутуу байж болох юм. Энэ талаар та бүхэн дэлгэрүүлж яриач хө.

Шүрэнцэцэг:

- ГБХЗХГ-ийн харъяа нийгмийн ажилтан байх хамгийн чухал. Тэгэхгүй болохоор хороо, сум дээр захиргааны ажлыг илүү их анхаарна. УБ-ын дүүрэг дээр маш их хүнтэй. Энэ нь чанартай хариу үйлчилгээ үзүүлэхэд яалтгүй ч их нөлөөлнө. Дүүргийн хамгааллын мэргэжилтэн өөрөө бүгдийг хийх ёстой. Хариу үйлчилгээ бусад бүх үйлчилгээг хийнэ. Хамтарсан баг өөрөө цогцоор нь явуулах суурь ойлголт чадвар байхгүй. Учир нь манай салбараас сургаад чадавхижуулаад байдаг, гэтэл засаг даргын нөлөөгөөр хорооны нийгмийн ажилтан байнга солигддог.
- Хариу үйлчилгээний хувьд – хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний журам гарлаа ш дээ. Хоног өдрийн хувьсах зардлыг 60680 гээд энэ хүрээнд яваад байж болно. Кейс болгоны үйлчилгээний зардал өөр. Хамтарсан баг кейс дээр гарсан зардал бүрээ бөглөх хүн байхгүй. Нэг кейс дээр ямар зардал гарч байгааг бөглөхгүй байна. Тиймээс энэ зардлыг авахгүй байна.
- Иргэдийн хурлаас кейс үйлчилгээний талаар зардал гаргаж өгөх гэсэн ч нэг кейс дээр ямар зардал гарсан, нийт хичнээн төгрөг гарсан гээд авчраад ир гэхээр барих юмгүй сууж байдаг.

А. Батхишиг: Яагаад барих юмгүй сууж байна гэж бодож байна

Шүрэнцэцэг:

- Анхан шатанд ажиллаж буй нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарын өөрийн утаснаас, машинаас гарсан зардлаа баримтжуулаад авчраад ав гэж гэсэн шаардлага тавьдаг. Гэтэл хамтарсан багийнхан яаж баримтжуулахаа мэдэхгүй байна гэж харсан.
- Зүгээр дүүргүүд дээр болохоор тухайн зардлаа тушаалын дагуу гаргаад байна.

Оюунболд: Та бүхэн гол асуудал руугаа ярих хэрэгтэй байна. Илүү эрүүгийн шинжтэй эсхүл өөр хууль дээр байдаг зүйл яриад байна. Хамтарсан баг өөр хууль дээр байдаг. Хамтарсан багийг энэ хууль руу авчирч болно. Хариу үйлчилгээ яагаад ажиллахгүй байна гэхээр асуудал байдаггүй байхгүй юу.

Юмжирдулам. 10 дугаар зүйл дээр хамтарсан багийн заалт учир дутагдалтай.

Оюунболд: Та нар үйлчилгээ үзүүлэхгүй шүү дээ. Өөр хүмүүс үзүүлнэ шүү дээ. Гол нь тэр дэд бүтцүүд байна уу

Юмжирдулам:

- Хариу үйлчилгээ- 10.1-10-4 хүртэл хийгдээд явж байна.

- 10.5 -д Хууль эрх зүйн хорооны асуудлыг маш нарийн гаргах ёстой. Энэ ерөөсөө ажилладаг. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо ажилладаггүй. Дарга нар байдаг. -тодорхой гаргах ёстой.
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг задлах ёстой. Хэвийн орчин алдагдсан – хучирхийлэлд өртсөн хүүхэд гэж оруулах хэрэгтэй. Хучирхийлэлд өртсөн зүйлийг оруулж хэрэгтэй тодруулах хэрэгтэй. Эрсдэлт нөхцөл гэж юу хэлээд байгаа нь их ерөнхий хэдхэн зүйл байдаг. Хучирхийлэлд өртсөн гэдгийг заавал оруулах ёстой.

Оюунболд- Наадах чинь зохицуулах өөр хууль, Эрүүгийн хуульд байдаг.

Юмжирдулам: Гэхдээ Хүүхэд хамгааллын тухай хууль болохоор энд давхар оруулах ёстой.

Оюунболд: Өөрийгөө хамгаалж чадахгүй хүний тухай ярина ш дээ тээ.

Юмжирдулам- Тийм. Энд давхар оруулах, задлах ёстой.

- Боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал- Хуулинд суурь боловсролын үйлчилгээг тасралтгүй үзүүлнэ гээд заасан. Гэтэл 10- 11 ангийн хүүхдийн боловсролын үйлчилгээнд оруулах гэхээр хүндрэл гардаг.

Оюунболд: Яг ямар хүндрэл гардаг вэ.

Юмжирдулам:

- Суурь боловсролын үйлчилгээ гээд заачихсан. Бүрэн дунд боловсрол эзэмшүүлнэ гэж оруулна *Боловсролын үйлчилгээ тасралтгүй үзүүлнэ гэж оруулах хэрэгтэй.* Сургуулиуд журмуудаа сайн мэддэг болсон. Суурь үйлчилгээ авсан гээд дараагийнх нь бидэн хамаагүй гэж ярьдаг.
- Мэргэжлийн нийгмийн ажилтан үзүүлнэ- Хороон дээр хорооны нийгмийн мэргэжлийн ажилтан байхгүй байна. *Хороон дээр хорооны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүл судлаач ажиллана гэж маш тодорхой заах хэрэгтэй. Нийгмийн ажилтны орон тоон дээр мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллана гэдгийг тодорхой заах хэрэгтэй.*
- Гэр бүлд нь илүү ажиллаж байж хүүхдийн эрсдэл буурна гэж харж байна.
- Тодорхой үйлчлэх хүрээг нь зааж өгч болно. Халамжийн мэргэжилтэн шиг Зее хүнд нэг нийгмийн ажилтан гэдэгтэй адил тоог зааж өгч болно. Мөн хороон дээр хоёр хүн ажиллана нэг нь хүүхдийн эрхийн чиглэлээр, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллана гэж салгуулсан зүгээр байж болох юм.
- Хүүхдийн хууль зүйн хороо гэдэг илүү дээр анхаарах хэрэгтэй

Оюунболд- Хууль зүйн хорооны сургалт дээр ажиллаж байгаа. Үүнийг өөрчилж болно. Харин хамгааллын олон үйлчилгээ байхгүй, та нар өөрсдөө үзүүлж чадахгүй ш дээ. Өөр хүн хийдэг ажил ш дээ.

А. Батхишиг- Оюунболд зөвлөхөө та нар хийж чадахгүй ш дээ гэж болохгүй. Одоо үйлчилгээ дээр суурилж мөнгө санхүүжилт авах гэж ярьж байгаа шүү дээ. Төхиолдол дээр суурилсан санхүүжилт авах гээд яригдаж байна. Үйлчилгээний тарифаа тодорхой болгох хэрэгтэй. Үйлчилгээгээ тодорхой болгох. Үзүүлсэн слайдаа дахин харуулж тайлбарлав.

Дараагийн асуулт гэр бүлийн дэмжихэд хэдийн хугацаа зарцуулдаг вэ

Дашням- Хэлтэс дээр үйлчилсэн архины хамааралтай 5 хүүхэдтэй гэр бүлтэй ажилласан жишээг ярья. Хугацааны хувьд хагас жилээс 8 сар зарцуулсан. Зан төлөвийг өөрчлөхөд 8 сар зарцуулсан. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс гадна нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, залуучуудын хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн 2-р хэлтсээс гэр бүлийн байцаагч ажилласан. 6 сарын төлөвлөгөө гаргасан Асуудал нь 8 жил архи уусан, таван хүүхэд нь байнгын 108 дуудлагатай гэр бүл байсан. Асуудал нь эцэ эхийг яаж архинаас гаргах вэ хүүхдүүдийн асуудлыг хичээлийн хоцрогдлыг арилгах, эрүүл мэндийн асуудалд чиглэсэн төлөвлөгөө хийсэн. Хамтарсан багийг оруулаагүй. Учир нь хороон дээрээ 8 жил амьдраад өөрчлөлт ороогүй. Тиймээс хэлтэс дээр ажиллах баг ажилласан.

А. Батхишиг- Слайд дээр ороогүй үйлчилгээ байна уу.

Дашням- Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг оруулж болох уу. Бид хороон дээр удаан байсан учраас хороон дээр байдаг хүний нөлөөллөөс гаргах зохицуулалтыг хийсэн. 3 сар орчны нөлөөллийг арилгах- БЗД-тай хамт амьдраад дүүрэг дээр оруулсан

ДЗ ОУБ-ын хөдөлмөр эрхлэх боломжийг нь олгосон- ээжийг нь маникюурийн тоног төхөөрөмжийг, будаг шунхийг нь олгож олгож өгсөн. Архины эмчилгээ, хүүхдийн сургалтыг ДЗМОУБ-ыг ашигласан.

А. Батхишиг- ДЗМОУБ байхгүй хорооны нийгмийн ажилтан юу хийж болох вэ
Төрийн байгууллага- мөнгө байхгүй- төрийн санхүүгээр босгох-
Кейс цаг хугацаандаа хөрөнгө босгох ажил их хэрэгтэй.

Дашням: Хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хэрэгтэй.

- Хувийн ажлын зохион байгуулалттай байх хэрэгтэй.
- Ерөнхий нэршлээр оруулах хэрэгтэй.
- Хамтарч ажиллах боломж их байдаг ч бид өөрсдөө хуулийн мэдлэг дутуу байдаг.
- Ерөнхий утгаар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ерөнхий утгаар оруулах- бусад байгууллагатай хамтрах бүрэн байдаг.
- Өөрөө сайн судлах хэрэгтэй болдог. Өмнөх хүнээс, удирдлагаас ямар нэг тусламж, дэмжлэг, мэдээлэл авах боломжгүй байдаг.

А. Батхишиг- Үйлчилгээтэй холбоотой ямар бэрхшээл тулгарч байна вэ?

БГД-ийн Юмжирдулам- Санал хэлье

- 4.1.7. р зүйл дээр хүүхийн эрхийн ажилтан гэж хүүхдийн эрхийн улсын байцаагч л ажиллахаар томилсон. Манай дээр хүүхдийн эрхийн улсын байцаагч хоёр л байдаг. Хуулиараа бид хүүхдийн эрхийн чиглэлээр ямар ч эрхгүй болоод байна. **Хуулийн заалтаар хүүхдийн эрхийн ажилтан, хүүхийн эрхийн байцаагч гэж тусад нь оруулах хэрэгтэй.**
- 4.1.7- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн боловсролыг тасалдуулахгүй байх гэж оруулбал зүгээр
- Таны слайд дээр халамжийн үйлчилгээ гэж байсан. Босоо удирдлагатай байгууллага. Халамжийн үйлчилгээ- Халамжийн бүх үйлчилгээ журмаараа зохицуулдаг. Ээж ааваар нь яваад байгаа. Архи уудаг хүмүүсийг зогсоох- Хүнсний толанд- ордог-
- Халамжийг – хүүхэд хамгаалалтай холбоход хүндрэлтэй байдаг.
- Шаардлагатай тохиолдолд- ГБХЗХГ-ын санал дээр үндэслээд халамж- хүүхэд хамгааллын холбох хэрэгтэй.
- Хүүхэд хохирсон тохиолдолд

А. Батхишиг- Халамжийг хамгаалалтай холбох тухай ярилцана.

Юмжирдулам: Хууль дээр асуудал эрхэлсэн байгууллага- санал хүргүүлэх, албан бичиг барих- гэсэн зүйлүүдийг оруулах,

А. Батхишиг- Ингэж зохицуулах боломжтой юу?

Оюунболд:

Хүүхдийн байгууллагын саналыг үндэслэх гэдэг нэмэх, *Халамжийн хуульд тусгах зэргээр. Хатуу зааж өгч болохгүй. Гэхдээ хүүхдийн нөхцөл байдлын тухайн ГБХЗХГ-ыг санал дээр үндэслэн шийднэ гэж оруулж болно.*

Юмжирдулам

- Асрамжийн төв рүү хүүхэд очсон мөртлөө хүүхэд нь авахгүй- хүүхдийн дансанд оруулах гэдэг хуульд байхгүй. Асрамжийн төвд хүүхдийн
- Эцэг байх эрхийг хасуулах тухай тодорхой заалт оруулах. Архидан согтуурах эцэг эрхийг хязгаарлах- Хөл гарыг хугартал Зодож шийтгэсэн эцэг эхийн эрхийг хасуулах боломж нөхцөл байдаг эсэхийг хүүхдийг эрхийг түр хязгаарлах тухай оруулах боломжтой.

Оюунболд:

Хүүхэд эцэг эхтэйгээ байх эрхтэй. Хүний эцэг эх байх эхийг хязгаарлах нь суурь эрхтэй холбоотой. Энэ нь Гэр бүлийн хууль дээр байдаг. Эмзэг асуудал. Хэдийд сэргэж болох вэ гэдгийг

Оюунболд: Хүүхэд хамгааллын асуудал, ажилтан ажилтнууд эрх хүч сул. Боловсон хүчний асуудал.

- Хүүхэд хамгааллын байгууллагын өөрийн асуудал- цалин мөнгө бага, босоо тогтолцоогүй байгаа зүйл байна.
- Хуулиар биш зохион байгуулалтаар шийдэх асуудал байна.

Юмжирдулам:

- Санхүүжилтын илүү доторхой болгох хэрэгтэй. Хүүхэд хамгааллын нэг кейс дээр хэдэн төгрөг байх ёстой.
- Үл хайхрах хүчирхийлэл дээр өртсөн зардал өөр өөрөөр бичих

Бүжинлхам:

Оюутболд:

Хүүхэд хамгааллын жишиг зардлыг бичих Нэг кейс менежментийн зардлын жишиг хэмжээ байна. Жишиг- зардлыг хэн хийх вэ гэж журмаар батална. Ийм зардлын жишиг зардал. Хууль дээр эрх олгож, эрх шилжүүлэх ажлыг журмаар хэрэгжүүлнэ.

А. Батхишиг: Урьдчилан сэргийлэх хөтөлбөр гэж тавихаар төлөвлөж байна. Орон нутгийн асуудалдаа тохирсон хөтөлбөр байна. Танай дээр ямар ямар хөтөлбөр байдаг вэ. Урьдчилсан сэргийлэх ажлыг хийж амждаг уу.

Оюунболд: Нийгэмд сөрөг үзэгдлийг арилгах нь ХЗДХЯ-ны үүрэг, тусламж дэмжлэгийг ХНХЯ үзүүлнэ. Нэг яамны үүргийг нөгөөх нь хулгайлж болохгүй.

А. Батхишиг: Урьдчилан сэргийлэх зардлыг

Юмжирдулам:

- Илрүүлэлт- хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг арга хэмжээнүүд Тодорхой үйл ажиллагаа явагддаг. Зардал төсөл тухайн тушаалын дагуу хийгддэг
- Дүүрэг, нийслэлийн ажлууд байгаа

А. Батхишиг: Урьдчилсан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулдаг уу. Үүнийг хийх боломжтой юу.

Дашням

- Урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд байдаг Үл хайхрах хүчирхийлэл 50-70 хувь эзэлдэг. Энэ үл хайхрах хүчирхийлэл нь архитай хамааралтай гээд архины хамааралтай айл өрхөөс
- Архины хамааралтай 10 өрхийг архинаас гаргах хөтөлбөр боловсруулаад хэрэгжүүлээд явж байна.

Юмжирдулам

- Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлаас урьдчилан сэргийлэх дээр хэдэн хувь, шуурхай тусламж хэдэн хувь, нөхөн сэргээх дээр хэдэн хувь гэж зааж өгөх ёстой. Энэ нь ил тод байх ёстой.
- Нэг кейс дээр хэдэн хэдэн төгрөг хэрэгтэй- тушаал гаргуулдаг
- Дүүргийн хэмжээнд урьдчилан сэргийлэх хариуцах мэргэжилтэн тусдаа байдаг. Тэр мэргэжилтэн маань хүүхэдтэй холбоотой бүх сэргийллийн ажлыг хариуцдаг, бусад хүмүс нь хамгааллын чиглэлээр ажилладаг.

А. Батхишиг- Хамгийн сүүлийн хэлэх, асуух зүйл байна уу. Өөр санаа оноо байвал санал емейл хаягаар явууллаа.

Идэвхтэй оролцсонд баярлалаа.

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 4

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 6 -ны өдрийн 14 цагаас 16 цагийн хооронд болов.

Цахим хэлэлцүүлэгт ЧД-ийн Нэг цэгийн үйлчилгээний нийгмийн ажилтан Н. Ивгээлт, СХД-ийн 15 хорооны нийгмийн ажилтан Ц.Чимэдбалдир, БЗД-ийн нэг цэгийн үйлчилгээний зохицуулагч Т. Ариунтуяа, БГД-ийн Түр хамгаалах байрны нийгмийн ажилтан Ц. Булган, Чингэлтэй дүүргийн 13-р хорооны нийгмийн ажилтан Энх-Амгалан нар

Зөвлөх А. Батхишиг, Бүжинлхам, Х. Өлзийтунгалаг, С. Болорцэцэг, Т. Цэндсүрэн нар оролцлоо.

Чимэдбалдир:

Хамтарсан багтай холбоотой асуудлуудаас эхэлж ярья.

- Нэг цэг дээр суудаг. Хороо дээр банкны ажилтан шиг шилэн хоргоны цаана суудаг. Нэг цэгийн үйлчилгээ- дээр ажиллахад үйлчлүүлэгчтэй тулж ажиллах ямар ч нөхцөлгүй.
- Төрөл бүрийн захиргааны ажил хийдэг 60-70 хувь – захиргааны ажил хийдэг.
- Нийгмийн ажилтан тусдаа өрөөтэй байх хэрэгтэй. Нийгмийн ажилтнууд мэргэжлийн, мэргэшсэн байх ёстой.
- Хороон дээр хамтарсан баг ажиллах боломжгүй. Санхүү мөнгөний асуудал хэцүү. Ямар ч санхүүжилт байхгүй.
- Тусдаа өрөөтэй бол хамтарсан баг нь үйлчилгээ үзүүлэх боломжтой болно.

Үйлчилгээний талаар яривал:

- Тусдаа өрөөтэй нийгмийн ажилтан хамтарсан багийг үйлчлэх гээд боломжтой байна. 43 хорооны 33 хорооны нийгмийн ажилтнууд нэг цэгийн ард суугаад үйлчилгээ үзүүлж байна. Тусдаа өрөөтэй хороо бараг л байхгүй.
- Нөхөн сэргээх үйлчилгээ- Үйлчлүүлэгчээ хөтлөөд тал тал тийшээ явдаг- Нийгмийн ажилтан зөвлөгөө өгөх чадвартай байх ёстой.
- Нийгмийн ажлын бакалавртай. Мэргэжлийн биш нийгмийн ажилтан дийлэнх нь
- 5-10 жил ажилласан нийгмийн ажилтан 4-6 л байгаа.
- СХД-ийн ГБХЗХХ-ийн мэргэжилтнүүд байнга солигддог хүн байхгүй учраас удаан жил ажилламан мань мэт тэдэнд зөвлөж тусалдаг.
- Хуулинд өөрчлөлт оруулж босоо удирдлагатай болох ёстой.
- Халамжийн ажилтнууд- орж ирсэн хүний материалыг аваад буцаагаад программд шивээд суудаг.
- Халамжийн үйлчилгээг- хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбох боломжтой.
- Хэрэв тийм бол халамжийн журамд өөрчлөлт оруулах шаардлагатай.

Ариунтуяа: БЗД-ийн нэг цэгийн үйлчилгээний зохицуулагч хийдэг.

- ЦЕГ-ийн хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллаж байгаад- хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 жил ажилласан. БЗД-т Хүүхийн албаны хэлтэст 10 жил ажилласан.
- Нэг цэгийн үйлчилгээний төвийн явцаас харахад байнга сайжруулж, засах, сэтгэж бодох, хамтрах ажил, хүний төлөө хийх ёстой ажил байна. Нэг цэгийн үйлчилгээ эмнэлэгт, цагдаа, төрийн бус байгууллага.
- БЗД-ийн төв нь цагдаагийн газар түшиглэсэн, орон нутгаас санхүүжилт авдаг.

- Манай нэг цэгийн үйлчилгээгээ 2019 онд 62 гэр бүлийн 103 хүн, 2020 онд 74 гэр бүлийн 166 хүн үйлчилгээ авсан. 2021 оны эхний 6 сарын байдлаар 28 гэр бүлийн 55 хүний хүлээж авч ажиллаж байна.
- Нийт үйлчлүүлэгчийн 55 хүний 36 хүн буюу 65 хувь хүүхэд үйлчилгээ авч байна.
- 3 төрлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхэд ирдэг. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, үл хайхрагдсан хүүхэд
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон нэг цэгийн үйлчилгээний журамд нийцсэн үйлчилгээ үзүүлдэг.
- Манайд нийт 8 ажилтантай, тэдний 4 нь өмнө нь цагдаад ажиллаж байсан.
- Нэг мэргэжлийн нийгмийн ажилтан, нэг сэтгэл зүйч ажилладаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн авч хамгаалдаг газар байхгүй

Булган:

- БГД-ийн түр хамгаалах байх ихэнхдээ нөхөн сэргээх үйлчилгээ үйлчилгээ үзүүлдэг.
- 65 хүүхэд үйлчилгээ аваад байна.
- Үйлчилгээний төрлүүдийн хувьд ариун цэврийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх- айдас түгшүүрийг арилгахад чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг.
- Ээлжийн нийгмийн ажилтан- хоёр мэргэжлийн нийгмийн ажилтан
- Түр хамгаалах байран ирсний дараа ррчинг танилцуулдаг.
- Хөгжлийн үйлчилгээ: дуу шүлэг зааж өгөх, дуулуулах, бүжиглэх, үлгэр ярьж өгөх зэргээр хүүхдийг стрессийг бууруулах хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг.
- Боловсролын үйлчилгээ- цахимд хичээлд үзүүлж байна. Танхимаар хичээлд нь явуулах үед бидэнд анхаарах асуудал гарч ирнэ. Том хүүхдүүд хүүхдийн тусламжийн утас- түр хамгаалах байрны хаягтай машинаар явах дургүй. Иймд унааны асуудал гарч байна
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг яах- өмгөөлөгчдөө яаж хэлбэрээг ярих вэ зэрэг ойлголт өгч, хуулийн мэдлэг олгоно.
- Төвд 1-ээс 3 сар хүртэлх байх ёстой.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрамжийн төвүүд- асрамжийн төвүүд байдаг.
- Туслах нийгмийн ажилтан байхгүй тул мэргэжлийн нийгмийн ажилтан хүүхэд асрагчийн ажлыг хийдэг.
- Нийгмийн ажилтан ажиллах бүх хугацаандаа хүүхдүүдтэй байна. Нэг үйлчлүүлэгч- 8 цагийн үйлчлүүлэгчтэй.
- 16 хүүхэдтэй нэг нийгмийн ажилтан байдаг.
- Төв байгаа хүүхдүүдийн 10 нь 3-аас 16 настай, гурван настай 1, таван настай 1 хүүхэд байна. Харах хүнгүй ганцаараа ирж байгаа нярай хүүхдийг бол ээлжийн нийгмийн ажилтан асрах хэрэгтэй болно.
- Хүүхдүүдтэй сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлдэг- Урлагийн заслын ашиглаж байна.
- Хүүхдээ харах ээлжин дээрээ хүүхдүүдээ унтуулаад кейс файлаа бичдэг.
- 3 сарын 10-наас хойш - 30 кейс дээр ажилласан. Нэг кейс дээр ажиллах хугацаа 7-10 хоног байдаг.
- Гэр гэр лүүгээ буцах- дүүргийн хэлтсийн байгаа.

Энх-Амгалан:

- Эргэн нэгтгэх ажлыг хорооны нийгмийн ажилтан л хийдэг.
- Хууль дээр дүүргийн ГБХЗХХ-ийн үүрэг оролцоог нэмэх хэрэгтэй. Тэд илүү мэргэжлийн, бас дараагийн шатны түвшинд ажиллаж байгаа тул хүнд кейс дээр дээр буюу дараагийн үйлчилгээг хүргэх хэрэгтэй.
- Учир нь тэднийг ахисан түвшний мэргэжилтнүүд гэдэг. Мэргэжлийн сэтгэл зүйч, бидэнд арга зүйн дэмжлэг үзүүлж ёстой учраас тэд ахисан түвшинд ажиллах ёстой.

- Хороон дээр ажиллаж чадахгүй байгаа үндэслэл- архи уугаад эхнэрээ зодсон – баривчилгаанд явуулах, архины хамааралтай байх нь байнга давтагддаг учир тэдний давуу тал болоод байна. Эцэг эх байх эрхээ биелүүлж чадахгүй тохиолдолд- хуулийн хариуцлага хүлээх, хариуцлага тооцох хэрэгтэй. Хууль чанга байх хэрэгтэй байна.
- Хүүхдийг асрамж халамжинд өгөх дээр анхаарах
- Хорооны түвшинд хэлэлцэж, мэргэжлийн анхан шатны үйлчилгээг хүргээд шаардлагатай тохиолдолд дараагийн шатны мэргэжлийн үйлчилгээтэй холбон зуучлах хэрэгтэй байна.
- Ах дүү хамаатан садны тусламжийг ашиглах, сургалтын – гэр бүлтэй ажиллахад нь оронд

Үйлчилгээ үзүүлдэг дарааллын хувьд

- 108-ний дуудлагын дагуу гэрт нь очиж НБҮ хийнэ. Хүүхэдтэй хэн байна гэдгээс хамаарна. 10 дээш насны хүүхдийг өрөөндөө авчраад ярих нь амар байдаг.
- Төлөвлөгөө гаргаад- эрсдлийн түвшин хир байхаас гаргана. Хамтарсан багаараа төлөвлөгөө гаргана. Ямар асуудалтай байгаагаас хамаарч холбон зуучилна. Зөвлөгөө өгөх, олон талаас тодруулга. Холбон зуучлахаас гадна- эмнэлгийн – сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.

А. Батхишиг: Нэг тохиолдол дээр хэдэн хүн ажиллах вэ?

Нэг тохиолдолтой нийгмийн ажилтан, өрхийн эмч, хорооны хэсгийн байцаагч, хэсгийн ахлагч нар ажиллана.

Нэг тохиолдол дээр хир удаан ажиллах вэ, хэдэн удаа уулзах вэ

- Жишээ авбал нэг архины хамааралтай эцэг эхийн хүүхэдтэй ажиллах тохиолдолд хамгийн багадаа 3 сар ажиллана.
- Нэг кейс ажиллахад доод тал 5-6 удаа уулзах
- Эцэг эхтэй нь олон уулзана-
- Сургуулийн нийгмийн ажилтан хүүхэдтэй түлхүү ажиллана.

Ариунтуяа- Анхаармаар олон асуудал байна. Үүнд:

- Хүний нөөц их асуудалтай. Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байран дээр их тогтвор суурьшилгүй байна.
- Оффисийн ажил байдлаар ажиллах гэж боддог шиг байгаа юм.
- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх- олон хүн ажиллаж байна. Өөрсдөө сайн боловсорсон, сэтгэл гаргах шаардлагатай.
- Хорооны нийгмийн ажилтнуудын ажиллах нөхцөл, санхүүжилт их муу байна. Санхүүжилт- нөхцөл бололцоо их тааруу байна. Явган ирж байна-
- Үйлчилгээ үзүүлж буй хоног өөр байна- 1 сараас 3 сар үйлчилгээ үзүүлэх ёстой.
- Нэг цэгийн үйлчилгээ богино хугацаанд байдаг.

Боловсон хүчнээс гадна өөр ямар зүйлийг төлөвлөх ёстой вэ?

- Нэг цэгийн үйлчилгээнд байр сав, хоол, амьдрах -өдрийн хоол, боловсролын тухайд- монгол наадгай-боловсрол асуудал тасалдах явдал- интернетээр холбоно. Тоглоом-хандивын журмаар цуглуулдаг. Хамтарсан багтай холбогдож ажиллаж байна.
- Хороо, дүүрэг, нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг бидний хооронд бичиг хэргээ солилцдог сан, цахим сүлжээ байвал их зүгээр.

- Нэг цэгийн үйлчилгээний хувьд тоног төхөөрөмж хангалттай. Өнгөрсөн онд НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр байгуулагдсан учир боломжтой.
- Бид үйлчилгээгээ дууссны дараа Албан бичиг заавал явуулдаг-нөхөн сэргээх үйлчилгээний талаар зөвлөдөг.

Анхан шатанд- хороо, сум дээр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудад дараа зүйл хэрэгтэй: Үүнд

- Дуу хураагуур
- Зургийн аппарат
- Хурдтай компьютер, принтер
- Өрөө
- Өрөөнд хүүхэд тоглох тоглоом
- Өрөөний стандарт байх ёстой

Ариунтуяа-

- Утасны зардал байдаг болов уу. Утасны нэгж их хэрэгтэй
- Машин унаа байхгүй юмаа гэхэд унааны, таксины мөнгө оруулах хэрэгтэй.
- Хүүхдийн өрөө байх ёстой. Хамтарсан багт зориулсан- хүүхдийн хоол, хүнс байвал зүгээр. Хороон дээр байж байгаад ирсэн хүүхдүүлд өдөржин цайгүй байлаа гэж ярьдаг.
- Нэг цэгийн төв, хамтарсан баг, нийгмийн үйлчилгээний төв, ГБХЗХХ-ийн ажлын ачаалал ихтэй болоод тэрүү мэргэжлийн арга зүйгээр ажил учир дутагдалтай.

Чимэдбалдир-

- Тогтолцоогоор нь өөрчлөх ёстой. Байгууллагын хоорондын уялдаа холбоо муу.

А.Батхишиг: Цаг гаргаж ярилцлагад оролцсон та бүхэнд баярлалаа. Хэрэв сая асуусан зүйлтэй холбоотой санаа төрвөл бидний емейл хаяг руу илгээнэ үү. Их баярлалаа.

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 5

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 7 өдрийн 10 цагаас 12 цагийн хооронд болов.

Хүйсийн тэгш эрх төвийн зохицуулагч Э. Хишигбаяр, Хүүхдийн хөгжил, хамгаалал төв ТББ-ийн нийгмийн ажилтан Даваа, Хөөрхөн зүрхнүүд ТББ-ийн гүйцэтгэх захирал Б. Оюундарь, ХНХЯ-ны ХАХБХЗГ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комиссын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Сэндэн, Эрхэм нандийн сувд ТББ-ийн (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн төлөөлөл-Энхчимэг, Энэрэлийн түүчээ ТББ, Хүслийн ордон хүүхэд хөгжүүлэх төвийн Бадамаа нар оролцов.

Уулзалтын эхэнд зөвлөх А. Батхишиг- хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглалын төслийг танилцуулав. Танилцуулгын дараа слайдад үзүүлсэн үйлчилгээнээс ямар үйлчилгээг үзүүлж байна, ямар үйлчилгээг энэ слайдад нэмэх шаардлагатай асуув.

Хуулийн зөвлөх Оюунболд- ТББ-аад эдгээр үйлчилгээ үзүүлэх боломжууд байгаа эсэх, хүүхэд хамгааллын хуульд ямар өөрчлөлт оруулах шаардлагатайг асуув

Б.Оюундарь: Бэлгийн хүчирхийлэлд- нийгэм сэтгэл зүй нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж байна. Кейс менежментийн үйлчилгээг бүрэн утгаар үзүүлэхийг зорьж ажиллаж байна.

- Магадлан итгэмжлэгдсэн байгууллага. Эхлээд урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 10 сая төгрөгийн санхүүжилтыг төндэрт авсан. Харин сэтгэл зүйн үйлчилгээнд мөнгө авч байсан түүх байхгүй.
- Төрийн байгууллага бидний өрсөлдөгч гэж үздэг. Манай байгууллагад үйлчилгээ авч байгааг сонсоод яагаад тийшээ очсон гэж асуудаг.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар нэгдсэн ойлголт заавар зөвлөгөө өгөөгүй учраас- өөр өөрийн ойлголттой байна. Нэгдсэн ойлголт байлгах хэрэгтэй
- Магадлан итгэмжлэгдсэн ч гэсэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ гэдэг утгаар төндэрт орсны хэрэг гараагүй дээр ямар ч дэмжлэг авч байгаагүй.
- Төрөөс гэрээлэн гүйцэтгэнэ гэсэн гэрээлэн гүйцэтгэдэггүй.

А. Батхишиг- Танай байгууллагад хүүхэд хэрхэн ханддаг байна вэ. Үйлчлүүлэгч хүүхдийг хаанаас танай байгууллага руу холбодог вэ?

Оюундарь:

- Манай байгууллагад ирж үйлчилгээ авч байгаа охидын 12-15 хувь нь хүчиндэх гэмт хэргийн хохирогч, 40-50 хувь нь ГБХЗХГ-аас холбон зуучилсан, үлдсэн хувь нь
- нь цагдаа, прокуророос , иргэний ТББ, олон нийтийн мэдээллийн байгууллагуудаас утсаар холбогдож тус тус ирж манай байгууллагаас үйлчилгээ авдаг.
- Манай байгууллага кейс менежментийн үйлчилгээ хийдэг, өөрөөр хэлбэл илрүүлэхээс хаах хүртэл үйлчилгээ хүргэдэг. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид удаан хугацаанд 1-2 жил сэтгэл заслын үйлчилгээ үйлчилгээ, хууль эрх зүйн, боловсролын, асрамжийн гэх мэт үйлчилгээ хүргэдэг.
- Кейс менежер кейс дээр ажиллана. Төр байгууллага ямар үйлчилгээг үзүүлэх, ТББ-ийн ямар үйлчилгээ хүргэхийг тодорхой болгох хэрэгтэй.

- Төрийн байгууллагууд цогцоор үйлчилгээ авахгүй зөвхөн сэтгэл зүйн үйлчилгээ авна гэж хүсээд хохирогч мэдүүлгээ буруу өгөөд байна, мэдүүлгээ зөв өгөхөд туслаач гэж хэлдэг.
- Үйлчилгээ үзүүлэхэд хохирогчийн ар гэрийн туслалцаа хэрэгтэй. Хүүхэд бусад эрсдэлд өртөнө. Сэтгэл зүйн долоо хоногт долоо хоногт нэг л удаа 45 минут уулзалт хийдэг.
- Ийм нөхцөлд төрийн байгууллагаас гэр бүлийн дэмжих хэрэгтэй байдаг ч тэр бүр дэмждэггүй. Тиймээс долоо хоногт 1 л удаа 45 минут уулзахад өөрчлөлт гарахгүй байх хүндрэлтэй. Уг нь гэрт дэмжлэг үзүүлэх үйлчилгээг зэрэг хийх ёстой.
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх их ерөнхий ойлгодог. Мэргэжилтэн бүр хувийн хандлагаар үйлчилгээ үзүүлдэг. Кейсийг зохицуулах, үйлчилгээ үзүүлэхэд саад болдог.
- ТББ-ийн оролцооны, үйлчилгээний талаарх үйл явцыг тодорхой бичих хэрэгтэй
- Төрийн байгууллагын сэтгэл зүйч болсон явдлыг дахин яриулдаг нь их буруу.

Хишигбаяр: Манай байгууллага хүн худалдах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ хүргэдэг. Үүнд:

- Хандах хүн олон сувгаар манай байгууллагад ханддаг.
- Үйлчилгээг- анхан шатны эрүүл мэнд, хоол, асрамжийн туслалцаанаас эхлээд үйлчилгээнд хамрагдсны дараа эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр- урт хугацаанд хамруулдаг.
- Боловсрол, орлоготой болоход туслах – амьдралын нөхцлөөс хохирогч болдог. Урт хугацааны үйлчилгээ шаардлагатай. Гэвч урт хугацааны хөтөлбөр санхүүжүүлэлтээс хамаарагдаж хязгаарлагдана.
- ГБХЗХГ-аас Хүүхэд хамгааллын байгууллагын төсвөөс санхүүжилт авсан түүх байхгүй.
- Манай байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс зарласан тендерт оролцож санхүүжилт авдаг.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ их хэрэгтэй- Үнэ төлбөргүй өмгөөллийн асуудлыг шийдэж байж асуудлыг хохирогчид ээлтэй байдлаар шийдэх боломжтой болдог.
- Манайхаас үйлчлүүлэгч нарт орлого дэмжих үйлчилгээ их хэрэгтэй байдаг.
- Магадлан итгэмжлэхэд орж байгаагүй, бусад байгууллагын байдлаас харахад их олон зүйлийг хүсдэг, шалгуур өндөр гэж ойлгодог.

Энхчимэг- Эрхэм нандийн сувд- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн нэгдэл- ТББ- ийн төлөөлөл:

- Эцэг эх нь хамгаалдаг хүн байна. Хамгаалахгүй хүн байна. Сүхбаатар дүүрэг дээр кейс дээр ажиллахад аав ээжийг албан саатуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг яах вэ гэсэн асуудал гарсан. Хүүхдийг хамгаалах газар луу аваачихад авах газар байхгүй, аваачих газар байхгүй байсан.
- Хүүхдийн хүчирхийлэл- хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өөрөө хөгжлийн бэрхшээлийн улмаас хамгаалуулах эрхээ хасуулдаг- өөрсдийгөө оношлуулж чадахгүй байна. Эмчилгээ байхгүй. Боловсрол байхгүй- авдаг хүн байхгүй. Хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдэд нарийн мэргэжлийн үйлчилгээ байхгүй
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээж авахгүй байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүрч чадахгүй байхгүй.
- Хөгжлийн бэрхшээлийн хүүхэдтэй эцэг эхийн бүлэгтэй-3000 гаруй эцэг эх нэгддэг байна.

Сэндэн: Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй дахиад танилцах хэрэгтэй.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамгааллын талаар- Хүүхэд хамгааллын сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хууль байхгүй.
- Төрийн байгууллагын сэтгэл зүйч хууль байхгүй. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг зангидаж байх хүн төрийн байгууллагад ажиллах хэрэгтэй.

А. Батхишиг: Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний талаарх нарийвчилсан бодлого, төлөвлөлтийн сэтгэл зүйчид өөрсдөө хийх хэрэгтэй болов уу. Харин хүүхэд хамгааллын үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэгт сэтгэл зүйн засал, эмчилгээ гэсэн хэлбэр орно. Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө гэдгийг нийгмийн ажилтан ч хийнэ, сэтгэл зүй ч хийнэ. харин сэтгэл зүйчийн ялгаа нь зөвлөгөөнөөс илүү давсан сэтгэл зүйн засал, эмчилгээ хийх шаардлагатай.

Даваа- Хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй ажилладаг байж байгаад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх- хөдөлмөр эрхэлдэг хүүхдийг оруулахгүй гээд заахаар хүүхдэд хортой нөлөөтэй.
- Насанд нь тохирсон хүүхдийг ажиллуулах- хэрэгтэй. Туслах хэрэгтэй-
- Хэрэв хүүхэд хөдөлмөр эрхэлж болохгүй гэж хориод байвал нууцаар, аюултай хөдөлмөр эрхэлж байна.
- Хөдөлмөрийн хууль дээр өөрчлөлт орох хэрэгтэй.

А. Батхишиг:

Даваа- Манай байгууллага нэгээс гурван жилийн үйлчилгээ үзүүлдэг.

Хишигбаяр- Нэгээс хоёр жил үйлчилгээ үзүүлдэг.

Оюундарь- гэр бүлийн дэмжлэгтэй бол 6 сараас 2 жилийн үйлчилгээ үзүүлж байна. Гэр бүлийн дэмжлэггүй бол 4 жил, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг.

А. Батхишиг: Хэдэн хүн нэг кейс дээр ажилладаг вэ?

Оюундарь:

- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид- сэтгэл засал, 4 мэргэжилтэн- кейс менежер- нийгмийн ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургагч
- Үйлчилгээ- амьдрах ухааны сургалт- зохион байгуулах- өөрийгөө хамгаалах, бэлгийн ариун цэвэр гэх амьдрах ухааны сургалт оруулдаг. Үүнийг нөхөн сэргээх үйлчилгээнд оруулж болно.

Сэндэн- сэтгэл зүйн шинжлэх ухаан- оношлогоо- заавал хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зөв оношлох хэрэгтэй.

Хишигбаяр- манай байгууллагын нэг хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, хамгаалах байрны нэг хүн тус тус оролцдог.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд ямар тоног төхөөрөмж хэрэгсэл хэрэгтэй вэ?

Хишигбаяр:

- Үйлчилгээний программ- бүртгэл- үйлчилгээний програм байх- мэдээллийн сан хэрэгтэй.
- Диктофон – дуу хураагуур ашиглах
- Мэргэжлийн чиг баримжаа олгоход шаардлагатай зүйл, маникурын хэрэгсэл,

- Хүүхдүүдээ сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй- нэг хүүхдэд 250-500 мянган төгрөг
- Хишигбаяр – магадлан итгэмжлэхэд материал бүрдүүлэлт болон шалгуур өндөр байдаг
- Даваа-: Манай байгууллага магадлан итгэмжлэгдэж санхүүжилт авахад зарцуулалтын 70 баримтаа бүрдүүлсний дараа үлдсэн 30 хувийн баримтыг өгөхийг шаардаж бүх баримтаа өгсний дараа нилээн удсны дараа үлдсэн 30 хувийн мөнгийг өгсөн.

А. Батхишиг- Цаг гарган оролцсонд баярлалаа. Хүүхэд хамгааллын тухай хуультай холбоотой ямар нэг санал толгойд нь орж ирвэл энэ долоо хоногийн эцсээс өмнө зөвлөхүүхдийн емейл хаяг руу илгээнэ үү. Баярлалаа. Сайхан амраарай.

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 6

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 7 өдрийн 14 цагаас 16 цагийн хооронд болов.

Төв аймгийн ГБХЗГ-ын дарга Д. Бадамцэцэг, Архангай аймгийн ГБХЗХГ-ын дарга Ч.Уранцэцэг, Дорнод аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн, хүүхдийн хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн Ж. Сайхангэрэл, мэргэжилтэн Н. Туяацэцэг, Архангай аймгийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн Г. Оюуннаран

Уулзалтын эхэнд зөвлөх Т. Цэндсүрэн хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглалын төслийг танилцуулав. Танилцуулгын дараа слайдад үзүүлсэн үйлчилгээнээс ямар үйлчилгээг үзүүлж байна, ямар үйлчилгээг энэ слайдад нэмэх шаардлагатай асуув. Зөвлөх А. Батхишиг- нэмэлт танилцуулгыг хийв.

Д. Бадамцэцэг:

- Урьдчилан сэргийлэх үйлчилгээ хуульд байхгүй.
- ГБХЗХГ-ийн таваас зургаан мэргэжилтний хийдэг ажлыг нэг л хүн аймаг, орон нутгийн ГБХЗХГ-т хийдэг.
- Магадлан итгэмжлэгдсэн байгууллага манай аймагт байхгүй.
- Сумын нийгмийн бодлогын сумын мэргэжилтэн манай харъяа биш ч манай хөл шиг ажилладаг. Гэхдээ тэд улс төрийн шалтгаанаар амархан солигддог
- Явуулын хамгааллын үйлчилгээ хэрэгтэй
- Төв аймагт 27 сумын тойроход их хугацаатай. Хүний нөөц хангалтгүйн улмаас хамгааллын хоёр ажилтан хөдөө явахад аймгийн төв дээрх үйлчилгээ зогсдог.
- Явуулын үйлчилгээ хуульчлаад ороод ирэхэд их зүгээр.
- Бид багийн өдөрлөг дээр үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн хүчирхийллийг илрүүлэх ажлуудыг хийдэг.

Дорнод аймгийн ГБХЗХГ-ийн мэргэжилтэн Туяацэцэг:

- Явуулын үйлчилгээг их хэрэгтэй. Явуулын үйлчилгээ нь хүүхдэд хүрэх боломжтой, очиж чадахгүй айлд очдог. Их хэрэгтэй
- Хүүхэд хамгааллын тухай хуульд- Хүүхэд хамгааллын мэргэжилтний тоог нэмэх хэрэгтэй. 108-- дуудлагын дагуу ажиллах боловсон хүний тоог нэмэх хэрэгтэй.
- Боловсон хүчний – хамгааллын мэргэжилтний тоог нэмэх хэрэгтэй
- **Хамгааллын мэргэжилтнийг хамгаалах хэрэгтэй- аюулгүй байдлын тухай асуудал их тулгардаг.** Цахилгаан бороохой хэрэгтэй.
- Хохирогч хүүхдийн эцэг эх янз бүрийн хүмүүс орж ирдэг- **ГБХЗХГ-ын хууль ёсны төлөөлөгчөөр орох эрхтэй, энэ хүүхдийн төлөөлөл болж чадна гэсэн төлөөлөл байх ёстой.**
- Эцэг эх асран хамгаалагч нь хүүхдээ хамгаалах чадваргүй тохиолдолд хүүхийн байгууллагын ажилтан хууль ёсны төлөөлөл болж чадна гэж оруулах ёстой гэхэд тодорхой оруулах ёстой.
- Сэтгэцийн өвчтэй хүмүүс их хүүхэд төрүүлдэг. Хуулийн хариуцлага хүлээлгэх гэхээр ухаан муутай болдог. Асуудал болохоор эрүүл болдог. Сэтгэцийн өвчтэй хүний хүүхдийн эрх зөрчиж байна. Архины хамааралтай

Архангай аймгийн ГБХЗХГ-ийн дарга Уранцэцэг:

- Хүүхэд хамгааллын тухай 10 дугаар зүйл дээр сэтгэл зүйн үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээ- Санхүүжилт авахад мөнгө гардаггүй. Аль үйлчилгээн дээр мөнгө нь гарахгүй байдаг. Тиймээс үйлчилгээний нэрийг зааж өгөх хэрэгтэй.
- Орон нутагт сэтгэл зүйн зөвлөгөө өгч байна, сэтгэл зүйн оношлогоо хэрэгтэй байна. Хууль дээр оруулах
- Хууль зүйн туслалцаа авах, сэтгэл зүйн үйлчилгээ нь заавал мөнгөөр төлөх ёстой. Өмгөөллийн үйлчилгээний тарифаар өгөх хэрэгтэй. Түр хамгаалах байранд сэтгэл зүйчийг нарийвчлах хэрэгтэй.
- Орон нутагт хүүхдийн эрхийн, хүүхэд хамгааллын мэргэжлийн орон тооны хүн байх ёстой.
- Нийгмийн бодлогын мэргэжилтэн мэргэжлийн хүн байх ёстой. Мэргэжлийн хүний нөөцтэй байх хэрэгтэй.
- Магадлан итгэмжлэгдсэн ТББ-ийн мэргэжлийн хүний нөөцтэй байх ёстой. Харин цүнх үүрсэн хүн үйлчилгээ үзүүлэх боломжгүй
- 18-р зүйлд- орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллагын үйл ажиллагаа явуулах уу, эсхүл үйлчилгээ явуулах уу чиг үүргийг тодорхой болгох
- Үйлчилгээ – үйл ажиллагаа хэлбэрээр тодорхой болгох- үйлчилгээ хэлбэрээр тодорхой байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ гэдгээр тодорхой зааж өгөх хэрэгтэй.
- 18.2 дээр явуулна. Хүүхэд хамгааллын чиглэлээр юу хийх хэрэгтэй гэдгийг

Б.Даваасүрэн Баянхонгорын аймгийн ГБХЗХГ-ын хүүхдийн эрх, хамгааллын мэргэжилтэн.

- Явуулын үйлчилгээний хувьд 4000 гаруй айл өрхөөр явсан
- Хамгаалах байруудыг сумын төв болгон дээр заавал байна гэж оруулбал их зүгээр.
- Хэнтийн хэлдэгтэй санал нэг байна. хамгааллын мэргэжилтний тоог нэмэх хэрэгтэй. Хамгааллын мэргэжилтнүүд маш их ачаалалтай байдаг.
- Суман дээр нийгмийн бодлогын мэргэжилтэн ТЗ-3-аар ажилладаг халамжийн нийгмийн ажилтан
- Бие даасан хүний нөөцийг ТЗ-ийн 5-аар болговол зүгээр байна. Анхан шатанд ажиллаж байгаа нийгмийн ажилтанг авна. Доороо хүний нөөц байх ёстой.
- Тогтолцоо- хүний
- Хамгааллын хамгааллын тухай тодорхойлолт дээр – шуурхай тусламж,нөхөн сэргээх, урьдчилгаа

Г. Оюуннаран

- Гамшиг, онцгой байдлын үеийн хамгаалал- хараа хяналтгүй хүүхдийг асрах хамгаалах
- Эрүүл мэндийн үйлчилгээнд анхаарах
- 2-р бүлэг дээр Гэр бүл, боловсрол, - гудамж талбайд орчин тодорхой болгох
- 15-р зүйл дээр- Хууль зүйн хорооны тухай үйлчлэл
- Хамтарсан багийн тухай тодорхой оруулах

- Хурдан морины тухай уралдаан-хуралдааны морин спортын ТББ-ын хүмүүст үүрэг хариуцлагыг хүлээлгэх

Д. Бадамцэцэг:

- 13-р хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээний тухай тодорхой оруулах.
- Хамаатан садангийн хувилбарт үйлчилгээ-

А. Батхишиг. Цар тахлын улмаас томилолтоор явж чадахгүй хүлээж байна. Боломж гарвал явна. Хэрэв Хүүхэд хамгааллын тухай хуульд зайлшгүй өөрчлөх зүйлийн

ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ NO 7

Цахим хэлэлцүүлэг болсон өдөр, цаг 2021 оны 7 сарын 8 өдрийн 13 цагаас 14 цагийн хооронд болов.

Дархан СОС-ын зохицуулагч Баатарцогт, Бадамлянхуя төвийн нийгмийн ажилтан Нарантуяа, Удвал, Кристина Нобелийн сангийн нийгмийн ажилтан Ганчимэг, Нархан төрийн нийгмийн ажилтан нар нар оролцов.

Уулзалтын эхэнд зөвлөх А. Батхишиг- хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглалын төслийг танилцуулав. Танилцуулгын дараа слайдад үзүүлсэн үйлчилгээнээс ямар үйлчилгээг үзүүлж байна, ямар үйлчилгээг энэ слайдад нэмэх шаардлагатай асуув.

Дархан СОС- Баатарцогт- ас 73-хүүхдийн 55 хувь нь Дархан, үлдсэн хувь

- СОС ээжтэй 7 хүүхэдтэй.
- Хагас ба бүтэн өнчин,
- ямар шалгуураар авдаг.

Бадамлянхуяа 75 хүүхэдтэй.

Нарантуяа нийгмийн ажилтан-ОУС, Удвал- нийгмийн ажилтан

- 2-13 насны хүүхэд байрладаг. Гэр бүлтэй янз бүрийн байдаг. Архины хамаарал
- 108-аас аваад бичиг баримтын бүрдэлт-ээс дүүргээс хамаараад- бичиг
- НБҮ-, эрсдлийн үнэлгээ-Хүүхэд хамгааллын бодлогын дараах- асрах хамгаалагчийн эрх шилжсэн. Шийдэгдээгүй хэдэн хүүхэд байдаг. Дүүргээс хамаараад- ар гэрээс холбогдоогүй ирдэг. Захирамж гарсан
- Эрүүл мэндийн
- Боловсролын
- Амьдрах ухаан гэдэг бакери, хоол хийх,
- Нийгмийн ажлын үйлчилгээ- хөгжлийн онцлогт
- Гурван нийгмийн ажилтай

Гэр бүлд нь эргэн нэгтгэх чиглэлээр:

Кристина Нобелийн багш нийгмийн ажилтан Ганчимэг- асрамж халамжийн чиглэлээр 2006 оноос хойш, 3 жил болж байна.

5-20 насны 51 хүүхэдтэй. 12 дугаар ангиа энэ жил төгсөж байгаа, эцэг эхгүй. Төвдөө-дамжин өнгөрөх төвөөр 2 жил үйлчлүүлдэг. 19-23 насны 7 хүүхэд дамжин өнгөрөхөд амьдардаг. Хувиараа байр түрүүлсээд явахаар бэлтгэж байна. Дамжин өнгөрөх байр луу явж байгаа учраас 4 жил болж байгаа учраас нэг жилийн зохих хэмжээний санхүүжилт авсан.

Магадлан итгэмжлэхэ 3 дахь удаа магадлан итгэмжлэгдсэн.

Нархан төвд ирсэн хүүхдийг шууд хүлээж авахгүйгээр төвийн Хүүхэд хамгааллын багтай хамтарч үнэлгээ хийж шаардлагатай бол төвдөө авдаг. Урт шаардлагатай үйлчилгээ Хүүхэд хамгааллын багт – нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, менежер, төв оффисийн ажилтан- хотхон дээр ямар нэг асуудал гарлаа

Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө- хоёр сэтгэл зүйчтэй, гурван нийгмийн ажилтантай ажилладаг.

70 орчим албан хаагч, ажилтан 30 багш,

Халамжийн дараах үйлчилгээ- нийгэмшүүлэх- тал дээр төвүүд дээр алдаад байгаа зүйл их

Гэр бүлийг давхар нийгэмшүүлэх ажил хийдэг- Гэр айлчлалаар эцэг эхийн нөхцлийг сайжруулах чиглэлээр нөхцөл байдлыг шалгаж, эргэн нэгтгэхэд харъяа орон нутагтай хамтарч ажилладаг.

Оюунболд- Халамжийн хуулиар зохицуулдаг.

Бадамлянхуй – төрөөс ямар нэг санхүүжилт авч байгаагүй.

Ганчимэг- Залуусыг чадавхижуулах дамжин өнгөрөх дээр нэг, хүүхдийн эрхтэй-холбоотой спонсорын төсөл байдаг.

А. Батхишиг- Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой нэмэлт санал байвал бидэнд илгээгээрэй. Цаг гарган оролцсон та бүхэнд баярлалаа.



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар
дундын ажлын хэсэг байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалттайгаар хэрэгжүүлэх салбар дундын байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Ажлын хэсгийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэхэд салбар бүрийн оролцоог хангаж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Хүүхэд хөгжил, хамгааллын ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Дэд сайд /С.Зулпхар/-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/218 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



А.АРИУНЗАЯА

D: 2021 on 05 sar 19 131200913

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
Сайдын 2021 оны 05 дугаар сарын
12-ны өдрийн тогтоол тунхагалын
10-н үндсээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

С. Зулпхар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд

Ажлын хэсгийн дэд дарга:

Н. Баярмаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Г. Батдорж

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Гишүүд:

Л. Нямгэрэл

Хууль зүй дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга /тохиролцсоноор/

А. Амарбал

Үндэсний Статистикийн хорооны Хүн ам нийгмийн статистикийн газрын дарга /тохиролцсоноор/

Ч. Адъяахишиг

Хүний эрхийн үндэсний комиссын Хүний эрхийн боловсрол судалгааны хэлтсийн дарга /тохиролцсоноор/

Д. Ундраа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын орон тооны бус зөвлөх

Н. Өлзийхутаг

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын газрын дарга /тохиролцсоноор/

Б. Дуламжав

Хууль зүй дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/

Б. Оролзодмаа

Эрүүл мэндийн яамны Халдварт бус өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтсийн нөхөн үржихүй, хүүхэд, өсвөр үе залуучуудын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/

Б. Цолмон

Берилга хот байгуулалтын яамны хүний нөөцийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах шинжээч /тохиролцсоноор/

Д. Оюунсүрэн

Зам, тээврийн хөгжлийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн /тохиролцсоноор/

Ж. Байгаль

Боловсрол, шинжлэх ухааны яам Бага, дунд боловсролын газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/

С. Пүрэвсайхан

Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/

Д. Оюунчимэг	Эрчим хүчний яамны Төрийн захиргаа удирдлагын газрын шинжээч /тохиролцсоноор/
Б. Гантулга	Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа удирдлагын газрын шинжээч /тохиролцсоноор/
Ж. Төгөлдөр	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/
Ц. Навчаа	Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ эрхзүйн газрын хүний эрхийн хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Л. Ариунтунгалаг	Солонгосын яамны Урлаг, уран бүтээлийн газрын хүүхдэд зориулсан бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/
О. Туяацэцэг	Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/
Л. Отгонболор	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/
С. Баярцэцэг	Байгаль, эрчин аялал, жуулчлалын яамны Инноваци, цэвэр технологийн хэлтсийн мэргэжилтэн /тохиролцсоноор/
Э. Баярбаясгалан	Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Б. Будзаан	Цагдаагийн ерөнхий газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч /тохиролцсоноор/
Г. Золбоо	Нийслэлийн засаг даргын Тамгын газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
Ө. Ган-Өлзий	Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын дарга
Ч. Амарбаясгалан	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/
Ө. Бодьгэрэл	Нийгмийн даатгалын ерөнхий газрын бодлогын хэрэгжилт судалгааны газрын мэргэжилтэн /тохиролцсоноор/
Ц. Номин	Гадаадын иргэн, харьяатын газрын Олон улсын ТББ, гадаадын иргэнд хүүхэд үрчлэл хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/
А. Чимэгсүрэн	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Халамж үйлчилгээний хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Б. Батсүх	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч (СӨБ) /тохиролцсоноор/
Д. Өнөржаргал	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч (ЕБС) /тохиролцсоноор/
Б. Должинхорол	Онцгой байдлын ерөнхий газрын хүүхэд хамгааллын сургалт хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/

Т. Батболд	Харилцаа, холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлого хэрэгжүүлэх газрын Интернетэд суурилсан үйлчилгээ, технологийн хэлтсийн дарга /тохиролцсоноор/
Ц. Түвшинцэнгэл	Хил хамгаалах газрын шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, Хурандаа /тохиролцсоноор/
Б. Отгон	Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын ахлах бүртгэгч /тохиролцсоноор/
Д. Амараа	НҮБ-ын Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн
Д. Болорчимэг	НҮБ-ын Хүүхдийн Сангийн ХДХВ, ДОХ-ын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /тохиролцсоноор/
Э. Цолмон	Ялсны хүүхдийг ивээх сангийн Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн менежер /тохиролцсоноор/
Б. Мөнхбаяр	ДЗОУБ-ын нэгдсэн хөтөлбөрийн захирал /тохиролцсоноор/
Н. Нямдорж	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн багш, доктор /тохиролцсоноор/
А. Батхишиг	Монгол Улсын Их Сургуулийн Социологи, нийгмийн ухааны сургуулийн багш, доктор /тохиролцсоноор/
Х. Өлзийтунгалаг	Монгол Улсын Багшийн Их Сургуулийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн ахлах багш /тохиролцсоноор/
Х. Баавгай	Гүүд Нейборс олон улсын төрийн бус байгууллагын зөвлөх /тохиролцсоноор/
П. Цэвээн	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч /тохиролцсоноор/
Б. Жавзанхүү	Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал /тохиролцсоноор/
Д. Ууганбаяр	Хүүхдийн хөгжил оролцооны үндэсний сүлжээний зохицуулагч /тохиролцсоноор/
Ц. Баттуяа	Хүүхдийн хөдөлмөрийн төвчишгүй хэлбэрүүдийн эсрэг үндэсний сүлжээний зохицуулагч /тохиролцсоноор/
Д. Тунгалаг	Бүх нийтийн боловсролын иргэний нийгмийн үндэсний зөвлөлийн ерөнхий зохицуулагч /тохиролцсоноор/
У. Ганбаяр	Лангуун дохис ТББ-ын тэргүүн /тохиролцсоноор/
Э. Хишигбаяр	Хүйсийн тэгш эрхийн төвийн захирал /тохиролцсоноор/
Н. Арвинтариа	Хөдөлмөрийн эсрэг төвийн захирал /тохиролцсоноор/
Н. Байгаль	Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Гэр бүлийн сувгийн захирал /тохиролцсоноор/
Нарийн бичгийн дарга	
Г. Саранхүү	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрх, Хамгааллын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Ж. Азжаргал	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын газрын ахлах мэргэжилтэн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
Сайдын 2021 оны 25 дугаар сарын
19-ны өдрийн тоот тушаалын
орлоо аар хавсралт

**ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН САЛБАР ДУНДЫН
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг шинэчлэн баталж, Хууль тогтоомжийн тухай хууль¹, Хүүхэд хамгааллын тухай хууль (ХХТХ)² -д заасны дагуу хэрэгжилтийг үнэлэх үнэлгээг хийсэн. Үнэлгээ, судалгааны зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт хийх, салбар дундын ажиллагааг сайжруулах, хүүхэд гэр бүлтэй ажилладаг албан хаагчдыг чадавхжуулах, нийгмийн ажлын арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдэж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг сайжруулж, үнэлж, дүгнэх, үндэсний хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Засгийн Газрын 5-р тайлан илтгэлд Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмжийн биелэлтийг үнэлэх, Засгийн газрын 6, 7 дугаар тайлан илтгэлийг боловсруулах, хэлэлцүүлэх ажлыг салбар бүрийн оролцоо хангаж, хамтын ажиллагааг хангаж нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн удирдлага зохицуулалттайгаар хүүхдийн эрхийг хангах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл:

- 3.1. Хууль тогтоомжийн, хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар зохион байгуулж, салбар дундын зохицуулалтыг хангах;
- 3.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмийн бүх орчинд хориглох, хүүхдийг хүчирхийлэлд өртөх, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг хамтран зохион байгуулах;
- 3.3. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдал, тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар харилцан мэдээлэл, туршлага солилцох

¹ Хууль тогтоомжийн тухай хууль (2017) 51 дүгээр зүйл.

² Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) 22.1.7 дугаар зүйл.

3.4. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлуудыг эрт шатанд илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хохирогч хүүхдэд үйлчилгээг цогцоор нь үзүүлэхэд байгууллага хоорондын уялдаа холбоог ханган ажиллах

3.5. Хүүхэд гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх

Дөрөв. Ажлын хэсгийн зохион байгуулалт:

4.1 Ажлын хэсгийн гишүүд хүүхдийн эрх хамгааллын асуудлаар хариуцан хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дэд ажлын хэсэгт орж ажиллана.

4.1.1. Хүүхэд хамгааллын дэд ажлын хэсэг

4.1.2. Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих дэд хэсэг

4.3. Дэд ажлын хэсгүүд Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөж, улирал тутам хуралдаж, салбар дундын зохицуулалтыг хангаж ажиллах бөгөөд, ажлын хэсгийн өргөтгөсөн хагас бүтэн жилээр зохион байгуулна. Цаг уеийн асуудалтай холбоотой даргын зүгээс хурал зарлаж болно.

4.4 Ажлын хэсэг нь ажлаа Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд тайлагнана.

Тав. Үүрэг хариуцлага

5.1 Ажлын хэсгийн даргын үүрэг:

- Ээлжит болон цаг уеийн асуудлаар ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулах, хурлыг удирдах;
- Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гишүүдийн хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах.

5.2. Ажлын хэсгийн бүх гишүүдийн үүрэг:

- Хүүхэд хамгааллын асуудлаар үндэсний болон салбар хооронд хэрэгжүүлэх ажлын санаачлага гаргаж ажиллах;
- Ажлын хэсгийн бусад гишүүд өөрийн хариуцсан салбарыг мэдээллээр хангах, ажлын хэсгээс явуулж буй үйл ажиллагааг салбартаа хэрэгжүүлэх
- Ажлын хэсгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа хууль тогтоомж болон НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийг өөрийн төлөөлж буй салбартаа хэрэгжилтийг хангах, нөлөөллийн ажил зохион байгуулах;
- Ажлын хэсгийн хурал болон зохион байгуулж санал баловсруулах, судалгаа хийх, мэдээлэл цуглуулах зэрэг ажлын хэсгийн санаачлагыг хэрэгжүүлэхэд оролцох;
- Хүүхдийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенци, зөвлөмж болон дотоодын хууль тогтоомж, дүрэм, журмыг уншиж судлах

5.5 Нарийн бичгийн дарга нарын үүрэг:

- Хурлын товыг ажлын хэсгийн даргатай зөвшилцсөний үндсэн дээр зарлах
- Хэлэлцэх асуудал, хөтөлбөрийг гишүүдэд урьдчилан хүргүүлж хуралдааныг зохион байгуулах
- Ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангах

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛАХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС**

№	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Сархадын Зулпхар	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Дэд сайд	99029952
2	Ж.Ариунаа	Улсын Ерөнхий Прокурорын газар	Орлогч прокурор	99176801
3	Нарантуяагийн Баярмаа	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	88087788
4	Дугаржавын Ренчиндорж	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	89017707
5	Жанцандоржийн Азжаргал	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	88100729
6	Начиндагвын Өлзийхутаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99180397
7	Батсүхийн Батсайхан	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга	99736124
8	Жадамбаагийн Мягмар	Боловсрол, шинжлэх ухааны яам	Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга	99094743
9	Аръяагийн Цолмон	Боловсрол, шинжлэх ухааны яам	Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч	99897380
10	Батсуурийн Дуламсүрэн	Боловсрол, шинжлэх ухааны яам	Шинжээч	99056900
11	Өлзийхутагийн Энхмаа	Эрүүл мэндийн яам	Ахлах шинжээч	99164101
12	Тойруулын Батболд	Харилцаа холбооны зохицуулах хороо	Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга	88888911
13	Энхбатын Оюун-Эрдэнэ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Шинжээч	99135626

14	Бумцэндийн Янжмаа	Хүний эрхийн үндэсний комисс	Судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн	80064307
15	Пүрэвээгийн Баттулга	-	Хуулийн зөвлөх, өмгөөлөгч	99915239
16	Ганчулуун Оюунболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Шинжээч /Хуулийн зөвлөх/	99194710
17	Ринзааны Булгамаа	-	Өмгөөлөгч	99118576
18	Алтангадасын Энхбаатар	-	Өмгөөлөгч	99107107
19	Адилбишийн Батхишиг	Монгол Улсын Их Сургуулийн Нийгэм, социологийн тэнхим	Багш, доктор	99878556
20	Мишигийн Нямдорж	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхим	Ахлах багш	99811808
21	Сүхбаатарын Энхтуяа	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан	Гэрээт зөвлөх, Хүүхэд хамгааллын судлаач	99004924
22	Сүхбаатарын Энхтуяа	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан	Гэрээт зөвлөх, Хүүхдийн эрхийн судлаач	99004924
23	Балжиннямын Жавзанхүү	Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэн	Тэргүүн	99107138
24	Пэрэнлэйн Цэвээн	Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ	Зохицуулагч	99010297
25	Даржаагийн Ундраа	Хүүхэд хүчирхийлэхийн эсрэг үндэсний хөдөлгөөн	Ерөнхий зохицуулагч	91115981
26	Баянбаатарын Оюундарь	“Хөөрхөн зүрх” Төрийн бус байгууллага	Захирал	95959688
27	Гэлэгийн Ганбаясах	“Хүйсийн тэгш эрхийн төв” Төрийн бус байгууллага	Тэргүүн	99187446